



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ням-Осорын УЧРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-04-69, Факс: 32-70-16
E-mail: uchral@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.12.17 № УЧХ-03/14486

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг багасгах хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Н.УЧРАЛ

Х.ГАНХУЯГ

Б.ЗАЯАБАЛ

0000000207



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ням-Осорын УЧРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-04-69, Факс: 32-70-16
E-mail: uchral@parliament.mn
http://www.parliament.mn

2025.12.17 № УИА-03/14485

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг багасгах хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.


Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН





Н.УЧРАЛ

Х.ГАНХУЯГ

Б.ЗАЯАБАЛ

0000000010

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“18.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нараас санаачлан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нараас санаачлан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд зарчмын хувьд дэмжиж, дараах саналыг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов:

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад “мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны хугацаа гурван жилээс дээшгүй байна” гэж тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд “мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны хугацаа нэг жилээс дээшгүй байх” гэж заасантай нийцэхгүй байгааг анхаарч, Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна” гэж заасныг баримтлах;

2.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл /цаашид “зөвшөөрөл” гэх/-тэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно” гэж заасан боловч эрх бүхий байгууллага, албан тушаалтан тус заалтыг зөрчиж тухайн үйл ажиллагаанд тавих шаардлагыг хангаагүй гэх үндэслэлээр үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, зогсоох зэргээр хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулсаар байна.

Иймд хуулийн төслийн холбогдох хэсэгт “Энэ хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад үйл ажиллагааг аливаа шаардлага хангахгүй үндэслэлээр зогсоох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон саад болох бусад хязгаарлалт тогтоохыг хориглоно” гэж нэмэх;

3.хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 22 дахь заалтад “мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх”, “кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх” үйл ажиллагааг энгийн зөвшөөрлийн төрлөөс хасаж мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаанд хамруулсан байх ба мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны хугацаа гурван жилээс дээшгүй байхаар заасан байна.

Энэ нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 9¹ дүгээр зүйлд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.УЧРАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.12.17 № НЭГ/3555
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Та бүхний санаачлан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 04 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

этгээдийг бүртгэх асуудлыг зохицуулж, мөн хуулийн 9^{1.3}-т “Зөвшөөрлийн хугацаа нь зөвшөөрөл эзэмшигчийн орон тооны ажилтны олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллага, эсхүл түүнтэй дүйцэхүйц байгууллагаас олгосон хүчин төгөлдөр зөвшөөрөл олгосон гэрчилгээний дуусах хугацаатай адил байна” гэж заасантай зөрчилдөж байх тул уг гэрчилгээ бүхий ажилтны гэрчилгээний хугацаа харилцан адилгүй байх нөхцөлийг харгалзан энэ төрлийн зөвшөөрлийг одоо мөрдөж байгаа энгийн зөвшөөрлийн төрөлд үлдээх нь зүйтэй.

Энэ төрлийн зөвшөөрөл бүхий байгууллагууд нь Монгол Улсын онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлж, мэдээллийн систем, сүлжээний эмзэг байдлыг илрүүлэх, кибер халдлага, зөрчил, мэдээлэл алдагдах, үйл ажиллагаа тасалдах эрсдэлийг тодорхойлох, цаашлаад урьдчилан сэргийлэх, хамгаалалтыг сайжруулах бодитой зөвлөмжийг боловсруулахад өндөр ач холбогдол бүхий үйл ажиллагааг явуулдаг бөгөөд Үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд шууд нөлөө үзүүлэх тул эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэх ажилтнуудад хуулиар тавьсан шаардлагыг хангасан эсэхийг судалж, эрх олгож байх нь зүйтэй байна;

4. хуулийн төсөлд энгийн болон тусгай зөвшөөрлөөс гадна “мэдэгдэл”-ээр үйл ажиллагаа явуулах шинэ хэлбэрийг тусгаж, зарим үйл ажиллагааг мэдэгдлээр явуулж болохоор заасан нь зарчмын шинжтэй өөрчлөлт байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулж байгаа хуулийн төслийг боловсруулахад хийнэ” гэж заасныг баримтлан холбогдох судалгааг хийж, эрсдэлийн зэргийг ангилах шалгуурыг тодорхойлох нь зүйтэй байна;

5. Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана” гэж, мөн хуулийн 5.3 дахь хэсэгт “энэ хуульд өөрчлөлт оруулах асуудлаар санал, дүгнэлт гаргах” чиг үүргийг тус Зөвлөл хэрэгжүүлэхээр тус тус заасныг анхаарч, холбогдох санал, дүгнэлтийг авах шаардлагатай.

Түүнчлэн, хуулийн төслийн үзэл баримтлалд 122 зөвшөөрөлд хамаарах харилцаа захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулагдаж байгааг дурдсан нь эдгээр зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт нийцүүлэн холбогдох салбарын хууль тогтоомжид тусгах шаардлагатайг харуулж байна. Харин хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан зарим хуулийн төслүүдэд холбогдох захиргааны хэм хэмжээний актын зохицуулалтыг хэсэгчлэн тусгасан, зарим зохицуулалтыг огт тусгаагүй орхигдуулсан, эсхүл зөвшөөрөлтэй холбогдох харилцааг үргэлжлүүлэн захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулахаар тусгажээ.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн одоо хүчин төгөлдөр үйлчилж буй, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй бүхий л шийдвэрүүд дэх холбогдох зохицуулалтыг нэгтгэн, дагалдуулан

боловсруулсан холбогдох хуулийн төслүүдэд бүрэн гүйцэт, цогц байдлаар тусгах нь зүйтэй.

Хоёр.Хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

2.1.Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Радио долгионы тухай хуульд айл гэрт ашиглагдаж байгаа цахилгаан хэрэгслүүд болох зурагт, радио, зурагтын удирдлага гэх мэтийг бүртгэлгүй ашиглаж болохоор заасан.

Харин “радио долгион хүлээн авагч” гэдэгт телевизийн болон радио өргөн нэвтрүүлгийн хүлээн авагчаас гадна хоёр талт радио дамжуулагч буюу харилцааны станц, сансрын хүлээн авагч газрын антен буюу тавган антен, релейний антен зэрэг өргөн хүрээний тоног төхөөрөмж, техник хэрэгслүүд хамаардаг тул эдгээрийг бүртгэлгүй ашигласнаар бусад үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа радио долгионд харилцан нөлөөлөл үүсгэж болзошгүй сөрөг үр дагаврыг үүсгэхээр байна. Тухайлбал онцгой байдлын зориулалттай аврах алба, агаарын навигаци, зэвсэгт хүчний холбоо зэрэг системд радио давтамжийн харилцан нөлөөлөл үзүүлснээр нийтийн аюулгүй байдалд эрсдэл үүсэж болзошгүй байна.

Иймд хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Радио долгионы тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт”-ыг хэвээр үлдээх, эсхүл “бүх төрлийн радио долгион хүлээн авагч” гэснийг “өрхийн хэрэглээнд зориулсан радио долгион хүлээн авагч” гэж өөрчлөх;

2.Олон улсын сонирхогчдын радиогийн холбоо буюу International Amateur Radio Union нь улс орнууд дотооддоо радио спортыг богино долгионоор холбоо барих болон эсрэг талынхаа холбоог олж илрүүлэх гэсэн хоёр үндсэн төрөлд олон улсын чанартай тэмцээн, уралдаануудыг зохион байгуулдаг бөгөөд олон улсын радио давтамжийн хяналт хуваарилалтын байгууллага “Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ITU)”-аас радио сонирхогчдын ажиллах богино долгионы царануудыг хуваарь тогтоож баталсан.

Радио долгионы тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт заасан сонирхогчийн радио станцын зориулалтаар ашиглах эрхийн бичгийг гурван сарын хугацаагаар олгох зохицуулалтыг хассанаар энэхүү богино хугацаанд зохион байгуулдаг уралдаан, тэмцээнд зориулсан радио давтамжийг энгийн зөвшөөрлөөр буюу 3 жилийн хугацаагаар авах шаардлага үүсэх ба энэ нь үйлчилгээ эрхлэгчээс радио давтамжийн ашиглалтын төлбөрийг ашиглаагүй хугацаанд нь гаргуулах буюу нэмэлт зардал үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд заасан мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт оруулахаар тусгасан өөрчлөлтийг хасах;

3.хуулийн төслийн 4 дүгээр зүйлд “Радио долгионы тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “13.2” гэснийг “13.1” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 8.3-т заасан зөвшөөрөл” гэсэн агуулга бүхий хэсгийг нэмэх;

4.Монгол Улсын олон улсын гэрээ болох Дэлхийн Радио холбооны дүрмийн 1.16, 1.17, 1.18-д зааснаар радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалтын 3 түвшинг хэрэглэдэг бөгөөд 1 дүгээр түвшинд үндэсний хэмжээнд зурвасын хуваарилалт хийх, 2 дугаар түвшинд бүсийн хэмжээнд сувгийн хуваарилалт хийх, 3 дугаар түвшинд тухайн үйлчилгээнд ашиглах радио станцад зориулсан сувгийн оноолт хийх хуваарилалт хамаардаг.

Монгол Улсын хувьд Радио долгионы тухай хуулиар уг хуваарилалтыг хийх эрх бүхий байгууллагыг тодорхойлсон ч үндэсний болон бүсийн, радио станцын түвшний хуваарилалтыг дээрх байдлаар нарийвчлан тодорхойлоогүйгээс “радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх” ойлголтыг Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаас зөрүүтэй хэрэглэх нөхцөл үүсэхээс сэргийлж хуульд “тайлбар” оруулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Иймд Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан “5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2} дахь заалтад “Тайлбар: Энэ зүйлд заасан “хуваарилалт хийх” гэдэгт радио давтамж, радио давтамжийн зурвасыг тухайн үйлчилгээнд ашиглах зурвасын өргөн, тодорхой бүс нутгаар хуваасан хуваарилалтыг ойлгоно” гэсэн тайлбар нэмэх;

2.2.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөл, мэдэгдлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулах агуулгатай тул хуулийн төслийн 3 дугаар зүйлд “10 дугаар зүйлийн нэршлийг “Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, өөрчлөлт оруулах”” гэснийг хасах.

2.3.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлчилгээ эрхлэгч нарт олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа өөр өөр буюу 15-20 хүртэлх жилийн хугацаагаар олгож байсан нь анх олгосон хугацаагаар тусгай зөвшөөрлийг сунгах хуулийн зохицуулалтыг хэрэглэхэд зөрүүтэй байдал үүсгэж байгааг нэг мөр болгох зорилгоор хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “12.5.Зөвшөөрлийн хугацааг сунгахад энэ хуулийн 12.1 дэх хэсэгт заасан хугацааг баримтална” гэж нэмэх;

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3-т “14.21.Нэмүү өртөгт тусгай дугаарлалт” гэснийг “Нэмэлт төлбөртэй үйлчилгээний зориулалт бүхий тусгай дугаарлалт” гэж, 1 дүгээр зүйлийн 7-д “Зохицуулах хорооны даргын тушаалаар” гэснийг “Зохицуулах хорооны хуралдаанаар” гэж, 2 дугаар зүйлийн 1-д заасныг “3.1.5.“үйлчлэгч” гэж энэ хуулийн 3.1.10-д заасан төрлөөр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг,” гэж тус тус өөрчлөх.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Н.УЧРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ТӨРИЙН ОРОЛЦООГ БУУРУУЛАХ, ЗАХ ЗЭЭЛД НЭВТРЭХЭД АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ТУЛГАРДАГ СААД ХОРИГИЙГ БАГАСГАХ ХҮРЭЭНД ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.30-д “Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.” гэж, 3.5.11-д “Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.” гэж, 5.3.11-д “Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 6.2.18-д “Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөц ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны цахим зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2-ын “БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН” зорилтын 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, 3.2.2.4-т “Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ.” гэж, 4.2.2-ын “ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ” зорилтын 4.2.2.5-д “Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, зөвшөөрлийн тогтолцоог шинэчилж, бүрэн цахимжуулан төрийн захиргааны үйл ажиллагааг идэвхжүүлэх, төрийн албан хаагчдыг тогтмол чадавхжуулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолоор Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн зөвшөөрөлгүй эрхлэх үйл ажиллагааг бүртгэл, эрх олголт, дүгнэлт зэрэг баримт бичгээр зөвшөөрөлжүүлсэн, эсхүл нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад бүртгэлгүй захиргааны актаар зөвшөөрөл олгож буй асуудлын хуулийн хариуцлагыг

чангатгах, хуулийн нэр томъёо, эрх зүйн зохицуулалтыг оновчтой тодорхойлох, Зөвшөөрлийн тухай хууль, салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, уялдааг хангах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг боловсруулахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.” гэж заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөлтэй холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангаар тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлох, нэр томъёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн тусгай зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгаж оруулах, тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах дүгнэлт, зөвлөмж гарсан.

1.2. Практик шаардлага

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах зорилгоор Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан 1000 гаруй төрлийн тусгай зөвшөөрлийн тоог 14 чиглэлийн салбарт **251** “тусгай зөвшөөрөл”, **130** “энгийн зөвшөөрөл”, нийт **381** төрлийн зөвшөөрөл болгон бууруулж хуульчилсан.

Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 16 зөвшөөрлөөр буюу боловсролын салбарт 4, байгаль орчны салбарт 3, банк, санхүүгийн салбарт 2, хүнс, хөдөө аж ахуйн салбарт 2, батлан хамгаалах салбарт 2, хууль зүйн салбарт 1, аймаг, нийслэлийн засаг даргаас олгох 2 зөвшөөрөл тус тус нэмэгдсэн байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлох, зөвшөөрөл шинээр бий болгох, олгох үйл ажиллагаанд холбогдох санал, зөвлөмж гаргуулах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл Ерөнхий сайдын дэргэд ажилладаг бөгөөд уг зөвлөлөөс зөвшөөрөл олгох зарим эрх бүхий байгууллагууд энэ процессыг алгасаж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөрчлийг гаргаж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд дурдсанаар Зөвшөөрлийн тухай хуулиар салбар бүрийн зөвшөөрөл олголтын процессийг нарийвчлан зохицуулах боломжгүй бөгөөд салбарын хуулиар энэ төрлийн харилцааг хуульчилж өгөөгүй тохиолдолд эрх бүхий этгээдийн баталсан захиргааны хэм хэмжээний актаар зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулж байгаа нь тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасан “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасантай зөрчилдөж байна.

Уг тайланд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцаа хуульчлагдсан болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байгаа байдлыг судалж үзэхэд, нийт **251** тусгай зөвшөөрлөөс **89** тусгай зөвшөөрөлд хамаарах харилцаа нь эрх бүхий байгууллагаас батлагдсан захиргааны хэм хэмжээний акт, журмаар, **33** зөвшөөрөлд хамаарах харилцаа нь хууль болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар давхардсан байдлаар зохицуулагдаж байгааг дурджээ. Өөрөөр хэлбэл нийт **251** төрлийн тусгай зөвшөөрлийн **122** зөвшөөрөлд хамаарах харилцааг захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байна гэсэн судалгааны дүн гарсаны дагуу Зөвшөөрлийн зөвлөлөөс Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тус хуулийн зохицуулалтад салбарын хууль тогтоомж, журмуудыг нийцүүлэх чиглэлээр холбогдох дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудад хүргүүлсний дагуу эрх бүхий байгууллагуудаас нийт 60 гаруй захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, зарим зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хэрэгжүүлсэн.

Харин салбаруудад дагаж мөрдөж байгаа зарим захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгоход хүндрэлтэй буюу холбогдох хуульд тухайн төрлийн харилцааг зохицуулсан зохицуулалт байхгүйн улмаас практикт хийдэл үүсэж болзошгүй тул холбогдох зохицуулалтыг хуульд тусгасны үндсэн дээр захиргааны хэм хэмжээний актуудыг хүчингүй болгох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Түүнчлэн зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлөөс судалж үзэхэд Монгол Улсын хуулиудад бүртгэл 264, дүгнэлт 232, гэрчилгээ 132, магадлан итгэмжлэл 30, сертификат 9 байна гэсэн үр дүн гарчээ. Салбарын хуулиуд болон эрх бүхий байгууллагаас захиргааны хэм хэмжээний акт батлах замаар зөвшөөрлийн шинжтэй бүртгэл, гэрчилгээ, эрх олголтыг бий болгож, зөвшөөрөл олгох процесстой адилхан процессыг бүрдүүлж байгаа нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.” гэж заасантай зөрчил үүсгэж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд салбарууд дахь зөвшөөрлийг цахимжуулах процесс хангалтгүй байгаа бөгөөд судалгаанаас үзэхэд зөвшөөрлийн цахимжилт Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан нийт **251** тусгай зөвшөөрлөөс **178** төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжтой, харин үлдсэн **73** тусгай зөвшөөрлийг уламжлалт аргаар буюу биеэр ирж очин, цаасаар харилцах байдлаар олгож байна гэсэн үр дүн гарсан.

Өөрөөр хэлбэл, цахимжилт хангалтгүй байгаа шалтгааныг Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс хуулиар, захиргааны хэм хэмжээний акт, журмаар дахин дахин шаарддаг, салбарын хуулиуд дээрх зохицуулалтууд нь цахимжилтыг хязгаарладаг, мөн зөвшөөрлийг хэрхэн, яаж олгох, ямар баримт бичиг бүрдүүлэх нь тодорхойгүй байгаагаас зөвшөөрөл олгох явцад дураар баримт бичиг шаардах, өөрийн үзэмжээр асуудлыг шийдвэрлэх, цахимаар мэдүүлэх системийг бүрдүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа талаар дурджээ.

Зөвшөөрөл олголтын процессыг хөнгөвчлөх хүрээнд олон улсын байгууллагаас хийсэн судалгааны тайлан, гадаадын зарим улсын зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж үзэхэд тусгай болон энгийн

зөвшөөрлөөс гадна зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад мэдэгдэл хүргүүлэх замаар тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зохицуулалт үйлчилж байна.

Тухайлбал, Бүгд Найрамдах Казахстан Улсын Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд нэг удаагийн шинжтэй, эхлэх, дуусах хугацаатай, ахуйн хэрэгцээнд зориулан хийх эрсдэлийн түвшин багатай зөвшөөрлийн шинжтэй үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх нийтлэг харилцааг тусгасан байна. Тус хуульд “Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа” гэж төрийн байгууллагаас баталсан мэдэгдлийн хуудасны дагуу тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх”-ийг хэлэх ба тухайн байгууллагын цахим мэдээллийн санд мэдэгдэх хуудсыг байршуулж, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд магадлан шалгах ажиллагааг зохион байгуулах, эрсдэлийн үнэлгээ хийдэг байхаар хуульчилжээ. Иргэн, хуулийн этгээд мэдэгдлийн хуудсанд заасан хугацаанд үйл ажиллагаагаа эхлүүлж, дуусгавар болгох ба уг үйл ажиллагаатай холбоотой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээдэг байна.

Иймд олон улсад хэрэглэгдэж байгаа мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг бий болгож зарим төрлийн тусгай болон энгийн зөвшөөрлийг мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр эрхлэх, тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлох, нэр томъёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгаж оруулах, зөвшөөрөл эзэмшигчид тавих явцын хяналтыг сайжруулах замаар Зөвшөөрлийн тухай хуульд нийцээгүй захиргааны хэм хэмжээний акт, журмаар зөвшөөрлийн харилцааг зохицуулж, зөвшөөрөл олголтын процессийг хүндрүүлж байгаа нөхцөлийг арилгах, цахимжилтыг сайжруулах, хуульд заасан хугацаанд түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй зөвшөөрөл авах нөхцөлийг бүрдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайланд үндэслэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж дараах харилцааг тусгана:

-Зөвшөөрлийн эрсдэлийн түвшингөөс хамааруулан бага эрсдэлтэй үйл ажиллагаа, эсхүл нэг удаагийн шинжтэй, тодорхой хугацаанд эрхлэх, ахуйн хэрэгцээний зориулалтаар эрхлэх үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх;

-Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны жагсаалтыг тодорхой болгох;

-Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны хугацаа гурван жилээс дээшгүй байх;

-Мэдэгдэл хүлээн авах төрийн байгууллагын бүрэн эрх, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага;

-Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны журам, хяналт тавих зохицуулалт;

-Мэдэгдлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглох зохицуулалт;

-Зөвшөөрлийн онцлогтой уялдуулан салбарын хуулиуд дахь зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгоход иргэн, хуулийн этгээдээс шаардах баримт бичиг, процессын журмыг тодорхой болгох;

-Зөвшөөрлийн тухай хуульд нийцээгүй салбарын хуулиудад тусгасан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой эрх олгосон зохицуулалтыг хүчингүй болгох;

-Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх зохицуулалт;

-Практик шаардлагад тулгуурлан зарим төрлийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг өөрчлөх;

- Явцын хяналтаар зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа доголдолгүй тохиолдолд шууд сунгадаг байх;

-Зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг цэгцлэх, багасгах, эрх зүйн зохицуулалтыг ойлгомжтой болгох.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар бий болно:

-Бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, зөвшөөрөлтэй холбоотой авлига, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг багасгана;

-Иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог бууруулж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, өрсөлдөөнт, чөлөөт зах зээлийн эдийн засгийг бүрдүүлж, аж ахуй эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах суурь зарчим, зохицуулалтыг бий болгоно;

-Зах зээлийн өрсөлдөөн, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ;

-Зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой шаардах баримт бичгийн тоо, шат дамжлагыг багасгана;

-Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулан зөвшөөрлийн процессыг хялбаршуулж, цаг хугацаа, зардлыг хэмнэж, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай хүргэнэ;

-Ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэнэ;

-Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал амьтны тэжээлийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Оюуны өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлын үр, сортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын мэргэшсэн зөвлөх

үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд асрах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, зэрэг хуулийн төсүүдийг хамтад нь боловсруулна.

---o0o---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.30-д “Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.” гэж, 3.5.11-д “Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.” гэж, 5.3.11-д “Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 6.2.18-д “Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөц ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны цахим зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2-т заасан “БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН” зорилтын 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, 3.2.2.4-т “Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ.” гэж, 4.2.2-т заасан “ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ” зорилтын 4.2.2.5-д “Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, зөвшөөрлийн тогтолцоог шинэчилж, бүрэн цахимжуулан төрийн захиргааны үйл ажиллагааг идэвхжүүлэх, төрийн албан хаагчдыг тогтмол чадавхжуулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолоор Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн зөвшөөрөлгүй эрхлэх үйл ажиллагааг бүртгэл, эрх олголт, дүгнэлт зэрэг баримт бичгээр зөвшөөрөлжүүлсэн, эсхүл нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад бүртгэлгүй захиргааны актаар зөвшөөрөл олгож буй асуудлын хуулийн хариуцлагыг чангатгах, хуулийн нэр томьёо, эрх зүйн зохицуулалтыг оновчтой тодорхойлох, Зөвшөөрлийн тухай хууль, салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, уялдааг хангах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг боловсруулахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт

оруулах хуулийн төсөл боловсруулна.” гэж заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөлтэй холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангаар тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлох, нэр томъёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн тусгай зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгаж оруулах, тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах дүгнэлт, зөвлөмж гарсан.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтооходой холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах зорилгоор Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан 1000 гаруй төрлийн тусгай зөвшөөрлийн тоог 14 чиглэлийн салбарт **251** “тусгай зөвшөөрөл”, **130** “энгийн зөвшөөрөл”, нийт **381** төрлийн зөвшөөрөл болгон бууруулж хуульчилсан.

Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 16 зөвшөөрлөөр буюу боловсролын салбарт 4, байгаль орчны салбарт 3, банк, санхүүгийн салбарт 2, хүнс, хөдөө аж ахуйн салбарт 2, батлан хамгаалах салбарт 2, хууль зүйн салбарт 1, аймаг, нийслэлийн засаг даргаас олгох 2 зөвшөөрөл тус тус нэмэгдсэн байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлох, зөвшөөрөл шинээр бий болгох, олгох үйл ажиллагаанд холбогдох санал, зөвлөмж гаргуулах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл Ерөнхий сайдын дэргэд ажилладаг бөгөөд уг зөвлөлөөс зөвшөөрөл олгох зарим эрх бүхий байгууллагууд энэ процессыг алгасаж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөрчлүүд гаргаж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд дурдсанаар Зөвшөөрлийн тухай хуулиар салбар бүрийн зөвшөөрөл олголтын процессийг нарийвчлан зохицуулах боломжгүй бөгөөд салбарын хуулиар энэ төрлийн харилцааг хуульчилж өгөөгүй тохиолдолд эрх бүхий этгээдийн баталсан захиргааны хэм хэмжээний актаар зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулж байгаа нь тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасан “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасантай зөрчилдөж байна.

Уг тайланд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцаа хуульчлагдсан болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байгаа байдлыг судалж үзэхэд, нийт **251** тусгай зөвшөөрлөөс **89** тусгай зөвшөөрөлд хамаарах харилцаа нь эрх бүхий байгууллагаас батлагдсан захиргааны хэм хэмжээний акт, журмаар, **33** зөвшөөрөлд хамаарах харилцаа нь хууль болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар давхардсан байдлаар зохицуулагдаж байгааг дурджээ. Өөрөөр хэлбэл нийт **251** төрлийн тусгай зөвшөөрлийн **122** зөвшөөрөлд хамаарах харилцааг захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байна гэсэн судалгааны дүн

гарсаны дагуу Зөвшөөрлийн зөвлөлөөс Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тус хуулийн зохицуулалтад салбарын хууль тогтоомж, журмуудыг нийцүүлэх чиглэлээр холбогдох дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудад хүргүүлсний дагуу эрх бүхий байгууллагуудаас нийт 60 гаруй захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, зарим зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хэрэгжүүлсэн.

Харин салбаруудад дагаж мөрдөж байгаа зарим захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгоход хүндрэлтэй буюу холбогдох хуульд тухайн төрлийн харилцааг зохицуулсан зохицуулалт байхгүйн улмаас практикт хийдэл үүсэж болзошгүй тул холбогдох зохицуулалтыг хуульд тусгасны үндсэн дээр захиргааны хэм хэмжээний актуудыг хүчингүй болгох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Түүнчлэн зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлөөс судалж үзэхэд Монгол Улсын хуулиудад бүртгэл 264, дүгнэлт 232, гэрчилгээ 132, магадлан итгэмжлэл 30, сертификат 9 байна гэсэн үр дүн гарчээ. Салбарын хуулиуд болон эрх бүхий байгууллагаас захиргааны хэм хэмжээний акт батлах замаар зөвшөөрлийн шинжтэй бүртгэл, гэрчилгээ, эрх олголтыг бий болгож, зөвшөөрөл олгох процесстой адилхан процессыг бүрдүүлж байгаа нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.” гэж заасантай зөрчил үүсгэж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд салбарууд дахь зөвшөөрлийг цахимжуулах процесс хангалтгүй байгаа бөгөөд судалгаанаас үзэхэд зөвшөөрлийн цахимжилт Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан нийт **251** тусгай зөвшөөрлөөс **178** төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжтой, харин үлдсэн **73** тусгай зөвшөөрлийг уламжлалт аргаар буюу биеэр ирж очин, цаасаар харилцах байдлаар олгож байна гэсэн үр дүн гарсан.

Өөрөөр хэлбэл, цахимжилт хангалтгүй байгаа шалтгааныг Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс хуулиар, захиргааны хэм хэмжээний акт, журмаар дахин дахин шаарддаг, салбарын хуулиуд дээрх зохицуулалтууд нь цахимжилтыг хязгаарладаг, мөн зөвшөөрлийг хэрхэн, яаж олгох, ямар баримт бичиг бүрдүүлэх нь тодорхойгүй байгаагаас зөвшөөрөл олгох явцад дураар баримт бичиг шаардах, өөрийн үзэмжээр асуудлыг шийдвэрлэх, цахимаар мэдүүлэх системийг бүрдүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа талаар дурджээ.

Зөвшөөрөл олголтын процессыг хөнгөвчлөх хүрээнд олон улсын байгууллагаас хийсэн судалгааны тайлан, гадаадын зарим улсын зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж үзэхэд тусгай болон энгийн зөвшөөрлөөс гадна зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад мэдэгдэл хүргүүлэх замаар тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зохицуулалт үйлчилж байна.

Тухайлбал, Бүгд Найрамдах Казахстан Улсын Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд нэг удаагийн шинжтэй, эхлэх, дуусах хугацаатай, ахуйн хэрэгцээнд зориулан хийх эрсдэлийн түвшин багатай зөвшөөрлийн шинжтэй үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх нийтлэг харилцааг тусгасан байна. Тус хуульд “Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа” гэж төрийн байгууллагаас баталсан мэдэгдлийн хуудасны дагуу тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх”-ийг хэлэх ба тухайн байгууллагын цахим мэдээллийн санд мэдэгдэх хуудсыг байршуулж, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд магадлан шалгах ажиллагааг зохион байгуулах, эрсдэлийн үнэлгээ хийдэг байхаар хуульчилжээ. Иргэн, хуулийн этгээд мэдэгдлийн хуудсанд заасан хугацаанд үйл ажиллагаагаа эхлүүлж, дуусгавар болгох ба уг үйл ажиллагаатай холбоотой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээдэг байна.

Иймд олон улсад хэрэглэгдэж байгаа мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг бий болгож зарим төрлийн тусгай болон энгийн зөвшөөрлийг мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр эрхлэх, тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлох, нэр томъёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгаж оруулах, зөвшөөрөл эзэмшигчид тавих явцын хяналтыг сайжруулах замаар Зөвшөөрлийн тухай хуульд нийцээгүй захиргааны хэм хэмжээний акт, журмаар зөвшөөрлийн харилцааг зохицуулж, зөвшөөрөл олголтын процессыг хүндрүүлж байгаа нөхцөлийг арилгах, цахимжилтыг сайжруулах, хуульд заасан хугацаанд түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй зөвшөөрөл авах нөхцөлийг бүрдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайланд үндэслэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж дараах харилцааг тусгасан болно:

-Зөвшөөрлийн эрсдэлийн түвшингөөс хамааруулан бага эрсдэлтэй үйл ажиллагаа, эсхүл нэг удаагийн шинжтэй, тодорхой хугацаанд эрхлэх, ахуйн хэрэгцээний зориулалтаар эрхлэх үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх;

-Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны жагсаалтыг тодорхой болгох;

-Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны хугацааг гурван жилээс дээшгүй байх;

-Мэдэгдэл хүлээн авах төрийн байгууллагын бүрэн эрх, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага;

-Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны журам, хяналт тавих зохицуулалт;

-Мэдэгдлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглох зохицуулалт;

-Зөвшөөрлийн онцлогтой уялдуулан салбарын хуулиуд дахь зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгоход иргэн, хуулийн этгээдээс шаардах баримт бичиг, процессын журмыг тодорхой болгох;

-Зөвшөөрлийн тухай хуульд нийцээгүй салбарын хуулиудад тусгасан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой эрх олгосон зохицуулалтыг хүчингүй болгох;

-Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх зохицуулалт;

-Практик шаардлагад тулгуурлан зарим төрлийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг өөрчлөх;

-Явцын хяналтаар зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа доголдолгүй тохиолдолд шууд сунгадаг байх.

-Зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг цэгцлэх, багасгах, эрх зүйн зохицуулалтыг ойлгомжтой болгох зэрэг болно.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон түүнийг дагалдуулан холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу "D-Parliament.mn" цахим хуудсанд байршуулсан боловч иргэд, олон нийтээс санал ирүүлээгүй болно.

---o0o---

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.30-д “Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.” гэж, 3.5.11-д “Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.” гэж, 5.3.11-д “Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 6.2.18-д “Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөц ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны цахим зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2-т заасан “БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН” зорилтын 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хorigийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, 3.2.2.4-т “Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ.” гэж, 4.2.2-т заасан “ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ” зорилтын 4.2.2.5-д “Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, зөвшөөрлийн тогтолцоог шинэчилж, бүрэн цахимжуулан төрийн захиргааны үйл ажиллагааг идэвхжүүлэх, төрийн албан хаагчдыг тогтмол чадавхжуулна.” гэж тус тус заасан.

Дэлхийн өв уламжлалын сангаас “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ийг засаглалын үр ашиг, Засгийн газрын оролцоо, зохицуулалтын үр ашигтай байдал, нээлттэй зах зээл гэсэн нийт 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлт ашиглан тооцдог бөгөөд Монгол Улс 2024 онд нийт дүнгээрээ 176 улсаас 60.6 оноотойгоор 76 дугаар байранд эрэмбэлэгдсэн ба V децилд байна.

Бүлэг	Шалгуур үзүүлэлт/дэд хүчин зүйлс	Оноо	Онооны ангилал	Байр
Засаглалын үр ашиг	Өмчийн эрх	48.8	муу	92/176
	Шүүхийн үр ашиг	34.8	бага	71/176
	Төрийн зарчимт байдал	55.0	муу	117/176
Засгийн газрын хэмжээ	Татварын дарамт	84.0	бүрэн	59/176
	Засгийн газрын зарлага	62.0	дунд	113/176
	Төсвийн сахилга бат	64.3	дунд	83/176
Зохицуулалтын үр ашигтай байдал	Бизнесийн эрх чөлөө	68.0	дунд	79/176
	Хөдөлмөрлөх эрх чөлөө	67.5	дунд	24/176
	Мөнгөний эрх чөлөө	67.9	дунд	117/176
Нээлттэй зах зээл	Худалдааны эрх чөлөө	74.4	сайн	72/176

Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал	50	бага	119/176
Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал	50	бага	96/176

Дээрх индексийн дэд хүчин зүйлсийг шалгуур үзүүлэлт болгон үнэлэхдээ дараах агуулгын хүрээнд хянадаг байна. Үүнд:

1.Өмчийн эрх - Хувь хүмүүс өмч эзэмших эрх чөлөө, эрсдэл, оюуны өмчийн хамгаалалт, газар эзэмших эрсдэл

2.Шүүхийн үр ашиг - Иргэдийг хэр сайн хамгаалагдаж байгааг харуулна.

3.Төрийн ёс зүй – Төрийн албаны авлига авах байдлыг үнэлдэг.

4.Татварын дарамт- Хувь хүмүүс болон аж ахуйн нэгжүүдэд татвар хэр их дарамт учруулж байгааг харуулна.

5.Засгийн газрын зарлага – Төсвийн алдагдал, хэт их зардал нь төсөвт хэр их дарамт учруулж байгааг харуулна.

6.Төсвийн сахилга бат – Засгийн газрын буруу менежментийг харуулна.

7.Бизнесийн эрх чөлөө – Бизнесийн үр ашигтай үйл ажиллагааг хэр зэрэг хязгаарлаж байгааг харуулна.

8.Хөдөлмөр эрхлэх эрх чөлөөт байдал – Хөдөлмөр эрхлэх боломжийн эрх чөлөөг харуулна.

9.Мөнгөний бодлогын чөлөөт байдал – Мөнгөний бодлогын үр дүнтэй байдал болон дотоодын инфляцын байдлыг дүгнэн үнэлдэг.

10.Чөлөөт худалдаа - Экспорт, импортод нөлөөлж буй тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг харуулна.

11.Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал – Хөрөнгө оруулалтын эрсдэл, хөрөнгө оруулалтын урсгалд хэр их хязгаарлалт байгааг харуулна.

12.Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал - Банкны үйл ажиллагааны үр ашгийг харуулна.

Шалгуур үзүүлэлтүүдийн онооны ангиллаар өмчийн эрх 92/176 муу, төрийн зарчимт байдал 117/176 муу, бизнесийн эрх чөлөө 79/176 дунд, хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал 119/176 бага гэж үнэлэгдсэн байна. Эндээс харахад иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, авлигаас авах эрсдэлийг бууруулах, бизнесийн үр ашигтай үйл ажиллагааны хязгаарлалтыг арилгах, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолоор Зөвшөөрлийн

тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн зөвшөөрөлгүй эрхлэх үйл ажиллагааг бүртгэл, эрх олголт, дүгнэлт зэрэг баримт бичгээр зөвшөөрөлжүүлсэн, эсхүл нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад бүртгэлгүй захиргааны актаар зөвшөөрөл олгож буй асуудлын хуулийн хариуцлагыг чангатгах, хуулийн нэр томьёо, эрх зүйн зохицуулалтыг оновчтой тодорхойлох, Зөвшөөрлийн тухай хууль, салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, уялдааг хангах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг боловсруулахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт “Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.” гэж заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрөлтэй холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангаар тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлох, нэр томьёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн тусгай зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгаж оруулах, тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах дүгнэлт, зөвлөмжийг салбар тус бүрээр нэг бүрчлэн тусгасан байна:

Зөвшөөрлийн тухай хуульд заасан 14 салбарт олгож буй тусгай зөвшөөрлүүдэд хийсэн нийтлэг дүгнэлт, зөвлөмж		
1	Байгаль орчны чиглэл	<p>Байгаль орчны чиглэлийн нийт 31 төрлийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд зааж өгсөн. Тэдгээрийг нэг бүрчлэн шалгахад, 12 тусгай зөвшөөрлийг нарийвчилсан хуулиар, 3 зөвшөөрлийг хууль болон журмаар, 10 зөвшөөрлийг журмаар, харин 6 төрлийн зөвшөөрлийн процессын зохицуулалт нь тодорхойгүй (бүрдүүлэх бичиг баримт, олгох процесс) байдалтай байна. Мөн 31 зөвшөөрлөөс 18 төрлийн тусгай зөвшөөрлийг л цахимаар авах боломжтой байна:</p> <p>Байгаль орчны чиглэлийн тусгай зөвшөөрлүүдийг бусад тусгай зөвшөөрлүүдтэй харьцуулахад салбар бүрийг хамарсан процессын зохицуулалт байхгүйн улмаас энэ чиглэлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын ажиллагаанд тодорхойгүй бөгөөд хүндрэлтэй асуудлууд бий болж байна. Өөрөөр хэлбэл байгаль орчны чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой хуулийн зохицуулалт дутмаг байгаа тул эрх бүхий захиргааны байгууллагаас тодорхойгүй нөхцөл байдлыг тодорхой болгохын тулд журмын дагуу зохицуулахаас өөр аргагүй байна. Тодруулбал, “ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах” тусгай зөвшөөрлийн хувьд процессын ажиллагааг зохицуулах журам</p>

		<p>батлагдсан эсэх нь тодорхойгүй байх боловч практикт цахим хэлбэрээр тусгай зөвшөөрөл олгогдож буй нөхцөл байдалтай байна. Үүнээс үзэхэд дээрх тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцааг зохицуулах журам батлах зайлшгүй шаардлагатай байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангилал тус бүрийн процесс, журмыг салбарын нарийвчилсан хуульд хуульчлах; ❖ Процесс нь тодорхойгүй тусгай зөвшөөрлүүдийг процессжуулах, журамлах, хуульд тусгаж өгөх; <p>Тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах.</p>
2	<p>Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэл</p>	<p>Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлийн тусгай зөвшөөрлүүдийн ихэнх зөвшөөрөл олгох процесс, шаардлага зэрэг нь хууль болон холбогдох салбарын нарийвчилсан хууль тогтоомж болон журмаар давхар зохицуулагдаж байна. Тодруулбал, нийт 38 тусгай зөвшөөрлийн 21 төрлийн тусгай зөвшөөрөл авах процессыг хууль болон журмаар давхар зохицуулж байгаа бол 12 төрлийн тусгай зөвшөөрлийг зөвхөн журмаар, 5 тусгай зөвшөөрлийг огт хуулиар зохицуулаагүй байна.</p> <p>Эдийн засгийн тогтвортой байдалтай холбоотой чухал салбар учраас мөнгө угаахтай тэмцэх зэрэг олон төрлийн хяналт, шалгалтын хүрээнд бусад салбартай харьцуулахад журмаар харьцангуй нарийн зохицуулалтуудыг хийсэн салбар билээ.</p> <p>Цахимжуулалтын хувьд Төв банкнаас олгож буй зөвшөөрлүүд нь цахимаар шийдвэрлэх боломжгүй гэх хариуг өгсөн. Харин Санхүүгийн зохицуулах хорооноос Банк бус санхүүгийн үйлчилгээний чиглэлтэй холбоотой тусгай зөвшөөрлүүдийн хүсэлтийг цахим систем буй 2 цонхоор дамжуулан авч байна. Тодруулбал ББСБ байгуулах зөвшөөрлийг нэг цонхоор, түүнээс бусад бүх зөвшөөрлийг нэг цонхоор хүлээн авч байна. Гэвч тус байгууллагаас олгож байгаа тусгай зөвшөөрлүүд нь бүгд хоорондоо ялгаатай байхад ББСБ байгуулах болон бусад гэж ангилж хүсэлтийг хүлээн авч байгаа нь хэт ерөнхийлсөн шинжтэй байна. Жишээ нь: банк бус санхүүгийн байгууллагын нэмэлт тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөл гаргах хэсэг байх боловч аль тусгай зөвшөөрлийг нэмэлтээр гэж үзэж ямар журам, зүйл заалтад үндэслэн олгож байгаа нь тодорхой бус байна.</p>

		<p>Цахимжилтын хувьд, 38 тусгай зөвшөөрлөөс 24 тусгай зөвшөөрлийг авах үйлчилгээг цахимаар авах боломжтой буюу хангалттай биш гэж дүгнэхээр байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж салгаж хуульчлах; ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангилал тус бүрийн процесс, журмыг салбарын нарийвчилсан хуульд хуульчлах; <p>Тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах.</p>
3	Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэл	<p>Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлийн нийт 22 зөвшөөрлийг хуульд заасан ба тухайн зөвшөөрөл нэг бүрийг олгох процесс нь бүгд журмаар зохицуулагдаж байна. Нийт 22 зөвшөөрлөөс 21 зөвшөөрлийг цахимаар мэдүүлж байна.</p> <p>Энэ салбарын 22 тусгай зөвшөөрөл олгох процессыг бүгдийг журмаар зохицуулж байгаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5.17 заасан хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулахгүй гэж заасантай зөрчилдөж байх бөгөөд салбарын хуулиудад нь хуульчилж өгөх шаардлагатай.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангилал тус бүрийн процесс, журмыг салбарын нарийвчилсан хуульд хуульчлах; ❖ Тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах.
4	Зам, тээврийн чиглэл	<p>Зөвшөөрлийн тухай хуулиар Зам, тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад 12 төрлийн тусгай зөвшөөрлийг хуульчилж өгчээ. Гэхдээ эдгээр тусгай зөвшөөрөл нь дотроо задарч өөр олон тусгай зөвшөөрөл болж байна. Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.5.2-т “Авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэсэн нэг заалт нь дотроо 15 төрлийн тусгай зөвшөөрөл болон задарч байна.</p> <p>Энэ салбарын 12 тусгай зөвшөөрлийн бүрдүүлэх бичиг баримт, шаардлага, тусгай зөвшөөрөл олгох процессыг журмаар зохицуулж байна. Мөн эдгээр төрлийн тусгай зөвшөөрлийн 11-г уламжлалт байдлаар цаасаар бүрдүүлж байгаа бол 1 тусгай зөвшөөрөл нь цахим хэлбэрт шилжсэн байна. Түүнчлэн, Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын хуулиар томъёологдсон</p>

		<p>зөвшөөрлийн нэр томьёо зөрөх тохиолдол мөн байна. Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.5.4 болон Төмөр замын тээврийн тухай хуулийн 14.1.3 байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж салгаж хуульчлах; ❖ Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын журмыг салбарын хуулиудад нь тусгаж оруулах; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах; ❖ Нэр томьёог жигдлэх.
6	Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэл	<p>Энэ төрлийн үйл ажиллагааг эрхлэхэд нийт 12 тусгай зөвшөөрлийг хуульд жагсааж өгчээ. Үүнээс тусгай зөвшөөрлийн процессыг салбарын хуулиараа зохицуулж өгсөн 3, журмаар зохицуулж байгаа 8, хууль болон журмаар зохицуулаагүй 1 тусгай зөвшөөрөл байна. Нийт 10 тусгай зөвшөөрөл цахимжсан бол 2 тусгай зөвшөөрөл цахимжаагүй байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.6.5-т “эд мөнгөний хожворт сугалаа гаргах” гэсэн тусгай зөвшөөрөл байх бөгөөд мөн зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.11.4-т “төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх” гэсэн тусгай зөвшөөрөл байх бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлийн давхардал хийдлийг арилгах, хэрэгцээ шаардлагыг дахин доторхойлох хэрэгтэй байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.6.5 болон 8.1.11.4-ийн давхардлыг арилгах, хэрэгцээ шаардлагад үнэлгээ хийх; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах.
7	Соёл, боловсролын чиглэл	<p>Соёл, боловсролын чиглэлийн нийт 12 тусгай зөвшөөрлийг хуульд жагсааж өгсөн байна. Үүнээс тусгай зөвшөөрлийн процессыг хуулиар зохицуулж өгсөн 7, журмаар зохицуулсан 3, хууль болон журмаар тусгай зөвшөөрөл олгох процессыг зохицуулж өгөөгүй 2 (Зөвшөөрлийн тухай хуулийн 7.7, 7.9) тусгай зөвшөөрөл байна. Нийт 9 тусгай зөвшөөрөл цахимжсан бол 3 тусгай зөвшөөрөл цахимжаагүй байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын журмыг салбарын хуулиудад нь тусгаж оруулах; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах; ❖ 8.1.7.7 болон 8.1.7.9-т заасан тусгай зөвшөөрлийг процессыг хуульд тусгаж өгөх, аль эсвэл энэ төрлийн тусгай

		зөвшөөрөл байх шаардлагатай эсэхэд хяналт шинжилгээ хийх.
8	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэл	<p>Уг чиглэлийн тусгай зөвшөөрлүүдээс одоогийн байдлаар 24 төрлийн тусгай зөвшөөрөл салбарын нарийвчилсан хуулиар зохицуулагдаж байгаа бөгөөд 1 тусгай зөвшөөрөл хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа болно.</p> <p>Харин зарим тусгай зөвшөөрлийн хувьд эрх зүйн орчин огтоос бүрэлдэн тогтоогүй байна. Тухайлбал, 8.1.8.11-д заасан “төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх”, 8.1.8.12-т заасан “үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх” зэрэг тусгай зөвшөөрлүүдийг олгох шаардлага, нөхцөл, цаашлаад цуцлах, сунгах, түдгэлзүүлэх гэх мэт процессыг нь эрх зүйн орчин бүхэлдээ байхгүй байгаа юм. Уг чиглэлийн тусгай зөвшөөрлүүдийн хувьд дээрх 2 тусгай зөвшөөрлөөс гадна 8.1-ийн 8.1, 8.13, 8.28-д заасан тусгай зөвшөөрлүүд ч мөн адил хууль болоод журмаар зохицуулагдаагүй байгаа юм. Харин бусад 25 төрлийн тусгай зөвшөөрлийн хувьд нарийвчилсан хуулиудаар зохицуулагдсан харьцангуй эрх зүйн орчин нь бүрэн тогтсон байгаа юм.</p>
9	Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэл	<p>Уг чиглэлийн 15 тусгай зөвшөөрлүүдийн 12 нь хуулиар зохицуулагдаж, 3 нь хууль болон журмаар давхар байдлаар зохицуулагдаж байна. Харин цахимжилтын хувьд бусад салбартай харьцуулахад харьцангуй цахижилт сайн явагдсан буюу 14 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимаар авах боломжтой байна.</p> <p>Салбарын хуулиудад бүхий л зөвшөөрөл олгох шаардлага, процессын журмыг хуульчлан зохицуулсан байна. Хэдий тийм боловч дээрх салбарын хуулиуд дээр өөр өөр төрлийн тусгай зөвшөөрлүүд дээр нийтлэг нэг баримт бичгүүд шаардаж буй нь ажиглагдаж байна. Үүнийг зөвшөөрөл бүрт нь тусгайлан олон давхар чирэгдэлгүй байдлаар сайжруулах хэрэгтэй.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж салгаж хуульчлах; ❖ Тусгай зөвшөөрлийн зарим төрлүүдийн хууль эрх зүйн орчинг бий болгох, сайжруулах; ❖ Тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах.
10	Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэл	Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Зөвшөөрлийн тухай хуульд 1 тусгай зөвшөөрөл олгохоор

		<p>хуульчилжээ. Гэхдээ, Зөвшөөрлийн тухай хуулийн 10.1-т заасан зөвшөөрөл нь “Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл үү, аль эсвэл “Монгол Улсын иргэнийг дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл эсэх нь хуульд тодорхойгүй тусгагджээ. Өөрөөр хэлбэл Зөвшөөрлийн тухай хуулийн 10.1-т хоёр төрлийн тусгай зөвшөөрлийг хуульчилж өгсөн үү, аль эсвэл нэг л тусгай зөвшөөрөл үү гэдэг нь тодохойгүй байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг цахимаар мэдүүлэх систем хөгжөөгүй байна. Харьцангуй сүүлд батлагдсан хууль болохоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага, зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх процессын журмыг хуульд өөрт нь суулгаж өгсөн байна. Түүнчлэн, хэрэв энэ төрлийн тусгай зөвшөөрлийн “Монгол Улсын Иргэний дадлагажихад зуучлах” үйл ажиллагааг тусдаа тусгай зөвшөөрөл гэж үзвэл, энэ төрлийн тусгай зөвшөөрлийг холбогдох яам бодит байдал дээр олгохгүй байгаа зөрчил байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж, салгаж хуульчлах; <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах; ❖ Дадлагажихад зуучлах тусгай зөвшөөрлийг олгох.
11	Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар	<p>Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар тусгай зөвшөөрөл олгох 13 төрлийн зөвшөөрлийг жагсааж өгчээ. Эдгээрээс зөвшөөрөл олгох процессыг хуулиар зохицуулсан 1, журмаар зохицуулагдсан 12 тусгай зөвшөөрөл байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлөөс 2 зөвшөөрөл нь цахимжиж, 11 зөвшөөрөл цахимжаагүй байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг нэг бүрчлэн шалгаж үзэхэд салбарын тусгайлсан хуульд зөвшөөрөл авахаар хуульчлагдаагүй байхад Зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрлийн төрөл болон хуульчлагдсан байна. Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.11.2 болон Галт зэвсгийн тухай хуулийн 11.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 11.5 болон Галт зэвсгийн тухай хуулийн 16.1 байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж, нэр

		<p>томъёог жигдлэн хуульчлах;</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тухайн тусгай зөвшөөрөл нь байх шаардлагатай эсэхэд хяналт шинжилгээ хийх; ❖ Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын журмыг салбарын хуулиудад нь тусгаж оруулах; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах.
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэл	<p>Энэ төрлийн чиглэлээр олгох нийт 14 төрлийн тусгай зөвшөөрлийг жагсааж өгсөн. Үүнээс тусгай зөвшөөрөл олгох процессыг тус тусын хуульд нь тусгаж процессжуулж өгсөн 12, жармаар зохицуулсан 1, хууль болон журмаар зөвшөөрөл олгох процессыг тодорхойлоогүй 1 тусгай зөвшөөрөл байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлөөс 13 зөвшөөрөл нь цахимжиж, 1 зөвшөөрөл цахимжаагүй байна.</p> <p>Харьцангуй сүүлд батлагдсан хуулиуд нь өөртөө тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох процессын журмыг тусгаж өгсөн нийтлэг дүр зураг ажиглагдаж байна.</p> <p>Зөвлөмж болгох нь: Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах;</p>
13	Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагаа	<p>Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад олгох 17 тусгай зөвшөөрлийг хуульд жагсааж өгсөн байна. Тусгай зөвшөөрлүүдийг нэг бүрчлэн шалгаж үзэхэд тусгай зөвшөөрөл олгох процессыг хуулиар зохицуулсан 3, хууль болон журмаар давхар зохицуулагдсан 5, журмаар зохицуулагдсан 9 тусгай зөвшөөрөл байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлөөс 16 зөвшөөрөл нь цахимжиж, 1 зөвшөөрөл цахимжаагүй байна.</p> <p>Түүнчлэн, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.13.18-т “Эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх” тусгай зөвшөөрлийг бүхэлд нь олгож байх бөгөөд аж ахуйн нэгжүүд энэ тусгай зөвшөөрлөөс зөвхөн эмнэлгийн хэрэгсэл импортлох үйл ажиллагаа явуулж байхад, төрийн байгууллагаас бусад төрлийн үйл ажиллагааг нь явуулахыг шаардах, холбогдох тайлан нэхэх зэргээр хүндрэл учруулдаг байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж салгаж хуульчлах; ❖ Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг

		<p>олгох процессын журмыг салбарын хуулиудад нь тусгаж оруулах;</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах.
14	Эрчим хүчний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагаа	<p>Эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулахад олгох 34 төрлийн тусгай зөвшөөрлийг хуульд заасан байна. Тусгай зөвшөөрлүүдийг нэг бүрчлэн шалгаж үзэхэд тусгай зөвшөөрөл олгох процессыг хуулиар зохицуулсан 34 буюу бүх тусгай зөвшөөрөл хуульд заасан зохицуулалтын дагуу явагдаж байна. Цахимжилтын хувьд license.energy.gov.mn цахим хуудсаар дамжуулан энэ төрлийн бүх тусгай зөвшөөрлийг авах боломжтой байна.</p> <p>Уг салбарын тусгай зөвшөөрлүүдийг бүгдийг нь эрчим хүчний тухай хуулиар зохицуулсан ба олон тооны өөр өөр тусгай зөвшөөрлүүдэд нийтлэг нэг янзын баримт бичиг шаарддаг байдал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл зөвшөөрөл бүрт тавигдах шаардлагыг ялгамжтай тогтоож өгөх байдлаар сайжруулах шаардлагатай байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагыг ялгамжтай тодорхойлох; ❖ Хуульд заасан процессын шаардлагуудыг хянаж, тухай бүрийн онцлогт тааруулж хуульд тусгах.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тэдгээрийн бүртгэл, хяналт, зөвшөөрлийн ангилал, жагсаалтыг тогтоохтой холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах зорилгоор Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан 1000 гаруй төрлийн тусгай зөвшөөрлийн тоог 14 чиглэлийн салбарт **251** “тусгай зөвшөөрөл”, **130** “энгийн зөвшөөрөл”, нийт **381** төрлийн зөвшөөрөл болгон бууруулж хуульчилсан.

Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 16 зөвшөөрлөөр буюу боловсролын салбарт 4, байгаль орчны салбарт 3, банк, санхүүгийн салбарт 2, хүнс, хөдөө аж ахуйн салбарт 2, батлан хамгаалах салбарт 2, хууль зүйн салбарт 1, аймаг, нийслэлийн засаг даргаас олгох 2 зөвшөөрөл тус тус нэмэгдсэн байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлох, зөвшөөрөл шинээр бий болгох, олгох үйл ажиллагаанд холбогдох санал, зөвлөмж гаргуулах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл Ерөнхий сайдын дэргэд

ажилладаг бөгөөд уг зөвлөлөөс зөвшөөрөл олгох зарим эрх бүхий байгууллагууд энэ процессыг алгасаж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөрчлүүд гаргаж байна.

Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцаа хуульчлагдсан болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байгаа байдлыг судалж үзэхэд, нийт **251** тусгай зөвшөөрлөөс **89** тусгай зөвшөөрөлд хамаарах харилцаа нь эрх бүхий байгууллагаас батлагдсан захиргааны хэм хэмжээний акт, журмаар, **33** зөвшөөрөлд хамаарах харилцаа нь хууль болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар давхардсан байдлаар зохицуулагдаж байгааг дурджээ. Өөрөөр хэлбэл нийт **251** төрлийн тусгай зөвшөөрлийн **122** зөвшөөрөлд хамаарах харилцааг захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байна гэсэн судалгааны дүн гарсны дагуу Зөвшөөрлийн зөвлөлөөс Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тус хуулийн зохицуулалтад салбарын хууль тогтоомж, журмуудыг нийцүүлэх чиглэлээр холбогдох дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудад хүргүүлсний дагуу эрх бүхий байгууллагуудаас нийт 60 гаруй захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, зарим зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хэрэгжүүлсэн.

Хууль тогтоомжид зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлөөс судалж үзэхэд Монгол Улсын хуулиудад бүртгэл 264, дүгнэлт 232, гэрчилгээ 132, магадлан итгэмжлэл 30, сертификат 9 байна гэсэн үр дүн гарч, зөвшөөрөл олгох процесстой адилхан процессыг бүрдүүлж байгаа нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.” гэж заасантай зөрчил үүсгэж байна.

Зөвшөөрөл олголтын процессыг хөнгөвчлөх хүрээнд олон улсын байгууллагаас хийсэн судалгааны тайлан, гадаадын зарим улсын зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалж үзэхэд тусгай болон энгийн зөвшөөрлөөс гадна зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад мэдэгдэл хүргүүлэх замаар тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зохицуулалт үйлчилж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Казахстан Улсын Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд нэг удаагийн шинжтэй, эхлэх, дуусах хугацаатай, ахуйн хэрэгцээнд зориулан хийх эрсдэлийн түвшин багатай зөвшөөрлийн шинжтэй үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх нийтлэг харилцааг тусгасан байна. Тус хуульд “Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа” гэж төрийн байгууллагаас баталсан мэдэгдлийн хуудасны дагуу тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх”-ийг хэлэх ба тухайн байгууллагын цахим мэдээллийн санд мэдэгдэх хуудсыг байршуулж, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд магадлан шалгах ажиллагааг зохион байгуулах, эрсдэлийн үнэлгээ хийдэг байхаар хуульчилжээ. Иргэн, хуулийн этгээд мэдэгдлийн хуудсанд заасан хугацаанд үйл ажиллагаагаа эхлүүлж, дуусгавар болгох ба уг үйл ажиллагаатай холбоотой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээдэг байна.

Иймд олон улсад хэрэглэгдэж байгаа мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг бий болгож зарим төрлийн тусгай болон энгийн зөвшөөрлийг мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр эрхлэх, тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлох, нэр томъёог жигдлэн хуульчлах, тодорхой төрлийн зөвшөөрөл олгох процессын журмыг салбарын хуулиудад тусгаж оруулах, зөвшөөрөл эзэмшигчид тавих явцын хяналтыг сайжруулах замаар Зөвшөөрлийн

тухай хуульд нийцээгүй захиргааны хэм хэмжээний акт, журмаар зөвшөөрлийн харилцааг зохицуулж, зөвшөөрөл олголтын процессыг хүндрүүлж байгаа нөхцөлийг арилгах, цахимжилтыг сайжруулах, хуульд заасан хугацаанд түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй зөвшөөрөл авах нөхцөлийг бүрдүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, эдийн засагт нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг шийдвэрлэхийн тулд эдийн засгийг төрөлжүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжсэн таатай орчныг бүрдүүлэх чухал болоод байна. Энэ хүрээнд аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгах, гарааны компаниудын бизнесийг дэмжих, экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр бодлого, зохицуулалтын арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 933 (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2025.09.08-ны өдрийн байдлаар байршсан тоо) хуулиас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх (бизнес, хөрөнгө оруулалт, худалдаа г.м)-тэй шууд болон шууд бус холбоотой харилцааг зохицуулсан ойролцоогоор 360 гаруй хууль үйлчилж байна. Эдгээр хууль нь тухайн салбарын харилцааг нарийвчлан зохицуулсан байх ба ингэхдээ аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарласан, хориглосон, нэмэлт шаардлага тавьсан, зайлшгүй шаардлагатайгаас бусад байдлаар зөвшөөрөл авахыг шаардсан зэрэг зохицуулалтууд нэлээдгүй байна.

Иймд хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, өмчийн халдашгүй байдлыг хангаж, аж ахуйн үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах, гадаад, дотоодын зах зээлд чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог багасгах шаардлагатай байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайланд үндэслэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж дараах харилцааг тусгасан болно:

-Зөвшөөрлийн эрсдэлийн түвшингөөс хамааруулан бага эрсдэлтэй үйл ажиллагаа, эсхүл нэг удаагийн шинжтэй, тодорхой хугацаанд эрхлэх, ахуйн хэрэгцээний зориулалтаар эрхлэх үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх;

-Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны жагсаалтыг тодорхой болгох;

-Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны хугацааг гурван жилээс дээшгүй байх;

-Мэдэгдэл хүлээн авах төрийн байгууллагын бүрэн эрх, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага;

-Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны журам, хяналт тавих зохицуулалт;

-Мэдэгдлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглох зохицуулалт;

-Зөвшөөрлийн онцлогтой уялдуулан салбарын хуулиуд дахь зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгоход иргэн, хуулийн этгээдээс шаардах баримт бичиг, процессын журмыг тодорхой болгох;

-Зөвшөөрлийн тухай хуульд нийцээгүй салбарын хуулиудад тусгасан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой эрх олгосон зохицуулалтыг хүчингүй болгох;

-Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх зохицуулалт;

-Практик шаардлагад тулгуурлан зарим төрлийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг өөрчлөх;

-Явцын хяналтаар зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа доголдолгүй тохиолдолд шууд сунгадаг байх.

-Зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг цэгцлэх, багасгах, эрх зүйн зохицуулалтыг ойлгомжтой болгох зэрэг болно.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар бий болно:

-Бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, зөвшөөрөлтэй холбоотой авлига, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг багасгана;

-Иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог бууруулж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, өрсөлдөөнт, чөлөөт зах зээлийн эдийн засгийг бүрдүүлж, аж ахуй эрхлэгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах суурь зарчим, зохицуулалтыг бий болгоно;

-Зах зээлийн өрсөлдөөн, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ;

-Зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой шаардах баримт бичгийн тоо, шат дамжлагыг багасгана;

-Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулан зөвшөөрлийн процессыг хялбаршуулж, цаг хугацаа, зардлыг хэмнэж, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай хүргэнэ;

-Ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэнэ;

-Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны .. дугаар
сарын .. -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/1.4 дүгээр зүйлийн 1.4, 1.5 дахь заалт:

“1.4. “мэдэгдэл” гэж энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг;

1.5. “мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг эрхлэх этгээдийг.”

2/2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5. Энэ хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4-т заасан мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны хугацаа гурван жилээс дээшгүй байна.”

3/2.4 дүгээр зүйл:

“2.4 дүгээр зүйл. Зөвшөөрөл, мэдэгдлийн баримт бичиг

1. Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгосныг тодорхойлох зөвшөөрлийн баримт бичиг буюу гэрчилгээ, түүнтэй адилтгах эрхийн бичгийг цахим хэлбэрээр олгоно.

2. Зөвшөөрлийн баримт бичиг нь зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаанд зөвшөөрөл олгосон шийдвэр, зөвшөөрлийн лавлагааны нэгэн адил эрх зүйн хүчинтэй байна.

3. Зөвшөөрлийн баримт бичгийг гээх, үрэгдүүлэх, гэмтээх, хүлээж аваагүй байх нь зөвшөөрлийг хүчингүй гэж үзэх үндэслэл болохгүй.

4. Мэдэгдлээр үйл ажиллагаа эрхэлж байгааг тодорхойлох мэдэгдлийн баримт бичиг нь Зөвшөөрөл, мэдэгдлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн лавлагаа байна.”

4/3.2 дугаар зүйлийн 1.4 дэх заалт:

“1.4. энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг мэдэгдэлгүй эрхэлсэн, эсхүл хуульд заасан зөрчил илэрсэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох.”

5/3.2 дугаар зүйлийн 2.10 дахь заалт:

“2.10.зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон болон мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 1 өдрийн дотор энэ тухай хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон холбогдох бусад эрх бүхий байгууллагад мэдэгдэх;”

6/4.2 дугаар зүйлийн 2.9 дэх заалт:

“2.9.зөвшөөрөл эзэмшигч, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр, хаяг, байршил болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан холбогдох бусад мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд эрх бүхий этгээдэд ажлын 5 өдрийн дотор мэдэгдэх.”

7/4.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаа эрхлэх хугацаанд мэдэгдлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.”

8/5.5 дугаар зүйлийн 21, 22 дахь хэсэг:

“21.Зөвшөөрлийг сунгуулах хүсэлт гаргасан этгээд нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1 жилээс доошгүй хугацаанд зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй болох нь хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд зөвшөөрлийг энэ зүйлд заасан магадлан шалгах ажиллагаа хийхгүйгээр сунгана.

22.Эрх бүхий этгээд энэ хуулийн 5.5 дугаар зүйлийн 21 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор сунгана.

9/5.7 дугаар зүйл:

“5.7 дугаар зүйл.Мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх журам

“1.Мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5.6-д заасны дагуу баталсан мэдээллийг бүрдүүлж эрх бүхий этгээдэд цахим хэлбэрээр хүргүүлснээр үйл ажиллагааг эрхэлнэ.

2.Мэдэгдэл хүргүүлэлгүйгээр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.”

10/6.1 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт:

“1.4.хуульд заасан бусад”

11/6.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Эрх бүхий этгээд энэ хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.3, 1.6, 1.7-д заасан хүчингүй болгох үндэслэл байгаа тухай мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдэд цахим хэлбэрээр урьдчилан мэдэгдэнэ.”

12/8.1 дүгээр зүйлийн 2.39 дэх заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
2.39.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо

13/8.1 дүгээр зүйлийн 13.21 дэх хэсэг:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
13.21.жоргүй олгох эм худалдаалах	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

14/8.2 дугаар зүйлийн 1.17, 1.18 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1.17.нэг жилийн нийт хэрэглээ нь 100-1000 килограмм хүртэл химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.18.ойгоос мод бэлтгэх эрх	Ойн анги, эсхүл сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан

15/8.2 дугаар зүйлийн 3.4, 3.5, 3.6, 3.7 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
3.4.газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрх олгох	Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
3.5.газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох	Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
3.6.барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэнд экспертийн эрх олгох	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
3.7.Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд эрх олгох	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

16/8.2 дугаар зүйлийн 4.6, 4.7 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
4.6.тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4.7.орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга

17/8.2 дугаар зүйлийн 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.9, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14 дэх заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
5.5.аудитын үйл ажиллагаа эрхлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.6.татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ эрхлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.7.хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.8.гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.9.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх	Гаалийн удирдах төв байгууллага
5.10.гаалийн баталгаат барилгын талбай ажиллуулах	Гаалийн удирдах төв байгууллага
5.11.гаалийн баталгаат үйлдвэрийн газар ажиллуулах	Гаалийн удирдах төв байгууллага
5.12.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар ажиллуулах	Гаалийн удирдах төв байгууллага
5.13.гаалийн тусгай бүс байгуулах	Гаалийн удирдах төв байгууллага
5.14.татваргүй барааны дэлгүүр ажиллуулах	Гаалийн удирдах төв байгууллага

18/8.2 дугаар зүйлийн 6.15 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
6.15.хүүхэд харах үйлчилгээ эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга

19/8.2 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.5 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
7.3.бүх төрлийн шатахууны бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэх	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7.4.түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга
7.5.түгээмэл тархацтай ашигт малтмал хайх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга

20/8.2 дугаар зүйлийн 8.4 дэх заалт:

Энгийн зөвшөөрөл	Эрх бүхий этгээд
8.4.тусгай дугаарлалт ашиглан лавлах үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо

21/8.2 дугаар зүйлийн 10.16, 10.17, 10.18, 10.19, 10.20, 10.21, 10.22 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд

10.16.архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх	Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
10.17.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Хуульчдын холбоо
10.18.өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Өмгөөлөгчдийн холбоо
10.19.харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
10.20.хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх	Цагдаагийн төв байгууллага
10.21.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх	Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
10.22.гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх	Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

22/8.2 дугаар зүйлийн 11.9 дэх заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
11.9.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч
11.10.ургамал бүтээгдэхүүнийг худалдаалах хамгааллын импортлох,	Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

23/8.3 дугаар зүйл:

“8.3 дугаар зүйл.Мэдэгдлийн жагсаалт

1.Байгаль орчны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
1.1.нэг жилийн нийт хэрэглээ нь 100 килограмм хүртэл химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

2.Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
2.1.банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг өөрчлөх	Санхүүгийн зохицуулах хороо
2.2.даатгалын байгууллагын нэр, байршлыг өөрчлөх	Санхүүгийн зохицуулах хороо
2.3.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн салбарыг бүртгүүлэх	Санхүүгийн зохицуулах хороо, эсхүл тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга

2.4.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага, оноосон нэр, хаяг байршилд өөрчлөлт оруулах	Санхүүгийн зохицуулах хороо, эсхүл тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга
2.5.даатгалын байгууллагын эрх бүхий албан тушаалтныг бүртгэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.6.даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.7.банк бус санхүүгийн салбар, төлөөлөгчийн газар, нэгж нээх	Санхүүгийн зохицуулах хороо
2.8.даатгагч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа нээх	Санхүүгийн зохицуулах хороо
2.9.үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах	Санхүүгийн зохицуулах хороо

3.Зам, тээврийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
3.1.такси үйлчилгээ эрхлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга

4.Соёл, боловсролын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, хуулийн этгээд кино зураг авалт хийх	Кино урлагийн зөвлөл

5.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
5.1.мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.2.кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх	Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

6.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
6.1.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах	Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

7.Худалдаа, үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд дараах этгээдэд мэдэгдлийг хүргүүлнэ:

Мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаа	Эрх бүхий этгээд
7.1.хүнсний худалдааны үйл ажиллагаа эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
7.2.хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
7.3.үсчин, гоо засал, алжаал тайлах бариа засал, хумс засал, хими цэвэрлэгээ, цоож, түлхүүр засварын үйл ажиллагаа эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
7.4.нийтийн халуун ус, саун, усан бассейны үйл ажиллагаа эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
7.5.бялдаржуулах төв, спнинг, цанын баазын үйл ажиллагаа эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга
7.6.зочлох үйлчилгээ эрхлэх	Тухайн сум, дүүргийн Засаг дарга

24/9.1 дүгээр зүйлийн 5.6 дахь заалт:

“5.6.хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг эрхлэхээс өмнө эрх бүхий этгээдэд хүргүүлэх мэдээллийн жагсаалтыг батлах,”

25/9.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгож байгаа үйл ажиллагаанд Засгийн газар дахь хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.”

2 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Захиргааны ерөнхий хууль,” гэж, 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хүчингүй болгох” гэсний дараа “, эсхүл мэдэгдлээр эрхлэх” гэж, 1.4 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтын “зөвшөөрөл олгох” гэсний дараа “, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, мэдэгдэл хүлээн авах” гэж, мөн заалтын “хэрэгжүүлэхээр заасан” гэсний дараа “, эсхүл хуулиар мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаатай холбогдох харилцааг хэрэгжүүлэхээр заасан” гэж, 1.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “бүртгэл” гэсний дараа “, баталгаажуулалт” гэж, мөн зүйлийн 13 дахь хэсгийн “эзэмшигч” гэсний дараа “, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж, мөн зүйлийн 16 дахь хэсгийн “8.2” гэсний дараа “, 8.3” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ЗӨВШӨӨРӨЛ” гэсний дараа “, МЭДЭГДЭЛ” гэж, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “шилжүүлж болно.” гэсний дараа “Эрх бүхий этгээд энэ хуулийн 8.2, 8.3 дугаар зүйлд заасан зөвшөөрөл олгох, мэдэгдэл бүртгэх эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн мэргэжлийн нэгдсэн холбоонд шилжүүлж болно.” гэж, 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “эрхлэх этгээд” гэсний дараа “, 8.3 дугаар зүйлд заасан мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж, 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эзэмшигч” гэсний дараа “, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж, Тавдугаар бүлгийн гарчгийн “СУНГАХ” гэсний дараа “, МЭДЭГДЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ” гэж, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “11.1,” гэсний дараа “11.2, 11.5,” гэж, 6.2 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.7 дахь заалтын “эзэмшигч” гэсний дараа “, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж, 6.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “этгээд” гэсний дараа “, эсхүл мэдэгдлээр үйл ажиллагаа эрхэлж байсан этгээд” гэж, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтын “нутагшуулах” гэсний дараа “, өсгөн

үржүүлэх” гэж, 8.2 дугаар зүйлийн 1.7 дахь заалтын “эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх,” гэсний дараа “сүргийн бүтцийг зохицуулах,” гэж, 6.9 дэх заалтын “засварлах” гэсний дараа “, зөөж тээвэрлэн” гэж, 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 11 гишүүнээс бүрдэх бөгөөд Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлнэ.” гэсний дараа “Зөвлөлийн бүрэлдэхүүний 50-иас доошгүй хувь нь мэргэжлийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.” гэж, 9.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтын “8.2” гэсний дараа “, 8.3” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу тогтоосон энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл /цаашид “зөвшөөрөл” гэх/, 8.3 дугаар зүйлд заасан мэдэгдлээр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг холбогдох хуульд нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.”

2/1.5 дугаар зүйлийн 1.7, 1.8 дахь заалт:

“1.7.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
1.8.иргэн, хуулийн этгээд, төрийн ашиг сонирхлын тэнцвэрт байдлыг хангах.”

3/1.5 дугаар зүйлийн 14, 15 дахь хэсэг:

“14.Зөвшөөрөл, мэдэгдлийг шинээр бий болгох, нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх, өөрчлөх, жагсаалтаас хасах асуудлаар эрсдэлийн үнэлгээний аргачлалыг Засгийн газар батална.

15.Эрсдэлийн үнэлгээний аргачлалаар тухайн үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөг тодорхойлсны үндсэн дээр эрсдэлийн түвшинг тогтооно.”

4/2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглах тохиолдолд энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 15-д заасан аргачлалын дагуу эрсдэлийн түвшнээс хамааруулан зөвшөөрлийг доор дурдсанаар ангилна:

- 1.1.эрсдэлийн түвшин өндөр бол тусгай зөвшөөрөл;
- 1.2.эрсдэлийн түвшин дунд бол энгийн зөвшөөрөл;

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрсдэлийн түвшин бага үйл ажиллагааг мэдэгдлийн үндсэн дээр эрхэлнэ.”

5/3.2 дугаар зүйлийн 2.6 дахь заалт:

“2.6.энэ хуулийн 8.3 дугаар зүйлд заасан мэдэгдлийг хүлээн авсан даруйд бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах;”

6/8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, 1.11, 1.12, 1.13, 1.14, 1.15, 1.19 дэх заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1.4.амьтныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.11.ойн тооллого, зохион байгуулалт хийх, мод үржүүлэх, ойг нөхөн сэргээх, ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийж тэмцэх, ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах, арчилгаа цэвэрлэгээ хийх, ойн дагалт баялгийг ашиглах, хамгаалах ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
1.12.усны хайгуул, судалгаа явуулах, цооног өрөмдөх, тоноглох, сэргээн засварлах, усны барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барих, тоноглох, сэргээн засварлах мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэж өөрчлөх
1.13.байгалийн ургамлыг тарималжуулах, ашиглах, нөхөн сэргээх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.14.нэг жилийн нийт хэрэглээ нь 1000 килограмаас их химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.15.амьтны цуглуулга хийх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.19.ургамлыг судалгаа шинжилгээ, үйлдвэрлэлийн зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэх, тарималжуулсан байгалийн ургамлыг гадаад улсад гаргах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

7/8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.1, 5.4, 5.5, 5.12 дахь заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
5.1.төмөр замын суурь бүтэц барих, үйлдвэрлэх, угсрах, засварлах, ашиглах, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ;	Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.4.төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн эд анги үйлдвэрлэх, угсрах, засварлах	Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.5.улс хоорондын болон хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.12.олон улс, хот хооронд, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн тогтмол үйлчилгээ эрхлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга

8/8.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн 7.9 дэх заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
7.9.боловсролын сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эрхлэх	Чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага

9/8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.13, 9.15 дахь заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
9.13.шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо
9.15.шуудангийн үйлчилгээ эрхлэх	Харилцаа холбооны зохицуулах хороо

10/8.1 дүгээр зүйлийн 13 дахь хэсгийн 13.9, 13.10, 13.11, 13.12, 13.13, 13.14, 13.20 дахь заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
13.9.өрх, сум, тосгоны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
13.10.клиникийн тусламж, үйлчилгээ эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
13.11.нэгдсэн эмнэлэг, уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

13.12.төрөлжсөн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн тусламж, үйлчилгээ эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
13.13.тусгай эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
13.14.амаржих газрын тусламж, үйлчилгээ эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
13.20.сувилал, хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв, түргэн тусламжийн төв, сэргээн засах төв, сувилахуйн төвийн үйл ажиллагаа эрхлэх	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

11/8.1 дүгээр зүйлийн 14 дэх хэсгийн 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.7 дахь заалт:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
14.1.0.1-100 МВт-ын эрчим хүчний эх үүсвэрийн засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.2.100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэрийн засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.3.0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.4.110 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.5.0.07-8.0 МПа даралттай зуух, даралтат сав, дулаан дамжуулах төв, шугам, хоолой, тоноглолын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14.6.8.0 МПа-аас дээш даралттай зуух, даралтат сав, дулаан дамжуулах төв, шугам, хоолой, тоноглолын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

14.7.Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
--	--

12/8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.8, 1.13 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1.8.нэг жилийн нийт хэрэглээ нь 100-аас 1000 килограмм хүртэл химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.13.ховор ургамлыг ахуйн зориулалтаар ашиглах	Тухайн сум, дүүргийн Засаг дарга

13/8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.27, 2.28, 2.32, 2.33, 2.34, 2.38, 2.40, 2.41, 2.43 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
2.27.үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.28.үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.32.үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.33.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа	Санхүүгийн зохицуулах хороо
2.34.актуарчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.38.даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.40.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.41.үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.43.мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо

14/8.2 дугаар зүйлийн 10.8 дахь заалт:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
10.8.ан агнах, спорт-сургалтын зорилгоор галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр оруулах, гаргах, худалдан авах	Цагдаагийн төв байгууллага

15/9.2 дугаар зүйл:

“9.2 дугаар зүйл.Зөвшөөрөл, мэдэгдлийн эрсдэлийг үнэлэх

1.Зөвлөл зөвшөөрөл, мэдэгдэл, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь энэ хуулийн зорилго, зарчим, нөхцөл, шаардлагад нийцэж байгаа эсэхэд энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 14-т заасан аргачлалын дагуу хоёр жил тутам үнэлгээ хийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, шинээр бий болгох, хэвээр үлдээх, нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх, жагсаалтаас хасах, өөрчлөх асуудлаар дүгнэлт гаргаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

2.Энэ зүйлийн 9.2-т заасны дагуу үнэлгээ хийхдээ мэргэжлийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон төрийн бус байгууллагын оролцоог хангана.”

16/9.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

“1.Зөвшөөрөл, мэдэгдлийг шинээр бий болгох, нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх, өөрчлөх, жагсаалтаас хасах асуудлаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд Зөвлөл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 14-т заасан аргачлалын дагуу үнэлсэн эрсдэлийн түвшинг харгалзан санал, дүгнэлт гаргаж Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

2.Зөвлөл шинээр бий болгох зөвшөөрөл, мэдэгдлийн талаар дүгнэлт гаргахдаа энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрсдэлийн түвшнээс гадна дараах нөхцөлийг тодорхойлно:”

4 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн нэрийн “**ЗӨВШӨӨРЛИЙН**” гэснийг “**ЗӨВШӨӨРӨЛ, МЭДЭГДЛИЙН**” гэж, 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 1.2 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 1.5 дахь заалт, 2.2 дугаар зүйлийн гарчиг, 7.1 дүгээр зүйлийн гарчгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн зүйлийн 2.2 дахь заалт, 9.3 дугаар зүйлийн 2.2 дахь заалтын “зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “этгээдийг” гэснийг “этгээд болон мэдэгдлийн жагсаалт, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдийг” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Хуулиар зөвшөөрөлтэйгөөр” гэснийг “Энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл, мэдэгдлээр” гэж, 1.5 дугаар зүйлийн гарчгийн “Зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн харилцаанд” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрөл олгох, сунгах болон зөвшөөрөлтэй” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдэлтэй” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Хуульд” гэснийг “Энэ хуульд” гэж, мөн хэсгийн “аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл” гэснийг “аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой зөвшөөрөл, мэдэгдэл,” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “үйл ажиллагаанд” гэснийг “, эсхүл мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаанд” гэж, мөн зүйлийн 14 дэх хэсгийн “Зөвшөөрлийг шинээр бий болгоход” гэснийг “Зөвшөөрлийг шинээр бий болгох, зөвшөөрлийн ангилал өөрчлөх, зөвшөөрлөөс хасахад” гэж, мөн зүйлийн 16 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийг” гэж, мөн зүйлийн 17 дахь хэсгийн “болгохтой” гэснийг “болгох болон мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаатай” гэж, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “таван” гэснийг “арван” гэж, мөн хэсгийн “гурван” гэснийг “таван” гэж, Гуравдугаар бүлгийн гарчгийн “ЭТГЭЭД,” гэснийг “ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ,” гэж, 3.2 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх” гэснийг “эрх, үүрэг” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “бүрэн эрхийг” гэснийг “эрх, үүргийг” гэж, мөн зүйлийн 1.2 дахь заалтын “эсэхэд” гэснийг “эсэх, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагаанд хуульд заасны дагуу” гэж, мөн зүйлийн 1.3 дахь заалтын “тухайн зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн заалтын “эзэмшигчээс” гэснийг “эзэмшигч, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх

этгээдээс” гэж, Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “ЭЗЭМШИГЧИД” гэснийг ЭЗЭМШИГЧ, МЭДЭГДЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДЭД” гэж, мөн гарчгийн “ЭЗЭМШИГЧИЙН” гэснийг “ЭЗЭМШИГЧ, МЭДЭГДЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ ЭТГЭЭДИЙН” гэж, 4.1 дүгээр зүйлийн гарчгийн “эзэмшигчид” гэснийг “эзэмшигч, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэгч этгээдэд” гэж, 4.2 дугаар зүйлийн гарчгийн “эзэмшигчийн” гэснийг “эзэмшигч, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдийн” гэж, мөн зүйлийн 1.1 дэх заалтын “зөвшөөрөлд” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдэлд” гэж, мөн зүйлийн 1.5 дахь заалтын “зөвшөөрөлтэй” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдэлтэй” гэж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “зөвшөөрөлд” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдэлд” гэж, мөн зүйлийн 2.8 дахь заалтын “зөвшөөрлийн” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны” гэж, 4.2 дугаар зүйлийн 2.9 дэх заалтын дугаарыг “2.10” гэж, 5.4 дүгээр зүйлийн гарчгийн “Зөвшөөрлийн баримт бичиг” гэснийг “Баримт бичиг” гэж, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “1.15” гэснийг “1.16” гэж, мөн хэсгийн “9.11 дэх заалт” гэснийг “9.11, 9.13 дахь заалт” гэж, 6.2 дугаар зүйлийн гарчгийн “Зөвшөөрлийг” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийг” гэж, мөн зүйлийн 1.6 дахь заалтын “зөвшөөрлийг авахдаа” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн үйл ажиллагаа эрхлэхдээ” гэж, 6.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дугаарыг “5” гэж, Долдугаар бүлгийн гарчгийн “ЗӨВШӨӨРЛИЙН” гэснийг “ЗӨВШӨӨРӨЛ, МЭДЭГДЛИЙН” гэж, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “мэдээллийг агуулсан зөвшөөрлийн” гэснийг “мэдээлэл, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны мэдээллийг агуулсан зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “шийдвэрийг” гэснийг “шийдвэр, мэдэгдлийг” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “шийдвэрийг зөвшөөрлийн” гэснийг “шийдвэр, мэдэгдлийг” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “зөвшөөрлийг” гэснийг “зөвшөөрөл, мэдэгдлийг” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “шийдвэрийн” гэснийг “шийдвэр, мэдэгдлийн” гэж, Наймдугаар бүлгийн гарчгийн “ЗӨВШӨӨРЛӨӨР” гэснийг “ЗӨВШӨӨРӨЛ, МЭДЭГДЛЭЭР” гэж, 8.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “Засгийн газар” гэснийг, мөн зүйлийн 1.18 дахь заалтын “Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг, мөн зүйлийн 1.20 дахь заалтын “Удирдан зохицуулах зөвлөл” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн зүйлийн 1.23 дахь заалтын “Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн зүйлийн 1.8 дахь заалтын “генетикийн” гэснийг “генетик” гэж, мөн зүйлийн 1.24, 1.25 дахь заалтын “Тухайн сум, дүүргийн Засаг дарга” гэснийг “Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга” гэж, мөн зүйлийн 1.27 дахь заалтын “алба” гэснийг “газар” гэж, мөн зүйлийн 1.28 дахь заалтын “Тухайн сав газрын захиргаа” гэснийг “Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга” гэж, мөн зүйлийн 1.29 дэх заалтын “Тухайн ойн анги, эсхүл тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч” гэснийг “Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга” гэж, мөн зүйлийн 2.22 дахь заалтын “арилжааны тооцооны” гэснийг “клирингийн” гэж, мөн зүйлийн 2.23 дахь заалтын “төлбөрийн” гэснийг “төлбөр, тооцооны” гэж, мөн зүйлийн 7.2 дахь заалтын “их сургууль, дээд сургууль, коллежийн” гэснийг “дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын” гэж, 7.3 дахь заалтын “олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль байгуулах” гэснийг “олон улсын хөтөлбөрөөр ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэж, 7.4 дэх заалтын “төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэж, 7.6 дахь заалтын “цэцэрлэгийн үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэж, 7.7 дахь заалтын “ерөнхий боловсролын сургууль байгуулах” гэснийг “ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэж, мөн зүйлийн 8.1, 8.3 дахь заалтын “Засгийн газар” гэснийг “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага” гэж, 8.2 дахь заалтын “Засгийн газар” гэснийг “хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн зүйлийн 8.20, 8.21, 8.22, 8.23 дахь заалтын “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 8.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Тухай сав газрын захиргаа” гэж, мөн зүйлийн 1.11 дэх заалтын “Тухайн сум, дүүргийн Засаг дарга” гэснийг “Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга” гэж, мөн зүйлийн 2.2 дахь заалтын “салбар” гэснийг “нэгж”, мөн зүйлийн 6.2 дахь заалтын “дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт явуулах” гэснийг “дээд боловсролын шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэх үйл ажиллагаа” гэж, 6.3 дахь заалтын “сургууль байгуулах” гэснийг “ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол болон дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэж, 6.4 дэх заалтын “их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль байгуулах” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ерөнхий боловсрол болон сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх” гэж, мөн зүйлийн 10.8 дахь заалтын “зорилгоор галт зэвсэг” гэснийг “болон спортын тэмцээн, сургалтад оролцох зорилгоор Монгол Улсын иргэн иргэний зориулалттай галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг” гэж, 9.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэснийг “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн 5.3 дахь заалтын “энэ хуульд өөрчлөлт оруулах” гэснийг “энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, 9.3 дугаар зүйлийн гарчгийн “Зөвшөөрөл шинээр бий болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг өөрчлөхөд дүгнэлт гаргах” гэснийг “Санал, дүгнэлт гаргах” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5 дахь хэсгийн “зөвшөөрлийн” гэснийг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “1.15” гэснийг, 8.1 дүгээр зүйлийн 1.16 дахь заалтын “эм” гэснийг, 8.22 дахь заалтын “болон түүнтэй холбогдсон бусад” гэснийг, 9.3 дугаар зүйлийн 2.3 дахь заалтын “зөвшөөрлийн ангилалд үндэслэн” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.30, 2.13, 2.19, 2.20, 3.6, 3.7, 5.5, 6.1, 6.2, 6.4, 6.6, 6.7, 6.8, 6.9, 6.10, 6.11, 6.12, 7.8, 8.4, 7.1, 7.10, 7.11, 7.12, 8.29, 8.30, 11.6, 11.7, 11.8, 11.9, 11.11, 11.13, 12.4, 12.13, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13, 14.14, 14.15, 14.16, 14.17, 14.18, 14.19, 14.20, 14.21, 14.22 дахь заалт, 8.2 дугаар зүйлийн 1.12, 2.7, 2.39, 2.44, 2.45, 2.46, 2.47, 2.48, 2.49, 2.50, 2.51, 3.2, 6.5, 6.13, 8.1, 8.2, 10.9, 10.10, 11.8 дахь заалт, 9.3 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, мөн зүйлийн 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дугаар зүйл.Авто замын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“33.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд Зөвшөөрлийн тухай хуульд заасан шаардлагаас гадна тавигдах нөхцөл, шаардлагыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл.Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дугаар зүйл.Автотээврийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

2/15 дугаар зүйлийн 15.11 дэх хэсэг:

“15.11.Орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, такси үйлчилгээг стандартын шаардлага хангасан этгээд эрхэлнэ.”

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг:

“15.1.Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх, олон улс, хот хооронд, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн тогтмол үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.3, 5.5-д заасан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, автотээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх, орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 8.2 дугаар зүйлийн 4.6, 4.7-д заасан энгийн зөвшөөрөлтэй хуулийн этгээд, такси үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 3.1-д заасан мэдэгдэл хүргүүлсэн хуулийн этгээд эрхэлнэ.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулиар зохицуулна.”

2/15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг:

“15.5.Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдэд олгоно:

15.5.1.техникийн хяналтын үзлэг явуулах байр, тоног төхөөрөмж, боловсон хүчин нь холбогдох стандартын шаардлагыг хангасан байх;

15.5.2.автотээврийн хэрэгсэл, түүний агрегат, зангилаа, системийн техникийн байдлыг шалгах, хэмжих, оношлох багаж, тоног төхөөрөмж нь тохирлын үнэлгээнд хамрагдаж, холбогдох байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн байх;

15.5.3.үйлчлүүлэгчдийн автотээврийн хэрэгслийг аюулгүй байрлуулах зориулалтын зогсоол талбайтай байх;

15.5.4.автомашин болон явган хүний хөдөлгөөний урсгалыг аюулгүй зохицуулах зориулалтын хучилттай зам, гарцтай байх;

15.5.5.автотээврийн хэрэгслийн улсын дугаар, ерөнхий байдал, үзлэгийн үйл явцыг бүрэн хянах боломжтой дүрс бичлэгийн төхөөрөмжийг байршуулж, бичлэгийг хадгалах, шалгах боломжтой байх;

15.5.6.техникийн хяналтын үзлэгийн инженер нь автотээврийн инженер, механикч мэргэжилтэй, мэргэшсэн инженер байх ба холбогдох мэргэжлийн диплом, гэрчилгээтэй байх.”

3/15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсэг:

“15.9.Олон улс, хот хооронд, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн тогтмол үйлчилгээ эрхлэх этгээд нь дараах шаардлага хангасан байна.”

4/15 дугаар зүйлийн 15.9.6 дахь заалт:

“15.9.6.олон улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн тогтмол үйлчилгээнд ашиглах тээврийн хэрэгсэл нь үйлдвэрлэгдсэнээс хойш 12 жилээс, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн тогтмол үйлчилгээнд ашиглах тээврийн хэрэгсэл нь үйлдвэрлэгдсэнээс хойш 10 жилээс хэтрээгүй зүүн талдаа жолооны хүрдтэй байх;”

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдэл” гэж, мөн зүйлийн 15.6 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 15.10 дахь хэсгийн “Такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг” гэснийг “Такси үйлчилгээг мэдэгдлээр эрхлэхэд” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалт:

“7.1.10.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.9, 1.10-д заасан тусгай зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох;”

2/7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг:

“7.2.Энэ хуулийн 7.1.10-д заасан тусгай зөвшөөрөл олгох эрхийг мэргэжлийн эрх бүхий байгууллагад шилжүүлж болно.”

2 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.4 дэх хэсгийн “Зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй.

1/6¹ дүгээр зүйл:

“6¹ дүгээр зүйл. Амьтныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа

6^{1.1}. Амьтныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд үйл ажиллагааны танилцуулга, ажилтны мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн талаарх нотлох баримт, ажлын байр, техник, тоног төхөөрөмжийн мэдээллийг хавсаргана.

6^{1.2}. Амьтныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага таван жилийн хугацаагаар олгож, үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн тохиолдолд Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан журмын дагуу сунгана.

2/7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэг:

“7.8. Амьтныг эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор агнах, барих зөвшөөрөл авахдаа судалгааны багийн бүрэлдэхүүн, судалгаа шинжилгээний арга зүй, судалгааны ажлын батлагдсан удирдамж, хөтөлбөр, ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарийг хавсаргана.

3/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:

“8.3. Амьтан сэргээн нутагшуулах, өсгөн үржүүлэх тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааны танилцуулга, амьтныг сэргээн нутагшуулах, өсгөн үржүүлэх газрын мэдээлэл, аргачлал, ажлын удирдамж, хөтөлбөр, ажил гүйцэтгэх хугацааны хуваарийг хавсаргана.

4/20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг:

“20.4. Амьтны цуглуулга хийх тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд үйл ажиллагааны танилцуулга, зорилгыг тодорхой тусгана.”

5/29¹ дүгээр зүйлийн 29¹.1 дэх хэсэг:

“29^{1.1}.энэ хуулийн 27.1, 29.2.2-т заасан зөвшөөрлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу дуудлага худалдааны журмаар олгоно.

6/29¹ дүгээр зүйлийн 29^{1.15}, 29^{1.16}, 29^{1.17}, 29^{1.18} дахь хэсэг:

“29^{1.15}.Энэ хуулийн 29^{1.1}-д заасан зөвшөөрлийн дуудлага худалдааны эхлэх босго үнэ тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээний 50 хувьтай тэнцүү байна.

29^{1.16}.Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүсийг гэрээгээр эзэмшигч бол тусгай зөвшөөрлийг өөрийн хариуцдаг агнуурын бүс нутаг дээр бүртгүүлж, аймгийн Байгаль орчны газартай гэрээ байгуулна.

29^{1.17}.Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүсийг гэрээгээр эзэмшигч биш бол аймгийн Байгаль орчны газар болон агнуурын бүс нутгийг гэрээгээр эзэмшигч хуулийн этгээдтэй гурвалсан гэрээ байгуулна.

29^{1.18}.Аймаг, нийслэлийн байгаль орчны газар дуудлага худалдааны ялагчийн жагсаалт, агнуурын нөөц ашигласны төлбөр, хураамжийг төлсөн баримт, энэ хуулийн 29^{1.16}-д заасан гэрээг үндэслэн тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.”

2 дугаар зүйл.Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2 дахь заалтын “6.1.3, 6.1.7, 6.1.8, 6.1.9, 6.1.11” гэсний дараа “35 дугаар зүйлийн 35.1” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “амьтныг сэргээн нутагшуулах” гэсний дараа “, өсгөн үржүүлэх” гэж, 25.6 дахь хэсгийн “25.1,” гэсний дараа “27.1,” гэж, 29¹ дүгээр зүйлийн 29^{1.11} дэх хэсгийн “29^{1.7}” гэсний дараа “, 29^{1.8}” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Амьтны тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:

“20.2.Амьтны цуглуулга хийх тусгай зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 3 хүртэлх сарын хугацаатай олгоно.

2/ 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг:

“27.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг Зөвшөөрөл, мэдэгдэлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу олгоно.”

3/29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“29.2.Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон агнуурын амьтныг тусгай зориулалтаар агнах, барих зөвшөөрлөөр эрдэм шинжилгээ, соёл, спорт агнуур болон олзворын зориулалтаар амьтныг агнаж, барьж болно.”

3/36 дугаар зүйлийн 36.2, 36.3 дахь хэсэг:

“36.2.Энэ хуулийн 36.1-д заасан амьтнаас бусад амьтныг амьдаар нь, амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг улсын хилээр нэвтрүүлэх

зөвшөөрлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 2 сар хүртэлх хугацаагаар олгож, сунгалт нь нэг удаа 1 сар байна.

36.3.Энэ хуулийн 36.2-т заасан зөвшөөрлийг авах хүсэлтэд тухайн амьтныг агнах, барих, дээж цуглуулах зөвшөөрөл, гарал үүслийн тодорхойлолт, эзэмшлийн амьтан, амьтны гаралтай эд зүйлс бол гарал үүслийн тодорхойлолт, зүүлт, амьтныг тээвэрлэх, түр байршуулах бол байр, технологийг тусгасан аргачлал, үйлдвэрлэлийн зориулалтаар агнаж, барьсан бол эрх олгосон шийдвэр, гэрээний хуулбар, хүлээн авагч талтай байгуулсан гэрээ, эсхүл санамж бичгийн хувь, харь амьтныг хилээр нэвтрүүлэх бол экспортлогч талын гарал үүслийн тодорхойлолт, импортлогч талын итгэмжлэгдсэн эрдэм шинжилгээний байгууллагын дүгнэлтийг хавсаргана.”

5/29¹ дүгээр зүйлийн 29¹.3, 29¹.4 дэх хэсэг:

“29¹.3.Энэ хуулийн 6¹.3-т заасан мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дэнчин төлж, бүртгүүлэн дуудлага худалдаанд оролцоно.

29¹.4.Дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаа эхлэх босго үнэтэй тэнцүү хэмжээний дэнчинг дуудлага худалдаа эхлэхээс 24 цагийн өмнө дуудлага худалдаа зохион байгуулагчийн холбогдох дансанд байршуулна.”

7/29¹ дүгээр зүйлийн 29¹.8 дахь хэсэг:

“29¹.8.Дуудлага худалдааны ялагч энэ хуулийн 29¹.7-д заасан хугацаанд төлбөрийг бүрэн төлөөгүй бол дэнчинг улсын орлого болгож, дуудлага худалдааны үед дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээдэд түүний санал гаргасан үнийн дүнгээр нь 24 цагийн дотор санал тавина. Саналыг хүлээж авсан тохиолдолд тухайн этгээд төлбөрийг 24 цагийн дотор дуудлага худалдаа зохион байгуулагчийн холбогдох дансанд бүрэн төлсний дараа зохион байгуулагч ялагчийг баталгаажуулсан шийдвэр гаргана.”

4 дүгээр зүйл.Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.5, 5.7.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1, 36.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “байгаль орчны мэргэжлийн байгууллага” гэснийг “амьтныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах мэргэжлийн байгууллага” гэж, 7 дугаар зүйлийн 7.5.1 дэх заалтын “соёл, урлаг, эмчилгээний” гэснийг “соёлын” гэж, 29¹ дүгээр зүйлийн 29¹.12 дахь хэсгийн “хоёр дахь” гэснийг “дахин” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Амьтны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “Тусгай төлбөр төлсөн иргэнд” гэснийг, 25.1-д заасан “хуулийн этгээд гэсний өмнөх” “иргэн,” гэснийг, 29¹ дүгээр зүйлийн 29¹.6 дахь хэсгийн “Дуудлага худалдаанд оролцогчид үнийн санал гаргаагүй тохиолдолд долоо хоногийн дотор хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулна.” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 29¹ дүгээр зүйлийн 29¹.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 26 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 26.8, 26.9, 26.10, 26.11 дэх хэсгийг тус тус нэмсүгэй:

“26.8.Архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдийн гаргасан зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

26.9.Архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ:

26.9.1.архивын сан хөмрөгийн аюулгүй байдал, архивын аюулгүй ажиллагаа алдагдсан;

26.9.2.архивын байранд архивын үйл ажиллагаанаас өөр төрлийн үйл ажиллагаа явуулсан;

26.9.3.архивын байр, тоног төхөөрөмж, тавиур шүүгээнд тавигдах стандартын шаардлага хангагдахгүй болсон;

26.9.4.архивын мэргэжлийн бус ажилтан архивын үйл ажиллагааг явуулсан.

26.10.Архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх болон энэ хуулийн 26.2-т заасан гэрээ байгуулахтай холбогдсон энэ хуульд тусгаагүй бусад асуудлыг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хууль, Иргэний хуульд заасны дагуу зохицуулна.

26.11.Архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгохдоо энэ хуулийн 12.7-д заасныг баримтална.”

2 дугаар зүйл. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг:

“26.3.Архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

26.3.1.энэ хуулийн 29.6-д заасан стандартын шаардлага хангасан архивын зориулалтын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх;

26.3.2.архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр мэргэжлийн 2-оос доошгүй ажилтантай байх;

26.3.3.архивын аюулгүй байдлын баталгааг хангасан, баримтын хадгалалт, хамгаалалтын тохиромжтой нөхцөлийг бүрдүүлсэн, хамгаалалтын болон галын дохиололтой, харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр хамгаалуулдаг байх;

26.3.6.архивын баримт хадгалах байранд гал түймрийн аюулын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байх”

2/26 дугаар зүйлийн 26.6, 26.7 дахь хэсэг:

“26.6.Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар архивын баримт хадгалах үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээд энэ хуулийн 26.3-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулна.

26.7.Ажлын хэсэг магадлан шалгах ажиллагааны дүгнэлтийг гаргах бөгөөд дүгнэлтийг үндэслэн архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга энэ хуулийн 26.1-д заасан зөвшөөрөл олгоно.”

3 дугаар зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3.4 дэх заалт, мөн зүйлийн 26.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “тусгай” гэснийг хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.1.1, 20.1.2 дахь заалт, 20.2, 20.3 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 22.1, 22.2, 22.3, 22.4, 22.5, 22.7 дахь хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

“10.4.Энэ хуулийн 10.3-т заасан комиссын гишүүн нь хууль, геологийн салбарын мэргэжил эзэмшсэн, геологийн судалгаа, хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг үнэлэх мэргэжлийн чадвар туршлагатай байна.”

2/20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт:

“20.1.3.хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчид 60 (жаран) оноо бусад оролцогчдын ирүүлсэн үнэ бүрийг цахим системд илгээсний дагуу хамгийн өндөр үнэтэй харьцуулж тооцоолох.”

3/20 дугаар зүйлийн 20.5.7, 20.5.8 дахь заалт:

“20.5.7.энэ хуулийн 20.5.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд нийлбэр оноогоор хоёрт орсон оролцогчид тусгай зөвшөөрлийг олгох;

20.5.8.энэ хуулийн 20.5.7-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг олгохдоо хоёрт орсон оролцогчийн нийлбэр оноо шалгарсан оролцогчийн нийлбэр онооноос 8 хувиас хэтрээгүй байх.”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт:

“10.1.2.сонгон шалгаруулалтын үнэлгээний маягт батлах;”

2/18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг:

“18.1.Энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана.”

3/20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт:

“20.1.2.оролцогчдын сонгон шалгаруулалтын үнийн саналын оноо нь 20 (хорин) оноонд хүрээгүй тохиолдолд техникийн саналд үнэлгээ хийхгүй бөгөөд цахим хуудсанд байршуулж нийтэд нээлттэй мэдээлэх;”

4/20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт:

“20.2.1.сонгон шалгаруулалтын комисс үнийн саналыг энэ хуулийн 10.1.2-т заасан үнэлгээний маягтын дагуу нээснээс хойш ажлын таван өдрийн дотор техникийн саналыг үнэлнэ.”

5/49 дүгээр зүйлийн 49.7 дахь хэсэг:

“49.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Иргэний хууль, Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай хуульд заасны дагуу хуваагдах, тусгаарлагдах замаар өөрчлөн байгуулагдсан тохиолдолд уг тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны байгууллагад буцааж өгнө.”

3 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсгийг нэмсүгэй:

1/10¹ дугаар зүйлийн 6, 7, 8 дахь хэсэг:

“6. Байгаль орчны аудит хийх эрхтэй хуулийн этгээд нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгаль орчны бусад төрлийн тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг давхар эрхлэхгүй.

7. Байгаль орчны аудит хийх хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь байгаль орчны аудитор байх ба нийт гурваас доошгүй орон тооны байгаль орчны аудитортой байна.

8. Байгаль орчны аудитор нь байгалийн шинжлэх ухаан, хүрээлэн буй орчин болон эрх зүйч мэргэжилтэй, байгаль орчны чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, сургалтын байгууллагаас зохион байгуулсан байгаль орчны аудиторын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.”

2/30 дугаар зүйлийн 4, 5, 6, 7 дахь хэсэг:

“4. Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.31-д заасан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

1/хүрээлэн буй орчин, байгалийн шинжлэх ухааны чиглэлийн 3-аас доошгүй боловсон хүчний мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн нотлох баримт, ажилд томилсон тушаал, хөдөлмөрийн гэрээ;

2/нөхөн сэргээлтийг аргачлалын дагуу гүйцэтгэхэд шаардлагатай хүнд машин механизм, техник хэрэгслийн гэрчилгээний хуулбар;

5. Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх сунгуулах хүсэлтэд нөхөн сэргээлт хийсэн ажлын тайлан, нөхөн сэргээлт хүлээлгэж өгсөн актын мэдээллийг хавсаргана.

6. Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан тохиолдолд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан баримт бичгийг шаардахгүйгээр сунгана.

7. Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.31-д заасан зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг зөрчиж, ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хүчингүй болгоно.”

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3. Байгаль орчны аудит хийх тусгай зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

3 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Монгол Улсын аж ахуйн нэгжид” гэснийг “хуулийн этгээдэд” гэж, мөн хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн зүйлийн 12.2, 12.9 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Нэн ховор, ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар батална.”

2/11 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг:

“4.Судалгаа, шинжилгээний зориулалтаар олгох нэг удаагийн зөвшөөрлийн хэмжээ нэн ховор ургамлын газрын дээрх хэсэг 0,2 кг, газрын доорх хэсэг 0,2 кг, ховор ургамлын газрын дээрх хэсэг 0,5 кг, газрын доорх хэсэг 0,5 кг, элбэг ургамлын газрын дээрх хэсэг 2 кг, газрын доорх хэсэг 1,5 кг-аас илүүгүй байна.

5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвшөөрөл хүссэн өргөдөлд судалгааны ажлын товч танилцуулгыг хавсаргаж ирүүлнэ.”

3/12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Ахуйн зориулалтаар нэг удаагийн зөвшөөрлөөр олгох ховор ургамал газрын дээрх хэсэг 3 кг, газрын доорх хэсэг 2 кг, элбэг ургамал газрын дээрх хэсэг 8 кг, газрын доорх хэсэг 5 кг-аас илүүгүй байна.”

4/13¹ дүгээр зүйл:

“13¹ дүгээр зүйл. Дуудлага худалдаа зохион байгуулах

1.Энэ хуулийн 13.4-т заасан зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу дуудлага худалдааны журмаар олгоно.

2.Дуудлага худалдааг энэ хуулийн 7¹.4-т заасны дагуу үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын дээд хэмжээ баталсан шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор олон нийтэд нээлттэй зарлаж, 30 хоногийн дотор цахим хэлбэрээр зохион байгуулна.

3.Дуудлага худалдааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.25-д заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

4.Дэнчин төлж бүртгүүлсэн этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дуудлага худалдаанд оролцоно.

5.Дуудлага худалдаанд оролцогч дуудлага худалдаа эхлэх босго үнийн 50 хувьтай тэнцэх хэмжээний дэнчинг дуудлага худалдаа эхлэхээс 24 цагийн өмнө

холбогдох дансанд байршуулж, бүртгэл хийлгэнэ. Дуудлага худалдаанд оролцоогүй, эсхүл оролцсон боловч ялаагүй этгээдэд дэнчинг буцаан олгоно.

6. Анхны үнийн санал гарснаар дуудлага худалдааг эхэлсэнд тооцох бөгөөд хамгийн өндөр үнийн санал өгөөд 30 секундын дотор өөр оролцогч үнэ өсгөөгүй тохиолдолд дуудлага худалдаа зохион байгуулагч сүүлийн үнийг зарлан ялагчийг тодруулж дуудлага худалдааг дуусгавар болгоно.

7. Дуудлага худалдааны ялагч нь дуудлага худалдаанд ялсан үнийг 24 цагийн дотор холбогдох дансанд бүрэн төлсний дараа зохион байгуулагч ялагчийг баталгаажуулсан шийдвэр гаргана.

8. Дуудлага худалдааны ялагч энэ зүйлийн 7-д заасан хугацаанд төлбөрийг бүрэн төлөөгүй, эсхүл өөрийн хүсэлтээр татгалзсан тохиолдолд дуудлага худалдааны үед дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээдэд 24 цагийн дотор дуудлага худалдааны ялагч болох саналыг хүргүүлнэ.

9. Дуудлага худалдааг зохион байгуулагч дуудлага худалдааны явцад тэмдэглэл үйлдэж, дуу, дүрсний бичлэгийн төхөөрөмжөөр баталгаажуулах бөгөөд оролцогчид болон зохион байгуулагч талын төлөөлөл тэмдэглэлд гарын үсэг зурна.

10. Энэ зүйлийн 7-д заасан төлбөрийг төлөхөд дуудлага худалдаанд оролцоход урьдчилан төлсөн дэнчинг үнийн дүнд оруулж тооцно.

11. Дараах тохиолдолд дараагийн дуудлага худалдааг зохион байгуулна:

1/дуудлага худалдаанд нэг оролцогч оролцсон;
2/дуудлага худалдаанд оролцогчид үнийн санал гаргаагүй;
3/энэ зүйлийн 8-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээд татгалзсан;

4/байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон, дуудлага худалдаа хэвийн явагдах боломжгүй болсон нь нотлогдсон.

12. Дуудлага худалдааны босго үнийг Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээний 50 хувиар тооцно. Дуудлага худалдааг өсгөх үнэ босго үнийн 50 хувиас хэтрэхгүй байна.

13. Дуудлага худалдаанаас олсон нийт орлогын 50 хувийг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлнэ.

5/15¹ дүгээр зүйл:

“15¹ дүгээр зүйл. Байгалийн ургамлын мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагаа

1. Байгалийн ургамлын мэргэжлийн байгууллага нь өмчийн аль ч хэлбэртэй байж болох бөгөөд Монгол Улсад бүртгэлтэй, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлөгч хуулийн этгээд байна.

2.Энэ хуулийн 15¹ дүгээр зүйлийн 1-д заасан байгууллага нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

- 1/байгалийн ургамлыг түүж бэлтгэх, нөхөн сэргээх;
- 2/байгалийн ургамлыг тарималжуулах.

3.Мэргэжлийн байгууллагын эрх авахыг хүссэн өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргасан байна:

1/тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэргэжлийн хүний нөөцийн жагсаалт, дипломын хуулбар;

2/хүний нөөцийг ажилд томилсон тушаал, хөдөлмөрийн гэрээ;

3/шаардлагатай багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийн гэрчилгээний хуулбар;

5.Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэжлийн байгууллагын эрхийг 5 жилийн хугацаатай олгож, Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан журмын дагуу сунгана.

6.Мэргэжлийн байгууллага тухайн онд гүйцэтгэсэн ажлын тайланг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор үйл ажиллагаа эрхэлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлнэ.

7.Аймаг, нийслэлийн байгаль орчны газар энэ хуулийн 15¹ дүгээр зүйлийн 9-д заасны дагуу ирүүлсэн тайланг нэгтгэн энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1-д заасан мэдээллийн санд оруулна.”

2 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “заасны дагуу” гэсний дараа “байгаль орчны асуудал эрхэлсэн” гэж, 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “мэдээлэх” гэсний өмнө “6 сараас 1.5 жилийн дотор” гэж, 13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “1.16-д заасны дагуу” гэсний дараа “байгаль орчны асуудал эрхэлсэн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

“1.Байгалийн ургамлын мэргэжлийн байгууллага ховор, элбэг ургамлыг зөвшөөрлийн үндсэн дээр түүж бэлтгэж болно.

2.Байгалийн ургамлын мэргэжлийн байгууллага байгалийн нэн ховор, ховор, элбэг ургамлыг тарималжуулан ашиглаж болно.

3/17 дугаар зүйл:

“17 дугаар зүйл.Ургамлыг улсын хилээр нэвтрүүлэх

1.Нэн ховор ургамлыг судалгаа шинжилгээ, ховор, элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэх, тарималжуулсан байгалийн ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн

8.1 дүгээр зүйлийн 1.19-д заасны дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

2.Судалгаа шинжилгээний зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл хүссэн өргөдөлд судалгааны ажлын товч танилцуулга, судалгаа хийх талтай байгуулсан гэрээг хавсаргана.

3.Үйлдвэрлэлийн зориулалтаар гадаад улсад гаргах зөвшөөрөл хүссэн өргөдөлд ургамал түүж бэлтгэх болон нийлүүлэгч талтай байгуулсан гэрээ, гадаад улсаас оруулахад ургамал ашиглах зориулалт, танилцуулгыг хавсаргана.

4.Тарималжуулсан байгалийн ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрөл хүссэн өргөдөлд байгалийн ургамлыг тарималжуулсан нь үнэн болохыг тогтоосон сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт, төрийн шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтийг хавсаргана.

5.Ховор, элбэг ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдийг хатаасан болон боловсруулалт хийсэн, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

6.Гадаад улсаас оруулсан харь зүйл ургамлыг байгальд тарималжуулахыг хориглоно.

4 дүгээр зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 6, 8 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 3, 5 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 2, 7 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 2, 3, 5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “тайлангаа Генетик нөөцийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл” гэснийг “тайлан, үр дүнг энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1-д заасан” гэж, 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “сум, дүүргийн” гэснийг “аймгийн” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “/энэ хуулийн хавсралтаар тогтоосон/” гэснийг, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар батална.” гэснийг, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “эмийн” гэснийг, 13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “эм” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр” гэснийг “Монголбанкинд мэдэгдсэнээр” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт:

“8.1.9.хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн дансанд байршуулсан талаарх банкны дансны хуулга.”

2/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:

“9.1.5.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан.”

3/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

“9.3.Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг энэ хуулийн 9.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан этгээдэд олгоно:

9.3.1.Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааг гурваас доошгүй жил эрхэлсэн, сүүлийн 4 улирал дараалан энэ хуулийн 13.4-т заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж, ашигтай ажилласан, чанаргүй зээлийн багц нь салбарын дундаж үзүүлэлтээс хэтрээгүй;

9.3.2.гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүнээс бүрдсэн төлөөлөн удирдах зөвлөлтэй байх;

9.3.3.Зөрчлийн тухай хуулийн 11.5, 11.8-д заасан үндэслэлээр сүүлийн нэг жилийн хугацаанд хоёр ба түүнээс дээш удаа хариуцлага хүлээгээгүй.”

4/9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь хэсэг:

“9.5.Банк бус санхүүгийн байгууллага нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан санхүүгийн бусад үйлчилгээг Хорооноос зөвшөөрсөн тохиолдолд хавсран эрхэлж болно.

9.6.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхэлнэ.

9.7.Энэ зүйлийн 9.6-д заасан мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааг цахимаар явуулна.”

5/19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг:

“19.4.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

19.4.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээснээс хойш хоёр жилийн дотор энэ хуулийн 19.3-т заасан зөрчлийг гаргасан;

19.4.2.Зөрчлийн тухай хуулийн 11.5, 11.8-д заасан зөрчлийг нэг жилийн дотор гурав буюу түүнээс дээш удаа гаргасан.”

2 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 зүйлийн гарчгийн “зөвшөөрөл” гэсний дараа “, мэдэгдэл” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19.3.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

“19.3.1.санхүүгийн тайлан, мэдээг хоёр улирал дараалан ирүүлээгүй;

19.3.2.энэ хуулийн 14.2-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллаагүй;

19.3.3.хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг зөвшөөрөлтэй үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаанд зарцуулсан;

19.3.4.энэ хуулийн 19.2.1-д заасан үүрэг даалгаврыг биелүүлээгүй.

19.3.5.газар дээрх хяналт шалгалтаас санаатай зайлсхийсэн.”

4 дүгээр зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “санхүүгийн тайлан;” гэснийг “санхүүгийн тайлан, эсхүл эхлэлтийн тайлан тэнцэл;” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “хүрсэн;” гэснийг “хүрсэн, тухайн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл хууль ёсны эх үүсвэрээс бүрдсэн;” гэж, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “хорооны зөвшөөрөлтэйгээр” гэснийг “хороонд мэдэгдснээр” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.11 дэх заалтын “үзүүлэх” гэсний дараа “зөвшөөрөл бүхий” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг:

“20.3.Барилгын үйл ажиллагааны болон барилгын ажлын зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан хуулийн этгээд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ:

20.3.1.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил эрхлэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд:

20.3.1.а.хүний нөөцийн талаарх мэдээлэл;
20.3.1.б.багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт;
20.3.1.в.тусгай зөвшөөрлийн сунгалт хийлгэх хуулийн этгээдийн хувьд үйл ажиллагааны тайлан болон нормчлолын сангийн шимтгэл төлсөн баримт.

20.3.2.даацын хийц, бүтээц, эдлэхүүн, материал, түүний түүхий эд болон шатамхай, химийн хортой, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд:

20.3.2.а.барилгын материал үйлдвэрлэгч хуулийн этгээдийн тохирлын гэрчилгээ;

20.3.2.б.тусгай зөвшөөрлийн сунгалт хийлгэх болон нэмэлт ажлын төрлөөр хүсэлт гаргах аж ахуйн нэгж, байгууллагын хувьд үйл ажиллагааны тайлан.

20.3.3.Барилгын ажлын зөвшөөрөл хүссэн өргөдөлд:

20.3.3.а.барилга байгууламжийн байршил, газрын бүртгэлийн мэдээлэл, загвар зураг, техникийн нөхцөлийг баталгаажуулсан шийдвэр;

20.3.3.б.барилга байгууламжийн магадлал хийгдсэн иж бүрэн зураг төсөл, магадлалын дүгнэлт;

20.3.3.в.байгаль орчны хууль тогтоомжийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай барилга байгууламжийн үнэлгээний тайлан;

20.3.3.г.гэнэтийн ослын болон хариуцлагын даатгалд даатгуулсан баримт;

20.3.3.д.барилгын ажлын захиалагч, гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл;

20.3.3.е.төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхыг нотлох баримт.

20.3.4.энэ хуулийн 10.1.5, 20.2-т заасан зөвшөөрөл хүссэн өргөдөлд:

20.3.4.а.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг хэлэлцүүлсэн холбогдох мэргэжлийн зөвлөлийн шийдвэр;

20.3.4.б.барилга байгууламжийн ажлын зураг төсөлд хийсэн магадлалын дүгнэлт;

20.3.4.в.өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар.”

2/21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг:

“21.2.Энэ хуулийн 21.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан ангилалын дагуу тавигдах нөхцөл, шаардлагыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.3, 20.6, 20.8, 20.12, 20.13 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.7, 27.8 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “зөвшөөрөл, бүртгэлийн” гэснийг “зөвшөөрлийн” гэж, 18.2 дахь хэсгийн “байгууламжийн барилгын ажлыг” гэснийг “байгууламж барих үйл ажиллагааг” гэж, 20.1 дэх хэсгийн “шийдвэрлэнэ.” гэснийг “шийдвэрлэж, зөвшөөрөл олгоно.” гэж, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсгийн “27.1.2” гэснийг “27.1.3” гэж, 30.5 хэсгийн, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсгийн “шаардлага, бүртгэх журмыг” гэснийг “шаардлагыг” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “бүртгэлийн” гэснийг, 20 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 20.1 дэх хэсгийн “тусгай” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалт, 27.8 дахь хэсгийн “27.1.2” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь заалтын “, хяналт тавих журмыг батлах” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.12 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, 28 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 33.1.25 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.8, 20.9 дэх хэсэг нэмсүгэй:

“20.8.Боловсролын сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад доор дурдсан шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг бүрдүүлж зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахим хэлбэрээр хүргүүлнэ:

20.8.1.гадаад хуулийн этгээд бол чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага, эсхүл олон улсын чанарын баталгаажуулалтын сүлжээ байгууллагад гишүүнчлэлтэй байх;

20.8.2.дотоодын хуулийн этгээд бол Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангасан мэргэжлийн нэгдсэн холбоо, мэргэжлийн холбоо байх.”

20.9.Энэ хуулийн 20.1 дэх хэсэг сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй этгээдэд нэгэн адил хамаарна.

2 дугаар зүйл.Боловсролын ерөнхий хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг:

“20.1.Энэ хуулийн 19.1-д заасан этгээд зөвшөөрөл авахдаа Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг хичээлийн жил эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахим хэлбэрээр хүргүүлнэ:”

2/20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2, 20.1.9 дэх заалт:

“20.1.1.боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөн байгуулах болон Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан зөвшөөрлийн үйл ажиллагаа эрхлэх талаарх үүсгэн байгуулагчийн шийдвэр;

20.1.2.сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, багшлах хүний нөөцийн боловсролын түвшин, цолны баримт бичгийн хуулбар;

20.1.9.боловсролын сургалтын байгууллагад гадаадын харьяат багш, удирдах ажилтан ажиллах тохиолдолд багшийн мэргэжлийн үнэмлэхийн хуулбар.”

3 дугаар зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.22 дахь заалтын “эрх бүхий байгууллагаас тогтоосон” гэснийг “чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллагаас тогтоосон” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.14 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 20.5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь заалтын “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 20 дугаар зүйлийн гарчигийн “, түүнд тавих шаардлага” гэснийг, мөн зүйлийн 20.5 дахь хэсгийн “20.1.3, 20.1.4, 20.1.5,” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 20.1.10-т заасан” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.4, 20.1.5, 20.1.10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.1.17, 7.1.18, 7.1.19, 7.1.20 дахь заалт:

“7.1.17.тав буюу түүнээс дээш гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байх;

7.1.18.энэ хуулийн 7.1.17-д заасан төлөөлөн удирдах зөвлөл дараах баримт бичгийг баталсан байна:

7.1.18.а.төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

7.1.18.б.компанийн дөрвөн жилийн бизнес төлөвлөгөө;

7.1.18.в.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, дотоод хяналтын хөтөлбөр;

7.1.18.г.мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;

7.1.18.д.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 7.2-т заасан журам;

7.1.18.е.дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахаас сэргийлэх, хяналт тавих журам;

7.1.18.ё.арилжааг урвуулан ашиглахаас сэргийлэх, хяналт тавих журам;

7.1.18.ж.үйл ажиллагааг түр зогсоох, хязгаарлалт тогтоох, татан буугдах, үйлчилгээ зогсох, кибер халдлага, түрэмгийлэлд өртөх зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө;

7.1.18.з.энэ хуулийн 6.1-д заасан үйлчилгээг эрхлэхтэй холбоотой үйл ажиллагааны журам.

7.1.19.виртуал хөрөнгийн үйлчилгээг шуурхай, тасралтгүй үзүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны онцлогт тохирсон дараах шаардлагыг хангасан программ хангамжтай байна:

7.1.19.а.арилжаанд оролцогчид нэгнийгээ таньж мэдэх боломжгүй байх;

7.1.19.б.харилцагчийн хувийн мэдээлэл гуравдагч этгээдээс нууц байх;

7.1.19.в.зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, шинэчлэх боломжтой байх;

7.1.19.г.олон нийтэд мэдээлэл хүргэх боломжтой байх;

7.1.19.д.арилжааны хяналтын системтэй байх;

7.1.19.е.албан ёсны лицензтэй аюулгүй байдлыг хангах системтэй байх.

7.1.20.мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, нууцлалын хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны шаардлагыг тогтоосон Монгол Улсын стандартын сүүлийн хувилбарыг хангаж, хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байх;”

2/7 дугаар зүйлийн 7.2.5 дахь заалт:

“7.2.5.энэ хуулийн 8.7-д заасны дагуу Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох шаардлагыг хангасан байх.”

3/7 дугаар зүйлийн 7.8, 7.9, 7.10, 7.11 дэх хэсэг:

“7.8.Энэ хуулийн 7.1.18.з-д заасан журамд өөрийн программ хангамж дээр виртуал хөрөнгийг арилжих, арилжаанаас хасахтай холбогдох зохицуулалт, нийтэд санал болгох виртуал хөрөнгө гаргагч болон тухайн виртуал хөрөнгө, түүний танилцуулгад тавигдах шаардлага, виртуал хөрөнгө гаргагчийн биелүүлэх үүрэг, түүнд хүргүүлэх мэдээллийн агуулга, хугацаа, виртуал хөрөнгийг бүртгэлээс хасах нөхцөлийг тусгасан байна.

7.9.энэ хуулийн 7.1.4.а, 7.1.4.б, 7.1.4.в, 7.1.4.г-д заасан ажилтны чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

7.10.энэ хуулийн 7.1.4-т заасан ажилтан нь энэ хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шаардлагыг хангасан, хуульд өөрөөр заагаагүй бол ашиг сонирхлын зөрчил болон виртуал хөрөнгө гаргагч, эзэмшигч, харилцагчид хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэх тохиолдолд давхар ажил хавсран эрхлэхгүй.

7.11.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг Хороонд бичгээр, эсхүл цахимаар ирүүлнэ:

7.11.1.компанийн дүрмийн баталгаажуулсан хуулбар, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх тухай хувьцаа эзэмшигчийн шийдвэр;

7.11.2.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан болон тухайн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн талаарх баримт бичиг;

7.11.3.харилцагчийн мөнгөн хөрөнгийг өөрийн компанийн данснаас тусад нь харилцагчид үйлчилгээ үзүүлэхэд ашиглах зорилгоор банканд тусгайлан нээсэн дансны талаарх мэдээлэл, банктай байгуулсан гэрээ;

7.11.4.Хороонд хүсэлт гаргахаас өмнөх хугацаанд үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээдийн хувьд сүүлийн 3 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, дүгнэлт, шинээр үүсгэн байгуулсан бол эхлэлтийн санхүүгийн байдлын тайлан;

7.11.5.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

7.11.6.эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээд нь энэ хуулийн 8.7-д заасны дагуу Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан талаарх баримт бичиг;

7.11.7.үйлчилгээний төрлөөс хамаарч харилцагчийн төлөх хураамжийн хувь хэмжээ, харилцагчтай байгуулах гэрээний төсөл;

7.10.8.үйл ажиллагаа явуулах ажлын байр нь компанийн өөрийн өмчлөлийнх бол үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, түрээсийн байр бол түрээсийн гэрээний баталгаажуулсан хуулбар;

7.10.9.энэ хуулийн 7.1-д заасан шаардлагыг хангасан талаарх баримт бичиг.

7.11.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгчийн үйл ажиллагаа явуулах ажлын байр, тоног төхөөрөмж, программ хангамж нь энэ хууль болон Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан эсэхийг Хорооны холбогдох албан тушаалтан газар дээр нь шалгаж, танилцаж болно.”

4/8 дугаар зүйлийн 8.7, 8.8 дахь хэсэг:

“8.7.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтныг өөрчлөх тохиолдолд энэ хууль болон Хорооноос тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянуулахаар холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

8.8.Хороо энэ хуулийн 8.7-д заасан баримт бичгийг бүрэн гүйцэд ирүүлснээр хянаж, шийдвэрлэнэ.”

5/10 дугаар зүйлийн 10.9.11 дэх заалт:

“10.9.11.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, заавар, аргачлал, маягт, стандартыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.”

6/11 дүгээр зүйлийн 11.3, 11.4, 11.5, 11.6, 11.7, 11.8, 11.9 дэх хэсэг:

“11.3.Энэ хуулийн 10.8-д заасан үйл ажиллагаа болон тухайлсан виртуал хөрөнгө, түүнтэй холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээнд Хорооноос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор хязгаарлалт тогтоож болно.

11.4.Энэ хуулийн 11.3-т заасан хязгаарлалтыг тогтооход хяналт шалгалт, бусад эрх бүхий байгууллагын дүгнэлт, зөвлөмж, мэдэгдэл, тодорхойлолтыг үндэслэнэ.

11.5.Энэ хуулийн 11.4-т заасан үндэслэл болсон шалтгаан, нөхцөл байдал арилсан гэж үзвэл Хороо хязгаарлалтаас чөлөөлнө.

11.6.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах тохиолдолд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг түдгэлзүүлнэ:

11.6.1.зөвшөөрлийн болон үйл ажиллагааны шаардлагыг зөрчсөн, эсхүл хангахгүй болсон;

11.6.2.Хороо, түүний эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүргийг биелүүлээгүй, эсхүл улсын байцаагчаас хүргүүлсэн албан шаардлагыг заасан хугацаанд хангаж ажиллаагүй;

11.6.3.Хороо, түүний эрх бүхий албан тушаалтан, эсхүл улсын байцаагчаас виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотойгоор удаа дараа хүргүүлсэн мэдэгдэл, анхааруулгын биелэлтийг хангаагүй;

11.6.4.гэмт хэрэг үйлдэх замаар үйл ажиллагаа эрхэлж байгаа талаар эрх бүхий этгээдээс үндэслэл бүхий мэдэгдэл ирүүлсэн.

11.6.5.Хороо болон түүний эрх бүхий албан тушаалтны шаардсан мэдээллийг хугацаанд гаргаж өгөөгүй болон алдаатай, зөрүүтэй, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн мэдээлэл ирүүлсэн;

11.6.6.энэ хуулийн 8.7-д заасны дагуу тохиромжтой этгээдийн шаардлагыг хангахгүй болсон.

11.7.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчингүй болсон компани энэ хуулийн 7.1.18.ж-д заасан төлөвлөгөө, харилцагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч, тайланг ажлын 20 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

11.8.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон тохиолдолд харилцагчийн зөвшөөрлөөр түүний виртуал болон мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийх виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрхийг хязгаарлахгүй.”

2 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

“6.2.Виртуал хөрөнгийг энэ хуулийн 6.1-д заасан үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр дамжуулахгүйгээр нийтэд санал болгох, худалдахыг хориглоно.”

2/7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт:

“7.1.4.дараах мэргэшсэн хүний нөөцтэй байх:

7.1.4.а.дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажилтантай байх;

7.1.4.б.мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан ажилтантай байх;

7.1.4.в.харилцагчийн үйлчилгээ хариуцсан ажилтантай байх;

7.1.4.г.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажилтантай байх ба хэрэгжилтэд хяналт тавих этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл байх;

7.1.4.д.энэ хуулийн 6.1-д заасан үйлчилгээг эрхлэхтэй холбоотой үйл ажиллагааг хариуцсан ажилтантай байх.”

3/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:

“7.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Хороо тогтооно.”

3 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “этгээдийг бүртгэх” гэснийг “этгээдэд зөвшөөрөл олгох” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргагч” гэснийг “үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч” гэж, мөн зүйлийн 7.1.17 дахь заалтын дугаарыг “7.1.21” гэж, мөн зүйлийн 7.2.5 дахь заалтын дугаарыг “7.2.6” гэж, мөн зүйлийн 7.5 дахь хэсгийн “7.2.3-т” гэснийг “7.2.3, 7.2.5-д” гэж, мөн зүйлийн 7.6 дахь хэсгийн “бүртгүүлээгүй” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “үйл ажиллагааг түр зогсоосон, эсхүл бүртгэлээс хассан” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “үзүүлэгч бүртгэлээс хасагдаж” гэснийг “үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болж” гэж, Гуравдугаар бүлгийн гарчгийн “БҮРТГЭЛ” гэснийг “ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ” гэж, 10 дугаар зүйлийн гарчгийн “ҮЗҮҮЛЭГЧИЙГ БҮРТГЭХ” гэснийг “ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ” гэж, мөн зүйлийн 10.1 дэх хэсгийн “үзүүлэх компани Хороонд хүсэлт гаргаж, бүртгүүлнэ” гэснийг “үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь өргөдлөө Хороонд гаргана” гэж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн “бүртгэх” гэснийг “зөвшөөрөл олгох” гэж, мөн зүйлийн 10.9.9 дэх заалтын “түр зогсоох, бүртгэлээс хасах” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох” гэж, мөн зүйлийн 10.13 дахь хэсгийн “үзүүлэгчээр бүртгэснийг” гэснийг “үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосныг” гэж, 11 дүгээр зүйлийн гарчгийн “БҮРТГЭЛЭЭС ХАСАХ” гэснийг “ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ” гэж, мөн зүйлийн 11.1 дэх хэсгийн “түр зогсоох, эсхүл бүртгэлээс хасна” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно” гэж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийн дугаарыг “11.10” гэж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийн “үзүүлэгчийг бүртгэлээс хассан” гэснийг “үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болсон” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “үзүүлэгчийг бүртгэх” гэснийг “үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “хүсэлт гаргагч болон хүсэлтэд дурдсан” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “Хороонд бүртгүүлсэн” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтын “виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл” гэснийг, мөн заалтын “хөрөнгө болон өөрийн” гэснийг, мөн заалтын “аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9, 7.1.10 дахь заалт, 7.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.6, 10.7 дахь хэсэг, 10.9.5, 10.9.10 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 70.4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 70.2, 70.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн зүйлийн 70.6 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрлийг” гэснийг “Зөвшөөрлийг” гэж, тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн гарчгийн, 70.1, 70.3, 70.4, 70.5 дахь хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай 58¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“58¹ дүгээр зүйл. Зөвшөөрөл

58¹.1. Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

58¹.2. Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан нийтлэг нөхцөл, шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

58¹.2.1. газар зохион байгуулагчийн бакалавр, эсхүл түүнээс дээш зэрэгтэй хоёроос доошгүй, газрын кадастрын бакалавр, эсхүл түүнээс дээш зэрэгтэй нэгээс доошгүй ажилтантай байх;

58¹.2.2. газар зохион байгуулагч нэг ажилтан нь мэргэшсэн инженер, эсхүл түүнээс дээш зэрэгтэй байх;

58¹.2.3. хөрс судлаач болон ургамал судлаачийн бакалавр, эсхүл түүнээс дээш зэрэгтэй хоёроос доошгүй ажилтантай байх.

58¹.3. Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 58¹.2-т заасан шаардлагыг хангасан баримт бичгийг бүрдүүлэн тусгай зөвшөөрлийн цахим системээр дамжуулан хүсэлтээ гаргана.

58¹.4. Зөвшөөрөл олгогдсон, сунгагдсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан хугацааны дотор гэрчилгээг олгоно.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг:

“19.4.Хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг тухай бүр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулна.”

2/20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалт:

“20.2.9.төрийн захиргааны байгууллагаас хайгуул, ашиглалтын талбайн геологийн судалгааны багц материал худалдан авсан баримт.”

2 дугаар зүйл. Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай;” гэснийг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу үнэлгээ хийж,” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Газрын тосны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 6, 8, 9 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 15 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “Засгийн газраас” гэснийг “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас” гэж, 42 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Галт зэвсгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, бүлэг нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.10 дахь хэсэг:

“11.10. Галт зэвсэг, сум ашиглан спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

11.10.1. энэ хуулийн 11.8 дахь хэсэгт заасан байгууллагын санал;

11.10.2. спорт-сургалтын төрөл, чиглэл, үйл ажиллагааны талаарх танилцуулга;

11.10.3. спорт-сургалтын зориулалтаар ашиглах буудлага үйлдэх шаардлага хангасан байгууламж /тир/-ийн танилцуулга;

11.10.4. өөрийн өмчлөлийн галт зэвсгийн нэр, төрөл, үйлдвэрлэсэн он, дугаарыг тодорхойлсон баримт бичгийн хуулбар, сумны төрөл, тоо, тэдгээрийн бүртгэл;

11.10.5. галт зэвсэг, сум хадгалах агуулахын дотоод зохион байгуулалт, галт зэвсэг, сум хадгалах шүүгээ /сав/-ний нарийвчилсан зураг, танилцуулга;

11.10.6. ажилтны галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;

11.10.7. галт зэвсэг, сум ашиглахад харшлах өвчин, гэмтэл согоггүйг тодорхойлсон эрүүл мэндийн хуудас;

11.10.8. харуул хамгаалалт, аюулгүй байдал хангасан талаарх баримт.”

2/ЗУРГАДУГААР БҮЛЭГ:

“ЗУРГАДУГААР БҮЛЭГ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАХ, ШАЛГАРУУЛАХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

21 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа

21.1. Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хуулийн этгээдэд олгоно.

21.2. Сонгон шалгаруулалтыг нээлттэй хэлбэрээр зохион байгуулах бөгөөд сонгон шалгаруулалтын зарыг 30-аас доошгүй хоногийн өмнө өдөр тутмын хоёроос доошгүй олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд байршуулна.

21.3. Сонгон шалгаруулалтын зард дараах мэдээллийг тусгана:

- 21.3.1. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлага;
- 21.3.2. энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан баримт бичиг;
- 21.3.3. сонгон шалгаруулалтын санал ирүүлэх, мэдээлэл авах хаяг;
- 21.3.4. сонгон шалгаруулалтын санал хүлээн авах эцсийн хугацаа.

22 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтад оролцох хуулийн этгээдэд тавигдах шаардлага

22.1. Галт зэвсэг, сум, тэдгээрийн дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

22.1.1. галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг хадгалах өөрийн өмчлөлийн агуулахтай байх;

22.1.2. галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл тээвэрлэх тусгайлан тоногдсон буюу бүхээгтэй, цоожтой, аюултай ачааны таних тэмдэгтэй, галд тэсвэртэй материалаар тоноглогдсон тээврийн хэрэгсэлтэй байх;

22.1.3. галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг экспортлогч талын, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчийн тодорхойлолттой байх;

22.1.4. гадаадын хөрөнгө оруулалтгүй, эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын иргэн байх;

22.1.5. гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх;

22.1.6. хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй, гааль, татвар, нийгмийн даатгалын байгууллагад болон шүүхийн шийдвэрийн дагуу иргэн, хуулийн этгээдэд төлөх өр төлбөргүй байх;

22.1.7. хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч болон гүйцэтгэх удирдлага нь ял шийтгүүлж байгаагүй байх;

22.1.8. галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлтэй харьцаж ажиллах ажилтнууд нь энэ хуулийн 9.1-д заасан насанд хүрсэн, сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэн байх;

22.1.9. буудлагын спорт-сургалтын үйл ажиллагаа эрхэлдэггүй байх.

22.2. Энэ хуулийн 22.1.1-д заасан сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдийн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг хадгалах агуулах нь дараах шаардлагыг хангасан байна:

22.2.1. хамгаалалтын болон галын дохиоллын систем, гал унтраагч, Монгол Улсын стандартад нийцсэн дуу, дүрсний төхөөрөмжөөр тоноглогдсон байх;

22.2.2. харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр хамгаалуулах;

22.2.3. агуулахын хаалга нь төмөр, дотор тал нь галд шатдаггүй материалаар хийгдсэн, давхар хаалга, лацтай байх;

22.2.4. нарны гэрэл шууд тусахгүй, ус чийгнээс хамгаалагдсан, агааржуулалтын систем, эсхүл дотор, гадна талаасаа төмөр хийцийн тороор хамгаалагдсан салхивчтай байх;

22.2.5. галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, дагалдах хэрэгслийн тавиур нь хананаас 40 см-ээс багагүй зайд шалнаас 20 см-ээс багагүй өндөрт байх;

22.2.6. агуулахад дагаж мөрдөх аюулгүй байдлыг хангах дотоод журамтай байх.

22.3. Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.2-т заасан сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх сонгон шалгаруулалтад оролцох хуулийн этгээд нь энэ хуулийн 22.2-т зааснаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

22.3.1. үйлдвэрлэх бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт, тодорхойлолт нь олон улсын стандартад нийцсэн байх;

22.3.2. түүхий эд нь чанар, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангасан байх;

22.3.3. сумны чанар шалгах буудлагын байр, гадна талбайтай байх;

22.3.4. байгаль орчны болон нийтийн эрүүл мэнд, орчны аюулгүй байдалд хяналт тавих үйл ажиллагааны төлөвлөгөө, заавартай байх;

22.3.5. үйлдвэрийн барилгатай байх;

22.3.6. төсөл хэрэгжүүлэх эдийн засгийн боломжтойг нотолсон төслийн товч танилцуулга, макро болон микро орчны судалгаа, төслийн зорилго, зорилт, үйлдвэрлэлийн төлөвлөлт, үйлдвэрлэл явуулах техник, технологийг ашиглахад шаардагдах мэргэжилтэн, боловсон хүчний төлөвлөлт, танилцуулга, маркетинг борлуулалтын болон санхүүгийн төлөвлөгөөтэй байх;

22.3.7. байгаль орчны төлөв байдлын судалгаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын болон нийтийн эрүүл мэнд, орчны аюулгүй байдлын ерөнхий болон нарийвчсан үнэлгээ хийлгэсэн байх.

22.4. Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.5-д заасан тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

22.4.1. өөрийн өмчлөлийн ажлын байр болон энэ хуулийн 22.2-т заасан агуулахтай байх;

22.4.2. энэ хуулийн 11.9-д заасан шаардлагад нийцсэн буудлага үйлдэх байгууламж буюу тиртэй байх;

22.4.3.галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл тээвэрлэх тусгайлан тоногдсон буюу бүхээгтэй, цоожтой, аюултай ачааны таних тэмдэгтэй, галд тэсвэртэй материалаар тоноглогдсон тээврийн хэрэгсэлтэй байх;

22.4.4.энэ зүйлийн 22.1.4, 22.1.5, 22.1.6-д заасан шаардлага хангасан байх.

23 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх баримт бичиг

23.1. Сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

23.1.1. хуулийн этгээдийг үүсгэн байгуулсанаас хойш явуулж байгаа үйл ажиллагааны болон үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

23.1.2. улсын хилээр оруулах, нийтэд худалдах галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн нэр, төрөл, марк, техникийн болон бусад үзүүлэлтийг заасан нийлүүлэгч хуулийн этгээдийн албан бичиг, эсхүл захидал;

23.1.3. үйлдвэрлэгч болон нийлүүлэгч байгууллагын тодорхойлолт, дэлгэрэнгүй танилцуулга;

23.1.4. банк, татвар, гааль, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа, тодорхойлолт;

23.1.5. эрх бүхий аудитын байгууллагаар баталгаажсан сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайлан, баланс;

23.1.6. галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл хадгалах агуулахтайг нотлох баримт бичиг, агуулахын байршил, дотоод зохион байгуулалт, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн тавиур, сум хадгалах шүүгээ, савны нарийвчилсан зураг, танилцуулга;

23.1.7. галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл тээвэрлэх тээврийн хэрэгслийн холбогдох баримт бичиг;

23.1.8. ажилтнуудын танилцуулга, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан гэрчилгээ;

23.1.9. харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ.

23.2. Сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээд нь энэ хуулийн 23.1-д заасан сонгон шалгаруулалтын баримт бичгийг зард дурдсан хугацаа, хаягаар хүргүүлэх бөгөөд тогтоосон хугацаанаас хожимдсон тохиолдолд хүлээж авахгүй.

24 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалт явуулах

24.1.Энэ хуулийн 16.3-т заасан Комисс нь оролцогч тус бүр энэ хуулийн 22-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, энэ хуулийн 23-т заасан баримт бичгийг бүрэн гүйцэд зохих журмын дагуу бүрдүүлсэн эсэхийг хянан үзнэ.

24.2.Комисс нь сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн баримт бичгийг хянан үзээд энэ хуульд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдийг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэн, санал, дүгнэлтээ гаргана.

24.3.Комисс нь баримт бичиг хүлээн авах хугацаа дууссан өдрөөс хойш ажлын 21 өдөрт багтаан сонгон шалгаруулалтыг хийж, санал, дүгнэлтээ гаргаж, Комиссын дарга нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

24.4.Комисс нь шалгарсан оролцогчид сонгон шалгаруулалтад шалгарсан тухай болон бусад оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг Комиссын санал, дүгнэлт гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор хүргүүлнэ.

25 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох

25.2.Энэ хуулийн 24.4-т заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Комиссын санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгоно.

25.3.Оролцогч нь Комиссын санал, дүгнэлтийг эс зөвшөөрвөл гомдлоо ажлын долоон өдрийн дотор хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргаж болно.

25.4.Гомдлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүлээн авснаас хойш Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 5.1-д заасан хугацаанд шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

25.5.Гомдол гаргасан хуулийн этгээд энэ хуулийн 25.4-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

26 дугаар зүйл.Сум үйлдвэрлэх, дахин цэнэглэхэд тавигдах шаардлага

26.1.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.2-т заасан сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

26.1.1.үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны техникийн шаардлага хангасан зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, лаборатори, энэ хуулийн 11.9-д заасан шаардлагад нийцсэн буудлага үйлдэх байгууламж буюу битүү тиртэй байх;

26.1.2.энэ хуульд заасан шаардлага хангасан зориулалтын агуулах, ачиж буулгах тусгай зориулалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй байх;

26.1.3.чанарын үзүүлэлт нь үндэсний болон олон улсын стандартын шаардлага хангасан байх;

26.1.5.гурваас доошгүй галт зэвсэг, сумны чиглэлээр мэргэшсэн ажилтантай байх;

26.1.6.цагдаагийн болон тагнуулын төв байгууллагын саналыг авсан байх;

26.1.7.байгаль орчинд болон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан, эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байх;

26.1.8.үйлдвэрийн байр, агуулахад гамшгийн эмзэг байдалд үнэлгээ хийлгэсэн байх.

26.2.Сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх хуулийн этгээд нь үйл ажиллагааны эрсдэл, албан хаагчийн амь нас, эрүүл мэндийг даатгуулсан байна.

26.3.Үйлдвэрлэсэн галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум, дахин цэнэглэлэгдсэн сумны сери /цуврал/ дугаар бүхий сав, баглаа боодолтой байх ба сери /цуврал/ дугаарыг цагдаагийн төв байгууллага олгож, хяналт тавина.

26.4.Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны сав, баглаа боодлын гадна талд үйлдвэрийн нэр, үйлдвэрлэсэн болон хадгалах баталгаат хугацаа, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны аюултайг анхааруулсан таних тэмдэгтэй байна.

26.5.Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэх үйлдвэрийг шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа үйлдвэр, барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөхөд Комиссын санал, дүгнэлтийг гаргуулна.

27 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

27.1.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ:

27.1.1.өөрийн эзэмшлийн газар, зориулалтын байр, тээврийн хэрэгсэл, мэргэжлийн ажиллах хүчин, гэрээт харуул хамгаалалтгүй хуулийн этгээдэд сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх тусгай зөвшөөрөл олгохгүй байх;

27.1.2.зориулалтын газарт сум үйлдвэрлэх, дахин цэнэглэхтэй холбоотой тэсэрч дэлбэрэх, шатамхай бодисыг хадгалах;

27.1.3.сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх хэрэгслийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх;

27.1.4.сумыг арилжааны зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд сурталчлахгүй байх;

27.1.5.сум, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодисыг тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийг аюулгүй байдлын удирдагч болон хамгаалалтын ажилтнаас бусад хүн дагалдан явахгүй байх;

27.1.6.сум үйлдвэрлэх, дахин цэнэглэхэд шаардлагатай түүхий эд материал, эд зүйлийг зориулалтын бусаар ашиглах, хадгалах, бусдад дамжуулан худалдах, шилжүүлэхгүй байх.

27.1.7.сумыг барьцаанд тавихгүй байх;

27.1.10.иргэнд сум, түүхий эд материал, эд зүйлийг үйлдвэрээс худалдахгүй байх.”

2 дугаар зүйл.Галт зэвсгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “зэвсгээ бүртгүүлж, 13 дугаар зүйлд заасан галт зэвсгийн гэрчилгээ авснаар” гэснийг “бүртгүүлснээр” гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “бүртгэх, галт зэвсгийн гэрчилгээ олгох эсэх асуудлаар” гэснийг “бүртгэж” гэж, 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсгийн “бүртгүүлж галт зэвсгийн гэрчилгээ авна” гэснийг “бүртгүүлнэ” гэж, “ЗУРГАДУГААР БҮЛЭГ” гэснийг “ДОЛДУГААР БҮЛЭГ” гэж, “21 дүгээр зүйл” гэснийг “28 дугаар зүйл” гэж, “22 дугаар зүйл” гэснийг “29 дүгээр зүйл” гэж, “23 дугаар зүйл” гэснийг “30 дугаар зүйл” гэж, “24 дүгээр зүйл” гэснийг “31 дүгээр зүйл” гэж, “25 дугаар зүйл” гэснийг “32 дугаар зүйл” гэж, “26 дугаар зүйл” гэснийг “33 дугаар зүйл” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Галт зэвсгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.10 дахь хэсгийн “Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Галт зэвсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.7 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.8-д” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.22-т” гэж, мөн зүйлийн 7.7 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 7.7 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.2.8 дахь заалтын “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Генетик нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурьдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/17 дугаар зүйлийн 17.4, 17.5, 17.6, 17.7, 17.8 дахь хэсэг:

“17.5. Бичил биетнийг улсын хилээр нэвтрүүлэх хүсэлтэд бичил биетэн, бичил биетний гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг хилээр нэвтрүүлэх талаар хүлээн авагч болон нийлүүлэгч талтай байгуулсан гэрээний хувь, гарал үүслийн гэрчилгээ, код, зүүлтийг хавсаргана.

17.6. Генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг 60 хоногийн хугацаатай олгож, нэг удаа 30 хоногийн хугацаагаар сунгана.

17.7. Энэ зүйлийн 17.1-д заасан зөвшөөрлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан журмын дагуу хүчингүй болгоно.

17.8. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олгосон зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг гаалийн болон татварын асуудал хариуцсан байгууллагатай хамтарч, улсын хилээр нэвтэрсэн генетик нөөцийн тоо хэмжээ, төлбөр, хураамжийн төлөлтийн байдалд хяналт тавьж ажиллана.”

2 дугаар зүйл. Генетик нөөцийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт:

“8.1.2.энэ хуульд заасан урьдчилсан тохиролцоо, биосоёлын тэмдэглэл, үр шимийн гэрээ, генетик нөөцийн материал дамжуулах гэрээ, газарзүйн гарал үүслийн тодорхойлолтын загварыг батлах;”.

2/17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:

“17.1. Генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

3 дугаар зүйл. Генетик нөөцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.4, 15.5, 15.11 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалт, 14 дүгээр зүйлийн гарчгийн “зөвшөөрөл” гэснийг “төхиролцоо” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “эзэмшигчээс урьдчилсан зөвшөөрөл авна.” гэснийг “эзэмшигчтэй урьдчилсан төхиролцоо хийнэ.” гэж, 14.2 дахь хэсгийн “урьдчилсан зөвшөөрөл авахыг” гэснийг “урьдчилсан төхиролцоо

хийхийг” гэж, 14.3 дахь хэсгийн “урьдчилсан зөвшөөрөл аваагүй” гэснийг “урьдчилсан тохиролцоо хийгээгүй” гэж, 14.4 дэх хэсгийн “урьдчилсан зөвшөөрөл авахын” гэснийг “урьдчилсан тохиролцоо хийхийн” гэж, 14.5 дахь хэсгийн “урьдчилсан зөвшөөрөл авах” гэснийг “урьдчилсан тохиролцоо хийх” гэж, 14.6 дахь хэсгийн “урьдчилсан зөвшөөрөл авснаар” гэснийг “урьдчилсан тохиролцоо хийснээр” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалтын “урьдчилсан зөвшөөрөл” гэснийг “урьдчилсан тохиролцоо” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Генетик нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн тухай хуульд доор дурдсан агуулгатай 5¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“5¹ дүгээр зүйл.Зөвшөөрөл

5^{1.1}.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

5^{1.2}.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл эзэмшигч Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан нийтлэг нөхцөл, шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

5^{1.2.1}.геодези, зураг зүйн бакалавр, түүнээс дээш зэрэгтэй нэгээс доошгүй ажилтантай байх;

5^{2.2.2}.таван сантиметрээс ихгүй дундаж квадрат алдаа бүхий геодезийн хэмжилтийн электрон тахеометр, эсхүл хиймэл дагуулаас байрлал тодорхойлох хоёр долгионы багажтай, таван миллиметрээс ихгүй хэмжилтийн нарийвчлалтай өндрийн хэмжилтийн багаж хэрэгсэлтэй байх.”

2 дугаар зүйл.Геодези, зураг зүйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.4 дэх хэсэг нэмсүгэй:

“21.4.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 6.1-д заасан эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагааг мэдэгдлээр эрхлэх бөгөөд цахимаар явуулна.”

2 дугаар зүйл. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “зөвшөөрөл авсан” гэснийг “баталсан маягтын дагуу мэдэгдэл хүргүүлсэн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.4, 7.5, 7.6 дахь хэсэг:

“7.4.Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

7.4.1.энэ хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангасан байх;

7.4.2.энэ хуульд заасан шаардлага хангасан наймаас доошгүй 60 хүртэлх насны харуул хамгаалалтын алба хаагчтай байх;

7.4.3.хуулийн этгээд нь гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх.

7.5.Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгуулахыг хүссэн хуулийн этгээд дараах шаардлага хангасан байна:

7.5.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй, гааль, татвар, нийгмийн даатгалын болон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр төлбөргүй байх;

7.5.2.нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй байх;

7.5.3.холбоо, дохиолол, техник, хэрэгсэлтэй байх;

7.5.4.харуул хамгаалалтын алба хаагч тус бүрийн энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан сургалтад хамрагдсан байх;

7.5.5.харуул хамгаалалтын алба хаагч тус бүрийн эрүүл мэндийн дүгнэлттэй байх;

7.5.6.харуул хамгаалалтын алба хаагч нь ял шийтгэлгүй байх.

7.6.Энэ зүйлийн 7.4, 7.5-д заасан баримт бичиг нь эрх бүхий байгууллагад байгаа, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системээс татан авах боломжтой бол иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.”

2/21 дүгээр зүйлийн 21.4, 21.5 дахь хэсэг:

“21.4.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах тохиолдолд түдгэлзүүлнэ:

21.4.1.харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд гэмт хэрэгт холбогдсон бол эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдсэн өдрөөс эхлэн уг тогтоолыг хүчингүй болгох, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох хүртэл хугацаагаар;

21.4.2.энэ хуулийн 6.1-д заасан шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

21.4.3.бусдыг мөрдөн мөшгөсөн, хүн, хуулийн этгээдийн талаар хууль бусаар баримт сэлт цуглуулсан, эсхүл гүйцэтгэх ажлын техник, хэрэгсэл ашигласан буюу ашиглахаар олж авсан болох нь эрх бүхий байгууллагаас тогтоосон.

21.5.Хуульд заасан түдгэлзүүлэх үндэслэл арилсан бол Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрлийг сэргээнэ.”

2 дугаар зүйл.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн гарчиг, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.2.1, 19.2.2, 19.2.3, 19.2.4, 19.2.5, 19.2.6, 19.2.7, 19.2.8 дахь заалт:

“19.2.1.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргаж, үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрэмд тусгасан байх;

19.2.2.хувь нийлүүлсэн хөрөнгө нь хууль ёсны эх үүсвэрээс бүрдсэн мөнгөн хөрөнгө байх бөгөөд Зохицуулах хорооноос тогтоосон доод хэмжээг хангасан байх;

19.2.3.хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

19.2.4.байнгын ажлын байр, техник, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;

19.2.5.хуульд зааснаас бусад тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл нь таваас доошгүй гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх;

19.2.6.гурваас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, даатгалын гомдол, маргааныг шийдвэрлэх, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдох харилцааг зохицуулсан журам, хүний нөөцийг хөгжүүлэх болон дотоод хяналтын бодлого, даатгалын хэлбэр тус бүрийн хувьд даатгалын зуучлагчид олгох даатгалын орлогын шимтгэлийн дээд хувь хэмжээг төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан байх;

19.2.7.эрхлэх даатгалын ангилал, хэлбэр, төрлийг тодорхойлсон байх;

19.2.8.зах зээлд борлуулах хоёроос доошгүй даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулсан байх.”

2/39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг:

“39.4.Зохицуулах хороо энэ хуулийн 39.1-д заасан зөвшөөрөл олгох чиг үүргээ Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-т заасан этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлж болно.”

3/60 дугаар зүйлийн 60.4 дэх хэсэг:

“60.4.Даатгагч нь оноосон нэр өөрчлөх тохиолдолд дараах баримт бичиг, мэдээллийг Зохицуулах хороонд мэдэгдлээр хүргүүлнэ:

60.4.1.хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

60.4.2.хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийсэн талаарх мэдээлэл;

60.4.3.компанийн шинэчилсэн дүрэмд холбогдох өөрчлөлт оруулсан талаарх мэдээлэл.”

2 дугаар зүйл.Даатгалын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/14 дүгээр зүйлийн 14.2.9 дэх заалт:

“14.2.9.актуарчийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага,”

2/21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг:

21.4.Даатгагч энэ хуулийн 21.3-т заасан үйлдэл хийх зөвшөөрөл хүссэн өргөдлийг Зохицуулах хороонд гаргах бөгөөд дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг хавсаргана:

21.4.1.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан байх;

21.4.2.компанийн шинэчилсэн дүрэмд холбогдох өөрчлөлтийг тусгасан байх;

21.4.3.хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэн байх;

21.4.4.шинэ хувьцаа эзэмшигч нь тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.”

3/33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг:

“33.2.Энэ хуулийн 33.1-д заасан зөвшөөрөл хүсэгч нь өргөдлийг дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийн хамт Зохицуулах хороонд гаргана:

33.2.1.аудитын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;

33.2.2.аудитын үйл ажиллагаа эрхэлж байгаа аудиторууд нь эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх.”

4/39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэг:

“39.2.Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь өргөдлийг дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийн хамт Зохицуулах хороонд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

39.2.1.эдийн засагч, статистикч, санхүүч, математикч, эдийн засгийн математик загварчлалын чиглэлээр аль нэг мэргэжлийг эзэмшсэн байх;

39.2.2.актуарчийн мэргэшлийн шалгалт, эсхүл түүнтэй дүйцэхүйц шалгалтыг өгч, тэнцсэн байх.”

4/54 дүгээр зүйлийн 54.1, 54.2 дахь хэсэг:

“54.1.Даатгагч өөрийн салбар, төлөөлөгчийн газраа нээх тохиолдолд дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг Зохицуулах хороонд мэдэгдлээр хүргүүлнэ:

“54.1.1.салбар, төлөөлөгчийн газар нээх тухай хувьцаа эзэмшигчдийн, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан байх;

54.1.2.салбар, төлөөлөгчийн газарт ажиллах удирдах болон бусад албан тушаалтныг томилсон байх;

54.1.3.байнгын ажлын байр, техник, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх.

54.2.Гадаадын даатгагч Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд энэ хуулийн 54.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан баримт бичгийг ирүүлсэн тохиолдолд Зохицуулах хороо зөвшөөрлийг олгоно:

54.2.1.салбар, төлөөлөгчийн газрын ажилтнуудын 50-аас доошгүй хувийг Монгол Улсын иргэдээс бүрдүүлсэн байх;

54.2.2.харьяалах улсын эрх бүхий төрийн байгууллагаас Монгол Улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн байх;

54.2.3.Монгол Улсын арилжааны банкны дансанд Зохицуулах хорооноос тогтоосон даатгалын баталгаа хөрөнгийг байршуулсан байх;

54.2.4.энэ хуулийн 19.2.7-д заасан шаардлагыг хангасан байх;

54.2.5.сүүлийн хоёр жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан, төлбөрийн чадвартай байх, санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх;

54.2.6.бүтэц, үйл ажиллагаа, борлуулах даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл, танилцуулгатай байх.”

5/55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэг:

“55.1.Даатгагч болон энэ хуулийн 12¹ дүгээр зүйлд заасан Холбоо нь даатгалын байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилж мэдээллийг мэдэгдлээр хүргүүлнэ.”

3 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлийн 12¹.9 дэх хэсгийн “зөвшөөрсөн” гэснийг “санал авч тусгасан” гэж, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “Зохицуулах хорооноос тогтоосон загварын дагуу энэ хууль болон даатгалын багц дүрэмд заасан” гэснийг “дараах шаардлагыг хангасан талаарх” гэж, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “аудиторыг” гэснийг “Зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан аудитын байгууллагыг” гэж, 39 дүгээр зүйл, мөн зүйлийн 39.1, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “эрх” гэснийг “зөвшөөрөл” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.15, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсэг:

“11.9. Зохицуулах хороо энэ хуулийн 8.1.1-д заасан зөвшөөрөл олгох чиг үүргээ Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-т заасан этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлж болно.”

2/13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг:

“13.4. Хүсэлтийг бичгээр, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр гаргах бөгөөд дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг хавсаргана:

13.4.1. салбар, төлөөлөгчийн газар нээх тухай хувьцаа эзэмшигчдийн, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан байх;

13.4.2. Монгол Улсын арилжааны банкны дансанд Зохицуулах хорооноос тогтоосон даатгалын баталгаа хөрөнгийг байршуулсан байх;

13.4.3. харьяалах улсын эрх бүхий төрийн байгууллагаас Монгол Улсын нутаг дэвсгэрт салбар, төлөөлөгчийн газар нээхийг зөвшөөрсөн байх;

13.4.4. сүүлийн хоёр жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан, төлбөрийн чадвартай байх, санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх;

13.4.5. салбар, төлөөлөгчийн газрын бүтэц, үйл ажиллагааны зорилго, төлөвлөгөөтэй байх, түүнд борлуулах даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл, танилцуулгыг нарийвчлан тусгасан байх;

13.4.6. салбар, төлөөлөгчийн газрын удирдлага нь тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.”

3/13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг:

“13.7. Энэ хуулийн дагуу зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулахдаа Зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд энэ хуулийн 10.1.5, 10.1.8, 13.4.1, 13.4.6-д заасан шалгуурыг хангасан талаарх баримт бичгийг хавсаргана.”

4/14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг:

“14.5.Даатгалын зуучлагч нь дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр дараах шаардлагыг хангасан баримт бичгийг Зохицуулах хороонд ирүүлнэ:

14.5.1.дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан байх;

14.5.2.компанийн шинэчилсэн дүрэмд холбогдох өөрчлөлтийг тусгасан байх;

14.5.3.хувь нийлүүлсэн хөрөнгө мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэн байх;

14.5.4.шинэ хувьцаа эзэмшигч нь тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.”

2 дугаар зүйл.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/10 дугаар зүйл:

“10 дугаар зүйл.Зөвшөөрөл авах хүсэлт гаргах

10.1.Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг Зохицуулах хороонд гаргана:

10.1.1.компани хэлбэртэй хуулийн этгээд байх;

10.1.2.даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргаж, үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрэмд тусгасан байх;

10.1.3.хувь нийлүүлсэн хөрөнгө нь хууль ёсны эх үүсвэрээс бүрдсэн мөнгөн хөрөнгө байх бөгөөд Зохицуулах хорооноос тогтоосон доод хэмжээг хангасан байх;

10.1.4.хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

10.1.5.байнгын ажлын байр, техник, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;

10.1.6.үйл ажиллагааны эрсдэл, хариуцлагаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр даатгуулсан байх;

10.1.7.хоёроос доошгүй даатгагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх;

10.1.8.даатгуулагч, үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх ажилтан нь сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх;

10.1.9.гурваас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, даатгалын гомдол, маргааныг шийдвэрлэх, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдох харилцааг зохицуулсан журам, хүний нөөцийг хөгжүүлэх болон дотоод хяналтын бодлого, даатгалын хэлбэр тус бүрийн хувьд даатгалын зуучлагчид олгох даатгалын орлогын шимтгэлийн дээд хувь хэмжээ зэргийг төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан байх.

10.2.Өргөдөл гаргагч нь банк бол энэ хуулийн 10.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг өргөдлийн хамт Зохицуулах хороонд гаргана:

10.2.1.даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд татгалзахгүй тухай Монголбанкны тодорхойлолтыг авсан байх;

10.2.2.банк нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгайлсан нэгжтэй байх ба даатгалын салбарт ажиллаж байсан туршлагатай нэгээс доошгүй ажилтантай байх.

10.3.Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5, 10.1.6-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг өргөдлийн хамт Зохицуулах хороонд гаргана:

10.3.1.хувь нийлүүлсэн хөрөнгө нь хууль ёсны эх үүсвэрээс бүрдсэн мөнгөн хөрөнгө байх бөгөөд Зохицуулах хорооноос тогтоосон доод хэмжээг хангасан байх;

10.3.2.хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөлтэй байх;

10.3.3.хоёроос доошгүй хөрөнгийн үнэлгээчинтэй байх;

10.3.4.хувьцаа эзэмшигч, үнэлгээчин, эрх бүхий албан тушаалтан нь даатгагч, даатгалын зуучлагчийн эрх бүхий албан тушаалтан биш байх;

10.3.5.даатгуулагчид үйлчилгээ үзүүлэх ажилтан нь даатгалын хохирол үнэлэгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх;

10.3.6.эрхлэх даатгалын хэлбэрээр хохирлын үнэлгээ хийх судалгаа, мэдээллийн санг бүрдүүлсэн байх.

10.4.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа мэдэгдлээр эрхлэх этгээд нь иргэн бол хүсэлтийг дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийн хамт Зохицуулах хороонд хүргүүлнэ:

10.4.1.тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

10.4.2.даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, мэргэшсэн байх;

10.4.3.төлөөлж ажиллах даатгагч болон эрхлэх даатгалын хэлбэрийг тодорхойлсон байх;

10.5. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа ажиллагаа мэдэгдлээр эрхлэх этгээд нь хуулийн этгээл бол хүсэлтийг энэ хуулийн 10.1.2, 10.1.4, 10.4.3-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийн хамт Зохицуулах хороонд хүргүүлнэ:

10.5.1. төлөөлж ажиллах даатгагч болон эрхлэх даатгалын хэлбэрийг тодорхойлсон байх;

10.5.2. даатгуулагчид үйлчилгээ үзүүлэх ажилтан нь даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх.”

2/13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсэг:

“13.3. Энэ хуулийн 13.1-д заасан зөвшөөрөл хүсэгч нь Зохицуулах хороонд өргөдөл гаргана.

13.4. Зөвшөөрөл хүсэгч нь зөвшөөрөл хүссэн өргөдлийг энэ хуулийн 10.1.5, 10.1.6, 10.1.8-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг Зохицуулах хороонд гаргана.”

4/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:

“20.2. Энэ хуулийн 20.1-д заасан зөвшөөрөл хүсэгч нь өргөдлийг Даатгалын тухай хуулийн 33.2.1, 33.2.2-т заасан шаардлагыг хангасан талаарх баримт бичгийг Зохицуулах хороонд гаргана.”

3 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн гарчигийн “Тусгай зөвшөөрөлгүйгээр” гэснийг “Зөвшөөрөлгүйгээр” гэж, мөн зүйлийн 9.4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 11, 12 дугаар зүйлийн гарчигийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “13.1-д заасан зөвшөөрлийг хүссэн өргөдлийг” гэснийг “13.1, 13.7-д заасан хүсэлтийг” гэж, мөн зүйлийн 13.6 дахь хэсгийн “13.1-д” гэснийг “13.1, 13.7-д” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “аудиторыг” гэснийг “Зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан аудитын байгууллагыг” гэж, 38, 39 дүгээр зүйлийн гарчигийн “Тусгай зөвшөөрлийг” гэснийг “Зөвшөөрлийг” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 7 дугаар зүйлийн 7.2, гуравдугаар бүлгийн гарчиг, 8 дугаар зүйлийн гарчиг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.1.1, 11.1.7, 11.2, 11.3, 11.3.1, 11.3.2, 11.3.7, 11.3.8, 11.4, 11.5, 11.6, 11.7 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1.5, 36.1.6 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.3, 38.4, 38.5, 38.6, 38.7, 38.8 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, 39.3, 39.4, 39.5 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.3 дахь хэсэг, мөн зүйлийн 40.4.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1.1 дэх заалтад заасан “тусгай” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.2, 20.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт:

“8.1.3.жолоодох эрхийн шалгалтыг зохион байгуулах.”

2/14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсэг:

“14.8.Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллага нь шалгалтад орох хүний мэдээллийг шалгалтад орохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө жолоочийн бүртгэл, мэдээллийн санд илгээсэн байна.”

3/14¹ дүгээр зүйл:

“14¹ дүгээр зүйл.Жолоодох эрхийн шалгалт авах

14¹.1.Жолоодох эрхийн шалгалтад орох хүн. доор дурдсан шаардлагыг хангасан байна:

14¹.1.1.Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох насанд хүрсэн байх;

14¹.1.2.эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн байх;

14¹.1.3.жолоодох эрхийн шалгалтад орох үнэлгээний хуудас авсан

байх;

14¹.1.4.“С” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтад орох тохиолдолд “В” ангиллын тээврийн хэрэгслийг 3 сараас доошгүй хугацаанд жолоодож дадлагажсан байх;

14¹.1.5.“D” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтад орох тохиолдолд “В” ангиллын тээврийн хэрэгслийг 6 сараас доошгүй хугацаанд жолоодож дадлагажсан байх;

14¹.1.6.“E” ангиллын нэмэлт эрх авах шалгалтад орох тохиолдолд тухайн үндсэн ангиллын тээврийн хэрэгслийг 6 сараас доошгүй хугацаанд жолоодож дадлагажсан байх.

14¹.2.Жолоодох эрхийн шалгалт нь онолын шалгалт болон жолоодох ур чадварыг тодорхойлох дадлага хийж гүйцэтгэх шалгалт бүрдэнэ. Жолоодох эрхийн шалгалтад “тэнцсэн”, “тэнцээгүй” гэсэн үнэлгээгээр дүгнэнэ.

14¹.3.Онолын шалгалтыг энэ хууль, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, тээврийн хэрэгслийг аюулгүй жолоодох онол, тухайн зам тээврийн осолд өртсөн хүнд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэгийг шалгах бөгөөд дараах байдлаар үнэлж, зохион байгуулна:

14¹.3.1.шалгалтыг цахимаар, эсхүл бичгийн хэлбэрээр авах;

14¹.3.2.шалгалт нь “В” ангилалд 20, “С”, “D” ангилалд нэмэлт 10 асуумжаар үнэлэх бөгөөд үргэлжлэх хугацаа 20 минут, нэмэлт мэдлэгийн тестээр авахад 10 минут байх;

14¹.3.3.техникийн болон цахилгааны саатлын улмаас цахим төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдвал шалгалтыг цахим хэлбэрээр өгч байгаа тухайн шалгуулагч дахин шалгалт өгөх;

14¹.3.4.шалгалтыг бичгэн хэлбэрээр авах тохиолдолд хариу тохироогүй, нэг нүдэнд нэгээс олон тоо бичсэн, гаргацгүй, давхардуулсан тэмдэглэл хийсэн бол алдаанд тооцох;

14¹.3.5.тухайн оногдсон тестийн 90, түүнээс дээш хувийг зөв хариулсан тохиолдолд тэнцсэнд тооцох;

14¹.3.6.урьд нь аль нэг ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх авч байгаагүй хүн “А”, эсхүл “М” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах тохиолдолд онолын ерөнхий шалгалт өгөх.

14¹.4.Жолоодох ур чадварын шалгалтыг “В” ангилалд замын хөдөлгөөнд, “А”, “С”, “D”, “E”, “М” ангилалд дадлагын талбайд тус тус авна.

14¹.5.Дадлагын талбайн жолоодлогын шалгалтыг дараах байдлаар үнэлж, зохион байгуулна:

14¹.5.1.“А” ангилалд цуваа байрлалтай таван туг сүлжих, наймын тоо хэлбэрийн зураас дээгүүр явах, 15 метрийн урт хяналтын шугамаар бага хурдтай явах;

14¹.5.2.“С” ангилалд ухрах үйлдлийг баруун, зүүн гар талаас гүйцэтгэж, зогсоолд байрлуулах, оврын хязгаарлалт бүхий хонгилоор гарах, ухрах, гүвээний өгсүүрт зогсож, өгсөж хөдлөх;

14¹.5.3.“D” ангилалд ухрах үйлдлийг баруун, зүүн гар талаас гүйцэтгэж зогсоолд байрлуулах, цуваа байрлалтай гурван туг сүлжих, хажуугийн зогсоолд зөв байрлуулах;

14¹.5.4.“BE”, “CE”, “DE” ангилалд ухрах үйлдлийг баруун, зүүн гар талаас гүйцэтгэж зогсоолд байрлуулах, цуваа байрлалтай гурван туг сүлжих, оврын хязгаарлалт бүхий хонгилоор гарах, ухрах;

14¹.5.5.“М” ангилалд оврын хязгаарлалт бүхий хонгилоор гарах, ухрах, гүвээний өгсүүрт зогсож, өгсөж хөдлөх.

14¹.5.6. талбайн жолоодлогын шалгалтын бүх үйлдлийг гүйцэтгэх хугацаа 10 минут бөгөөд хяналтын шон буюу хашлагыг мөргөх, шүргэх, унагаах, үйлдлийг эхний оролдлогоор гүйцэтгээгүй, эсхүл тээврийн хэрэгслийг хажуугийн зогсоолд багтаагаагүй, туг сүлжихдээ шон алгассан, ухрах байранд дутуу орж зогссон, гүвээний өгсүүрт зогсож, хөдлөхдөө ухарч алдсан, эсхүл хөдөлгүүрийг хоёр удаа унтраасан, эсхүл бүх үйлдлийг тогтоосон хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд тэнцээгүйд тооцно.

14¹.6. Замын хөдөлгөөний жолоодлогын шалгалтыг дараах байдлаар үнэлж, зохион байгуулна:

14¹.6.1. замын хөдөлгөөний түгжрэл, хязгаарлалт, техникийн саатал зэргээс шалтгаалан зогссон хугацааг тооцохгүйгээр шалгалтыг 10 минутаас багагүй хугацаанд авах;

14¹.6.2. хөдөлгөөн эхлэх, чиг өөрчлөх, гүйцэж түрүүлэх, түр, эсхүл удаан зогсох үйлдлийг зөвхөн эрх бүхий албан тушаалтны удирдлагаар гүйцэтгэх бөгөөд тухайн үйлдлийг гүйцэтгэх боломж бүхий зайнаас, товч тодорхой, ойлгогдохуйц байдлаар өгөх;

14¹.6.3. замын хөдөлгөөний жолоодлогын шалгалтаар хөдөлгөөн эхлэх, чиг өөрчлөх, байрлан явах, хурд тохируулах, гүйцэж түрүүлэх, уулзвар, гарц, явган хүний гарц нэвтрэх, түр зогсох, тээврийн хэрэгслийг зогсоолд ухрааж байрлуулах үйлдлийг гүйцэтгэх ур чадварыг шалгах;

14¹.6.4. үйлдлүүдийг гүйцэтгэх явцын алдааг “-1”, “-3”, “-5” гэсэн оноогоор тооцож дүгнэх бөгөөд онооны нийлбэр “-5” буюу түүнээс хэтэрсэн тохиолдолд тэнцээгүйд тооцох;

14¹.6.5. зогсоолын тоормостой хөдөлсөн, ар талыг харах толь ашиглаагүй, чиг заах дохио өгөөгүй, эсхүл буруу өгсөн, эсхүл хөдөлгөөн эхлэхдээ болон хөдөлгөөний үед хөдөлгүүр унтраасан тохиолдолд “-1” оноо өгөх;

14¹.6.6. хамгаалах бүс бүслээгүй, эгнээ байр эзлэх журам зөрчсөн, буцаж эргэх үйлдлийг буруу гүйцэтгэсэн, замын тэмдэглэлийн заалт зөрчсөн, хэт удаан явсан, түр зогсох үйлдлийг буруу гүйцэтгэсэн, зогсоолд ухрааж байрлуулах үйлдлийг эхний оролдлогоор бүрэн гүйцэд зөв гүйцэтгээгүй тохиолдолд “-3” оноо өгөх;

14¹.6.7. гэрэл, зохицуулагчийн дохио, замын тэмдгийн заалт зөрчсөн, давуу эрх бүхий тээврийн хэрэгсэлд зам тавьж өгөөгүй, хориглосон нөхцөлөөр эсрэг урсгал сөрсөн, гүйцэж түрүүлэх журам зөрчсөн, явган хүний гарц нэвтрэхдээ явган зорчигчид зам тавьж өгөөгүй, төмөр замын гарам нэвтрэх журам зөрчсөн, хурд хэтрүүлсэн, шаардлагатай тохиолдолд зогсоох арга хэмжээ авч чадаагүй тохиолдолд “-5” оноо өгнө.

14¹.7. Венийн конвенцийн гишүүн бус орноос олгогдсон жолоочийн эрхийн үнэмлэхтэй хүн онолын ерөнхий мэдлэгийн шалгалтад хамрагдах бөгөөд ур чадварын шалгалт шаардахгүй.

14¹.8. Шалгалтыг онол, дадлага гэсэн дарааллаар зохион байгуулах бөгөөд эхний шалгалтад тэнцээгүй хүнийг дараагийн шатны шалгалтад хамруулахгүй.

14¹.9.Шалгалтад тэнцээгүй хүн дахин шалгалт өгөх эрхтэй бөгөөд шалгалт хоорондын хугацаа 7 хоногоос багагүй байна.

14¹.10.Онолын шалгалтад тэнцсэнээс хойш 6 сарын хугацаанд дадлагын шалгалтад тэнцээгүй, хамрагдаагүй тохиолдолд шалгалтад тэнцсэн үнэлгээ хүчингүй болно.

14¹.11.Хөгжлийн бэрхшээлтэй хүнээс жолоодох эрхийн шалгалт авах тохиолдолд энэ хуулийн 21.1, 21.2-т заасан шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр шалгалтыг авч, жолоочийн үнэмлэхийн тусгай тэмдэглэлд тусгана.

14¹.12.Жолоодох эрхийн шалгалтад хамрагдаж байгаа шалгуулагч бусдаас туслалцаа авах, техник хэрэгсэл, материал ашиглахыг хориглох бөгөөд зөрчсөн тохиолдолд эрх бүхий албан тушаалтан “тэнцээгүй” үнэлгээг өгнө.

14¹.13.Дадлагын шалгалтад ашиглах тээврийн хэрэгсэл, дадлагын талбай нь Монгол Улсын стандартыг хангасан байна.

14¹.14.Эрх бүхий албан тушаалтан замын хөдөлгөөний жолоодлогын шалгалтыг жолоочийн хажуугийн суудлаас өөрийн шууд удирдлага, хяналтын дор авах бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүргийг хариуцаж, үнэлгээг баримтжуулан тэмдэглэл үйлдэнэ.”

4/15 дугаар зүйлийн 15.1.4 дэх хэсэг:

“15.1.4.гадаад улсын жолоодох эрхийн үнэмлэх солих тохиолдолд Монгол хэл дээр хөрвүүлсэн баталгаат орчуулга, тухайн улсаас олгогдсон жолоодох эрхийн үнэмлэхийг үнэн зөв эсэхийг тодорхойлох баримт бичиг.”

5/15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг:

“15.5.Монгол Улсад суугаа Элчин сайдын яам болон Консулын газрын дипломат төлөөлөгч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хүсэлтийг үндэслэн түүнд жолоочийн үнэмлэхтэй нь тохирох ангиллын үндэсний жолоочийн үнэмлэхийг олгож болно.”

6/18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг:

“18.3.4.шүүх болон эрх бүхий албан тушаалтны эрхийг сэргээх тухай шийдвэр гарсан.”

2 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “10 жил,” гэсний дараа “гадаад орны жолоодох эрхийн үнэмлэхийг сольж олгохдоо тухайн орны үндэсний жолоодох эрхийн үнэмлэхийн хүчинтэй хугацаагаар,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт:

“10.1.3.жолоочийн бүртгэл, мэдээллийн санд жолоодох эрхийн үнэмлэх шинээр, эсхүл нөхөн авах, ангилал нэмэх, жолоодох эрхийг хасах, сэргээх, олон улсын жолоодох эрхийн үнэмлэх болон түр зөвшөөрөл олгох бүртгэл, мэдээллийг хамруулах;”

2/15 дугаар зүйлийн 15.3, 15.4 дэх хэсэг:

“15.3.жолоодох эрхийн болон олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийг олгох, бүртгэх ажлыг цагдаагийн байгууллага хариуцах бөгөөд Монгол Улсын болон олон улсын жолоочийн үнэмлэхийг өөрт нь, эсхүл итгэмжлэл бүхий иргэн, хуулийн этгээдэд олгож болно.”

15.4.Жолооны багшийн үнэмлэхийн загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, жолоодох эрхийн үнэмлэхийн загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.”

3/18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг:

“18.4.Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцод нэгдэн орсон улсын иргэнд олгосон жолоодох эрхийн буюу олон улсын жолоодох эрхийн хүчин төгөлдөр үнэмлэх бүхий гадаад улсын иргэн тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасахаар заасан зөрчил үйлдсэн тохиолдолд үнэмлэхийг хураан авч, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж, жолоодох эрхийн үнэмлэхийг холбогдох шийдвэрийн хамт цагдаагийн төв байгууллага, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.”

4/24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг:

“24.2.Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх байгууллага, тээврийн хэрэгслийн цахим мэдээллийн санг цагдаагийн байгууллага хариуцан хөтөлнө.”

4 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтын “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалтын “зөрчлийн бүртгэлийн оноо тооцох” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, мөн зүйлийн 18.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 17 дугаар зүйлийн 17.3.4 дэх заалтын “үзүүлэгчээр бүртгүүлээгүй” гэснийг “үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.2.9, 7.2.10, 7.2.11, 7.2.12 дахь заалт:

“7.2.9. Амьтны тухай хуулийн 29¹.13 дугаар зүйлд заасан дуудлага худалдаанаас олсон орлого;

7.2.10. Ойн тухай хуулийн 38¹.25 дугаар зүйлд заасан дуудлага худалдаанаас олсон орлого;

7.2.11. Байгалийн нөөц ашиглах эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, мэргэжлийн байгууллагын эрхийн бичиг болон гэрчилгээг зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтийн дагуу цаасан хэлбэрээр хэвлүүлсэн тохиолдолд баримт бичиг хэвлүүлсний төлбөрийн орлого;

7.2.12. Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамжийн орлого.”

2/7 дугаар зүйлийн 7.3.14, 7.3.15 дахь заалт:

“7.3.14. ой, амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, судалгаа шинжилгээ, нөхөн сэргээх;

7.3.15. тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, судалгаа шинжилгээ хийх.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тусгай зөвшөөрөл, бүртгэл, эрхгүйгээр” гэснийг “зөвшөөрөлгүйгээр” гэж, 11.33 зүйлийн 1 дэх хэсгийн “бүртгэлгүй” гэснийг “зөвшөөрөлгүй” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “үзүүлэгчээр бүртгүүлсэн” гэснийг “үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“23.3.Монголбанк энэ хуулийн 23.2, 23.9-д заасан өргөдөл, холбогдох баримт бичгийг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 60 хоногийн дотор зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх, 30 хоногийн дотор сунгах эсэх асуудлыг хянан шийдвэрлэж, шийдвэр гарсанаас хойш ажлын гурав хоногийн дотор бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр хариу өгнө.”

2 дугаар зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.7 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд доор дурдсан агуулгатай 10¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“10¹ дүгээр зүйл.Зөвшөөрөл

10^{1.1}.Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

10^{1.2}.Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан нийтлэг нөхцөл, шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

10^{1.2.1}.газрын кадастрын бакалавр, эсхүл түүнээс дээш зэрэгтэй хоёроос доошгүй, газар зохион байгуулагчийн бакалавр, эсхүл түүнээс дээш зэрэгтэй нэгээс доошгүй ажилтантай байх;

10^{1.2.2}.газрын кадастрын нэг ажилтан нь лэнд менежер программ хангамжийн сургалтад хамрагдсан байх.

10^{1.3}.Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 10^{1.2}-т заасан шаардлагыг хангасан баримт бичгийг бүрдүүлэн тусгай зөвшөөрлийн цахим системээр дамжуулан хүсэлтээ гаргана.

10^{1.4}.Зөвшөөрөл олгогдсон, сунгагдсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан хугацааны дотор гэрчилгээг олгоно.”

2 дугаар зүйл.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5.10 дахь заалтын “тусгай” гэснийг хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, 9.2.5 дахь заалт, 9.3, 9.7, 9.13, 9.14 дэх хэсэг, 9.14.1, 9.14.3, 9.14.4 дахь заалтын “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 9.2.5 дахь заалтын “12.10” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**МАЛ, АМЬТНЫ ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.13 дахь хэсэг нэмсүгэй:

“11.13. Нийслэлийн Засаг дарга энэ хуульд заасан бүрэн эрхээ дүүргийн засаг даргад шилжүүлж болно.”

2 дугаар зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “үйл ажиллагааг” гэсний дараа “энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрлийн үндсэн дээр” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын “байх” гэсний дараа “бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь баримтаар тодорхойлж, нотлох боломжтой хууль ёсны орлого байх” гэж, 5.1.8 дахь заалтын “байх” гэсний дараа “бөгөөд тус санд мэдээлэл илгээх, хүлээн авах, дотоод бүртгэл мэдээллийг хөтлөх боломжтой компьютер, техник, тоног төхөөрөмжтэй байх” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:

“11.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 9.1-д заасан, Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн 9.2-т заасан өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авч Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан хугацаанд хянаж, шаардлага хангасан өргөдөл гаргагчид мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно.

2/13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг:

“13.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

13.2. Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, энэ тухай мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мэдэгдэнэ.”

4 дүгээр зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “иргэнийг бүртгэх” гэснийг “иргэнд зөвшөөрөл олгох” гэж, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “этгээдэд бүртгүүлсний” гэснийг “этгээдээс олгосон зөвшөөрлийн” гэж, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн” гэснийг “Мөнгөн” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “этгээдээр бүртгүүлээгүй” гэснийг “зөвшөөрөлгүй” гэж, Гуравдугаар бүлгийн

гарчгийн “ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ” гэснийг “ЗӨВШӨӨРӨЛ” гэж, 9 дүгээр зүйлийн гарчгийн “этгээдээр бүртгүүлэх” гэснийг “зөвшөөрлийн” гэж, мөн зүйлийн 9.1 дэх хэсгийн “этгээд аймаг, нийслэлийн Засаг даргад өргөдөл гаргаж бүртгүүлнэ” гэснийг “этгээдэд аймаг, нийслэлийн Засаг дарга зөвшөөрөл олгоно” гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн “хуулийн этгээд Санхүүгийн зохицуулах хороонд өргөдөл гаргаж бүртгүүлнэ” гэснийг “хуулийн этгээдэд Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөл олгоно” гэж, 11 дүгээр зүйлийн гарчгийн “этгээдийн бүртгэл” гэснийг “этгээдэд зөвшөөрөл олгох” гэж, мөн зүйлийн 11.2 дахь хэсгийн “Бүртгэлд бүртгүүлсэн мөнгөн” гэснийг “Мөнгөн” гэж, мөн зүйлийн 11.3 дахь хэсэг, 11.4 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 25.5 дахь хэсгийн “бүртгэх байгууллага” гэснийг “зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэж, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “бүртгэх байгууллага тухайн өргөдөл гаргагчийг бүртгэхээс” гэснийг “зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоос” гэж, мөн зүйлийн 11.5 дахь хэсгийн “бүртгэх байгууллага өргөдөл гаргагчийг бүртгэхээс” гэснийг “зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд өргөдөл гаргагчид зөвшөөрөл олгохоос” гэж, мөн зүйлийн 11.6 дахь хэсгийн “Бүртгэх байгууллага” гэснийг “Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэж, 11.10 дахь хэсгийн “Бүртгэх байгууллага энэ хуулийн 11.1-д заасан бүртгэлийг Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлийн” гэснийг “Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд энэ хуулийн 11.1-д заасан зөвшөөрлийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн” гэж, мөн зүйлийн 11.11 дэх хэсгийн “Бүртгэх байгууллага энэ хуулийн 11.1-д заасан бүртгэлтэй” гэснийг “Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд энэ хуулийн 11.1-д заасан зөвшөөрөлтэй” гэж, 12 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 12.1 дэх хэсгийн “Бүртгэлд бүртгүүлээгүй” гэснийг “Зөвшөөрөлгүй” гэж, 13 дугаар зүйлийн гарчгийн “бүртгэлд” гэснийг “мэдээлэлд” гэж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “харьяалах бүртгэх байгууллагад даруй мэдэгдэж, гэрчилгээг хураалгана” гэснийг “зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийн “бүртгэх байгууллагад” гэснийг “зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд” гэж, 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсгийн “харьяалах бүртгэх байгууллагад” гэснийг “Санхүүгийн зохицуулах хороонд” гэж, 25 дугаар зүйлийн гарчгийн “этгээдийн бүртгэлийг” гэснийг “зөвшөөрлийг” гэж, мөн зүйлийн 25.1 дэх хэсгийн “Харьяалах бүртгэх байгууллага” гэснийг “Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэж, мөн хэсгийн “бүртгэлийг” гэснийг “зөвшөөрлийг” гэж, мөн зүйлийн 25.1.7 дахь заалтын “гэрчилгээгээ хураалгасан” гэснийг “үйл ажиллагаагаа зогсоосон” гэж, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “бүртгэх байгууллагад бүртгүүлнэ” гэснийг “зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авна” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7, 11.8, 11.9, 11.12, 14 дүгээр зүйл, 25 дугаар зүйлийн 25.4 дүгээр хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.6. Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 8.1-д заасан шийдвэр гаргахаас өмнө хүсэлт гаргагч, өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон бусад этгээдээс тайлбар авах, нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл гаргуулах, шинжээч томилон ажиллуулж болно.

8.7. Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхтэй холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.”

2 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсэгт “Улсын дээд шүүхэд” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагад” гэж, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 дэх хэсгийн “Улсын дээд шүүх” гэснийг “Улсын бүртгэлийн байгууллага” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн” гэснийг “улсын бүртгэлийн байгууллагын” гэж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүх” гэснийг “улсын бүртгэлийн байгууллага” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэснийг “Улсын бүртгэлийн байгууллага” гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн Тамгын газар” гэснийг “улсын бүртгэлийн байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн “батална.” гэснийг “баталж, стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийн тохирлын гэрчилгээ олгоно.” гэж, мөн зүйлийн 19.7 дахь хэсгийн “газрыг магадлан итгэмжлэх болон түүний” гэснийг “газрын” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нотариатын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.6, 7.7, 7.8, 7.9 дэх хэсэг:

“7.6. Нотариатч тойрог шилжих хүсэлтээ хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд бичгээр гаргана.

7.7. Энэ хуулийн 7.6-д заасан тойрог шилжих нотариатч дараах шаардлагыг хангасан байна:

7.7.1. нотариатын үйл ажиллагаа эрхэлж байгаа тойрогтоо гурваас доошгүй жил ажилласан байх;

7.7.2. нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй байх;

7.7.3. сахилгын шийтгэлгүй байх.

7.8. Энэ хуулийн 15.1-д заасан Мэргэшлийн хороо нь энэ хуулийн 7.4-т заасан мэргэшлийн шалгалт өгсөн нотариатчийн шалгалтын дүн, мэргэшил, ур чадварын түвшинг үнэлсэн дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

7.9. Засгийн газрын гишүүн нотариатчийн тойрог шилжүүлэхдээ энэ хуулийн 7.10-д заасныг үндэслэж, хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан үзэж болно.

7.10. Энэ хуулийн 7.9-д заасан хүндэтгэн үзэх шалтгаанд нотариач өөрөө, эсхүл нөхөр /эхнэр/, төрсөн, үрчлэн авсан хүүхэд, өөрийн болон нөхөр /эхнэр/-ийн эцэг, эх нь хүнд өвчтэйн улмаас асран хамгаалах шаардлагатай зайлшгүй шалтгааныг хамруулах бөгөөд холбогдох баримтаар нотлогдсон байна.”

2/14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг:

“14.2. Мэргэшлийн шалгалтын зардлын бүртгэлийн хураамж, нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргахтай холбогдсон зардал болон Мэргэшлийн хорооны гишүүдэд олгох урамшууллыг Монголын Нотариатчдын танхимаас тус тус санхүүжүүлнэ.”

3/15 дугаар зүйлийн 15.9, 15.10, 15.11 дэх хэсэг:

“15.9.Мэргэшлийн хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно. Мэргэшлийн хороо хэлэлцсэн асуудлаараа тогтоол, дүгнэлт гаргаж холбогдох байгууллага, этгээдэд танилцуулна. Мэргэшлийн хороо хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана.

15.10.Мэргэшлийн хорооны хуралдааны тэмдэглэлийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нотариатын асуудал хариуцсан ажилтан хөтөлнө. Мэргэшлийн хорооны хуралдааны тэмдэглэлд хуралдаан даргалагч, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурснаар баталгаажна. Тэмдэглэлд тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг бүрэн тусгаж, холбогдох баримт бичгийг хавсаргана.

15.11.Мэргэшлийн хороо мэргэшлийн шалгалт явуулахтай холбогдуулж дараах эрх, үүрэгтэй байна:

15.11.1.мэргэшлийн шалгалтад хуульчдын бүртгэлийг баталгаажуулах;

15.11.2.мэргэшлийн шалгалт явуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах;

15.11.3.мэргэшлийн шалгалтыг товлосон хугацаанд явуулах;

15.11.4.мэргэшлийн шалгалтад оролцогчдоос ирүүлсэн баримт бичиг зохих шаардлагыг хангаж буй эсэхийг шалгаж, түүнийг мэргэшлийн шалгалтад оруулах эсэх асуудлыг шийдвэрлэх;

15.11.5.мэргэшлийн шалгалтын сорилго, бодлогыг боловсруулах, нууцлалыг хариуцах;

15.11.6.шалгалтад орох тухай хүсэлт, хуульчийн баримт бичгийн үнэн зөв байдлыг шалгах зорилгоор шаардлагатай лавлагаа, мэдээллийг гаргуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлт гаргах, хүсэлт гаргагчаас шаардах;

15.11.7.мэргэшлийн шалгалтын дүнг гаргаж, оролцогчдод мэдээлэх;

15.11.8.шалгалтад оролцогч нь хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд шалгалтыг хүчингүй болсонд тооцох;

15.11.9.бүртгэлийн хураамжийн хэмжээг тогтоох.”

4/15¹ дүгээр зүйл:

“15¹ дүгээр зүйл.Нотариатын мэргэшлийн шалгалт зохион байгуулах, дүгнэх

15¹.1.Мэргэшлийн хороо нь Нотариатын мэргэшлийн шалгалтын товыг энэ хуулийн 15.8-д заасан хугацаанд мэргэшлийн шалгалт явуулах газар, хугацаа, мэргэшлийн шалгалтад оролцогчдоос бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийн бүрдүүлбэрийн жагсаалт, бүртгүүлэх хэлбэр, сул орон тоо гарсан тойрог, шаардлагатай тохиолдолд тойргийн нутаг дэвсгэрийн хүрээн дэх тодорхой байршлын талаарх мэдээлэл агуулсан зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлана.

15¹.2.Мэргэшлийн шалгалтын товыг олон нийтэд зарласан өдрөөс хойш ажлын 7 өдөрт багтаан бүртгэлийг эхлүүлнэ. Бүртгэлийн үргэлжлэх хугацаа 30 хоног байна. Хугацаа хэтрүүлж ирүүлсэн хүсэлтийг бүртгэхгүй.

15¹.3.Хуульч нь шалгалтад орох шаардлагыг хангаж хүсэлтийг үнэн зөв бөглөсөн болохоо хариуцна.

15¹.4.Мэргэшлийн хороо нь энэ хуулийн 15.1.1-д заасан жагсаалтыг бүртгэл дууссанаас хойш 7 хоногт багтаан олон нийтэд мэдээлнэ.

15¹.5.Мэргэшлийн шалгалт, дүгнэх үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

15¹.6.Мэргэшлийн шалгалтын даалгаврын гүйцэтгэлийг тоогоор дугаарлах бөгөөд дугаартай холбогдох шалгалтад оролцогчийн нэр нууцлагдсан байна.

15¹.7.Мэргэшлийн хороо мэргэшлийн шалгалтын даалгаврын нууцлалыг шалгалт эхлэх хүртэл, түүний хариултын нууцлалыг шалгалт дуусах хүртэл хамгаална.

15¹.8.Мэргэшлийн шалгалт нь эрх зүйн ерөнхий мэдлэгийг сорьсон сорилгын болон эрх зүйн салбарын хүрээнд тодорхой тохиолдлыг хууль хэрэглэж шийдвэрлэх бодлогын шалгалтын хэлбэрээр явагдана.

15¹.9.Мэргэшлийн шалгалтад оролцогч сорилгын шалгалтын нийт онооны 60 ба түүнээс дээш хувийг авсан бол бодлогын шалгалтад орох эрхтэй болно.

15¹.10.Мэргэшлийн шалгалтад оролцогч нь бодлогын шалгалтын нийт онооны 60 ба түүнээс дээш хувийг авсан байвал зохино.

15¹.11.Сорилго, бодлогын нийт онооны 60 ба түүнээс дээш хувийг авсан хуульчийг шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

15¹.12.Бодлогыг дүгнэхдээ хариултын хууль зүйн үндэслэл, бүрэн хариулсан байдал, баримт бичгийн боловсруулалтын түвшинг харгалзана.

15¹.13.Хэрэв нэг тойрогт өрсөлдсөн шалгуулагчдын оноо тэнцсэн тохиолдолд бодлогын даалгаврыг илүү оноотой гүйцэтгэсэн шалгуулагчийг зарласан орон тоонд багтаана.

15¹.14.Бодлогын даалгаврыг шалгалт дууссан өдрөөс хойш ажлын гурван өдөрт багтаан дүгнэж, шалгалт дууссан өдрөөс хойш ажлын долоон өдөрт багтаан шалгалтын дүнг нэгтгэж, оролцогчдод мэдээлнэ.

15¹.15.Мэргэшлийн шалгалтад оролцогчийн шалгалтыг дараах тохиолдолд хүчингүй болсонд тооцно:

15¹.15.1.шалгуулж байгаа бусад оролцогчидтой харилцах, тэдэнд туслах буюу тусламж авах оролдлого хийсэн;

15¹.15.2.гүйцэтгэлийн хуудсанд зөвшөөрөгдсөнөөс бусад тэмдэглэгээ хийсэн, таних тэмдэг тавьсан, өөр өнгийн бэхээр бөглөсөн;

15¹.15.3.мэргэшлийн шалгалтад оролцохоор бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн буюу үнэн зөв мэдээлээгүй, эсхүл дутуу мэдээлэл өгсөн нь баримт бичгийг нягтлан шалгахад тодорхой болсон.

15¹.16.Мэргэшлийн хороо нь шалгалтын дүн гарсан өдрөөс хойш ажлын 15 хоногт багтаан шалгалтад тэнцсэн оролцлогчийн өргөдөлд дурдсан мэдээллийг баримтжуулж, баримт бичгийн үнэн зөв байдлыг нягтлан шалгаж үзсэний үндсэн дээр шалгалтын онооны дарааллыг харгалзан шалгалт зарлагдсан орон тоонд багтаан нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгуулах саналыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

15¹.17.Шалгалтад тэнцсэн боловч зарласан тойргийн орон тоонд багтаагүй хуульчийг бусад тойргийн зарласан сул орон тоонд зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

15¹.18.Мэргэшлийн хороо нь мэргэшлийн шалгалтын бүртгэлтэй холбоотой гомдол, энэ хуулийн 15¹.15-д заасан зөрчил, шалгалтыг хүчингүй болсонд тооцсон тогтоол болон шалгалтын дүнтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэнэ.

15¹.19.Хуульч мэргэшлийн шалгалтад оролцогчдын бүртгэлтэй холбоотой гомдлыг нэрсийн жагсаалтыг олон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор, сорилгын даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой гомдлыг шалгалт өгсөн өдрийн 20 цаг хүртэл, бодлогын даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой гарсан гомдлыг шалгалтын дүн гарсан өдрөөс хойш ажлын нэг өдрийн дотор, бусад гомдлыг шалгалт дууссан өдрөөс хойш 5 хоногийн дотор Мэргэшлийн хороонд тус тус бичгээр ирүүлнэ.

15¹.20.Гомдол гаргагч нь гомдолдоо үндэслэлээ тодорхой дурдаж, өөрийнхөө тавьж буй шаардлагын талаарх нотолгоо, бусад холбогдох баримтыг хавсаргана.

15¹.21.Мэргэшлийн хорооны дарга нь гомдлыг шалгах, хуралдаанд танилцуулах гишүүнийг томилж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай, шударгаар шалган, хорооны хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

5/15² дугаар зүйл:

“15² дугаар зүйл.Нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргах

15².1.Мэргэшлийн хороо нь нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшингийн талаар гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, хуульчийн гомдол, хүсэлтийг үндэслэн дүгнэлт гаргах эсэхийг хуралдаанаар олонхын саналаар шийдвэрлэнэ.

15².2.Мэргэшлийн хороо дараах тохиолдолд дүгнэлт гаргахгүй:

15².2.1.тухайн асуудалд хамаарах нотариатчийн үйлдлийн талаар шүүх болон эрх бүхий байгууллага хянаж, шийдвэр гаргасан бол;

15².2.2. тухайн асуудлыг энэ хуулийн 8.6-д заасан Сахилгын зөвлөл шалгаж байгаа бол;

15².2.3. нотариатч үйлдлийг гэрчилснээс хойш хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол.

15².3. Эрх бүхий байгууллагаас хүргүүлсэн шийдвэр, хуульчийн гомдол, хүсэлтийг Мэргэшлийн хорооны дарга гишүүдэд тойргийн журмаар хуваарилах ба хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт гаргана.

15².4. Нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргахдаа нотариатчийн хууль хэрэглэх, нотариатын үйлдэл хийх, баримт бичиг боловсруулах, эрх зүйн зөвлөгөө өгөх чадварыг бодлогын даалгавар гүйцэтгүүлэх, ярилцлага хийх замаар дүгнэнэ.

15².5. Нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинг үнэлсэн дүгнэлтэд Мэргэшлийн хорооны дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

15².6. Нотариатч мэргэшил, ур чадварын хувьд хангалтгүй, эсхүл тухайн асуудлаар мэргэшлийн алдаа гаргасан талаарх дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон хүсэлт гаргасан этгээд, нотариатчид хүргүүлнэ.

15².7. Нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинг үнэлсэн дүгнэлттэй холбогдох гомдлыг нотариатч хүлээн авснаас хойш ажлын 14 өдөрт багтаан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргаж болно.

15².8. Мэргэшлийн шалгалт, нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргахтай холбогдох баримт бичгийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын архивт хадгална.”

2 дугаар зүйл. Нотариатын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “Тойрог шилжих журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Нотариатын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.1.35 дахь заалт:

“13.1.35.ойн дагалт баялгийн нөөцийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх дээд хэмжээ, хугацааг аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр тогтоосон шийдвэр гаргах;”

2/14 дүгээр зүйлийн 14.3.26, 14.3.27, 14.3.28 дахь заалт:

“14.3.26.хуш модны самрын яс, идээний гарцыг тодорхойлох аргачлалыг батлах;

14.3.27.мод, сөөг нутагшуулах, тарималжуулахаар хийж байгаа туршилт, судалгаа, шилжүүлэх ажлын аргачлалыг батлах;

14.3.28.ойн дагалт баялгийн нөөцийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх дээд хэмжээ, хугацааг аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр тогтоосон саналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.”

3/38 дугаар зүйлийн 38.9, 38.10, 38.11, 38.12 дахь хэсэг:

“38.9.Ойн дагалт баялгийг нөөцөд тохируулан ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэнэ.

38.10.Ойн дагалт баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх нөөцийн дээд хэмжээг хуш модны самрын нийт нөөцийн 60 хувиас ихгүй, жимс, мөөгний нийт нөөцийн 40 хувиас ихгүй байхаар тогтооно.

38.11.Ойн дагалт баялгийн ахуйн зориулалтаар түүж бэлтгэх нөөцийн дээд хэмжээг хуш модны самар 50 кг, жимс, мөөг 20 кг, давирхай, хөвд, хөвх 10 кг, хатсан модны холтос, үйс 15 кг, хусны шүүс 5 литр хүртэл байхаар тогтооно.

38.12.Ойн дагалт баялгийг судалгаа, шинжилгээний зориулалтаар нэг удаа түүж бэлтгэх дээд хэмжээ 5 кг, хусны шүүс 3 литр хүртэл байна.”

4/38¹ дүгээр зүйл:

“38¹ дүгээр зүйл.Ойн дагалт баялагийн дуудлага худалдаа зохион байгуулах, улсын хилээр нэвтрүүлэх

38¹.1.Ойн дагалт баялгийн нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг Зөвшөөрөл, мэдэгдэлийн тухай хуулийн 5.6-д заасны дагуу дуудлага худалдааны журмаар олгоно.

38¹.2.Энэ хуулийн 38¹.1-д заасан дуудлага худалдааг аймаг, нийслэлийн Байгаль орчны газар цахимаар, эсхүл танхимын хэлбэрээр зохион байгуулахаар олон нийтэд мэдээлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зохион байгуулж ялагчийг тодруулах ба ялагчид ойн дагалт баялаг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.

38¹.3.Дуудлага худалдааг зохион байгуулах шийдвэр гарснаас хойш дуудлага худалдаа явуулах хэлбэр, он, сар, өдөр, цаг, байршил, хаягийг ажлын 5 өдрийн дотор олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

38¹.4.Дуудлага худалдааг дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх, дуудлага худалдааг явуулах, дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах гэсэн дарааллын дагуу зохион байгуулна.

38¹.5.Дуудлага худалдааг зохион байгуулахдаа оролцогч талууд үнийн саналаа ээлж дараалан өсгөх, сонгон шалгаруулалтын явц, үр дүн нээлттэй, ил тод, талуудын тэгш, шударга оролцоог хангасан байх зарчмыг баримтална.

38¹.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 13.1.35-д заасан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах нөөцийн дээд хэмжээнд багтаан дуудлага худалдаанд оруулах хуш модны самрын нөөцийн хэмжээг 70000 кг хүртэл бол 15000 кг, 70001 кг ба түүнээс дээш бол 20000 кг-аар тус тус багцлан явуулна.

38¹.7.Дуудлага худалдааг дараах байдлаар цахим хэлбэрээр зохион байгуулна:

38¹.7.1.дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаа явагдахаас ажлын 5 өдрийн өмнө дуудлага худалдааны хураамж болон дэнчин тушаасан баримтын хуулбарыг хавсарган, хүсэлтээ цахимаар илгээх;

38¹.7.2.дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаа эхлэхээс өмнө дуудлага худалдаа явуулах системд нэвтэрч тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлаа хангах;

38¹.7.3.үнийн санал өгөөд 30 секундын дотор өөр оролцогч үнэ өсгөөгүй тохиолдолд дуудлага худалдааны ялагч тодорсонд тооцох.

38¹.8.Дуудлага худалдааг танхимын хэлбэрээр зохион байгуулахад энэ зүйлийн 38¹.7.1-д заасан шаардлага хангасан оролцогч нь дуудлага худалдаа эхлэхээс 30 минутын өмнө дуудлага худалдаа зохион байгуулах танхимд ирсэн байна.

38¹.9.Нөөцийг бэлтгэх ойн талбайн тойм зургийг энэ хуулийн 38¹.6-д заасан багц тус бүрээр гаргана.

38¹.10.Дуудлага худалдаанд ойн дагалт баялаг ашиглах, хамгаалах мэргэжлийн байгууллага оролцоно.

38¹.11. Дуудлага худалдааны ойн дагалт баялгийн 1 килограмм тутмын босго үнийг ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээний 50 хувиар тооцно.

38¹.12. Дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаа эхлэх босго үнийн 50 хувьтай тэнцэх хэмжээний дэнчинг дуудлага худалдаа эхлэхээс 24 цагийн өмнө холбогдох дансанд байршуулах ба дэнчин төлсөн баримт, ойн дагалт баялаг ашиглах, хамгаалах мэргэжлийн байгууллагын гэрчилгээг үндэслэн дуудлага худалдааны оролцогчоор бүртгэнэ.

38¹.13. Дэнчин төлж бүртгүүлсэн хуулийн этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дуудлага худалдаанд оролцож болно.

38¹.14. Байгалийн давагдашгүй хүчин зүйл гарсан, эсхүл программ хангамж, техникийн саатал, цахилгаан эрчим хүч, сүлжээ тасарч доголдсоноос цахим дуудлага худалдаа хэвийн явагдах боломжгүй болсон тохиолдолд тухайн дуудлага худалдааг хүчингүйд тооцож, ажлын 5 өдрийн дотор дахин зохион байгуулна.

38¹.15. Анхны үнийн санал гаргаснаар дуудлага худалдааг эхэлсэнд тооцох ба дуудлага худалдаа зохион байгуулагч нь сүүлийн үнийг зарласнаар дуудлага худалдааг дуусгавар болгоно. Танхимаар зохион байгуулж байгаа тохиолдолд шууд, цахимаар зохион байгуулж байгаа тохиолдолд цахимаар ялагчийг тодруулж оролцогч тус бүрд мэдэгдэнэ.

38¹.16. Дуудлага худалдааны үнийг өсгөх алхам нь босго үнийн 30 хувиас хэтрэхгүй байна.

38¹.17. Дуудлага худалдааны ялагч нь төлбөрийг 24 цагийн дотор холбогдох дансанд бүрэн төлсний дараа зохион байгуулагч ялагчийг баталгаажуулсан шийдвэрийг ажлын нэг өдрийн дотор мэдэгдэнэ.

38¹.18. Ялагчийн төлөх төлбөрт урьдчилан төлсөн дэнчинг оруулж тооцно.

38¹.19. Дуудлага худалдааг зохион байгуулагч дуудлага худалдааны явцад тэмдэглэл үйлдэж, дуу, дүрсний бичлэгээр баталгаажуулна. Танхимаар зохион байгуулсан тохиолдолд оролцогчид болон зохион байгуулагч талын төлөөлөл тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулна.

38¹.20. Дуудлага худалдаанд оролцоогүй, эсхүл оролцсон боловч ялаагүй этгээдэд дэнчинг буцаан олгоно.

38¹.21. Дуудлага худалдааны ялагч энэ хуулийн 38¹.7.1-д заасан хугацаанд төлбөрийг бүрэн төлөөгүй бол дэнчинг улсын орлого болгож, дуудлага худалдааны үед дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээдэд түүний санал гаргасан үнийн дүнгээр нь 24 цагийн дотор санал тавина. Саналыг хүлээж авсан тохиолдолд тухайн этгээд төлбөрийг 24 цагийн дотор дуудлага худалдаа зохион байгуулагчийн холбогдох дансанд бүрэн төлсний дараа зохион байгуулагч ялагчийг баталгаажуулсан шийдвэр гаргана.

38¹.22. Дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаатай холбоотой гомдлыг аймаг, нийслэлийн Засаг даргад гаргана.

38¹.23. Дуудлага худалдааны ялагч төлбөрөө төлөөгүй, энэ хуулийн 38¹.21-д заасан дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээд татгалзсан, дуудлага худалдаанд нэгээс дээш тооны оролцогч оролцоогүй, үнийн санал гаргаагүй тохиолдолд дуудлага худалдааг дахин зохион байгуулна.

38¹.24. Төлбөрөө төлөөгүй ялагчийг хоёр дахь удаагийн дуудлага худалдаанд оролцуулахгүй.

38¹.25. Дуудлага худалдаанаас олсон нийт орлогын 50 хувийг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлнэ.

38¹.26. Дуудлага худалдаанаас орон нутагт төвлөрсөн орлогын 85 хувийг ойн аж ахуйн арга хэмжээнд зарцуулна.

38¹.27. Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.19-д заасан зөвшөөрлөөр ойн дагалт баялгийг улсын хилээр нэвтрүүлнэ.

38¹.28. Ойн дагалт баялгийг улсын хилээр нэвтрүүлэх хүсэлтэд ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээний болон ойн дагалт баялгийг ашиглах гэрээний хуулбар, самар түүж бэлтгэсэн талбайг хүлээн авсан акт, ойн дагалт баялгийн нөөц ашиглах эрхийн бичгийн эх хувь, лабораторийн шинжилгээний бичиг, худалдан авагч талтай байгуулсан гэрээний хуулбар, ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөрийн баримтыг хавсаргана.”

2 дугаар зүйл. Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.5 дахь заалтын “ойн” гэсний өмнө “ойгоос мод бэлтгэх,” гэж нэмсүгэй.”

3 дугаар зүйл. Ойн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/14 дүгээр зүйлийн 14.3.23 дахь заалт:

“14.3.23. ойн тооллого, зохион байгуулалт хийх, мод үржүүлэх, ойг нөхөн сэргээх, ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийж тэмцэх, ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах, арчилгаа цэвэрлэгээ хийх, ойн дагалт баялгийг ашиглах, хамгаалах ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгох, үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн тохиолдолд эрхийг нь сүүлийн 5 жилийн үйл ажиллганы тайлан, гэрээ, актыг үндэслэн таван жилээр сунгах, хүчингүй болгох;”

2/23 дугаар зүйл:

“23 дугаар зүйл. Ойн мэргэжлийн байгууллага, түүний үйл ажиллагааны чиглэл

23.1. Ойн мэргэжлийн байгууллага нь ойн тооллого, зохион байгуулалт хийх, мод үржүүлэх, ойг нөхөн сэргээх, ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийж тэмцэх, ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах, арчилгаа цэвэрлэгээ хийх, ойн дагалт баялгийг ашиглах, хамгаалах гэсэн чиглэлтэй байна.

23.2. Ойн мэргэжлийн байгууллагад чиглэлийн дагуу мэргэжлийн хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, судалгааны арга зүй, технологи, программ

хангамжтай байх бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, галын аюулгүй байдлыг хангаж ажиллана.

23.3. Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага:

23.3.1. ойд үйлдвэрлэлийн ашиглалт явуулах, арчилгаа цэвэрлэгээ хийх мэргэжлийн байгууллага:

23.3.1.а. мод бэлтгэлийн талбайн инженер, хөрөөчин, цагаалгын тракторчин, оосорлогч, ойжуулагчтай байх;

23.3.1.б. мод огтлох, цагаалах, ачигч, тээвэрлэх машин механизм, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх;

23.3.1.в. түймрээс хамгаалах халз болон харлуулсан зурвас байгуулах техник, тоног төхөөрөмжтэй байх;

23.3.1.г. ойн модны нөөцийн ашиглалт явуулсан талбайг ойжуулахад шаардагдах тарьц, суулгацын байнгын нөөцтэй байх, эсхүл мэргэжлийн байгууллагаар ойжуулалт хийлгэхээр урьдчилан тохиролцож гэрээ байгуулсан байх.

23.3.2. ойн тооллого, зохион байгуулалт, ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, тэмцэх мэргэжлийн байгууллага:

23.3.2.а. ойн аж ахуйн инженер, биологич, экологич, газарзүйн мэдээллийн системийн ажилтантай байх;

23.3.2.б. байршил тогтоогч, өнцөг хэмжигч, ойн таксацын дундаж үзүүлэлтийг тодорхойлох багаж, дрон, хэвлэх тоног төхөөрөмж, бичил цаг уур хэмжигч, бичил нарийвчлалтай электрон жин, нарийвчлалтай штангенциркуль, үүргийн шүршигч багаж, ус агуулах 1 тн болон түүнээс дээш хэмжээтэй сав, мотопомп, цахилгаан үүсгүүр, гэрлэн урхи, экран дэлгэц, лед гэрэл, дээж цуглуулан бойжуулах болон хадгалах зориулалтын сав, 20 килограммаас доошгүй жин хэмжих багаж, өндөг хусаж цуглуулах малтуур, судалгаанд ашиглах давуун дэлгэц, мод гэмтээхгүй хамгаалалтай доргиох лантуутай байх;

23.3.2.в. газар зүйн мэдээллийн системийн программ хангамжтай байх;

23.3.2.г. бактерийн бэлдмэл, бодисыг хадгалах стандарт шаардлагад нийцсэн зоорь болон агуулахтай байх эсхүл зориулалтын агуулах түрээслэх гэрээ байгуулсан байх;

23.3.2.д. бэлдмэл, бодис зөөвөрлөх тоноглогдсон тээврийн хэрэгсэлтэй байх.

23.3.3. мод үржүүлэх, ойг нөхөн сэргээх мэргэжлийн байгууллага:

23.3.3.а. ойн аж ахуйн инженер, техникч, ойжуулагчтай байх;

23.3.3.б. мод үржүүлгийн газартай байх;

23.3.3.в. тарьц, суулгац хадгалах зориулалтын зоорьтой байх;

23.3.3.г. усалгаа, хөрс боловсруулах, мод тарих зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй байх.

23.3.4.ойн дагалт баялгийг ашиглах, хамгаалах мэргэжлийн байгууллага:

23.3.4.а.ойн аж ахуйн инженер, биологич, экологичтой байх;

23.3.4.б.байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй дагалт баялаг ашиглах аргачлалтай байх;

23.3.4.в.ойн дагалт баялгийн нөөцийг хадгалах агуулах, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр, техник, тоног төхөөрөмжтэй байх;

23.3.4.г.ойг нөхөн сэргээхэд шаардагдах тарьц, суулгацын байнгын нөөцтэй байх, эсхүл энэ чиглэлийн мэргэжлийн байгууллагаар ойжуулалт хийлгэхээр урьдчилан тохиролцож гэрээ байгуулсан байх;

23.4.Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлагыг хангасан эсэхийг хянана.

23.5.Ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч нь хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр илгээнэ.”

3/38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг:

“38.8.Хуш модны боловсруулсан самрын идээний гарц, хорогдлыг төрийн шинжлэх ухааны холбогдох байгууллагаар тогтоолгоно.”

4 дүгээр зүйл.Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “13.1.35” гэсэн заалтын дугаарыг “13.1.36” гэж, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсгийн “38.8” гэсэн хэсгийн дугаарыг “38.9” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Ойн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “чиглэлээр” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Ойн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ОЮУНЫ ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Оюуны өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Оюуны өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.2.6 дахь заалтын “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Өмгөөллийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хууль,” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Өмгөөллийн үйл ажиллагаа” гэсний өмнө “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.18-д заасан” гэж тус тус нэмсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.3 дах хэсэг:

“9.3.Энэ хуулийн 7.3, 7.4.3, 7.4.6, 18, 19 дүгээр зүйлд заасан шаардлагуудыг хянан үзэж, дүгнэлт гаргахдаа Зохицуулах хороо нь хүсэлт гаргагчийн компанийн дүрэм, хувьцаа эзэмшигч, тэдгээрийн хувьцааны тоо хэмжээний талаарх лавлагааг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас цахим хэлбэрээр гаргуулан авна.”

2/10 дугаар зүйлийн 10.15, 10.16, 10.17, 10.18 дахь хэсэг:

“10.15.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9-д заасан тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, тусгай зөвшөөрөл хүсэгчээс ирүүлсэн баримт бичгийг үнэлэх чиг үүрэг бүхий 5-аас доошгүй сондгой тооны бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Зохицуулах хорооны даргын шийдвэрээр байгуулна.

10.16.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг энэ хуулийн 9.1-д заасан үзүүлэлтийн хүрээнд, үзүүлэлт тус бүрийг 35 хүртэлх оноогоор үнэлнэ. Сонгон шалгаруулалтын үзүүлэлтийн нийлбэр 100 оноо байна.

10.17.Сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийн үнэлгээг ажлын хэсгийн гишүүдийн дундаж оноогоор гаргаж, үзүүлэлт тус бүрээр авбал зохих онооны 50 хувиас доошгүй оноо авсан бөгөөд нийлбэр дүнгээр 80 ба түүнээс дээш оноо авсан баримт бичгийг шаардлага хангасанд тооцно.

10.18.Сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийн үнэлгээг ажлын 10 өдөрт багтаан үнэлж, шаардлагатай тохиолдолд хугацааг 1 удаа ажлын 5 өдрөөр сунгаж болно.”

2 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:

“9.1.Хуулийн этгээд зөвшөөрлийн хүсэлтийг Зохицуулах хорооноос баталсан маягтын дагуу гаргах бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана.”

9.1.1.өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо судалгаа бүхий батлагдсан 5 жилийн бизнес төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхыг нотолсон баримт;

9.1.2.үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай технологийн шийдэл, ерөнхий зураглал, тоног төхөөрөмжийн жагсаалт;

9.1.3.радио, телевизийн редакцын бодлого, хөтөлбөрийн төлөвлөлт;

9.1.4.олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тохиолдолд үйлчилгээ эрхлэх хүрээ, байршил, сүлжээний төлөвлөлт, гадаад, дотоод сувгийн төлөвлөлт, үндсэн багц, үйлчилгээний үнэ тарифын талаарх мэдээлэл; 9.1.6.радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тохиолдолд үйлчилгээ эрхлэх байршил, сүлжээний төлөвлөлт, тооцоолол.”

2/10 дугаар зүйлийн 10.8, 10.9 дэх хэсэг:

“10.8.Сонгон шалгаруулалтад оролцогч нь энэ хуулийн 8.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.

10.9.Зохицуулах хороо энэ хуулийн 10.17-д заасан ажлын хэсгийн дүгнэлтээр шаардлага хангасан, хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдэд энэ хуулийн 30.1.9-д нийцүүлэн тусгай зөвшөөрөл олгоно.”

3/14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг:

“14.2.Зохицуулах хороо энэ хуулийн 14.1-д заасан үндэслэл, зөрчлийг арилгасан гэж үзвэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.”

4/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

“16.4.Зохицуулах хороо энэ хуулийн 16.3-т заасан нотлох баримт бичгийг хянаж үндэслэлтэй гэж үзвэл холбогдох шийдвэрийг хүчингүй болгох, эсхүл үндэслэлгүй гэж үзвэл шийдвэрийг хэвээр үлдээж, энэ тухай тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ.”

3 дугаар зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн хэсгийн “нөхцөлийг” гэснийг “нөхцөл, шаардлагыг” гэж, мөн зүйлийн 8.1.1 дэх заалтын “дунд хугацааны стратеги” гэснийг “бизнес” гэж, мөн зүйлийн 8.1.2 дахь заалтын “стратеги” гэснийг “бизнес” гэж, 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийн “21.3-т” гэснийг “30.1.6-д” гэж, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1, 10.6 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1.7.6 дэх дэд заалтыг тус тус хүчингүй болгонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Радио долгионы тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.4¹ дэх хэсэг:

“11.4¹. Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.8-д заасан тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг үнэлэх чиг үүрэг бүхий 5-аас доошгүй сондгой тооны гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг Зохицуулах хорооны даргын шийдвэрээр байгуулна.”

2/11 дүгээр зүйлийн 11.14, 11.15 дах хэсэг:

“11.14. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг энэ хуулийн 11.6-д заасан нөхцөл тус бүрийг 25 хүртэлх оноогоор үнэлнэ. Сонгон шалгаруулалтын үнэлгээний нийлбэр 100 оноо байна.”

11.15. Сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг дараах зарчмын дагуу үнэлнэ:

11.15.1. нөхцөл тус бүрд ажлын хэсгийн гишүүдээс өгсөн дундаж онооны нийлбэрээр нэгдсэн үнэлгээг гаргах;

11.15.2. нэгдсэн үнэлгээгээр нөхцөл тус бүрийн авбал зохих онооны 50 хувиас доошгүй, нийт 70 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд шаардлага хангасанд тооцно.”

2 дугаар зүйл. Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.2 дахь заалтын “радио давтамжийн зурвасын” гэсний дараа “нөөц, ашиглалтад суурилсан үр ашигтай” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалтын “тусгай хэрэглээний ангилалд орсон,” гэсний дараа “үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн үндэсний хуваарилалттай нийцээгүй,” гэж, мөн заалтын “тусгай зөвшөөрөл” гэсний дараа “, эрхийн бичиг” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Радио долгионы тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг:

“10.1. Зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичиг, мэдээллийг хавсаргана:

10.1.1.радио төхөөрөмжийн зориулалт, технологийн төрөл, газар зүйн байршил, радио сүлжээний зураглал, түүний хамрах хүрээ, ашиглах радио давтамж, радио давтамжийн зурвас, техникийн үзүүлэлт;

10.1.2.радио төхөөрөмжийг баталгаажуулж эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичиг;

10.1.3.радио давтамж ашиглах хэрэгцээ шаардлага, төлөвлөж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

10.1.4.тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх бизнес төлөвлөгөө, хэрэгжүүлэх хугацааны хуваарь;

10.1.5.хиймэл дагуулын үйлчилгээнд ашиглах тохиолдолд хиймэл дагуул эзэмшигчээс радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглуулах боломжтой талаарх баримт.”

2/11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэг:

“11.7.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийн үнэлгээг энэ хуулийн 11.6-д заасан нөхцөлийн дагуу ажлын 10 өдөрт багтаан үнэлж, хамгийн өндөр үнэлгээ авсан оролцогчоос эрэмбэлж, эрэмбийн дагуу радио давтамжийн зурвасыг сонгуулж, Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл олгоно. Сонгон шалгаруулалтын баримт бичгийг үнэлэх хугацааг шаардлагатай тохиолдолд 1 удаа ажлын 5 өдрөөр сунгаж болно.”

3/14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт:

“14.1.1.бүх төрлийн радио долгион хүлээн авагч;”

4 дүгээр зүйл.Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.9 дэх хэсгийн “журам” гэснийг “нөхцөл, шаардлага” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “утас ба факсны дугаар” гэснийг “утасны дугаар, цахим хаяг” гэж, 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсгийн “10” гэснийг “7” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “факсны дугаар” гэснийг “цахим хаяг” гэж, мөн зүйлийн 13.6 дахь хэсгийн “, туршилт болон сонирхогчийн радио станцын” гэснийг “болон туршилтын” гэж, мөн зүйлийн 13.10.2 дахь заалтын “оруулахаар Зохицуулах хорооноос шийдвэрлэсэн” гэснийг “оруулах” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.7 дахь заалтын “аргачлалыг батлах,” гэснийг хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.6, 22.7, 22.8 дахь хэсэг нэмсүгэй:

“22.6.Энэ хуулийн 3.1.9-д заасан үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээд нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ:

22.6.1.үйл ажиллагаа явуулах ажлын байр нь тухайн этгээдийн өмч бол үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, түрээсийн байр бол түрээсийн гэрээний баталгаажуулсан хуулбар;

22.6.2.хуулийн этгээд бол компанийн дүрмийн баталгаажуулсан хуулбар, тухайн үйл ажиллагааг эрхлэх талаарх хувьцаа эзэмшигчийн шийдвэр;

22.6.3.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан болон тухайн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн талаарх баримт бичиг;

22.6.4.хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан талаарх баримт бичиг.

22.7.Энэ хуулийн 3.1.10-т заасан үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээд нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ:

22.7.1.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан болон тухайн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн талаарх баримт бичиг;

22.7.2.зуучлалын үйлчилгээний ерөнхий нөхцөл, хөлс, шагналын хэмжээний мэдээлэл;

22.7.3.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай, агент, эсхүл борлуулалтын ажилтнуудыг мэргэшил, арга зүйгээр хангаж ажиллах 1-ээс доошгүй брокертой байгаа талаарх мэдээлэл;

22.7.4.үйл ажиллагаа явуулах ажлын байр нь тухайн этгээдийн өмчлөлийнх бол үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, түрээсийн байр бол түрээсийн гэрээний баталгаажуулсан хуулбар;

22.7.5.эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигч нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан талаарх баримт бичиг.

22.8.Энэ хуулийн 3.1.9, 3.1.10-т заасан этгээд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг болон хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан, энэ хуулийн 22.6, 22.7-д заасан бусад баримт бичгийг бүрэн шаардлага ханган ирүүлсэн тохиолдолд Хороо зөвшөөрөл олгоно.”

2 дугаар зүйл.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалтын “4.1.10-т заасан этгээдийн нөлөө бүхий” гэснийг “4.1.10, 4.1.11-т заасан этгээд болон Хорооноос олгосон зөвшөөрөл эзэмшигчийн” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг “Хороо энэ хуулийн 3.1.9, 3.1.10-т заасан үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд тэдгээрийн үйл ажиллагаанд тавих шаардлага, зайны болон газар дээрх хяналт шалгалт, хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, мэргэжлийн холбоонд тавигдах шаардлага зэргийг баталж болно.” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН
СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсэг:

“5.11.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлэх баримт бичиг нь эрх бүхий байгууллагад байгаа, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системээс татан авах боломжтой бол иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.”

2/15 дугаар зүйлийн 15.11, 15.12 дахь хэсэг:

“15.11.Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, амралтын газрын дэргэдэх худалдаа, үйлчилгээний газар, аялал жуулчлалын гол чиглэл дагуух үйлчилгээний цогцолбор бүхий түр буудаллах цэгт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход энэ хуулийн 15.7 дахь хэсэг хамаарахгүй.

15.12.Энэ хуулийн 15¹ дүгээр зүйлд заасны дагуу бүрдүүлэх баримт бичиг нь эрх бүхий байгууллагад байгаа, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн болон дэмжих системээс татан авах боломжтой бол иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй.”

2/15¹ дүгээр зүйлийн 15¹.1.5, 15¹.1.6, 15¹.1.7 дахь заалт:

“15¹.1.5.дүрс бичлэгийг 24 цагийн турш хийх боломжтой, 720 цагаас багагүй буюу 30 хоног хадгалдаг, байнгын ажиллагаатай техник, хэрэгсэл суурилуулсан талаарх баримт;

15¹.1.6.өөрийн үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хэрэгжүүлэх дүрэм;

15¹.1.7.шөнийн цагаар үйлчилгээ үзүүлж байгаа барилга, байгууламжийн 10 метр доторх зайд гадна гэрэлтүүлэг төхөөрөмжийг байршуулсан талаарх нотлох баримт.”

2 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсгийн “согтууруулах ундаа үйлдвэрлэхэд” гэсний дараа “тухайн нутаг дэвсгэрийн хяналт шалгалт

хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага болон аймаг, нийслэлийн саналыг үндэслэн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4 дэх хэсэг:

“5.2.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 5.1-д заасан тоонд багтаан жилд нэг удаа сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.

5.3.Уламжлалт технологиор үйлдвэрлэснээс бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын оноог үндэслэн хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгож, сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.

5.4.Уламжлалт технологиор үйлдвэрлэх согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын оноог үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч олгож, сунгаж, түдгэлзүүлж, сэргээж, хүчингүй болгоно.”

2/6 дугаар зүйл:

“6 дугаар зүйл.Согтууруулах ундаа үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам

6.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, сонгон шалгаруулалтад оролцох тусгай зөвшөөрөл хүсэгчээс ирүүлсэн баримт бичигт үнэлгээ өгөх 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг энэ хуулийн 5.3, 5.4-т заасан эрх бүхий этгээд байгуулна.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хүнсний асуудал эрхэлсэн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль сахиулах байгууллага, эрүүл мэнд, хүнсний салбарын эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн байгууллага болон мэргэжлийн холбооны төлөөллийг оролцуулна. Ажлын хэсгийг хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын, эсхүл аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хүнсний асуудал хариуцсан нэгжийн удирдлага ахална.

6.3.Согтууруулах ундаа үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох төсөл сонгон шалгаруулах зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд зарлах бөгөөд төсөл хүлээн авах хугацаа 60 хоногоос доошгүй байна.

6.4.Энэ хуулийн 5.3, 5.4-т заасан тусгай зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

6.4.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

6.4.2.согтууруулах ундааны төслийн баримт бичиг;

6.4.3.аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан болон хуулийн дагуу татвар, хураамж, төлсөн талаарх мэдээлэл;

6.4.4.татварын өргүй талаарх татварын байгууллагын тодорхойлолт;

6.4.5.санхүүгийн чадавхийг тодорхойлсон харилцагч банкны мэдэгдэл, эсхүл нотлох бусад баримт бичиг;

6.4.6.энэ хуулийн 5.3-т заасан тусгай зөвшөөрөл хүсэгч нь аймаг, нийслэлийн Засаг даргын санал, энэ хуулийн 5.4-т заасан тусгай зөвшөөрөл хүсэгч нь сум, дүүргийн Засаг даргын санал.

6.5.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад ирүүлсэн зөвшөөрөл хүсэгчийн баримт бичгийг холбогдох стандартын шаардлагын дагуу дараах үзүүлэлт, оноогоор үнэлнэ:

6.5.1.согтууруулах ундаа үйлдвэрлэх төслийн макро, микро орчны орчны судалгааг 0-15 хүртэлх оноогоор;

6.5.2.согтууруулах ундаа үйлдвэрлэх төслийн санхүүгийн тооцооллыг 0-15 хүртэлх оноогоор;

6.5.3.үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, үүнээс нэвтрүүлэхээр төлөвлөсөн дэвшилтэт техникийг 0-10 хүртэлх оноогоор;

6.5.4.үйлдвэрлэлийн технологи, үүнээс нэвтрүүлэхээр төлөвлөсөн дэвшилтэт технологийг 0-10 хүртэлх оноогоор;

6.5.5.исгэлтийн үйлдвэрт ажиллах мэргэжлийн боловсон хүчний байдлыг 0-5 хүртэлх оноогоор;

6.5.6.үйлдвэрлэлийн зураг төсөлд хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг хянах лабораторийг тусгасан байдлыг 0-10 хүртэлх оноогоор;

6.5.7.үйлдвэрлэлийн зураг төсөлд хаягдал усанд механик, хими, биологийн цэвэрлэгээний бүрэн технологи бүхий урьдчилан цэвэрлэх байгууламжийг тусгаж, төлөвлөсөн байдлыг 0-10 хүртэлх оноогоор;

6.5.8.үйлдвэрлэлийн зураг төслийн иж бүрдлийг 0-7 хүртэл хоноогоор;

6.5.9.байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийсэн байдлыг 0-8 хүртэлх оноогоор;

6.5.10.согтууруулах ундааны хайрцаг, сав, шошго, савлагааны шаардлагыг 0-6 хүртэлх оноогоор;

6.5.11.баримт бичгийн бүрдлийг 0-4 хүртэлх оноогоор.

6.6.Сонгон шалгаруулах төсөл бүрийн үзүүлэлтийг ажлын хэсгийн гишүүн бүр үнэлж, оноог гишүүдийн дундаж үнэлгээгээр гаргах бөгөөд нийлбэр дүнгээр сонгон шалгаруулалтад оролцсон төслөөс 80 ба түүнээс дээш хамгийн өндөр оноо авсан нэг зөвшөөрөл хүсэгчийг сонгон шалгаруулалтад тэнцсэнд тооцно.

6.7.Ажлын хэсэг шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй.

6.8.Сонгон шалгаруулалтад оролцсон төсөл бүрийг ажлын таван өдөрт, холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд ажлын таван өдөрт багтаан шалгаж, зөвшөөрөл хүсэгчид ажлын нэг өдөрт мэдэгдэнэ.

6.9.Энэ хуулийн 6.8-д заасан сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогч нь дараах баримт бичгийг сонгон шалгаруулалт явагдсанаас хойш ажлын таван өдөрт бүрдүүлж хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл харьяалах аймаг, нийслэлийн тамгын газарт хүргүүлнэ:

6.9.1.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

6.9.2.үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, тэдгээрийн чанар, стандарт, өмчлөлийн талаарх мэдээлэл;

6.9.3.үйлдвэрлэх согтууруулах ундааны нэр төрөл, хэмжээ, үйлдвэрлэлийн хүчин чадлыг тодорхойлсон баримт бичиг;

6.9.4.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хатуулгийг бүртгэх, мэдээлэх тоног төхөөрөмж суурилуулах, түүнийг нэгдсэн сүлжээнд холбох тооцоолол;

6.9.5.энэ хуулийн 6.4.2-т заасан төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, мэргэжлийн хүний нөөцийн талаарх мэдээлэл;

6.9.6.үйл ажиллагаа явуулах барилга, байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн төхөөрөмжийн талаарх цагдаагийн байгууллагын санал;

6.9.7.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн тус бүр дахин давтагдашгүй, цахим өгөгдөл бүхий кодтой онцгой албан татварын тэмдэг наах, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбох тоног төхөөрөмж шаардлага хангасан эсэх талаар татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлт.

6.10.Сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогч нь энэ хуулийн 6.9-д заасан баримт бичгийн бүрдлийг хангаагүй тохиолдолд сонгон шалгаруулалтад 80 ба түүнээс дээш оноо авсан дараагийн зөвшөөрөл хүсэгчид согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах эрх шилжинэ.”

3/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:

“8.1.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулахад энэ хуулийн 6.1.1, 6.4.4, 6.9.2, 6.9.2, 6.9.3, 6.9.4, 6.9.7, 6.9.6-д заасан баримт бичиг болон аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн гурван жилийн санхүүгийн тайланг цахимаар хүргүүлнэ.”

4/15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг:

“15.7.Тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны

байршлыг харгалзан нийслэлд 1000 хүн ам тутамд 6 хүртэл, аймаг, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоно.”

5/16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг:

“16.6.Спортын үзвэр, үйлчилгээ үзүүлдэг болон кофе, цайгаар дагнасан үйлчилгээний байгууллагад спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.”

4 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 15¹ дүгээр зүйлийн 15^{1.4} дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 15¹ дүгээр зүйлийн 15^{1.3}, 15^{1.5} дахь хэсэг, 15² дугаар зүйлийн 15^{2.1} дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрлийг” гэснийг “Зөвшөөрлийг” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийг “Сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогч согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалт, мөн зүйлийн 6.2 дахь хэсгийн “6.1.3” гэснийг “6.4.2” гэж, 15¹ дүгээр зүйлийн 15^{1.1.3} дахь заалтын “эрхлэх талаар гаргасан” гэснийг “бага эрсдэлтэй болох нь тогтоогдсон” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн гарчиг, 15.1, 15.3, 15.4, 15.6, 15.7, 15.9, 15.10 дэх хэсэг, 15¹ дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 15^{1.1} дэх хэсэг, мөн зүйлийн 15^{1.1.1} дэх заалт, 15^{1.4}, 15² дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 15^{2.1.1} дэх заалт, 16 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 16.1, 16.2, 16.3, 16.4, 16.6 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 17.1, 17.2, 17.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 18.1 дэх хэсэг, мөн зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.3 18.1.5, 18.1.6, 18.1.7, 18.1.10 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 24.2, 24.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.5.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.5, 1.16, 1.17, 1.18, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 7 дахь хэсгийн 7.2, 7.4, 7.6 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийн болон 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.9, 1.11, 1.17, 1.18, 1.19, 1.21 дэх заалт, 7 дахь хэсгийн 7.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.16 дахь заалтад заасан энгийн зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаанд холбогдох техникийн зохицуулалтыг мөрдөнө.”

2 дугаар зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 7.12 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР, СОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.2.5 дахь заалт нэмсүгэй:

“6.2.5.татварын өргүй тухай татварын байгууллагын тодорхойлолт.”

2 дугаар зүйл.Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, 6.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “хуулиар” гэсний өмнөх “Зөвшөөрлийн тухай” гэснийг хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.13.4 дэх заалтын “бүртгэл” гэснийг “үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, 12 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 12.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн гарчиг, 13.1, 13.3 дахь хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

“14.5.Төмөр замын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

14.5.1.хүний нөөцийн мэдээлэл;

14.5.2.хуулийн этгээдийн танилцуулга;

14.5.3.тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг нотолсон баримт бичиг /Ажлын туршлага, үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл/.

14.6.Төмөр замын суурь бүтэц барих, үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 14.5-д зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

14.6.1.төмөр замын суурь бүтэц барихтай холбоотой урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийн баримт бичиг, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр);

14.6.2.төслийг удирдах этгээдийн ажлын туршлагын тодорхойлолт;

14.6.3.байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ;

14.6.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр;

14.6.5.тоног төхөөрөмжийн жагсаалт, хүчин чадлын тодорхойлолт;

14.6.6.санхүүгийн чадавхыг нотлох баримт (сүүлийн 2 жилийн тайлан).

14.7.Төмөр замын суурь бүтэц ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 14.5-д зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

14.7.1.суурь бүтцийн эзэмших, түрээслэх, өмчлөх эрхийн гэрээ;

14.7.2.ашиглалтын дотоод журам, засвар арчлалтын төлөвлөгөө;

14.7.3.санхүүгийн чадавхыг нотлох баримт (сүүлийн 2 жилийн тайлан).

14.8.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн эд анги үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 14.5-д зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

14.8.1.төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн эд ангийг үйлдвэрлэхтэй холбоотой урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл;

14.8.2.ажил гүйцэтгэх технологи;
14.8.3.аюулгүй ажиллагааны зааварчилгаа;
14.8.4.ажлын байрны мэдээлэл /үйлдвэрлэл хийх объектын дэлгэрэнгүй мэдээлэл/;

14.8.5.үйлдвэрлэх бүтээгдэхүүний танилцуулга;
14.8.6.түүхий эд материалын гарал үүслийн баталгаа.

14.9.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг засварлах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 14.5-д зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

14.9.1.эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан хэмжих хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан ажлын багаж, тоног төхөөрөмжийн танилцуулга /хөдлөх бүрэлдэхүүний засварын цех, тоног төхөөрөмжийн мэдээлэл/;

14.9.2.ажлын байрны мэдээлэл /засварын ажил хийх объект болон тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл/;

14.9.3.ажил гүйцэтгэх технологи;
14.9.4.аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйн дотоод журам;
14.9.5.засварын тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн үзүүлэлт;
14.9.6.чанарын хяналтын журам.

14.10.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг угсрах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 14.5-д зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

14.10.1.ажил гүйцэтгэх технологи;
14.10.2.аюулгүй ажиллагааны зааварчилгаа;
14.10.3.хөдлөх бүрэлдэхүүнийг угсрах ажлын байрны мэдээлэл /угсралт хийх объект болон тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл/.

14.11.Төмөр замын тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 14.5-д зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

14.11.1.суурь бүтэц эзэмшигчтэй гэрээ байгуулсан байх /зам ашиглах гэрээ/;

14.11.2.даатгалын гэрээ (зорчигч, ачаа, хариуцлагын даатгал);

14.12.Тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь галт тэрэгний хөдөлгөөнд шууд холбоотой ажилтнууд, зорчигчдыг аяллын замд амрах, хооллох байр, буудал, техник технологийн дагуу үзлэг үйлчилгээ үзүүлэх нэмэгдэл үйлчилгээний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

14.13.Төмөр замын суурь бүтцийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 14.5-д зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

14.13.1.технологийн программ хангамж, техник хэрэгслийн танилцуулга;

14.13.2.чанарын хяналтын журам.

14.14.Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 14.5-д зааснаас гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

14.14.1.мэргэшсэн зөвлөх инженерүүдийн мэдээлэл;

14.14.2.хяналт шалгалтын аргачлал, дотоод журам.”

2 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт:

“14.1.1.төмөр замын суурь бүтэц барих, үйлдвэрлэх, угсрах, засварлах, зураг төсөл боловсруулах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ;

2/14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалт:

“14.1.3.төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн эд анги үйлдвэрлэх, угсрах, засварлах.”

3 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨЛБӨР ТООЦООГ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР ГҮЙЦЭТГЭХ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“4.5. Монголбанк нь өөрийн үндсэн зорилт, хэрэгжүүлж буй мөнгөний бодлого болон гадаад валютын бодлого, зохицуулалтад нийцтэй эсэхийг харгалзан Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх зөвшөөрөл олгох, сунгах, зөвшөөрөл олгохоос татгалзах, зөвшөөрлийг түтгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэр гаргана.

4.6. Монголбанк Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нийтлэг шаардлагыг хангасан иргэн, хуулийн этгээдэд бараа, ажил, үйлчилгээний үнийг гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох зөвшөөрлийг дангаар, эсхүл бараа, ажил, үйлчилгээний үнийг гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх зөвшөөрлийг нэгэн зэрэг олгоно.

4.7. Монголбанк энэ хуулийн 4.6-д заасан иргэн, хуулийн этгээд нь эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдол бүхий зарим салбарыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, эсхүл мөнгөний бодлогын үр дүнг дээшлүүлж, үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах, хөрвөх чадварыг сайжруулж, тогтворжуулах үр нөлөө үзүүлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байх нөхцөл, шаардлагыг тогтоож болно.

4.8. Бараа, ажил, үйлчилгээний үнийг гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

4.8.1. зөвшөөрөл хүссэн хүсэлт;

4.8.2. зөвшөөрөл хүссэн үйл ажиллагааг зохицуулж буй гэрээний хуулбар, шаардлагатай бол түүний орчуулга;

4.8.3. бараа ажил, үйлчилгээг баталгаажуулсан гэрээ, олон улсын хэлэлцээр,

4.8.4. бараа, ажил, үйлчилгээний үнийг гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх үйл ажиллагааны 3-5 жилийн мөнгөн урсгалын төсөөлөл;

4.8.8. мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авилга, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт холбоогүйг нотлох эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

4.8.9.бараа, ажил, үйлчилгээний үнийг гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаа, түүний нөхцөл, шаардлагыг тусгасан удирдлага, зохион байгуулалтын бодлого, журам, шийдвэр;

4.8.10.зөвшөөрөл хүсэгчийн үйл ажиллагааны онцлог шинжид хамаарах баримт бичиг.

4.9.Энэ хуулийн 4.8-д заасны дагуу бүрдүүлж өгсөн баримт бичигтэй холбогдуулан Монголбанк хүсэлт гаргагчаас тодруулга авч болох бөгөөд хүсэлт гаргагч, түүний үйл ажиллагаа, эрх бүхий албан тушаалтантай холбоотой асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авч болно.

4.10.Монголбанк зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 2.2.1, 2.2.3-т заасан арга хэмжээг авна.

4.11.Зөвшөөрөл авах, зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргагч энэ хууль болон Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж холбогдох баримт бичгийг бүрдүүлж ирүүлснээс хойш зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг 60 хоногийн дотор шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ.

4.12.Тухайн зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа, хэлцэл нь энэ хуулийн 4.5-д заасан зорилт, бодлого, түүний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж Монголбанк дүгнэсэн, зөвшөөрөл авах, зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлт гаргагч нь энэ хууль болон Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй тохиолдолд Монголбанк зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзана.

4.13.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан зөвшөөрлийг түтгэлзүүлэх нөхцөл бүрдсэн тохиолдолд Монголбанк зөвшөөрлийг уг нөхцөл арилсаныг тогтоох хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, энэ тухай зөвшөөрөл эзэмшигчид ажлын хоёр өдрийн дотор мэдэгдэнэ.

4.14.Монголбанк энэ хуулийн 4.13-т заасан зөвшөөрлийг түтгэлзүүлэх нөхцөл арилсаныг тогтоосон тохиолдолд зөвшөөрлийг сэргээнэ.

4.15.Зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж буй үйл ажиллагаа нь энэ хуулийн 4.12-т заасан сөргөөр нөлөөлж болзошгүй нь тогтоогдсон болон Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан зөвшөөрлийг хүчингүй болгох нөхцөл бүрдсэн тохиолдолд Монголбанк зөвшөөрлийг цуцалж энэ тухай зөвшөөрөл эзэмшигчид ажлын хоёр өдрийн дотор мэдэгдэнэ.

4.16.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон тохиолдолд Монголбанкны шийдвэрт өөрөөр заагаагүй бол зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлөөр гүйцэтгэх өөрийн үйл ажиллагааг тухайн шийдвэр гарсан өдрөөс эхлэн зогсоож, уг үйл ажиллагаатай холбоотой аливаа хохирол учруулсан тохиолдолд түүнийг нөхөн төлнө.

4.17.Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой гарсан зардлыг зөвшөөрөл эзэмшигч хариуцан төлнө.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд доор дурьдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 19 дэх заалт:

“19/тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх бодлого, зохицуулалт, менежментийг сайжруулах, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зөвшөөрөлтэй холбоотой мэргэжлийн санал, зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батлах.”

2/41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

“3/тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах зөвшөөрөл авах хүсэлтэд судалгаа шинжилгээний батлагдсан арга зүй, судалгааны ажлын удирдамж, хөтөлбөр, ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарь, багийн бүрэлдэхүүний жагсаалтыг хавсарган ирүүлэх;”

2 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “журам,” гэсний дараа “гэрээний загвар,” гэж, 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын “ажлыг” гэсний дараа “батлагдсан арга зүй, удирдамж, хөтөлбөрийн дагуу” гэж, мөн хэсгийн 4 дэх заалтын “байгууллагад” гэсний дараа “гэрээнд заасан хугацаанд” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12, 13 дахь заалт, 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 6 дугаар зүйлийн гарчиг, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн гарчиг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.3, 27.4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2, 35.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4, 36.6 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.5 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 42.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 23, 24, 35 дугаар зүйлийн гарчиг, 39 дүгээр зүйлийн гарчиг, 39.1 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрлийн” гэж, 36 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрлөөр” гэснийг “Зөвшөөрлөөр” гэж, 37 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрлийг” гэснийг “Зөвшөөрлийг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.7, 4.1.8, 4.1.9, 4.1.11, 4.1.12 заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.5 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.2.2, 11.2.3, 11.2.4, 11.2.5, 11.2.6 дахь заалт, Гуравдугаар бүлгийн гарчиг, 12 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 12.2, 12.3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн гарчиг, 13.1, 13.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.7, 14.8, 14.9, 14.10 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 15.1 дэх хэсэг, 15.1.2, 15.1.3 дахь заалтын, 16 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 16.1, 16.2, 16.3, 16.4 дэх хэсэг, 16.1.1, 16.1.2, 16.1.4 дэх заалт, Дөрөвдүгээр бүлгийн гарчиг, 17 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 17.1, 17.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн гарчиг, 18.1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.2.1, 19.2.2, 19.3.2, 19.3.3 дахь заалт, 19.4, 19.5, 19.6, 19.7 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.1.5 дахь заалт, 21 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 21.1, 21.2, 21.3 дахь хэсэг, 21.1.1, 21.1.2 дахь заалт, Тавдугаар бүлгийн гарчиг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2, 24.3 дахь хэсэг, Зургаадугаар бүлгийн гарчиг, 25 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 25.1, 25.2, 25.3, 25.4, 25.5, 25.6 дахь хэсэг, 25.2.1 дэх заалт, 27 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 27.1, 27.2, 27.3 дэх хэсэг, 27.1.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 28.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1, 34.3, 34.5, 34.8, 34.9, 34.10 дэх хэсэг, 34.1.1, 34.5.1, 34.7.1 дэх заалт, Долдугаар бүлгийн гарчиг, 35 дугаар зүйлийн 35.1, 35.2, 35.3 дахь хэсэг, 35.1.1, 35.1.2, 35.1.3 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.1, 36.3, 36.4, 36.5 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 37.3, 37.4, 37.5, 37.6 дэх хэсэг, 37.1.1, 37.1.2, 37.1.3, 37.1.4 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Есдүгээр бүлгийн гарчиг, 41 дүгээр зүйлийн 41.3, 41.4 дэх заалтын “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.3, дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2, 16.1.3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усан замын тээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг:

“9.2. Тусгай зөвшөөрөл хүсэгч иргэн, хуулийн этгээд нь хүсэлтээ энэ хуулийн 17.1, 17.2, 17.3-т заасан даатгалд даатгуулсныг нотолсон баримт бичиг, усан замын тээврийн хэрэгслийн жолоодогч, эсхүл багийн гишүүний усчин-аврагч гэрчилгээ болон түүнтэй адилтгах баримт бичгийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

2 дугаар зүйл. Усан замын тээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Усан замын тээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуульд доор дурьдсан агуулгатай дараах заалт, дэд заалт нэмсүгэй:

1/16¹ дүгээр зүйлийн 16¹.4.15:

“16¹.4.15.усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох.”

2/21 дүгээр зүйлийн 21.6.2.а, 21.6.2.б, 21.6.2.в, 21.6.2.г:

“21.6.2.а.усны хайгуул, судалгаа хийхэд гидрогеологи, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан;

21.6.2.б.цооног өрөмдөх, тоноглох, сэргээн засварлахад гидрологи, усны барилга байгууламжийн инженер,

21.6.2.в.усны барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулахад гидрогеологи, геофизик, өрмийн мастер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан;

21.6.4.г.усны барилга байгууламж барих,тоноглох, сэргээн засварлахад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйч, усны барилга байгууламжийн инженер.”

2 дугаар зүйл. Усны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“21.4.Энэ хуулийн 21.1-д заасан усны мэргэжлийн байгууллагын эрхийг усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага таван жилийн хугацаагаар олгох бөгөөд Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан журмын дагуу сунгана.”

3 дугаар зүйл. Усны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл мэдэгдэлийн” гэж, 16¹ дүгээр зүйлийн “16¹.4.15” гэсэн дугаарыг “16¹.4.16” гэж, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “гүйцэтгэх үүргийг” гэснийг “гүйцэтгэх үүрэг, тавигдах шаардлагыг” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “ус хэмнэх технологи нэвтрүүлэх, усны шинжилгээ, аудит” гэснийг “сэргээн засварлах, усны шинжилгээ” гэж, мөн зүйлийн 21.6.2 дахь заалтын “нотариатаар баталгаажуулсан диплом, сертификатын хуулбар” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн нотлох баримт” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Усны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.4 дэх заалтын “эрх бүхий” гэсний болон “тайланг” гэсний өмнөх “шинэчлэх,” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл мэдэгдэлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.2.12 дахь заалтын “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

“9.3. Биржийн төлөөлөн удирдах зөвлөл нь дотоод үйл ажиллагаандаа мөрдөх дараах дүрэм, журмыг батална:

- 9.3.1. төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- 9.3.2. дотоод хяналтын журам;
- 9.3.3. ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журам;
- 9.3.4. эрсдэлийн удирдлагын журам;
- 9.3.5. ёс зүйн дүрэм;

9.3.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, эсхүл дотоод журам;”

2/17 дугаар зүйлийн 17.5, 17.6, 17.7, 17.8 дахь хэсэг:

“17.5. Энэ хуулийн 4.1.3, 4.1.12-т заасан тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд тогтоосон маягтын дагуу гаргасан өргөдлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ:

17.5.1. үндсэн үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн танилцуулга;

17.5.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

17.5.3. эрх бүхий албан тушаалтан болон үндсэн үйл ажиллагааг эрхлэх мэргэжилтэн нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг;

17.5.4. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан тухай баримт болон хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, баталгаа;

17.5.5. хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны орлогоос бүрдсэн талаарх баримт бичиг;

17.5.6. гурван жилийн бизнес төлөвлөгөө;

17.5.7. тухайн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалт, мэргэшсэн хүний нөөцийн талаарх танилцуулга болон холбогдох баримт бичиг;

17.5.8.техник тоног төхөөрөмж, программ хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул хамгаалалтын асуудлыг шийдвэрлэсэн талаарх бусад этгээдтэй байгуулсан гэрээ, дэлгэрэнгүй танилцуулга;

17.5.9.Хороонд хүсэлт гаргахаас өмнөх хугацаанд үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээдийн хувьд аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, дүгнэлт, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн тайлан тэнцэл;

17.5.10.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.1-д заасан журам;

17.5.11.итгэмжлэл олгож бүртгэх агуулах, терминал, тээвэр логистик, шинжилгээний лабораторийн талаарх мэдээлэл.

17.6.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 17.5-д зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

17.6.1.энэ хуулийн 9.2, 9.3-т заасан дүрэм, журам;

17.6.2.үнэт цаасны клирингийн болон төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээний төсөл.

17.7.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 17.5-д зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

17.7.1.үйл ажиллагаа эрхлэхэд дотооддоо дагаж мөрдөх журам;

17.7.2.уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны программ хангамжийн шаардлагыг хангасан тухай мэдээлэл;

17.7.3.арилжааны захиалга болон төлбөрийг гүйцэтгэх, арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, харилцагчид мэдээлэл өгөх программ хангамжийн танилцуулга;

17.7.4.харилцагчдад үзүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ, харилцагчтай байгуулах гэрээний төсөл;

17.7.5.ажлын байр нь компанийн өөрийн өмчлөлийнх бол үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, түрээсийн байр бол түрээсийн гэрээний баталгаажуулсан хуулбар.

17.8.Хороо тусгай зөвшөөрлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан үндэслэлээс гадна дараах тохиолдолд түдгэлзүүлнэ:

17.8.1.хууль, Хорооноос тогтоосон журмыг зөрчсөн талаар холбогдох байгууллагаас гаргасан хүсэлт нь үндэслэл бүхий гэж үзсэн;

17.8.2.Хорооноос энэ хуулийн 17.4-т заасны дагуу өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй;

17.8.3.тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 8.7-д заасны дагуу тохиромжтой этгээдийн шаардлагыг хангахгүй болсон.”

2 дугаар зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3 дахь заалтын “хүсэгч хуулийн этгээдэд” гэснийг “эзэмшигч хуулийн этгээдэд” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалтын “тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага,” гэснийг хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/27 дугаар зүйлийн 27.6, 27.7, 27.8, 27.9, 27.10, 27.11, 27.12, 27.13, 27.14, 27.15 дахь хэсэг:

“27.6.Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

27.6.1.харилцагчтай байгуулах өмчлөх эрхийн бүртгэлийн гэрээний төсөл;

27.6.2.харилцагчийн дансны хуулганы загвар;

27.6.3.үнэт цаасыг харилцагчийн дансанд бүртгэх, үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл хийхэд үндэслэх баримт бичгийн жагсаалт, түүнийг хадгалах заавар;

27.6.4.үнэт цаас гаргагчтай байгуулах үнэт цаасны бүртгэлийг хөтлөх гэрээний төсөл.

27.7.Үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

27.7.1.үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны болон төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл;

27.7.2.үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа эрхлэхэд үүсэх эрх, үүргийг тусгасан клирингийн үйл ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулах гэрээний төсөл.

27.8.Үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

27.8.1.үнэт цаасны клирингийн болон төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төсөл;

27.8.2.үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэхэд үүсэх эрх, үүргийг тусгасан төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцогч этгээдтэй байгуулах гэрээний төсөл.

27.9.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

27.9.1.харилцагч байгууллагатай байгуулах хадгаламжийн гэрээний төсөл;

27.9.2.харилцагчийн үнэт цаас худалдсан болон ногдол ашгийн мөнгөн хөрөнгийг байршуулан хадгалах арилжааны банктай байгуулах гэрээний төсөл.

27.10.Кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна Монголбанк, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, клиринг, төвлөрсөн хадгаламжийн байгууллага, бусад мэргэжлийн оролцогч болон харилцагчтай мэдээлэл солилцох, төлбөр тооцоо гүйцэтгэх тоног төхөөрөмж, техник, программ хангамжийн танилцуулгыг Хороонд ирүүлнэ.

27.11.Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

27.11.1.үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо, клиринг болон төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээний төсөл;

27.11.2.гишүүнчлэлийн гэрээний төсөл.

27.12.Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна зэрэглэл тогтоох аргачлал, тэмдэглэгээ, үзүүлэлт, тодорхойлолтын тухай танилцуулга, зэрэглэл тогтоох үйл ажиллагааны тайлангийн загварыг Хороонд ирүүлнэ.

27.13.Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

27.13.1.үнэт цаасны үнэлгээ, үнийн тооцооллыг хийх, төсөл, судалгаа, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчтай харилцах чиглэлээр дагнан ажиллах гурваас доошгүй мэргэжилтний талаарх мэдээлэл;

27.13.2.үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журам болон энэ чиглэлээр ажиллах мэргэжилтний талаарх мэдээлэл;

27.13.3.үнэт цаас гаргагч этгээдтэй байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний төсөлд дараах мэдээллийг тусгана:

27.13.3.а.гэрээ хүчин төгөлдөр байх хугацаа;

27.13.3.б.талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

27.13.3.в.нийтэд санал болгож буй үнэт цаасны захиалгын

хугацаа;

27.13.3.г.үнэт цаасны захиалгыг авах, хуваарилах арга аргачлал;

27.13.3.д.үнэт цаасны үнийг тогтворжуулах хугацаа, арга хэлбэр;

27.13.3.е.үйлчилгээний хураамжийн хэмжээ.

27.14.Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

27.14.1.хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх болон үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах мэргэжилтний талаарх мэдээлэл;

27.14.2.хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний гэрээ, хэлцлийг боловсруулж, хянах үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээс энэ чиглэлээр тогтмол үйлчилгээ авахаар байгуулсан гэрээний баталгаажуулсан хуулбар.

27.15.Зохицуулалттай этгээдийн үндсэн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн нь бусад хуулийн этгээдэд болон тухайн хуулийн этгээд дотроо өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглоно.

2/28 дугаар зүйлийн 28.3, 28.4, 28.5, 28.6, 28.7, 28.8, 28.9, 28.10, 28.11, 28.12, 28.13 дахь хэсэг:

“28.3.Энэ хуулийн 27.4-т заасны дагуу брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь харилцагчийг эрсдэлээс хамгаалах, харилцагч, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх журам, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх дотоод журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.4.Энэ хуулийн 27.5-д заасны дагуу дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх дотоод журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.5.Энэ хуулийн 27.6-д заасны дагуу үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл, шилжүүлэг хийхэд хяналт тавих журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.6.Үнэт цаас итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь үйл ажиллагаанд үүсч болзошгүй эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах журам болон зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх дотоод журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.7.Энэ хуулийн 27.7-д заасны дагуу үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь хөрөнгө оруулагчийг клирингийн үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдэлээс хамгаалах сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах нөхцөлийг тусгасан дотоод журам болон үнэт цаасны

арилжааны болон арилжааны бус хэлцлийн дүнд үүссэн тооцоог тодорхойлох, төлбөрийг хийж гүйцэтгэх журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.8.Энэ хуулийн 27.8-д заасны дагуу үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь үнэт цаасны арилжааны болон арилжааны бус хэлцлийн төлбөрийг хийж гүйцэтгэх журам, үнэт цаасны төлбөр тооцооны эрсдэлийн удирдлагын журам, хөрөнгө оруулагчийг үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдэлээс хамгаалах сан байгуулах, сангийн хөрөнгийг захиран зарцуулах нөхцөлийг тусгасан дотоод журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.9.Энэ хуулийн 27.9-д заасны дагуу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь гишүүн кастодиантай мэдээлэл тасралтгүй солилцох, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангах тухай үйл ажиллагааны журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.10.Энэ хуулийн 27.10-д заасны дагуу кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь харилцагчийн мэдээлэл, баримт бичгийг ашиглах, хадгалах, хамгаалах журам болон кастодианы үйлчилгээтэй холбоотой мэдээллийг харилцагчид хүргэх журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.11.Энэ хуулийн 27.10-д заасны дагуу үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл этгээд нь үнэт цаасны бүртгэлийн журам болон зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх дотоод журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.12.Энэ хуулийн 27.12-т заасны дагуу санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан зээлжих зэрэглэлийн байгууллагуудад зориулсан ёс зүйн дүрэмд нийцүүлэн боловсруулсан Зэрэглэл тогтоох үйл ажиллагааны ёс зүйн дүрэм болон тогтоосон зэрэглэлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

28.13.Энэ хуулийн 27.15-д заасны дагуу үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь үнэт цааснаас үүсэж болох эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм, журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.”

3/29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалт:

“29.1.8.тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмыг батлахгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн.”

4/33 дугаар зүйлийн 33.10, 33.11, 33.12, 33.13,33.14 дэх хэсэг:

“33.10.Энэ хуулийн 24.3-т заасан энгийн зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд тогтоосон маягтын дагуу Хороонд өргөдөл гаргана.

33.11.Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх энгийн зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 33.10-т заасан өргөдөлд

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

33.11.1.хуулийн этгээдийн дүрмийн хуулбар, эсхүл нөхөрлөлийн үүсгэн байгуулах гэрээ, батламжийн хуулбар;

33.11.2.орон тооны хуульчдын хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ, үнэт цаасны зах зээлийн төрөлжсөн сургалтад хамрагдсан болон мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан талаарх баримт;

33.11.3.хуульчид нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай холбогдох мэргэжлийн холбооны тодорхойлолт;

33.11.5.үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй танилцуулга, гурван жилийн бизнесийн төлөвлөгөө.

33.12.Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх энгийн зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 33.10-т заасан өргөдөлд Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

33.12.1.орон тооны үнэлгээчдийн үнэлгээчний эрхийн гэрчилгээ, үнэт цаасны зах зээлийн төрөлжсөн сургалтад хамрагдсаныг гэрчлэх болон мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан талаарх баримт;

33.12.2.үнэлгээчид нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай холбогдох хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын тодорхойлолт;

33.12.5.үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй танилцуулга, гурван жилийн бизнесийн төлөвлөгөө;

33.12.6.аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан.

33.13.Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх энгийн зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 33.10-т заасан өргөдөлд Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

33.13.1.үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй танилцуулга, гурван жилийн бизнесийн төлөвлөгөө;

33.13.2.орон тооны аудиторуудын аудитын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ, үнэт цаасны зах зээлийн төрөлжсөн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар, мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан талаарх баримт;

33.13.3.аудиторууд нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай холбогдох мэргэжлийн холбооны тодорхойлолт;

33.13.4.холбогдох эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан чанарын хяналтын шалгалтад хамрагдаж, хангалттай үнэлгээ авсан талаарх нотлох баримт;

33.13.5.аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан.

33.14.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 33.10-т заасан өргөдөл Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

33.14.1.эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг;

33.14.2.тухайн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн талаарх танилцуулга болон холбогдох баримт бичиг;

33.14.3.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан тухай баримт болон хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт;

33.14.4.хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны орлогоос бүрдсэн талаарх баримт бичиг;

33.14.5.харилцагчаас авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний төсөл;

33.14.6.ажлын байр нь компанийн өөрийн өмчлөлийнх бол үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, түрээсийн байр бол түрээсийн гэрээний баталгаажуулсан хуулбар;

33.14.7.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө;

33.14.8.дампуурах, татан буугдах, кибер халдлага, түрэмгийлэлд өртөх зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээний талаар болон үйл ажиллагаанд хүндрэл үүссэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох нарийвчилсан төлөвлөгөө;

33.15.Энэ хуулийн 33.11-д заасны дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх энгийн зөвшөөрөлтэй этгээд нь үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагааны болон дотоод хяналтын журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

33.16.Энэ хуулийн 33.12-т заасны дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх энгийн зөвшөөрөлтэй этгээд нь үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний үйл ажиллагааны болон хараат бус байдлыг тогтоох, хянах горим, чанарын хяналтын журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

33.17.Энэ хуулийн 33.13-т заасны дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх энгийн зөвшөөрөлтэй этгээд нь үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх аудитын үйл ажиллагааны болон чанарын хяналтын журам, аудитын үйл ажиллагаа, чанарын стандарт, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, чанарын хяналт болон мэдээллийн ил тод байдлын тухай журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

33.18.Энэ хуулийн 33.14-т заасны дагуу хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөлтэй этгээд нь үйл ажиллагаа эрхлэхээс өмнө дараах журмыг баталсан байна:

33.14.9.а.төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

33.14.9.б.мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;

33.14.9.в.дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахаас сэргийлэх журам;

33.14.9.г.төслөөр татан төвлөрүүлсэн санхүүжилтийг төсөлд тусгаснаас бусад зориулалтаар ашиглахаас сэргийлэх, хяналт тавих журам;

33.14.9.д.үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой харилцагч болон хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам;

33.14.9.е.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.1-д заасан журам.”

2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг:

“24.6.Энэ хуулийн 24.1.1-24.1.14-т заасан үйл ажиллагааг эрхлэх зохицуулалттай этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулахдаа энэ хуулийн 24.11-д шаардлагыг хангасан талаарх мэдээллийг мэдэгдлээр хүргүүлнэ.”

2/27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг:

“27.2.Энэ хуулийн 27.1-д заасан өргөдөлд Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг хавсаргана:

27.2.1.зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчийн шийдвэр;

27.2.2.хуулийн этгээдийн дүрмийн хуулбар;

27.2.3.хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл, тэдгээрийн төлбөрийн чадвар, банк, санхүүгийн байгууллагад болон бусад этгээдэд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай тодорхойлолт, тохиромжтой этгээд болох тухай мэдээлэл;

27.2.4.хувьцаа эзэмшигч нь гадаад улсын хуулийн этгээд бол тухайн улсынхаа бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар;

27.2.5.хугацаа хэтэрсэн зээлийн болон гааль, татварын байгууллага, шүүхийн шийдвэрээр бусдад өр, төлбөргүй тухай тодорхойлолт;

27.2.7.эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт;

27.2.8.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан тухай баримт болон хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт;

27.2.9.хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны орлогоос бүрдсэн талаарх баримт бичиг;

27.2.10.аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн тайлан тэнцэл;

27.2.11.Компанийн тухай хуульд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээлэл, танилцуулга;

27.2.12.ажлын байр нь компанийн өөрийн өмчлөлийнх бол үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, түрээсийн байр бол түрээсийн гэрээний баталгаажуулсан хуулбар;

27.2.13.тухайн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалтын танилцуулга, гурваас доошгүй жилийн бизнесийн болон эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

27.2.14.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтнүүдийн хувьд:

27.2.14.а.энэ хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу ажил, үйлчилгээний төрөлд нийцсэн эрх авсан талаарх нотлох баримт;

27.2.14.б.Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох шаардлагыг хангасан болон мэргэжил, мэргэшлийн дадлага туршлагатай гэдгийг нотлох баримт бичиг;

27.2.14.в.мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан болохыг нотлох баримт бичиг;

27.2.14.г.тухайн албан тушаалд томилогдсон шийдвэр болон өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.

27.2.15.үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрсдэл, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журмыг хэрэгжүүлэх хараат бус дотоод хяналтын ажилтны талаарх мэдээлэл, тохиромжтой этгээдийг тодорхойлох шаардлагыг хангасан тухай баримт бичиг;

27.2.16.харилцагчид үзүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээний талаарх мэдээлэл;

27.2.17.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр;

27.2.18.банкны нэгдлийн бусад оролцогч бол Банкны тухай хуулийн 6.4-т заасан Монголбанкны санал;

27.2.19.тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь дараах харилцааг тусгаж, зохицуулсан дүрэм, журмыг баталж Хороонд ирүүлнэ:

27.2.19.а.үндсэн үйл ажиллагааны журам;

27.2.19.б.сонирхлын зөрчлийг тодорхойлох, сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх журам;

27.2.19.в.гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний журам;

27.2.19.г.гүйцэтгэх удирдлага, мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрэм;

27.2.19.д.үйлчлүүлэгчийн дотоод мэдээлэл, баримт материалыг ашиглах, хадгалах, хамгаалах журам;

27.2.19.е.зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх тохиолдолд зохицуулалттай үйл ажиллагаа тус бүрийг дотооддоо удирдан зохион байгуулах нэгжийн танилцуулга болон үйл ажиллагааны эрсдэлийг тооцох аргачлал, харилцагчийн хохирлыг барагдуулах зохицуулалтыг тусгасан журам;

27.2.19.ё.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.1-д заасан журам.”

2/27 дугаар зүйлийн 27.4, 27.5 дахь хэсэг:

“27.4.Брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

27.4.3.үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас шинээр гишүүнээр элсүүлэхэд тавигдах шалгуур, арилжаанд оролцох шаардлагыг хангасан талаарх дүгнэлт;

27.4.4.үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, клирингийн байгууллагын программ хангамжийн шаардлагыг хангасан тухай тодорхойлолт.

27.5.Дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 27.2-т зааснаас гадна энэ хуулийн 27.4.3-т заасан баримт бичгийг Хороонд ирүүлнэ.”

3 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтын “Хороонд бүртгэлтэй” гэснийг “Хорооноос зөвшөөрөл авсан” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Хороонд бүртгүүлсний” гэснийг “Хорооноос энгийн зөвшөөрөл авсны” гэж, Дөрөвдүгээр бүлгийн хоёрдугаар дэд бүлгийн гарчгийн “ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, БҮРТГЭХ” гэснийг “ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ” гэж, 26 дугаар зүйлийн 26.2.2 дахь заалтын “этгээдэд тавих нөхцөл,” гэснийг “этгээдийн үйл ажиллагаанд тавих” гэж,

27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “24.2-т заасан” гэснийг “24.1.1, 24.1.2, 24.1.3, 24.1.4, 24.1.5, 24.1.6, 24.1.7, 24.1.8, 24.1.9, 24.1.10, 24.1.11, 24.1.13, 24.1.14-т заасан үйл ажиллагааг эрхлэх” гэж, мөн зүйлийн 27.4 дэх хэсгийн дугаарыг “27.17” гэж, мөн хэсгийн “төлбөр, тооцооны” гэснийг “төлбөр тооцооны, клирингийн” гэж, “хөрөнгийн биржийн” гэснийг “үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын” гэж, мөн зүйлийн 27.5 дахь хэсгийн дугаарыг “27.18” гэж, мөн хэсгийн “төлбөрийн болон тооцооны” гэснийг “төлбөр тооцооны болон клирингийн” гэж, мөн зүйлийн 27.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн зүйлийн 29.1.3, 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтын “тусгай зөвшөөрлийн нөхцөл,” гэснийг “зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд тавигдах” гэж, 33 дугаар зүйлийн гарчгийн “Бүртгэлийн” гэснийг “Энгийн зөвшөөрлийн” гэж, мөн зүйлийн 33.2.1 дэх заалтын “, тогтоосон” гэснийг “хоёроос доошгүй орон” гэж, 33.2.2 дахь заалтын “тогтоосон тооны” гэснийг “хоёроос доошгүй” гэж, 33.2.3 дахь заалтын “аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий тогтоосон тооны аудиторчтой байх” гэснийг “мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй, аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий дөрвөөс доошгүй аудиторчтой байх” гэж, мөн зүйлийн 33.4 дэх хэсгийн “бүртгэлд хамрагдах” гэснийг “энэ хуулийн 24.1.15, 24.5.16, 24.1.17, 24.1.19-д заасан үйл ажиллагааг эрхлэх” гэж, мөн зүйлийн 33.5 дахь хэсгийн “бүртгэлд хамрагдахаар” гэснийг “энгийн зөвшөөрөл авахаар” гэж, мөн зүйлийн 33.6 дахь хэсгийн “бүртгэлд бүртгэхээс татгалзана” гэснийг “зөвшөөрлийг түдгэлзүүлнэ” гэж, мөн зүйлийн 33.7 дахь хэсгийн “хуулийн этгээдийг бүртгэлээс хасна” гэснийг “зөвшөөрлийг хүчингүй болгоно” гэж, мөн зүйлийн 33.7.4 дэх заалтын “Хороонд бүртгүүлснээс” гэснийг “зөвшөөрөл авснаас” гэж, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “санхүүгийн” гэснийг “санхүүгийн, хүний нөөцийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.1 дэх заалтын “олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам болон” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “33.8,” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.12 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.8, 33.9 дэх хэсэг, 63 дугаар зүйлийн 63.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2, 12.3, 12.5 дахь хэсэг, “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.12 дахь хэсэг нэмсүгэй:

“13.12.Хадгаламж, зээлийн хоршоо нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан санхүүгийн бусад үйлчилгээг Хорооноос зөвшөөрсөн тохиолдолд хавсран эрхэлж болно.”

2 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсгай:

“15.2.Энэ хуулийн 13.4, 13.12-т заасны дагуу зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо тогтооно.”

3 дугаар зүйл.Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “13.4-т” гэснийг “13.4, 13.12-т” гэж, 15.7 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9.1.17 дахь заалт:

“9.1.17.боловсон хүчний мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн нотлох баримт.”

2 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “хадгалах,” гэсний дараа “тээвэрлэх,” гэж, 6.1.5 дахь заалтын “аюултай бодисын,” гэсний дараа “турших, бүртгэх,” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “импортлох,” гэсний дараа “хил дамжуулан тээвэрлэх,” гэж, мөн зүйлийн 9.1.6 дахь заалтын “болзошгүй осол,” гэсний өмнө “эрсдлийн үнэлгээ,” гэж, 9.1.7 дахь заалтын “явуулах” гэсний дараа “агуулах, эсхүл” гэж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “тусгай” гэсний дараа “өрөө болон” гэж, 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийн “мэдээг” гэсний дараа “энэ хуулийн 6.1.7-д заасан мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйл:

“5 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах үйл ажиллагаа эрхлэх

5.1.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 1.1-д заасан тэсэрч дэлбэрэхээс бусад эрсдэлийн түвшин бага болон нэг жилийн нийт хэрэглээ нь 100 килограмм хүртэл химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах үйл ажиллагаа эрхлэх мэдэгдлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.2.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.8-д заасан тэсэрч дэлбэрэхээс бусад нэг жилийн нийт хэрэглээ нь 100-1000 кг хүртэл химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 3 хүртэл жилийн хугацаатай олгоно.”

5.3.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.14-т заасан тэсэрч дэлбэрэхээс бусад нэг жилийн нийт хэрэглээ нь 1000 килограмаас их химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх,

үйлдвэрлэх, худалдах, ашиглах тусгай зөвшөөрлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 5 жилийн хугацаагаар олгоно.

5.4.Зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.”

2/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

“6.2.Энэ хуулийн 5.1-д заасан зөвшөөрөл олгох, химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус химийн мэргэжлийн зөвлөл Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:

“11.1.Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд химийн хорт болон аюултай бодис худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр, төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан мэдээллийг энэ хуулийн 6.1.7-д заасан мэдээллийн санд бүртгүүлнэ.”

4 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “жил бүр шинэчлэн батлах” гэснийг “баталж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах,” гэж 9 дүгээр зүйлийн 9.1.12 дахь заалтын “химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн Үндэсний зөвлөлийн шинжээчдийн багийн дүгнэлт” гэснийг “Химийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт” гэж, 9.1.13, 9.1.14 дэх заалтын “эх хувь” гэснийг “хуулбар хувь” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/26 дугаар зүйлийн 26.1.8, 16.1.9 дэх заалт:

“26.1.8.газар эзэмших гэрчилгээний баталгаажсан хуулбар, эсхүл түрээсийн гэрээ хийсэн байх;

26.1.9.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан хийсэн байх.”

2/38 дугаар зүйлийн 38.3.6, 38.3.7, 38.3.8 дахь заалт:

“38.3.6.аюултай хог хаягдал үүсгэгчийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан;

38.3.7.аюултай хог хаягдлын лабораторийн шинжилгээний дүн;

38.3.8.экспортлох аюултай хог хаягдлын сав баглаа боодол, хаяг шошгыг тодорхой харуулсан фото зураг.”

2 дугаар зүйл. Хог хаягдлын тухай хуулийн дараах заалтыг доор дурдснаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт:

“8.1.4.аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох;”

2/9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалт:

“9.3.2.энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга олгох;”

3 дугаар зүйл. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.3.2, 9.3.3 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.6, 37.7, 37.8 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.2, 38.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдэлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОВОРДСОН АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛИЙН ГАДААД ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.6, 8.7, 8.8 дахь хэсэг нэмсүгэй:

“8.6.Иргэн энэ хуулийн 8.1-д заасан зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

8.6.1.амьтан агнах, барих зөвшөөрөл, гарал үүслийн тодорхойлолт худалдан авсныг нотлох баримт бичиг;

8.6.2.хүлээн авах болон илгээх хаяг;

8.6.3.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан төлбөр, хураамж төлсөн баримт.

8.7.Хуулийн этгээд энэ хуулийн 8.1-д заасан зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

8.7.1.ан хийсэн протоколь гэрээний хуулбар;

8.7.2.судалгааны дээж шинжлүүлэх тохиолдолд гадаадын хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний хуулбар;

8.7.3.хүлээн авах болон илгээх хаяг;

8.7.4.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан төлбөр, хураамж тушаасан баримт бичиг.

8.8.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хилээр нэвтрүүлэхэд Генетик нөөцийн тухай хуулийн 10.1-д заасан генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлнэ.”

2 дугаар зүйл.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “зөвшөөрөл болон далай тэнгисээс олборлон оруулах гэрчилгээ авах хүсэлтээ Удирдан зохицуулах зөвлөлд ирүүлнэ” гэснийг “хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана” гэж, 8.2 дахь хэсгийн “Удирдан зохицуулах зөвлөл уг хүсэлтийг” гэснийг “Энэ зүйлийн 8.1-д заасан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өргөдлийг” гэж, 8.5 дахь хэсгийн “Зөвшөөрөл, гэрчилгээг” гэснийг “Зөвшөөрлийг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсгийн “Удирдан зохицуулах зөвлөл” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллага” гэж, 9.3 дахь хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “зөвшөөрөл, гэрчилгээг” гэснийг “зөвшөөрлийг” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Удирдан зохицуулах зөвлөлийн” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 8.2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 9.1, 9.2 дахь хэсгийн “, гэрчилгээ” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.2.1 дэх заалт нэмсүгэй:

“11.2.1. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд:

11.2.1.а. хүний нөөцийн талаарх мэдээлэл;

11.2.1.б. багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт, техникийн хүчин чадлын тодорхойлолт.”

2 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дэх хэсгийн “байгууллагаас” гэсний дараа “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна энэ зүйлийн 2.1-д заасан баримт бичгийг бүрдүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.4. хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОТ, СУУРИН УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН
АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.12 дахь хэсэг:

“4.12. Биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь тогтоосон маягтын дагуу гаргасан өргөдлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ:

4.12.1. хуулийн этгээдийн дүрмийн хуулбар;

4.12.2. үүсгэн байгуулагч, эсхүл хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл, тэдгээрийн төлбөрийн чадвар, банк, санхүүгийн байгууллагад болон бусад этгээдэд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай тодорхойлолт, тохиромжтой этгээд болох тухай мэдээлэл;

4.12.3. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан тухай баримт болон хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт;

4.12.4. хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны орлогоос бүрдсэн талаарх баримт бичиг;

4.12.5. тухайн үйл ажиллагааг эрхлэх ажлын байр, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн шаардлагыг хангасан тухай мэдээлэл;

4.12.6. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.1-д заасан журам;

4.12.7. ажлын байр нь компанийн өөрийн өмчлөлийнх бол үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, түрээсийн байр бол түрээсийн гэрээний баталгаажуулсан хуулбар;

4.12.8. эрх бүхий албан тушаалтан болон мэргэжилтэн нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг болон өмнө ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт;

4.12.9. аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн тайлан тэнцэл;

4.12.10. компанийн гурван жилийн бизнесийн төлөвлөгөө болон тухайн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай бүтэц, зохион байгуулалтын танилцуулга;

4.12.11. төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн болон гүйцэтгэх удирдлага, мэргэжилтнийг томилсон эрх бүхий этгээдийн шийдвэрийн хуулбар;

4.12.13.биржийн зохицуулах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирлын баталсан үйл ажиллагаанд мөрдөх холбогдох дүрэм, журам;

4.12.14.биржийн байнгын болон байнгын бус гишүүн оролцогчтой байгуулах гэрээний төсөл;

4.12.15.төлбөр тооцооны үйл ажиллагааг гүйцэтгэгч этгээдтэй байгуулсан гэрээний баталгаажуулсан хуулбар.”

4.13.Энэ хуулийн 4.12-т заасны дагуу биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь энэ хуулийн 5.2-т заасан журмыг үйл ажиллагаа эрхлэхээс өмнө баталсан байна.

2/10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэг:

“10.9.Биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь тогтоосон маягтын дагуу гаргасан өргөдлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ:

10.9.1.энэ хуулийн 4.12.1, 4.12.2, 4.12.3, 4.12.4, 4.12.5, 4.12.6, 4.12.7, 4.12.8, 4.12.9, 4.12.10-т заасан баримт бичиг;

10.9.2.хувьцаа эзэмшигчдийн, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар баталсан үйл ажиллагааны журам;

10.9.3.бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай бол холбогдох нотлох баримт, эсхүл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан бол гэрээний баталгаажуулсан хуулбар;

10.9.4.брокерийн, итгэмжлэгдсэн агуулах болон гэрээт итгэмжлэгдсэн тээвэрлэлт, лабораторын байгууллага, дотоод ажиллагааны горим нь тогтоосон шаардлагыг хангасан эсэх талаарх биржийн дүгнэлт;

10.9.5.биржээр арилжаалахаар заасан бараа, түүхий эдийн бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрд тохирсон бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай бол хуулийн этгээдийн биржийн итгэмжлэл, эсхүл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан бол гэрээний баталгаажуулсан хуулбар;

10.9.6.биржээр арилжаалахаар заасан бараа, түүхий эдийн бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрд тохирсон бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн лаборатори, тээвэрлэлтийн байгууллагатай байгуулсан гэрээний баталгаажуулсан хуулбар.”

2 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсгийн “арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон биржийн” гэснийг “болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл, шаардлага, тэдгээрийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 18 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 18.4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрлийн” гэж, 19, 20 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрлийг” гэснийг “Зөвшөөрлийг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.2.7 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Дөрөвдүгээр бүлгийн гарчиг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн гарчиг, 17.1, 17.2, 17.5 дахь хэсэг, мөн зүйлийн 17.1.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 18.4 дэх хэсэг, мөн зүйлийн 18.3.1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дэх хэсэг, 19.1.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.1.1, 20.1.2, 20.1.5 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.6, 6.7 дахь хэсэг:

“6.4. Энэ хуулийн 6.1, 20.1, 36.2-т заасан тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд тогтоосон маягтын дагуу гаргасан өргөдлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ:

6.4.1. тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчийн шийдвэр;

6.4.2. хуулийн этгээдийн дүрмийн хуулбар;

6.4.3. хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл, тэдгээрийн төлбөрийн чадвар, банк, санхүүгийн байгууллагад болон бусад этгээдэд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай тодорхойлолт, тохиромжтой этгээд болох тухай мэдээлэл;

6.4.4. ажлын байр нь компанийн өөрийн өмч бол үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа, түрээсийн байр бол түрээсийн гэрээний баталгаажуулсан хуулбар;

6.4.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан тухай баримт болон хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт;

6.4.6. орон сууц санхүүжилтийн компани болон Хорооноос тогтоосон бусад санхүүгийн байгууллага бол хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй, хууль ёсны орлогоос бүрдсэн талаарх баримт бичиг;

6.4.7. аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн тайлан тэнцэл;

6.4.8. тухайн үйл ажиллагааг эрхлэх ажлын байр, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн шаардлагыг хангасан тухай баримт;

6.4.9. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр;

6.4.10. энэ хуулийн 20.1-д заасан тусгай зөвшөөрлийг хүсэгч хуулийн этгээдийн хувьд хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны журам болон гэрээний төсөл;

6.4.11. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.1-д заасан журам.”

6.5.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд нь энэ хуулийн 6.4-т зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

6.5.1.үүсгэн байгуулагч нь банк бол Монголбанкнаас, орон сууцны санхүүжилтийн компани, эсхүл бусад этгээд бол холбогдох эрх бүхий байгууллагаас тэдгээрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон бусад хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргийг хангаж ажиллаж байгаа эсэх талаарх дүгнэлт;

6.5.2.хөрөнгийн мэдээллийг хадгалах нэгдсэн системийн талаарх мэдээлэл;

6.5.3.тусгай зориулалтын компани байгуулах данс, уг дансны орлого, зарлагын урсгалын тодорхойлолт, тэдгээрийг захиран зарцуулах эрхтэй этгээдийн талаарх мэдээлэл;

6.5.4.тусгай зориулалтын компанийн хөндлөнгийн аудиторыг сонгох, өөрчлөх журам.

6.6.Энэ хуулийн 6.5.3, 6.5.4-т заасан барьцаат үнэт цаас гаргах зорилгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд хамаарахгүй.

6.7.Хороо тусгай зөвшөөрлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан үндэслэлээс гадна нээлттэй хүрээнд гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн хувьд хууль болон Хорооноос тогтоосон журмыг зөрчсөн талаар үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гаргасан хүсэлт нь үндэслэл бүхий бол хуульд заасан хугацаагаар түдгэлзүүлнэ:

2/20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг:

“20.6.Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо тогтооно.”

2 дугаар зүйл.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “удирдагч нь” гэснийг “удирдагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо олгох бөгөөд” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.15 дахь хэсэг нэмсүгэй:

“19.15. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг доор дурдсан баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ:

19.15.1. хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулгад заасан хөрөнгө, санхүүгийн хэрэгслийг тусгаарласан дансанд бүрэн төвлөрүүлсэн тухай хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодианы тодорхойлолт;

19.15.2. хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, нээлттэй төрлийн хөрөнгө оруулалтын сангийн хувьд нэгж эрхийн танилцуулга, хаалттай төрлийн болон биржээр арилжаалагддаг сангийн хувьд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн нэгж эрхийн танилцуулга;

19.15.3. биржээр арилжаалагддаг сангийн хувьд нэгж эрхийг анхдагч зах зээлд санхүүгийн хэрэгслээр солих ажиллагаа амжилттай явагдсан гэж үзсэн талаарх үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт.”

2 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.3 дахь хэсэг нэмсүгэй:

“10.3.Хувийн хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх хүн нь Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 10.1-д заасан цагдаагийн төв байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдан, гэрчилгээ авсан байна.”

2 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1, 5.6, 5.7 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх хэсэг, 6.2.1, 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3 дахь хэсгийн “тусгай” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “...болон сургалт явуулах зөвшөөрөл олгох...” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1, 6.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Хувиргасан амьд организмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.2, 13.3, 13.4 дэх хэсэг:

“13.2.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.4-т заасан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараах нотлох баримт бичгийг хавсаргана:

13.2.1.үйлчилгээний найдвартай байдлыг хангахуйц удирдлага, хяналтын системтэй болохыг нотлох баримт;

13.2.2.холболтын байгууламж, хэрэглэгчийн бүртгэл, төлбөр тооцооны системтэй болохыг нотлох баримт;

13.2.3.системийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангасныг нотлох баримт.

13.3.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8.4-т заасан энгийн зөвшөөрлийн өргөдөлд иргэн, хуулийн этгээд дараах баримт бичгийг хавсаргана:

13.3.1.хэрэглэгчид хүргэх лавлах үйлчилгээний зорилго, танилцуулга;

13.3.2.мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл;

13.3.3.мэргэшсэн хүний нөөцийн талаарх мэдээлэл.”

13.4.Зохицуулах хороо нь зөвшөөрлийн хүсэлтийг магадлан шалгахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.5-д заасан баримт бичгийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас цахим хэлбэрээр гаргуулан авна.

2/14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт:

“14.2.5.үйлчлэгч нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9-д заасан тусгай зөвшөөрөл авах тохиолдолд холбогдох нөхцөл, шаардлага болон гэрээний хэрэгжилтийг хангаагүй.”

3/14 дүгээр зүйлийн 14.2¹ дэх хэсэг:

“14.2¹.Нэмүү өртөгт тусгай дугаарлалтыг төрийн байгууллагад олгохгүй.”

4/14 дүгээр зүйлийн 14.3¹ дэх хэсэг:

“14.3¹.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.10, 9.11-д заасан тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, сонгон шалгаруулалтад оролцогчийн ирүүлсэн баримт бичгийг үнэлэх чиг үүрэг бүхий 5-аас доошгүй сондгой тооны бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Зохицуулах хорооны даргын шийдвэрээр байгуулна.”

5/15¹ дугаар зүйл:

“15¹ дүгээр зүйл.Дугаарлалт

15¹.1.Зохицуулах хороо дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө, дугаарлалтын нөөц, ашиглалтын байдалд үндэслэж дугаарлалт олгох, өөрчлөлт оруулах шийдвэр гаргана.

15¹.2.Зохицуулах хороо гамшиг, цагдаа, хүүхэд хамгаалал, эмнэлэгийн яаралтай тусламжийн дугаарлалтыг төрийн эрх бүхий байгууллагад олгоно.

15¹.3.Хэрэглэгч яаралтай тусламжийн дугаарт харилцаа холбооны сүлжээнээс үнэ төлбөргүй холбогдоно.”

6/25 дугаар зүйлийн 25.2.13, 25.2.14, 25.2.15 дахь заалт:

“25.2.13.Зохицуулах хорооноос олгоогүй дугаарлалтыг өөрийн болон нийтийн сүлжээнд үүсгэхгүй;

25.2.14.Зохицуулах хорооноос олгосон дугаарлалтыг өөрийн сүлжээнд үүсгэх;

25.2.15.дугаарлалтыг дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө болон гэрээнд заасан хамрах хүрээ, зориулалт, технологийн дагуу ашиглах.”

7/14 дүгээр зүйлийн 14.1¹ дэх хэсэг:

14.1¹.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8.4-т заасан энгийн зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг Зохицуулах хорооны даргын тушаалаар шийдвэрлэнэ.”

8/14 дүгээр зүйлийн 14.5¹ дахь хэсэг:

“14.5¹.Сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг дараах зарчмын дагуу үнэлнэ:

14.5¹.1.үзүүлэлт тус бүрийг 5-20 оноогоор үнэлэх ба нийлбэр 100 оноо байх;

14.5¹.2.үзүүлэлт тус бүрд ажлын хэсгийн гишүүдээс өгсөн дундаж онооны нийлбэрээр нэгдсэн үнэлгээг гаргах;

14.5¹.3.нэгдсэн үнэлгээгээр үзүүлэлт тус бүрийн авбал зохих онооны

50 хувиас доошгүй, нийт 70 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд шаардлага хангасанд тооцох.”

2 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт:

“3.1.5."үйлчлэгч" гэж харилцаа холбоо, радио долгион, өргөн нэвтрүүлэг, шуудангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;”

2/9 дүгээр зүйлийн 9.1.15 дахь заалт:

“9.1.15.зөвшөөрөл эзэмшигчийн дугаарлалт ашиглахад тавигдах нөхцөл, шаардлагыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;”

3/13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт:

“13.1.3.тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө.”

4/14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг:

“14.6.Сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийн үнэлгээг энэ хуулийн 14.5-д заасан нөхцөлийн дагуу ажлын 10 өдөрт багтаан үнэлж, хамгийн өндөр үнэлгээ авсан этгээдэд тусгай зөвшөөрөл олгоно. Сонгон шалгаруулалтын баримт бичгийг үнэлэх хугацааг шаардлагатай тохиолдолд 1 удаа ажлын 5 өдрөөр сунгаж болно.”

3 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.18 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1, 12.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3, 14.12 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, 19¹ дүгээр зүйлийн 19^{1.1} дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.18 дахь заалтын “9.11-д” гэснийг “9.11, 9.13-г” гэж, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “10” гэснийг “7” гэж, 25 дугаар зүйлийн “25.2.3” заалтын дугаарыг “25.2.16” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн гарчгийн “ТУСГАЙ” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтын “сүлжээний” гэснийг, 13 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “Сонгон шалгаруулалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.” гэснийг, 14.13 дахь хэсгийн “, нөхцөл, шаардлага” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “шуудангийн сүлжээ” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.12 дахь хэсэг:

“18.12.Энэ хуулийн 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргагчийн баримт бичгийг магадлан шалгахдаа цацрагийн үүсгүүрийн ангилал, идэвх, төрөл, түүнд холбогдох эрсдэлийг харгалзан үзнэ.”

2/19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэг:

“19.9.Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 5-д заасны дагуу цахим хэлбэрээр гаргаж болно.”

2 дугаар дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг:

“26.3.Зөвшөөрөл олгох эрх байгууллага зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл тогтоогдсон тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.

2/38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг:

“38.1.Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг цацрагийн хамгаалалт, аюулгүйн шаардлагыг хангасан талаарх мэргэжлийн байгууллагын үнэлгээ хийлгэсэн зориулалтын хадгалах байранд Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.21-д заасан тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгална.”

3 дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 36 дугаар зүйлийн 36.1.7 дахь заалтын “төрийн захиргааны байгууллагын” гэснийг “цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9.2, 18.9.3, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.11 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шуудангийн тухай хуульд 10¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“10^{1.5}.Хуулийн этгээд зөвшөөрөл авах өргөдлийг Зохицуулах хорооноос баталсан маягтын дагуу гаргах бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана:

10^{1.5.1}.шуудангийн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, үйлчилгээнд ашиглах анхан шатны маягтууд, эдийн засгийн тооцоо судалгаа бүхий батлагдсан бизнес төлөвлөгөө;

10^{1.5.2}.бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, үйлчилгээний үнэ тарифын тооцоолол, санхүүгийн чадавхыг нотолсон баримт;

10^{1.5.3}.шуудангийн илгээмж хүргэх хугацаа, тээвэрлэлтийн болон шуудангийн технологи ажиллагааны шат дамжлагын зураглал;

10^{1.5.4}.шуудангийн сүлжээ, үйлчилгээг зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөө /шуудан илгээмжийн хадгалалт, ажлын байрны зохион байгуулалт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон гамшгийн үеийн аюулгүй байдал/;

10^{1.5.5}.улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тохиолдолд хилийн чанад дахь эрх бүхий хуулийн этгээдтэй хамтран ажиллах харилцаа тогтоосныг нотлох баримт бичиг.

10^{1.6}.Зохицуулах хороо нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.13-т заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулах журмаар олгоно.

10^{1.7}.Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, оролцогчийн ирүүлсэн баримт бичгийг үнэлэх үүрэг бүхий 5-аас доошгүй сондгой тооны бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Зохицуулах хорооны даргын шийдвэрээр байгуулна.

10^{1.8}.Зохицуулах хороо сонгон шалгаруулалтын баримт бичгийг баталж, сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө урилгыг олон нийтэд ил тод мэдээлэх бөгөөд энэ хугацааг нэг удаа 14 хоногоор сунгаж болно.

10^{1.9}.Сонгон шалгаруулалтад оролцогч нь энэ хуулийн 10^{1.5}-д заасны дагуу хүсэлтийг Зохицуулах хороонд ирүүлнэ.

10¹.10.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн энэ хуулийн 10¹.5-д заасан баримт бичгийн хүрээнд үзүүлэлт тус бүрийг 5-25 хүртэлх оноогоор үнэлэх ба нийлбэр нь 100 оноо байна.

10¹.11.Сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийн үзүүлэлт тус бүрт ажлын хэсгийн гишүүдээс өгсөн дундаж онооны нийлбэрээр нэгдсэн үнэлгээг гаргана. Нэгдсэн үнэлгээгээр үзүүлэлт тус бүрийн авбал зохих онооны 50 хувиас доошгүй, нийт 70 ба түүнээс дээш оноо авсан баримт бичгийг шаардлага хангасанд тооцно.

10¹.12.Сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийн үнэлгээг энэ хуулийн 10¹.10-т заасны дагуу ажлын 10 өдөрт багтаан үнэлж, Зохицуулах хороо шийдвэр гаргана. Сонгон шалгаруулалтын баримт бичгийг үнэлэх хугацааг шаардлагатай тохиолдолд 1 удаа ажлын 5 өдрөөр сунгаж болно.

10¹.13.Энэ хуулийн 10¹.12-т заасны дагуу шалгарсан этгээд эрх бүхий этгээдээс шалгарсан тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээг байгуулаагүй тохиолдолд дараагийн өндөр үнэлгээ авсан этгээдтэй гэрээ байгуулна.

10¹.14. Энэ хуулийн 10¹.6-д заасан сонгон шалгаруулалтад нэг этгээд хүсэлт ирүүлсэн тохиолдолд энэ хуулийн 10¹.12-т заасныг баримтлана.

10¹.15.Сонгон шалгаруулалтад сонирхогч этгээд хүсэлт ирүүлээгүй, оролцогч этгээдийн ирүүлсэн хүсэлт хуульд заасан шаардлага хангаагүй, энэ хуулийн 10¹.13-т заасан дараагийн этгээд гэрээ байгуулаагүй бол тухайн жилд дахин сонгон шалгаруулалт зарлахгүй.

10¹.16.Зохицуулах хороо Харилцаа холбооны тухай хуулийн 14.11-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзаж, мөн хуулийн 14.12, 15.1-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгоно.

2 дугаар зүйл.Шуудангийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсэг:

“10¹.1.Зохицуулах хороо Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.13-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаатай, 9.15-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаатай олгож, хугацааг анх олгосон хугацаагаар сунгана.”

3 дугаар зүйл.Шуудангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Шуудангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “4.2.3-т заасан дотоодын хэрэглээний шуудангийн журмыг Харилцаа холбооны зохицуулах хороо тус тус” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Шуудангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3, 10¹ дүгээр зүйлийн 10¹.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Шүүх шинжилгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/11¹ дүгээр зүйл:

**“11¹ дүгээр зүйл. Зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт,
үйл ажиллагаа**

11^{1.1}. Зөвлөл нь 16 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

11^{1.2}. Зөвлөлийн дарга нь Шүүх шинжилгээний төв байгууллагын шинжилгээний үйл ажиллагаа эрхэлсэн дэд дарга байна.

11^{1.3}. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь шүүх шинжилгээний төв байгууллагын шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажил хариуцсан нэгжийн дарга байна.

11^{1.4}. Энэ хуулийн 11.2-т заасан төлөөлөл нь мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, ял шийтгэлгүй байна.

11^{1.5}. Зөвлөлийн гишүүдийн 30-аас доошгүй хувь нь шүүх шинжилгээний туршлагатай байна.

11^{1.6}. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн баримт бичгийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч, хянан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр 3 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.

11^{1.7}. Зөвлөлийн гишүүнд хянан магадалгаа хийхэд урамшуулал олгоно.

11^{1.8}. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

11^{1.9}. Зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд 1-ээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд хуралдааныг Зөвлөлийн дарга удирдана. Даргын эзгүйд түүний томилсон зөвлөлийн гишүүн удирдана.

11^{1.10}. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл зөвлөлийн гишүүний саналаар хуралдуулж болно.

11^{1.11}. Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд Зөвлөлийн даргад албан ёсоор мэдэгдэж, хуралдаанаар хэлэлцэх асуудалд бичгээр санал өгч болно.

11^{1.12}. Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох үндэслэлийг тодорхойлсон баримт бичигт Зөвлөлийн даргын шийдвэрээр томилогдсон 3 гишүүнтэй комисс /цаашид “Комисс” гэх/ хянан магадалгаа хийнэ.

11^{1.13}. Комисс баримт бичгийн үнэн бодитой, шаардлага хангасан эсэхэд хянан магадалгаа хийж, зөвлөлөөс гарах санал, дүгнэлтийн төсөл боловсруулна.

11^{1.14}. Комиссын гаргасан санал, дүгнэлтийг зөвлөлийн гишүүдийн 75-аас доошгүй хувийн ирцтэйгээр хэлэлцэж, 60-аас доошгүй хувийн саналаар батална.

11^{1.15}. Зөвлөлийн санал, дүгнэлтэд зөвлөлийн дарга гарын үсэг зурна. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, тэмдэглэлд зөвлөлийн дарга, хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

11^{1.16}. Зөвлөлөөс гарсан санал, дүгнэлтийг шүүх шинжилгээний төв байгууллагын даргад уламжилж, шийдвэрлүүлнэ."

2/11² дугаар зүйл:

“11² дугаар зүйл. Зөвлөлийн ажлын алба, түүний чиг үүрэг

11^{2.1}. Зөвлөл нь Ажлын алба /цаашид “Ажлын алба” гэх/-тай байх бөгөөд Ажлын албаны чиг үүргийг Шүүх шинжилгээний төв байгууллагын шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажил хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

11^{2.2}. Ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11^{2.2.1}. зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримт, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулах;

11^{2.2.2}. зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хэлэлцэх асуудлын жагсаалтыг гаргаж зөвлөлийн даргаар батлуулах;

11^{2.2.3}. шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох үндэслэлийг тодорхойлсон баримт бичгийг хүлээн авч, зөвлөлийн даргад танилцуулан, хянан магадалгаа хийх Комисс томилуулах;

11^{2.2.4}. комиссын гаргасан зөвлөлийн санал, дүгнэлтийн төслийг зөвлөлийн гишүүдэд хуралдаан эхлэхээс 3 хоногийн өмнө цахимаар хүргүүлэх;

11^{2.2.5}. зөвлөлийн гаргасан санал, дүгнэлтийг шүүх шинжилгээний төв байгууллагын даргад танилцуулж, шийдвэрлүүлэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

11^{2.2.6}. шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,

түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгосон шийдвэрээр мэдээллийн сан үүсгэж, мэдээллийн санг нийтэд танилцуулах;

11².2.7. шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа дууссан бол шүүх шинжилгээний төв байгууллагын даргад танилцуулан шийдвэрлүүлэх.”

3/11 дүгээр зүйлийн 11.13, 11.14, 11.15 дахь хэсэг:

“11.13. Шүүх шинжилгээний төв байгууллага нь шүүх шинжилгээний мэргэжлийн болон үргэлжилсэн сургалтыг зохион байгуулж болно.

11.14. Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нь шүүх шинжилгээний төв байгууллагаас зохион байгуулах давтан сургалтад жил тутам хамрагдаж, тогтсон багц цагийг хангана.

11.15. Энэ хуулийн 11.12-т заасан сургалтыг зохион байгуулах, багц цаг тооцох журмыг Шүүх шинжилгээний төв байгууллагын дарга батална.”

2 дугаар зүйл. Шүүх шинжилгээний тухай хуулийн 11.4.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“11.4.5. гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байгаагүй байх”

3 дугаар зүйл. Шүүх шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.12.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.4.3.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.19, 13.21-т заасан зөвшөөрөл эзэмшигчээс бусад байгууллага, хувь хүнд эм ханган нийлүүлэх, худалдах;”

2 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 7 дугаар зүйлийн 7.5 дэх хэсгийн “19.10-т” гэснийг “19.5-д” гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Эрүүл мэндийн тухай хуулийн 19.17-д заасныг үндэслэнэ.” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан журмыг баримтална.” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй.

1/25 дугаар зүйлийн 25.8.5, 25.8.6, 25.8.7 дахь заалт:

“25.8.5.тухайн төрөлжсөн мэргэшлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг ажиллуулах үндэслэлийг тодорхойлсон эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт;

25.8.6.гадаадын эмнэлгийн мэргэжилтний танилцуулга;

25.8.7.гадаадын эмнэлгийн мэргэжилтний тухайн улсын бүртгэлийг нотлох баримт бичиг.”

2/25.9.3 дахь заалт:

“25.9.3.Засгийн газрын гэрээ, хэлэлцээрт заасныг хэрэгжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, гадаадад эмчлүүлэх иргэдийн тоог бууруулах, байгалийн гамшиг, осол, нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлт үүссэн тохиолдолд 30 хоног хүртэлх хугацаагаар.”

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн дараах зүйл, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/19 дүгээр зүйл:

“19 дүгээр зүйл. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах

19.1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зориулалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөцийн зохих шаардлага хангасан өмчийн аливаа хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл /цаашид "зөвшөөрөл" гэх/ олгоно.

19.2. Улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар тусгай зөвшөөрөл /цаашид "зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага" гэх/ олгоно.

19.3.Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага зөвшөөрөл олгох эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, эсхүл Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.7-д заасан хуулийн этгээдэд шилжүүлж болно.

19.4.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээлэлд Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага, тусламж, үйлчилгээний төрлийг тусгана.

19.5.Эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна өргөдөлд дараах мэдээлэл, баримт бичгийг хавсаргана:

19.5.1.зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны төрөл, чиглэл;

19.5.2.барилга байгууламжийн зориулалтыг нотлох баримт бичиг;

19.5.3.ажлын байрны дотоод, гадаад орчны төлөвлөлтийн зураглал;

19.5.4.хүний нөөцийн мэдээлэл, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх

зөвшөөрөл;

19.5.5.техник, технологи, тоног төхөөрөмжийн хүчин чадал, баталгаажилт, стандарт болон өмчлөлийн талаарх мэдээлэл.

19.6.Тусгай зөвшөөрлийн баримт бичигт дараах шаардлага тавигдана:

19.6.1.энэ хуулийн 19.5.2-т заасан баримт бичиг нь үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, шинээр ашиглалтад орсон барилга бол улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан актын хуулбар байх;

19.6.3.энэ хуулийн 19.5.4, 19.5.5-д заасан баримт бичиг нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын шаардлага хангасан байх.

19.7.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 19.5-д заасан хүсэлт гаргагчийн баримт бичгийг хүлээн авч, өргөдлийг хянан үзэх орон тооны бус шинжээчийн баг томилон ажиллуулна.

19.8.Энэ хуулийн 19.7-д заасан шинжээчийн баг баримт бичгийн бүрдлийг дараах байдлаар хянан үзнэ:

19.8.1.энэ хуулийн 19.5.2, 19.5.3, 19.5.4, 19.5.5-д заасан баримт бичиг, түүний хэрэгжилтийг газар дээр нь магадлан шалгах;

19.8.2.тусгай зөвшөөрөл олгох эсэх дүгнэлтийг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

19.9.Тусгай зөвшөөрлийг тухайн байгууллагад анх удаа олгож байгаа бол гурав, сунгаж байгаа бол таван жилийн хугацаагаар олгоно.

19.10.Зөвшөөрлийн хугацааг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуульд заасан журмын дагуу сунгана.

19.11.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

19.11.1.нэмэлт, өөрчлөлт, оруулахыг хүссэн хүсэлт;

19.11.2.эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүний мэдээлэл, хөдөлмөрийн гэрээ;

19.11.3.техник, технологи, тоног төхөөрөмжийн хүчин чадал, чанар, стандарт болон өмчлөлийн талаарх мэдээлэл;

19.11.4.барилга байгууламж болон хаяг, байршил өөрчлөгдөж байгаа тохиолдолд барилга байгууламжийн зориулалт, зураг төслийн дагуу баригдсан эсэх, улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан акт, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, ажлын байрны дотоод, гадаад орчны төлөвлөлт зураглал.”

2/25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг:

“25.3.Эмчлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгоно.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/20¹ дүгээр зүйлийн 20¹.2 дахь хэсэг:

“20¹.2.Энэ хуулийн 20¹.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл, шаардлагыг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2/21 дүгээр зүйлийн 21.2.11, 21.2.12 дахь заалт:

“21.2.11.барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комиссын дүгнэлт;

21.2.12.экспортлох цахилгаан эрчим хүчийг худалдан авахыг нотлох баримт.”

2 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтын “үндэслэл” гэсний дараа “, үзүүлэлт” гэж, мөн зүйлийн 21.2.8 дахь заалтын “чадавх” гэсний дараа “, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудитын тайлан” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт:

“9.1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, хүчин чадал, үйлчлэх хүрээ, түгээх эрчим хүчний хэмжээг тогтоох, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг хянах;”

2/20¹ дүгээр зүйлийн 20¹.1 дэх хэсэг:

“20¹.1.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.7, 14.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг сонирхогч хуулийн этгээд цахим хэлбэрээр эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.”

3/21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг:

“21.1.Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай

зөвшөөрөл авах, сунгуулах өргөдөл гаргасан хуулийн этгээд Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-т зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ:

21.1.1.энэ хуулийн 20¹.1-д заасан эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

21.1.1.а.хүний нөөцийн талаарх мэдээлэл;
21.1.1.б.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ.

21.1.2.энэ хуулийн 20¹.1-д заасан эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааг сунгуулах өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

21.1.2.а.гүйцэтгэсэн ажлын тайлан;
21.1.2.б.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ.”

4/21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалт:

“21.2.3.үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах эрчим хүчний төрөл, чанарын үзүүлэлт, эрх бүхий байгууллагаас тогтоосон түгээх эрчим хүчний хэмжээг хангасныг нотлох баримт;”.

4 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “1.5 МВт хүртэл хүчин чадалтай” гэснийг “нэгдсэн сүлжээнд холбогдохгүй” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.4, 21.9 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.21 дэх заалтын “гэрээний загварыг батлах” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8, 21.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

**СЭДЭВ: ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 8.1 ДҮГЭЭР ЗҮЙЛД ЗААСАН
“ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ”-ТЭЙ ХОЛБОГДОХ ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2024 он**

	АГУУЛГА	
ХУРААНГУЙЛСАН ҮГСИЙН ЖАГСААЛТ		2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ		3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ		3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ		4
1.1 Үнэлгээ хийх шалтгаан тодорхойлох		4
1.2 Үнэлгээний хүрээг тогтоох		5
1.3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт		6
1.4 Харьцуулах хэлбэрийг сонгох		6
1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох		7
1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох		8
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ		9
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ		11
3.1 ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМЖИЛТ		11
3.1.1 Зөвшөөрөл олгох процессын цахимжилт		11
3.1.2 Зөвшөөрлийн нэгдсэн сан үүсгэх		20
3.2 ЗӨВШӨӨРЛИЙН ТОО ЦӨӨРЧ, ЗӨВШӨӨРЛӨӨС ҮҮСЧ БУЙ ДАРАМТ БУУРЧ БАЙГАА ЭСЭХ		21
3.2.1 Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар үүссэн нөхцөл байдал		21
3.2.2 Зөвшөөрлийн тухай хуулиас гадуур зөвшөөрлийн харилцааг зохицуулахгүй байх 28		28
3.2.3 Бизнесийн дарамт бууруулсан эсэх		31
3.3 ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХИЙДЭЛ, ЗӨРЧИЛ АРИЛЖ, УЯЛДАА ХОЛБОО САЙЖИРСАН ЭСЭХ		33
3.3.1 Зөвшөөрлийн процессыг хэм хэмжээний актаар зохицуулахгүй байх		33
3.3.2 Зөвшөөрөл олгох эрхийг бусдад шилжүүлэхгүй байх		36
3.3.3 Зөвшөөрлийн тухайн хууль болон салбарын хуулийн хэм хэмжээний өрсөлдөөн, давхардал, нэр томъёоны зөрүүтэй байдал		37
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ		39
ТАВ. ЗӨВЛӨМЖ		43
ЗУРГАА. ЭХ СУРВАЛЖ		59
ДОЛОО. ХАВСРАЛТ		61

ХУРААНГУЙЛСАН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ЗтХ	Зөвшөөрлийн тухай хууль
ГТСМТТ	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ААНТЗтХ	Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль
ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын их хурал

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 01	Шалгах хүснэгт
Хүснэгт 02	Судлагдсан байдал
Хүснэгт 03	Ярилцлага хийх албан тушаалтнуудын жагсаалт
Хүснэгт 04	Танилцуулгын жагсаалт
Хүснэгт 05	Хуулийн хэлэлцүүлгийн тэмдэглэл
Хүснэгт 06	"И-Монгол академи" УТҮГ-аас авсан мэдээлэл
Хүснэгт 07	Тусгай зөвшөөрлийн үйлчилгээ цахимсан байдал
Хүснэгт 08	Эрх бүхий байгууллагуудын хөгжүүлсэн цахим систем
Хүснэгт 09	Цахимжуулах боломжгүй тусгай зөвшөөрөл
Хүснэгт 10	2024 оны байдлаарх зөвшөөрлийн тоо, статистик
Хүснэгт 11	Захиргааны ерөнхий хууль болон Зөвшөөрлийн тухай хуулийн уялдаа холбоо

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 01	Зөвшөөрлийн цахимжилт 2023 оны 1 дүгээр сарын байдлаар
Зураг 02	Зөвшөөрлийн цахимжилт 2024 оны 12 дугаар сарын байдлаар
Зураг 03	Зөвшөөрлийн цахим шилжилт
Зураг 04	License.mn сайтад ТЗ-ийн хүсэлт гаргах цонх байхгүй байгаа болохыг харуулав.
Зураг 05	Эрүүл мэндийн яамны https://tzmoh.gov.mn системийн мэдээлэл
Зураг 06	Зөвшөөрлийн нэгдсэн сан https://license.mn системийн мэдээлэл
Зураг 07	Улаанбаатар хотод худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн бүртгүүлэх систем

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэв.

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1 Үнэлгээ хийх шалтгаан тодорхойлох

Монгол Улсын Засгийн Газрын (цаашид ЗГ гэх) 2024-2028 оны “Үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг Монгол Улсын Их Хурлын (цаашид УИХ гэх) 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан.

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2-т “Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин” бүрдүүлэх зорилтын 3.2.2.4-т Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ хэмээн тодорхойлсон.

Зөвшөөрлийн хуулийн үзэл баримтлалын 3-т хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагаварыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжсэн тохиолдолд дараах эерэг нөлөөг бий болгоно гэжээ.

- Хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх Иргэний хуулийн суурь үзэл баримтлалыг баталгаажуулж, Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхлэхийг хориглосон үйл ажиллагаа болон зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа чиглэл, төрөл, эдгээр харилцаатай холбоотой суурь харилцаа тодорхой болно.
- Зөвшөөрлийг олгох, сунгах цахим хэлбэрээр зохион байгуулж болох зохицуулалт хуульчлагдаж, иргэдэд чирэгдэл хүнд сурталгүй төрийн үйлчилгээг хүргэх, зөвшөөрөл олгох харилцаа ил тод, хяналттай болно.
- Зах зээлийн харилцаан дахь оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийг дэмжих зохицуулалтыг оновчтой хийх, түүнчлэн зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах шаардлага тодорхой болох, нөгөө талаас үндэсний аюулгүй байдал, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах цэгцтэй механизмыг бүрдүүлэхэд чухал алхам болно.

- Хууль тогтоомжийн хийдэл, зөрчил арилж, уялдаа холбоо сайжирна гэж тодорхойлсон.

Хууль тогтоомжийн тухай хууль (2015) 8 дугаар зүйлийн 8.1-т Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна: 8.1.1.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;

ХТХ-ийн 51 дүгээр зүйлд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг боловсруулах харилцааг зохицуулж өгсөн. 51.1-т Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, багц хуулийн төсөл боловсруулахад түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно гэж заасны дагуу боловсруулдаг.

1.2 Үнэлгээний хүрээг тогтоох

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-т үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ гэж тодорхойлсон.

Захиалагчаас өгсөн үнэлгээний даалгаврын хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэхь заалтад тусгагдсан тусгай зөвшөөрлүүдийн хэрэгжилт, хэрэгжилтийн үр дагаврыг судалж үнэлгээг боловсруулна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 8.1-т 14 салбарын 257 төрлийн “тусгай” зөвшөөрлийн жагсаалт, түүний олгох эрх бүхий байгууллага, албан тушаалны жагсаалтыг баталсан. Тухайн зохицуулалтын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно гэж заасны дагуу үнэлгээг боловсруулна.

Үнэлгээний хязгаарлалт

Үнэлгээний мэдээлэл цуглуулах хугацаа богино байсан тул нээлттэй мэдээллийн хүрээнд (legalinfo.mn сайтад байрласан хуулиуд болон хэм хэмжээ тогтоосон актууд, салбар яамд болон агентлагын цахим хуудас, эдгээрт байрласан мэдээлэл) болон цахимжуулах ажлын хариуцан ажиллаж буй Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, түүний харьяа И-Монголиа Академи УТҮГ, Эдийн засаг хөгжлийн яамны холбогдох албан тушаалтнуудтай ярилцах хэлбэрээр судалгааны мэдээллийг цуглуулсан.

Үнэлгээ боловсруулах аргачлалын дагуу бусад төрлийн судалгааны аргуудыг хэрэглэх боломж нөхцөл хомс байсан тул хэрэглээгүй болно.

1.3 Үнэлгээний шалгуур үзүүлэлт

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

“Зорилгод хүрсэн түвшин” тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь зохимжтой байдаг. Энэхүү онцлог нь тус судалгааны зорилгод нийцэж буй юм. Мөн зорилгод хүрсэн түвшин нь хэдийгээр харьцангуй хийсвэр ч тус шалгуур шалгуур үзүүлэлт нь хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ерөнхий дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй байдаг.

Энэхүү шалгуур үзүүлэлтээр Зөвшөөрлийн тухай хуулийг анх батлахад тавьсан зорилтог түвшинд хүрсэн эсэхийг тогтооно. Үндсэн зорилгыг тодорхойлохдоо Зөвшөөрлийн тухай хуулийг анх батлахад гаргасан үзэл баримтлал, танилцуулга зэргээс хуулийг баталж хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрэхээр зорьсон зорилгыг тодорхойлж, тэрхүү зорилгодоо хүрсэн эсэхийг шалгах юм.

1.4 Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран, аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгодог. Харьцуулах доор дурдсан хэлбэрүүд байна. Үүнд:

- 1/ байх ёстой ба одоо байгаа;
- 2/ хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш;
- 3/ хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- 4/ тохиолдол судлах.

Дээрхээс “байх ёстой ба одоо байгаа” болон “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг энэхүү судалгаанд тохиромжтой гэж үзэж сонгов.

“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулах хэлбэрээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн болон үндсэн хуулийн эрх зүйн онолын хувьд тогтоосон шаардлага зэрэгт харьцуулах хэлбэрээр тус хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохыг зорив.

“Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрээр Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дэх заалт холбоотой хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Баримт бичиг судлах буюу Зөвшөөрлийн хуулийн 8.1-т заасан “тусгай” зөвшөөрөл тус бүрээр дараах шалгах хүснэгтийн дагуу мэдээллийг нарийвчлан үнэлж, анхан шатны үнэлгээ мэдээллийг цугуулна. Ингэхдээ Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан 14 салбар, ангилалд тусгагдсан нийт 257 тусгай зөвшөөрлийг нэг бүрчлэн шалгах ба үүнд тухайн тусгай зөвшөөрлийг олгох процесс нь хуулиар зохицуулагдаж байна уу, аль эсвэл хэм хэмжээний актаар зохицуулагдаж байна уу, бүрдүүлэх бичиг баримт нь тодорхой байгаа эсэх, зөвшөөрөл олгох хүсэх процесс цахимжсан эсэхэд нэг бүрчлэн шалгаж дүгнэлт өгнө.

Үнэлгээний үр дүнг хууль хэрэгжиж эхлэхээс өмнөх болон хэрэгжиж эхэлснээс өнөөдрийг хүртэлх хугацаанд хэрэгжилтийн нөхцөл, цахимжилт, материаллаг болон процессын харилцааг зохицуулж буй давхардсан зохицуулалт, түүнээс үүсч буй эерэг, сөрөг үр дагаваруудын талаар үнэлгээ өгнө.

Хүснэгт №1 Шалгах хүснэгт

№	ТУСГАЙ ЗӨВШӨӨ РӨЛ	ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨ Л ОЛГОХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД	НАРИЙВЧИЛ САН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛА ЛТ	ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ПРОЦЕСС	БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ	ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ПРОЦЕСС НЬ ЦАХИМЖСА Н ЭСЭХ
Салбар						
				Хуулиар зохицуулсан <input checked="" type="checkbox"/>	Тодорхой	Тийм
				Журмаар зохицуулсан эмэх	Тодорхой бус <input checked="" type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>
Дүгнэлт:						

1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг батлахдаа, хуулийн төсөл батлагдаж хэрэгжсэнээр үүсэх эерэг үр дагаварийн талаар хуулийн төсөл болон төслийн үзэл баримтлалд тусгагдсан байдаг. Үүний дагуу хуулийн төслийг анх батлахдаа тавьж байсан зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг шалган тогтоох үүднээс дараах асуултуудаар хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг шалгана.

- Зөвшөөрөл авахад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, тэдгээрийг цахимаар мэдүүлэх процессыг цахимжуулах зорилтод хүрсэн эсэх, хүрч чадаагүй бол түүний шалтгаан нөхцлийг судлах;

- Зөвшөөрлийн тоог бууруулж аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч буюу бизнес эрхлэгчдэд ирэх дарамтыг бууруулах зорилтод хүрсэн эсэх, хүрээгүй бол яагаад гэдэг шалтгааныг тодруулах;
- Зөвшөөрлийн тухай хууль батлагдсанаар тусгай болон энгийн зөвшөөрөл хүсэх процесс, бүрдүүлэх бичиг баримт, холбогдох эрх зүйн орчин нь тодорхой болсон эсэх талаар судлах;

“Практикт нийцэж байгаа байдал” тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

- Хуулийн зохицуулалтыг бодит практикт хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл нөлөөлж буй хүчин зүйл;
- Зөвшөөрлийн тухай хууль батлагдсанаар хууль хэрэглээний эрэмбэ, уялдаа холбоо хэрхэн хангагдаж байгаа эсэх;
- Зөвшөөрлийн тухай хуулиар салбарын хуулиар зохицуулсанаас бусад тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэглэхээр (ЗтХ-ийн 1.3.3) хуульчилж өгсөн, энэ нь бодит байдал практикт хэрхэн хэрэгжиж байгааг тодруулах;
- Зөвшөөрлийн тухай хуулиар зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотойгоор хэм хэмжээний акт гаргахыг хориглосон (ЗтХ-ийн 1.5.17) бөгөөд энэ заалт практикт хэрэгжиж буй байдлыг судлах;

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Өмнөх боловсруулагдсан зөвшөөрлийн харилцааны хүрээнд боловсруулагдсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглана.

Холбогдох субъектээс судалгаа авах: Ярилцлагын аргаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харьяа И-Монголиа Академи УТҮГ-ын албан тушаалтан, Эдийн засаг хөгжлийн яамны хариуцсан албан тушаалтнуудаас зөвшөөрлийг цахимжуулахад тулгарч хүндрэл бэрхшээл, одоогийн явц зэргийг тодруулах.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү судалгаанд ашиглагдсан эх сурвалжийн жагсаалт:

Хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол

1. Иргэний хууль, 2002 он
2. Захиргааны ерөнхий хууль, 2015 он
3. Зөвшөөрлийн тухай хууль, 2022 он
4. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан 14 ангилал, салбарын холбогдох бүхий л хуулиуд.

5. Нийслэлийн иргэний иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34 дүгээр “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам батлах тухай” тогтоол
6. Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 251 дүгээр “Журам батлах тухай” тогтоолын хавсралтаар “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийн бүртгэл, лавлагаа, мэдээлэл өгөх журам”

Ном, гарын авлага, өгүүлэл, нийлэл

Хүснэгт №2. Судлагдсан байдал

Д/д	СУДЛААЧ, БАЙГУУЛЛАГА	СУДАЛГААНЫ НЭР	ОГНОО
1	Т.Болор-Эрдэнэ	Хүрээлэн буй орчинд хохирол урчуулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим үйл ажиллагааг эрхлэхэд зөвшөөрөл олгох эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа (Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2001, Зөвшөөрлийн тухай хууль 2022)	2022.10.01
2	Judilogy Хэргийн мэдээллийн хуудас-Легалдата цахим хуудас	Хууль тогтоомжийн тодорхойгүй байдал нь тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл болохгүй(Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл)	2024.01.19

Хүснэгт №3. Ярилцлага хийх албан тушаалтнуудын жагсаалт

№	Нэр	Албан тушаал
1	О.Төгөлдөр	И-Монголиа Академи УТҮГ-ын цахим засаглалын хэлтсийн дарга
2	М.Хишигдэлгэр	И-Монголиа Академи УТҮГ-ын цахим засаглалын хэлтсийн шинжээч
3	Т.Золзаяа	Эдийн засаг хөгжлийн яам газрын дарга
4	Я.Хулан	Эдийн засаг хөгжлийн яам ахлах мэргэжилтэн

Хүснэгт №4. Танилцуулгын жагсаалт

№	Нэр	Танилцуулгын нэр
1	Хот суурины ус хангамж, ариутгах татуургын	Ус хангамж, ариутгах татуургын ашиглах, үйлчилгээний тусгай зөвшөөрөл

	ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо	
2	Монгол банк	Монголбанкнаас олгох зөвшөөрөл
3	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Тусгай зөвшөөрлийн танилцуулга
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, өөрчлөлт, шинэчлэлт
5	Боловсролын яам	Зөвшөөрлийн тухай хуулий хэрэгжилт, анхаарах асуудал
6	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт 2023-2024
7	Монгол Улсын Засгийн газар	Төрийн бүтээмжийн үндэсний хорооны хуралдаан
8	Зам, тээврийн яам	Зөвшөөрлийн тухай хуулийн зам, тээврийн салбарт хамаарах зохицуулалт
9	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олгож буй тусгай зөвшөөрлийн мэдээлэл
10	Санхүүгийн зохицуулах хороо	Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн танилцуулга/
11	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах тусгай болон энгийн зөвшөөрлийн талаарх мэдээлэл
12	Эрчим хүчний яам	Тусгай зөвшөөрөл
13	Монголын хуульчдын холбоо	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
14	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар	Тусгай зөвшөөрлийн мэдээлэл
15	Гаалийн ерөнхий газар	Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт
16	Монгол улсын засгийн газар	Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны танилцуулга
17	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
18	Нийслэлийн эрүүл мэндийн газар	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага
19	Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн олголт, тулгамдсан асуудал
20	Эдийн засаг хөгжлийн яам	Зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх

21	Ашигт малтмал газрын тосны газар	Зөвшөөрлийн тухай хууль батлагдсанаас хойш АМГХ, УУХҮС А-48 тушаалыг баримтлан олгосон сонгон шалгаруулалтын мэдээлэл
22	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Төрийн бүтээмжийн үндэсний хорооны хуралдаан
23	Зам тээврийн яам	Зөвшөөрлийн тухай хуулийн зам, тээврийн салбарт хамаарах зохицуулалт

Хүснэгт №5. Хуулийн хэлэлцүүлгийн тэмдэглэл

№	Нэр	Танилцуулгын нэр	ОГНОО
1	МҮХАҮТ	Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөө хэлэлцүүлэг амжилтай зохион байгуулагдлаа ¹	2024.02.27
2	МҮХАҮТ	Зөвшөөрлийн хуулийн 1 дүгээр хэлэлцүүлгийн тэмдэглэл	2024.10.02
3	МҮХАҮТ	Зөвшөөрлийн хуулийн 2 дугаар хэлэлцүүлгийн тэмдэглэл	2024.10.03

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Тогтоосон шалгуур үзүүлэлт болон шалгуур үзүүлэлтийг томьёолсон асуултуудад хариулах замаар үнэлгээг хийнэ. Үүнд:

- Зөвшөөрөл авахад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, тэдгээрийг цахимаар мэдүүлэх процессыг цахимжуулах зорилтод хүрсэн эсэх, хүрч чадаагүй бол түүний шалтгаан нөхцлийг судлах;
- Зөвшөөрлийн тоог бууруулж аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч буюу бизнес эрхлэгчдэд ирэх дарамтыг бууруулах зорилтод хүрсэн эсэх, хүрээгүй бол яагаад гэдэг шалтгааныг тодруулах;
- Зөвшөөрлийн тухай хууль батлагдсанаар тусгай болон энгийн зөвшөөрөл хүсэх процесс, бүрдүүлэх бичиг баримт, холбогдох эрх зүйн орчин нь тодорхой болсон эсэх талаар судлах;
- Хуулийн зохицуулалтыг бодит практикт хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл нөлөөлж буй хүчин зүйл;
- Зөвшөөрлийн тухай хууль батлагдсанаар хууль хэрэглээний эрэмбэ, уялдаа холбоо хэрхэн хангагдаж байгаа эсэх;
- Зөвшөөрлийн тухай хуулиар салбарын хуулиар зохицуулсанаас бусад тохиолдолд Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэглэхээр (ЗгХ-ийн 1.3.3) хуульчилж өгсөн, энэ нь бодит байдал практикт хэрхэн хэрэгжиж байгааг тодруулах;
- Зөвшөөрлийн тухай хуулиар зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотойгоор хэм хэмжээний акт гаргахыг хориглосон (ЗгХ-ийн 1.5.17) бөгөөд энэ заалт практикт хэрэгжиж буй байдлыг судлах;

¹ <https://www.mongolchamber.mn/a/1545> 2024.12.20-ны өдөр хандав.

3.1 ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМЖИЛТ

3.1.1 Зөвшөөрөл олгох процессын цахимжилт

2022 онд Зөвшөөрлийн тухай хууль батлагдаж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн Газраас 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 233 дугаар “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан.

Тогтоолын нэгдүгээр заалтаар “...Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс олгох зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт, тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдөрт багтаан цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ (Т.Батбилэг), “И-Монгол академи” УТҮГ (Б.Мягмарнаран)-т тус тус даалгасугай...” гэж заасан.

Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан бүх төрлийн зөвшөөрлийг цахим хэлбэрээр шийдвэрлэх, цахимжуулах үйл ажиллагааг “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ, “И-Монгол академи” УТҮГ тус тус хариуцан ажиллаж байна.

2024 оны 12 дугаар сарын байдлаар зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгох үйл ажиллагааны талаарх “И-Монгол академи” УТҮГ-аас авсан мэдээлэл.

Хүснэгт №6 “И-Монгол академи” УТҮГ-аас авсан мэдээлэл

№	2023 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн Зөвшөөрлийн тухай хуульд тусгагдсан тусгай зөвшөөрлийн цахимжилтын талаарх мэдээлэл					Нийт тоо
	И-Монгол академи хөгжүүлсэн	ГТСМТТ хөгжүүлсэн	Уламжлалт	Өөрийн цахим систем	Боломжгүй	
1	40	53	0	141	18	252
2	Цахимжсан	Цахимжсан		API холболт хийх, Дан системд холбох	Цахимжуулах боломжгүйг илэрхийлсэн	252 тусгай зөвшөөрөл


Монгол Улсын засгийн газрын 2023 оны 06 сарын 21-ний өдрийн 233-р тогтоолоор Эдийн засаг хөгжлийн яам, И-Монгол академи болон ГТСМТТ нарт тусгай болон энгийн зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгох боломжийг бүрдүүлэх ажлыг хамтран хийж гүйцэтгэхийг даалгасан. Тус ажлын хүрээнд И-Монгол академи үйлчилгээний судалгааг хийх, цаашид үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг хариуцаж, ГТСМТТ хөгжүүлэлтийн ажлыг хариуцахаар шийдвэрлэсэн. Мөн ажлын хүрээнд 3 тал

(И-Монгол академи , ГТСМТТ , Эдийн засаг хөгжлийн яам) хэд хэдэн удаагийн уулзалтыг зохион байгуулж үйлчилгээний судалгаа, бодлогын даалгаврын загварыг эцэслэн тохиролцсон.

И-Монгол академийн зүгээс ажил эхэлснээс хойш бүх тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдтэй холбогдон судалгаа мэдээлэл цуглуулж нийт 252 тусгай зөвшөөрөл байгаагаас эхний ээлжид ямар нэгэн цахим систем байхгүй, уламжлалт хэлбэрээр үзүүлж байгаа 89 төрлийн тусгай зөвшөөрөл байгааг илрүүлж (18-н тусгай зөвшөөрөл хуулийн хүрээнд цахимжих боломжгүй) тухайн тусгай зөвшөөрөл болгон дээр бодлогын даалгавар боловсруулан ажилласан. Өнөөдрийн байдлаар нийт 252 төрлийн тусгай зөвшөөрөл байгаагаас өөрийн цахим системтэй буюу зөвшөөрөл олгогч эрх бүхий этгээдийн өөрийн хариуцан хөгжүүлсэн цахимаар олгох боломжтой 141 зөвшөөрөл, e-business.mn болон license.mn платформд байршиж буй цахим хэлбэрээр авах боломжтой 93 тусгай зөвшөөрөл, хуулийн хүрээнд цахимаар олгох огт боломжгүй 18 тусгай зөвшөөрөл байгаа бөгөөд уламжлалт буюу цаасан хэлбэрээр үзүүлж байсан цахимжуулах боломжтой тусгай зөвшөөрлүүдийг 2023 онд цахимжуулж дууссан байна гэжээ.

Зөвшөөрлийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн Газраас баталсан 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 233 дугаар “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу Эдийн засаг хөгжлийн яам зөвшөөрлийг цахимжуулах үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүрэгтэйгээр ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 03-наас 05-ны өдрүүдэд “Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал”-ын талаар төрийн байгууллагатай хийсэн хуралд танилцуулсан танилцуулгаас зөвшөөрлийн цахимжилттай холбоотой өгсөн мэдээллүүдээс үзэхэд дараах нөхцөл байдалтай байна.

Зураг №1. 2023 оны 1 дүгээр сарын байдлаар ²




Дээрх зургаас үзэхэд Зөвшөөрлийн тухай хуульд зассан 14 чиглэлийн тусгай зөвшөөрөл олгох ажиллагаанаас тодорхой чиглэлүүд бүрэн цахимжаагүй байгаа нь

² Эдийн засаг хөгжлийн яамны 2024 оны 12 дугаар сарын 03-наас 05-ны өдрүүдэд “Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал”-ын талаар төрийн байгууллагатай хийсэн хуралд танилцуулсан танилцуулга

харагдах бөгөөд license.mn гэсэн системд нэвтрэн цахимаар тусгай зөвшөөрөл хүсэх боломжтой гэсэн танилцуулга хийжээ. Харин тусгай зөвшөөрлийн цахимжилт 2024 оны 12 дугаар сар буюу 2 жил орчмын хугацаанд дараах байдлаар өөрчлөгдөж, цахимжсан гэж дүгнэжээ.

Зураг №2. 2024 оны 12 дугаар сарын байдлаар³



Зураг №2-оос үзэхэд Зураг №1-т зааснаас хоёр орчим жилийн дараах нөхцөл байдлыг авч үзэхэд 90-ээс дээш хувьтай цахимжсан, ингэхдээ license.mn, e-business, өөрийн бүтээсэн системээр тусгай зөвшөөрлийг цахимаар олгодог болсон гэж тайлагнажээ. Энэхүү үр дүнг зөвшөөрлийн цахим системийн төрлөөр ангилж, хүснэлт байдлаар илэрхийлбэл дараах байдалтай байна.

Зураг №3. Зөвшөөрлийн цахим шилжилт⁴

³ Эдийн засаг хөгжлийн яамны 2024 оны 12 дугаар сарын 03-наас 05-ны өдрүүдэд “Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал”-ын талаар төрийн байгууллагатай хийсэн хуралд танилцуулсан танилцуулга

⁴ Эдийн засаг хөгжлийн яамны 2024 оны 12 дугаар сарын 03-наас 05-ны өдрүүдэд “Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал”-ын талаар төрийн байгууллагатай хийсэн хуралд танилцуулсан танилцуулга

	Тусгай зөвшөөрлийн тоо	License.mn	E-Business	БЭРИЙН СИСТЕМ		Уламжлалт
				Тоо	Систем	
1. Байгаль орчны чиглэлээр	31	0	28	0	license.mn.gov.mn	3
2. Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр	38	0	31	2	license.frc.mn	5
3. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр	22	14	8	0	license.mn.gov.mn license.gasar.gov.mn	0
5. Зам, тээврийн чиглэлээр	12	0	10	0		2
6. Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлээр	12	12	0	0		0
7. Соёл, боловсролын чиглэлээр	12	0	1	0		2
8. Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр	30	21	5	0		4
9. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр	15	0	14	1	customer.orc.gov.mn	0
10. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэлээр	1	1	0	0		0
11. Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар	13	2	10	1	gun.police.gov.mn sam.police.gov.mn	0
12. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр	16	0	15	1	license.mn.gov.mn veltonug.mn	0
13. Эрүүл мэндийн чиглэлээр	17	17	0	0	khov.tzrich.gov.mn	0
14. Эрчим хүчний чиглэлээр	34	0	34	0	license.irc.mn	0
НИЙТ	253	76	156	5		16

Зураг №3-аас үзэхэд license.mn-ээр 76 тусгай зөвшөөрлийг, E-business.mn-ээр 156 тусгай зөвшөөрөл, өөрийн хөгжүүлсэн системээр 5 тусгай зөвшөөрлийг нийт 237 тусгай зөвшөөрлийг цахимаар авах боломжтой бол 16 төрлийн тусгай зөвшөөрлийг уламжлалт байдлаар олгохоор тайлагнасан байна.

Гэтэл бодит байдал дээр зарим тусгай зөвшөөрлийн бүрдүүлэх бичиг баримт тодорхойгүй, цахимаар мэдүүлэх систем ажиллахгүй гэх шалтгааны улмаас цахимаар хүсэлт гаргах, тусгай зөвшөөрөлтэй холбоотой цахим үйлчилгээ авах боломжгүй нөхцөл байдалтай байна. Тодруулбал Зөвшөөрлийн тухай тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан нийт 251 тусгай зөвшөөрлөөс 178 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжтой байна. Үүнийг тоон баримтаар авч үзвэл дараах байдалтай байна. Хүснэгт №7-д буй тусгай зөвшөөрлийн үйлчилгээний цахимжилт нь бодит байдалд хэрэгжиж буй эсэхийг судалж, нэгтгэсэн мэдээллийг энэхүү тайланд хавсаргасан болно.

Хүснэгт №7 Тусгай зөвшөөрлийн үйлчилгээ цахимсан байдал

Тусгай зөвшөөрлийн төрөл	Нийт тоо	Цахимжсан	Цахимжаагүй
1. Байгаль орчны чиглэлээр	31	18	13
2. Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэл	38	24	14
3. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэл	22	21	1
5. Зам, тээврийн чиглэл	12	1	11
6. Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэл	12	10	2

Тусгай зөвшөөрлийн төрөл	Нийт тоо	Цахимжсан	Цахимжаагүй
7. Соёл, боловсролын чиглэл	12	9	3
8. Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэл	30	16	14
9. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэл	15	14	1
10. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэл	1	0	1
11. Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар	13	2	11
12. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэл	14	13	1
13. Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагаа	17	16	1
14. Эрчим хүчний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагаа	34	34	0
НИЙТ	251	178	73

Энэхүү тоон мэдээлэл нь төрийн байгууллагаас өгч буй мэдээллээс зөрүүтэй байгаа шалтгаан нь тухайн цахим системд тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах цонх нээгдсэн боловч тухайн цонхоор дамжуулан хүсэлт гаргах боломжгүй, ажилладаггүй, хэлбэрийн төдий цахимжсан байгаагаас улбаатай.

Жишээлбэл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлийн 12 тусгай зөвшөөрлийн үйлчилгээг license.mn сайтаар дамжуулан авах боломжтой гэж Эдийн засаг хөгжлийн яамны 2024 оны 12 дугаар сарын 03-наас 05-ны өдрүүдэд “Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал”-ын талаар төрийн байгууллагатай хийсэн хуралд танилцуулжээ. Гэвч бодит байдал дээр тухайн сайтад Сангийн яам, Гаалийн ерөнхий газраас олгодог тусгай зөвшөөрлийн илэрц олдохгүй байна. Үүнийг Зураг №4-өөс харах боломжтой байна. Мөн Сангийн яам болон Гаалийн ерөнхий газрын өөрсдийн веб хуудаст буй тусгай зөвшөөрөл гэх цонх руу дармагц, license.mn сайт руу шилжиж байгаа болно.

Зураг №4. License.mn сайтад ТЗ-ийн хүсэлт гаргах цонх байхгүй байгаа болохыг харуулав.



Өөрөөр хэлбэл тусгай зөвшөөрлийн үйлчилгээг license.mn, ebusiness.mn сайтуудаар дамжуулан авах боломжтой гэх боловч тухайн сайтуудад буй тусгай зөвшөөрлийн цонх ажилладаггүй, тухайн цахим системдээ хөгжүүлэлт хийдэггүйн улмаас төрийн зөвшөөрлийн үйлчилгээг цахимаар авах боломжгүй байна. Үүнээс үзэхэд төрийн үйлчилгээ цахимжсан гэх үр дүн нь бодит байдалд нийцэхгүй байна.

Цаашлаад тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтан, байгууллага нь дараах байдлаар өөрийн тусдаа систем хөгжүүлсэн⁵ бөгөөд эрх бүхий байгууллагын цахим системээр үйлчилгээ авах боломжтой 5 төрлийн тусгай зөвшөөрөл байна гэжээ.

Хүснэгт №8 Эрх бүхий байгууллагуудын хөгжүүлсэн цахим систем

№	Эрх бүхий байгууллага	Цахим систем
1	Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	https://license.mrtd.gov.mn/
2	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	http://license.met.gov.mn/
3	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	https://license.mcis.gov.mn/
4	Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	https://license.gazar.gov.mn/
5	Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	https://cmcs.mrpm.gov.mn/cmcs
6	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	https://www.urban.gov.mn/
7	Санхүүгийн зохицуулах хороо	https://license.frc.mn/home
8	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга	http://www.license.edu.mn/

⁵ "И-Монгол академи" УТҮГ-аас ирүүлсэн мэдээлэл

9	Харилцаа холбооны зохицуулах хороо	http://customer.crc.gov.mn/
10	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	http://sas.police.gov.mn/
11	Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	https://license.mofa.gov.mn/
12	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	http://vetdrug.mn/
13	Нийслэл Улаанбаатар хот	https://service.ulaanbaatar.mn/
14	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	http://tzmoh.gov.mn/
15	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	https://www.license.energy.gov.mn/user/login
16	Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл	https://license.erc.mn/auth/login

Дээрх цахим системүүдийн хөгжүүлэлтээс харвал тухайн эрх бүхий байгууллагаас олгодог тусгай зөвшөөрлийг эзэмшдэг аж ахуй нэгжүүдийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээллэх зорилготой байх бөгөөд цахим үйлчилгээ авах, хүсэлт гаргах боломжгүйгээр хөгжүүлэлт хийгдсэн байна. Түүнчлэн зарим байгууллагуудын хөгжүүлсэн гэх системийн домайн хаяг нь ажилладаггүй, идэвхгүй цахим системүүд байна.

Хэдий бодит байдал дээр тусгай зөвшөөрлийн үйлчилгээний дийлэнх хувь нь эрх бүхий байгууллагуудын өөрсдийн цахим системээр бус, license.mn болон ebusiness.mn цахим системээр явагдаж байгаа ч 5 нэр төрлийн тусгай зөвшөөрөл л эрх бүхий байгууллагын өөрсдийн цахим системээр олгогдож байгаа гэсэн тоон үзүүлэлт нь бодит байдалтай нийцэхгүй байна. Жишээлбэл Санхүүгийн зохицуулах хорооны <https://license.frc.mn/home> цахим системээр дамжуулан Санхүүгийн зохицуулах хорооноос олгодог нийт 33 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг авах боломжтой байна. Зөвхөн нэг байгууллагаас л олгодог 33 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг тухайн байгууллагын өөрийн хөгжүүлсэн цахим системээр дамжуулан авах боломжтой

байхад төрийн байгууллагаас уг тоон мэдээллийг 5 гэж мэдээллэсэн нь өөрөө учир дутагдалтай байна.

Цаашлаад нийт 18 төрлийн тусгай зөвшөөрлийн⁶ үйлчилгээг цахимжуулах боломжгүй гэх саналыг ирүүлсэн гэжээ.

Хүснэгт №9 Цахимжуулах боломжгүй тусгай зөвшөөрөл

Хууль эрх зүйн хүрээнд боломжгүй		
№	Тусгай зөвшөөрөл	Олгох эрх бүхий этгээд
1	1.1.нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах	Засгийн газар
2	1.17.хувиргасан амьд организмыг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3	1.22.энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга
4	2.1.банк байгуулах	Монголбанк
5	2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх	
6	2.3.зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх	
7	2.4.систем ажиллуулах	
8	2.5.төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	
9	5.1.төмөр замын суурь бүтэц барих	Засгийн газар
10	7.9.гадаадын хуулийн этгээд Монгол Улсад боловсролын байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эрхлэх	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
11	8.3.хүн амын эрүүл мэнд, мал, ан амьтан, байгаль орчинд онцгой нөлөө бүхий хортой бодисыг хамгаалан булахад зориулан газрын хэвлийг ашиглуулах	Засгийн газар
12	8.8.пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах	Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
13	8.9.үйлдвэрлэлийн зориулалтаар тээлгээний ажил явуулах	
14	8.10.үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тээлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх	
15	8.26.цөмийн төхөөрөмж ашиглах	Цөмийн энергийн комисс
16	8.27.цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах	

⁶ "И-Монгол академи" УТУГ-аас ирүүлсэн мэдээлэл

17	8.28.ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газрын хэвлийг ашиглуулах	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга
18	11.13.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Хуульчдын холбоо

Гэвч дээрх 18 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимжуулах боломжгүй шалтгаан нөхцлийг дахин судлах, тодруулах хэрэгцээ шаардлага бий гэж судлаачдын зүгээс үзлээ. Ийнхүү дээрх тусгай зөвшөөрлүүдийг цахимжуулах боломж бий гэж үзсэн шалтгааныг жишээгээр тайлбарлавал:

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.13 дахь хэсэгт заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хуульчдын холбооноос олгодог. Ингэхдээ уг зөвшөөрлийг авах хүсэлтэй этгээд нь хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж, хуульчийн гэрчилгээ авсаны үр дүнд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй болж байна. Дээрх хүснэгтийн 18 дахь хэсэгт дурьдсанчлан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх энэхүү тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимжуулах боломжгүй гэжээ. Гэтэл уг зөвшөөрөлтэй шинж чанарын хувьд ижил төрлийн тусгай зөвшөөрөл болох эрүүл мэндийн салбар дахь эмчлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үйлчилгээг HR.HDC.GOV.MN системээр цахим системээр дамжуулан авч болохоор байна.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх болон эмчлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх 2 тусгай зөвшөөрлийг харьцуулан үзвэл хоёулаа хувь хүнд, мэргэжлийн шалгалтанд тэнцсэний үндсэнд олгогддог тусгай зөвшөөрөл байхад юуны учраас ижил төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээний нэг нь цахимжих боломжтой, нөгөөх нь боломжгүй байгаа болох нь үндэслэлгүй байна.

Иймд Хүснэгт №9-д буй 18 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээ цахимжих боломжтой эсэхийг дахин судлах нь зүйтэй бөгөөд хэрэв цахимжих боломжгүй гэж дүгнэж байгаа бол түүний шалтгаан нөхцлийг тодруулах шаардлагатай байна.

3.1.2 Зөвшөөрлийн нэгдсэн сан үүсгэх


Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлд Эрх бүхий этгээдийн бүрэн эрхийн талаар зохицуулсан. Тус зүйлийн 2.4 дэх хэсэгт эрх бүхий этгээд нь “зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох тухай шийдвэрийг хуульд заасан хугацаанд гаргах” үүрэгтэй гээд, 2.5 дахь хэсэгт “энэ зүйлийн 2.4-т заасан шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухайн шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор бүртгүүлэх”, 2.6 дахь хэсэгт “зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийг зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулах, тухайн шийдвэрийг хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлэх” үүрэгтэй гэж зохицуулсан.

Үүний дагуу тухайн эрх бүхий албан тушаалтан нь иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрөл олгосон нөхцөлд зөвшөөрлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх үүрэгтэй байх боловч бодит байдал дээр тусгай зөвшөөрлийн нэгдсэн системд буй мэдээлэл хангалтгүй байна.

Тохиолдол шалгаж үзэв:


Эрүүл мэндийн яамны <https://tzmoh.gov.mn> системд дээр зөвшөөрөлтэй “Антиген” хуулийн этгээдийн мэдээллийг <https://license.mn> дээрх мэдээллийн нэгдсэн санд орсон эсэхийг шалгахад эрх бүхий байгууллагаас уг хуулийн этгээдийн мэдээллийг нэгдсэн санд оруулаагүй болох нь харагдаж байна.

Зураг №5. Эрүүл мэндийн яамны <https://tzmoh.gov.mn> системийн мэдээлэл



№	Нутаг дэвсгэр	Байгууллагын нэр	РД	Гэрмэлзэний Дугаар	Күнчитэй тугаааа системд
2..	Улаанбаатар хот	Анхны лавэр клиник	01050205	ГХ-10/22/3229	2020/08/02
2..	Улаанбаатар хот	Анхны	2842335	ГХ-17/22/3864	2028/07/03
2..	Улаанбаатар хот	Анхны	2880873	ЭК-06/22/2847	2020/03/17
2..	Улаанбаатар хот	Ану мед	6004113	ГХ-17/22/3770	2020/03/17
2..	Улаанбаатар хот	Ану мед	6004113	ГХ-17/22/3770	2022/10/11
2..	Улаанбаатар хот	Ануманал	5279992	ЭК-09/22/3187	2023/07/01
2..	Дархан-Уул аймаг	Анунбаадгай	4254287	ЭК-13/07/152	2019/04/11
2..	Орхон аймаг	Анхны оч	2308797	ЭК-01/12/1192	

Зураг №6. Зөвшөөрлийн нэгдсэн сан <https://license.mn> системийн мэдээлэл



Дан ганц эрүүл мэндийн салбараар зогсохгүй зарим тусгай зөвшөөрөл олгож буй байгууллагууд өөрийн систем дээр зөвшөөрөл олгосон этгээдийн мэдээллийг оруулсан ч “зөвшөөрлийн нэгдсэн сан”-д мэдээллээ оруулаагүй нөхцөл байдал нийтлэг тохиолдож байна.

Угтаа Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 251 дүгээр “Журам батлах тухай” тогтоолын хавсралтаар “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийн бүртгэл, лавлагаа, мэдээлэл өгөх журам” баталсан бөгөөд уг журмын дагуу эрх бүхий байгууллагууд Зөвшөөрлийн нэгдсэн сан буюу <https://license.mn/> системд “тусгай зөвшөөрөл”, “энгийн зөвшөөрөл”-ийг олгосон талаарх мэдээллээ оруулах үүргийг хүлээсэн байдаг. Өнөөдрийн байдлаар тухайн систем рүү зөвшөөрөл олгох эрх бүхий бүх байгууллагууд

нэвтэрч, мэдээлэл оруулах боломж хангалттай бүрдсэн боловч мэдээлэл бүрэн ороогүй байгаа нь төрийн байгууллагуудын өөрсдийн хариуцлагагүй, үйл ажиллагаагаа бүрэн цахимжуулж, иргэдэд нээлттэй ил тод мэдээллийг түгээж чадахгүй байгаа нөхцөл байдлыг харуулж байна.

3.2 ЗӨВШӨӨРЛИЙН ТОО ЦӨӨРЧ, ЗӨВШӨӨРЛӨӨС ҮҮСЧ БУЙ ДАРАМТ БУУРЧ БАЙГАА ЭСЭХ

3.2.1 Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар үүссэн нөхцөл байдал

А. Зөвшөөрлийн тоог цөөрүүлсэн тухай

Зөвшөөрлийн тухай хууль батлагдахаас өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль (цаашид “ААНТЗтХ” гэх)-ийг анх 2001 онд баталж, тус хуулиар 2022 оныг хүртэл зөвшөөрлийн харилцааг ерөнхий байдлаар зохицуулж ирсэн. Мөн тус хуулиас гадна салбар бүрийн төрөлжүүлсэн 100 гаруй хуулиар тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцаа тухайлан зохицуулагдаж байсан.

Тодруулбал ААНТЗтХ-д салбар яамдаас олгогдох 18 чиглэлийн 103 ерөнхий төрлийн үйл ажиллагаа, түүнд хамаарах 210 гаруй дэд төрлийн үйл ажиллагаа болон аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргаас олгох 7 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр зохицуулсан байсан боловч практикт тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий 54 байгууллагаас 914 төрлийн зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгож байсан.⁷

Ингээд 2022 онд Зөвшөөрлийн тухай хууль батлагдсанаар өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан ААНТЗтХ-ийн дагуу олгогддог байсан 914 төрлийн тусгай зөвшөөрлийн тоог цөөрүүлж, 381 төрлийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохоор зохицуулжээ. Өөрөөр хэлбэл 2022 онд батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 болон 8.2 дугаар зүйлд заасны дагуу олгож буй 251 төрлийн “тусгай зөвшөөрөл”, 130 төрлийн “энгийн зөвшөөрөл”, нийт 381 төрлийн зөвшөөрлийг олгохоор хуульд тусгасан байна.

Хүснэгт №10. 2024 оны байдлаарх зөвшөөрлийн тоо, статистик

Зөвшөөрлийн тухай хууль /2022.06.17/	Тоо	Хуулиар нэмсэн	Өөрчлөн найруулсан	Хуулиар өөрчлөлт оруулсан	Хүчингүй болсонд тооцсон
1. Байгаль орчны чиглэлээр:					
Тусгай	31	2		3	
Энгийн	16	1			
Нийт:	47			3	
2. Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр:					

⁷ Зөвшөөрлийн тухай, Зөвшөөрлийн жагсаалт батлах тухай хуулийн төслийн танилцуулга

Тусгай	38	2			
Энгийн	51				
Нийт:	89				
3.Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр:					
Тусгай	22			3	
Энгийн	3				
Нийт:	25				
4.Батлан хамгаалахын чиглэлээр:					
Тусгай	3				3
Энгийн					
Нийт:	3				
5.Зам, тээврийн чиглэлээр:					
Тусгай	12	1		2	
Энгийн	5				
Нийт:	17				
6.Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлээр:					
Тусгай	12				
Энгийн	4		1		1
Нийт:	16				
7.Соёл, боловсролын чиглэлээр:					
Тусгай	12	3		1	
Энгийн	14	1		2	
Нийт:	26				
8.Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр:					
Тусгай	30			3	
Энгийн	2				1
Нийт:	32				
9.Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр:					
Тусгай	15				
Энгийн	3		1		
Нийт:	18				

10.Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэлээр:					
Тусгай	1				
Энгийн	2				
Нийт:	3				
11.Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар;					
Тусгай	13				
Энгийн	15	4	1	1	1
Нийт:	28				
12.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр:					
Тусгай	14	1		3	
Энгийн	8	2			
Нийт:	22				
13.Эрүүл мэндийн чиглэлээр:					
Тусгай	20		3	2	3
Энгийн	1			2	
Нийт:	21				
14.Эрчим хүчний чиглэлээр:					
Тусгай	34				
Нийт:	34				
		Нэмсэн	Өөрчлөн найруулсан	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болсонд тооцсон
Нийтийн зөвшөөрлийн тоо үүнээс:	381	17	6	22	9
1/Тусгай зөвшөөрөл	257	9	3	17	6
2/Энгийн зөвшөөрөл	124	8	3	5	3

Зөвшөөрлийн тухай хуулиар шинэ төрлийн тусгай зөвшөөрөл бий болгох тохиолдолд Засгийн газраас тогтоосон аргачлалд үндэслэн, судалгаа шинжилгээ хийж, тухайн төрлийн үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох нь зохистой арга зам мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм эдийн засгийн хувьд ашигтай байх эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр шийдвэрлэдэг байхаар хуульд тусгаж өгсөн. (ЗтХ-ийн 1.5.14, 1.5.15)

Гэтэл Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5.14 болон 1.5.15-д заасан шинэ зөвшөөрөл бий болгоход тавигдах хэрэгцээ шаардлагын үнэлгээ, судалгааг хийлгүйгээр тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, 2022 оноос хойш өнөөдрийг хүртэл зөвшөөрлийн тоо нийтдээ 14 чиглэлийн салбарт 9 ширхэг зөвшөөрөл шинээр нэмсэн байна. Зөвшөөрлийн тухай хуулийн нэг гол хамгаалалт бол зөвшөөрөл нэмэгдэхдээ Зөвшөөрлийн зөвлөлөөр заавал дамжих ёстой байдаг. Гэтэл 3 төрлийн зөвшөөрлүүд зөвлөлөөр дамжаагүй байна. Учир нь зөвлөл нь өөрөө 2023 оны 8 сард буюу хууль хэрэгжээд жил орчмын дараа нь байгуулагдсан. Тэр хооронд хууль батлагдан тусгай зөвшөөрлийн тоо нэмэгдсэн байна.

Б. Зөвшөөрлийн тухай хууль батлагдснаас хойш нэмэгдсэн зөвшөөрлийн тухайд

1.5 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход баримтлах зарчим, хэрэгжүүлэх хүрээ

14.Зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зарчмыг баримтлан олон улсын жишиг, стандартыг харгалзана.

15.Энэ зүйлийн 14-т заасан судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын баталсан аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

9.3 дугаар зүйл.Зөвшөөрөл шинээр бий болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг өөрчлөхөд дүгнэлт гаргах

1.Зөвлөл шинээр бий болгох зөвшөөрлийн талаар дүгнэлт гаргахдаа энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 14-т заасан зарчмыг баримтална.

2.Зөвлөл шинээр бий болгох зөвшөөрлийн талаарх дүгнэлтийг дараах шалгуур үзүүлэлтээр гаргана:

2.1.хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хамгаалахад тухайн шинээр бий болгох зөвшөөрөл шаардлагатай эсэх;

2.2.энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн жагсаалттай давхардах, уялдах эсэх;

2.3.зөвшөөрлийн ангилалд үндэслэн тухайн зөвшөөрлийн хэрэгцээ, шаардлага, эрсдэлийн түвшин, үнэлгээтэй уялдах эсэх;

2.4.эдийн засаг, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөлөл;

2.5.тухайн шинээр бий болгох зөвшөөрөлтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас гарах зардал;

2.6. хууль санаачлагчаас Нийтийн сонсголын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасны дагуу хууль тогтоомжийн төслийн сонголт явуулсан эсэх.

3.Энэ зүйлийн 2-т заасан дүгнэлтийг энэ хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5.3-т заасан санал, дүгнэлтийн хамт Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 14 дэх хэсэг болон 9.3 дугаар зүйлд Зөвшөөрлийг шинээр бий болгоход олон улсын жишиг, стандартыг харгалзаж,

судалгаа шинжилгээний үндсэнд Зөвшөөрлийн зөвлөлийн дүгнэлтэд үндэслэх талаар зохицуулжээ. Өөрөөр хэлбэл аливаа үйл ажиллагааг зөвшөөрлийн үндсэнд эрхлэх эсэх асуудлыг шийдвэрлэхийн өмнө юуны түрүүнд тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай байна.

Ийнхүү зөвшөөрлийг шинээр бий болгоход заавал Зөвшөөрлийн зөвлөлөөр дамжих шаардлагыг тавьж буй учир нь төрийн байгууллагын хүнд сурталыг бий болгохгүй байх, судалгаа шинжилгээ болоод хяналтад үндэслэгдсэн байдлаар хуульд заасан үйл ажиллагааг зөвшөөрлийн үндсэнд эрхэлдэг байх баталгаа юм. Үүний дагуу Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 462 дугаар тогтоолын хавсралтаар *"Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий Зөвшөөрлийн зөвлөлийн ажиллах журам"* батлагдаж, хууль хэрэгжсэнээс хойш 1 жил орчмын дараа буюу 2023 оны 08 сард Зөвшөөрлийн зөвлөл байгуулагдсан байна.

Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхлэснээс хойш нийт 14 чиглэлийн салбарт 9 ширхэг зөвшөөрөл шинээр нэмсэн байна. Үүнээс 3 төрлийн зөвшөөрөл нь зөвлөлөөр дамжаагүй буюу хууль хэрэгжиж эхлэн зөвлөл байгуулагдах хүртэл хугацаанд нэмэгджээ. Энэ талаар МҮХАҮТ-ын дэргэдэх Хуулийн бодлогын зөвлөлийн дарга, Зөвшөөрлийн зөвлөлийн гишүүн Ө.Жамбалсүрэн 2024.10.02-ны өдрийн Зөвшөөрлийн хэлэлцлүүлэгт хэлэхдээ⁸ *"...Зөвшөөрлийн тухай хуулийн нэг гол хамгаалалт бол түрүүн гишүүний хэлдгээр зөвшөөрөл нэмэгдэхдээ Зөвшөөрлийн зөвлөлөөр заавал дамжих ёстой байдаг. Гэтэл 3 төрлийн зөвшөөрлүүд зөвлөлөөр дамжаагүй байна. Тэгээд зөвлөл маань өөрөө 2023 оны 8 сард буюу хууль хэрэгжээд жил орчмын дараа нь байгуулагдсан. Тэр хооронд буюу хууль батлагдсан 2022 оны 6 сарын 17-ноос хойш энэ өөрчлөлтүүд бий болсон байх жишээтэй..."* гэжээ. Гэтэл Зөвшөөрлийн тухай хуульд Зөвшөөрлийн зөвлөлөөр дамжаагүй нэмэгдсэн зөвшөөрлүүд нь одоо хэр нь эрх бүхий байгууллагаас олгогдоод, хуулийн зохицуулалт нь хэрэгжээд явж байдаг. Угтаа Зөвшөөрлийн зөвлөл байхын утга учир нь төрөөс зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, төрийн хүнд сурталыг хязгаарлах, тухайн зөвшөөрлийг олгох хэрэгцээ шаардлага бий эсэхэд хяналт тавиж байхад оршино.

Гэтэл Зөвшөөрлийн зөвлөл батлагдах хүртэлх завсрын хугацаанд нийт 10 удаа нэмэлт өөрчлөлт оруулж зөвшөөрлийн төрлийг нэмсээр байгаа нь өөрөө хууль зөрчсөн үйлдэл мөн бөгөөд энэ нь тус хуулийн үйлчлэлд тогтворгүй байдлыг бий болгохоос гарцаагүй. Үүний үр дүнд иргэн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаанд, цаашлаад эдийн засгийн эргэлтэд хүртэл сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байгаа юм.

Иймд Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулагдах харилцааг төрийн хяналтад хэрэгжүүлэх баталгааг хангаж хуулийн 1.5 болоод 9.3 дахь зүйлийн хэрэгжилтийг бодитойгоор хангах шаардлагатай байна.

⁸ Зөвшөөрлийн хуулийн 1-р хэлэлцүүлгийн ТЭМДЭГЛЭЛ

В. Нарийвчилсан хууль болон журмаар тусдаа зөвшөөрлүүд болж задарч байгаа нөхцөл байдал

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйл. Зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход баримтлах зарчим, хэрэгжүүлэх хүрээ
16.Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглоно.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд зохицуулагдсан энгийн болон тусгай зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглоно гэж заасан боловч бодит байдал дээр хуулийн дээрх зохицуулалт хэрэгжихгүй байгаа бөгөөд хуулийн 8.1 болон 8.2-т зохицуулагдсан зөвшөөрлүүдийг салбарын нарийвчилсан хууль болон журмаар зохицуулахдаа нь тусад нь салгаж олон төрлийн зөвшөөрөл болох тохиолдлууд байна.

Тухайлбал Зам тээвэр хөгжлийн сайдын 2021.06.30-ны өдрийн А/101 тоот тушаалын хавсралтаар батлагдсан *“Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”*-аар тусгай зөвшөөрлийн төрөл, бүрдүүлэх бичиг баримт, процессыг нарийвчлан зохицуулж өгсөн байна. Тус журмын 2.8-т Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрөл, ангиллыг зохицуулж өгсөн байх бөгөөд *“Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд”* гээд энэ төрлийн тусгай зөвшөөрөл нь дотроо 7-н төрлийн тусгай зөвшөөрөл болж задарч байна. Түүнчлэн *“Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд”* гээд энэ төрлийн тусгай зөвшөөрөл нь дотроо 7-н төрлийн тусгай зөвшөөрөл болж задарч байна. Мөн журамд, *“Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд”* гээд энэ төрлийн тусгай зөвшөөрөл нь дотроо 1 тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнээс дүгнэж үзвэл Авто замын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг болон Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан зөвшөөрөл нь Зам тээврийн яамны сайдын батлагдсан тушаалаар нийт 15 тусгай зөвшөөрөл болон задарч, тусгай зөвшөөрлийн тоо хуульд зааснаас олон төрөл болж байна.

Мөн түүнчлэн салбарын тухай хуулиудыг харвал дээрх жишээ нь ганц биш юм. Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2.16-д Санхүүгийн зохицуулах хорооноос *“Ердийн, урт хугацааны, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх”* тусгай зөвшөөрлийг олгохоор заасан байгаа юм. Энэхүү зүйл заалтаас *“Ердийн, урт хугацааны, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх”* гэх ганцхан тусгай зөвшөөрлийг авч тус үйл ажиллагаануудыг эрхлэх эрхтэй болно гэж ойлгогдохоор байгаа юм. Харин тус салбарын нарийвчилсан хууль, журмын заалтыг цааш судлан үзвэл, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.3-т *“Зохицуулах хороо урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй”* гэж заасан бөгөөд эндээс уг 2 үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг тус тусад нь авдаг болох нь харагдана.

Цаашлаад уг “Даатгалын багц дүрэм”-ийн 18-р хавсралт “Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 2.1.2-д “Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан заавар болон СЗХ04001 өргөдлийн маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (А)-ын 1-17-д дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ” гэж заажээ. Давхар даатгалын үйл ажиллагааг эрхлэхэд мөн л адил тусдаа зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд өөр төрлийн баримт бичиг цуглуулж авдаг байгаа юм.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт “Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглоно” гэж заасан боловч бодит байдал дээр дээрх 2 жишээг л аваад үзэхэд Зөвшөөрлийн тухай хуулиар заасан 1 тусгай зөвшөөрөл нь салбарын тусгай хууль, журмаар 2-3 өөр тусдаа зөвшөөрлүүд болж задарч байгаа юм.

Эндээс дүгнэвэл хэдий Зөвшөөрлийн тухай хуульд олон тоогоор олгогдож буй зөвшөөрлүүдийг цөөлсөн гэх боловч бодит байдал дээр салбарын хууль, журмаар тухайн заасан зөвшөөрөл нь 2-3 төрлийн тусгай зөвшөөрөл болж задардаг нөхцөл байдал тогтоогдож байгаа юм.

Г. Хуулийг анхнаасаа боловсруулахдаа тусдаа зөвшөөрлүүдийг нэг заалтад хуульчилсан байдал

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.18-т “эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх” гэсэн нэг тусгай зөвшөөрлийг олгохоор заасан байх бөгөөд энэ төрлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бүх төрлийн үйл ажиллагаа явуулсан байхыг шаардаж (жишээ нь зөвхөн эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжээс эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн талаар үйл ажиллагаа явуулсан тайлан, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг шаарддаг), тухайн чиглэл тус бүрээр тайлан шаардаж байгаа нь мөн л тусгай зөвшөөрлийн төрлийг зөв ангилж чадаагүйг харуулж байна.

Мөн түүнчлэн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.4-т Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас “Бүх төрлийн шатахууны бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэх” тусгай зөвшөөрлийг олгохоор заасан. Уг тусгай зөвшөөрлийг олгохтой холбогдсон харилцааг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулиар зохицуулах ба тус хуулийн 9.1-т бүх төрлийн шатахууны бөөний болон жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх талаар заагаад 9.2-т “Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч” ямар баримт бичиг бүрдүүлэх шаардлагатайг заасан. Мөн түүнчлэн тус хуулийн 9.5-д “Бүх төрлийн шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч” ямар бичиг баримт бүрдүүлэх шаардлагатайг мөн хуулиар зааж өгсөн байгаа юм.

Өөрөөр хэлбэл, салбарийн нарийвчилсан уг хуульд үйл ажиллагаа тус бүрээр нь тусгай зөвшөөрөл олгох байдлаар зохицуулж байгаа боловч Зөвшөөрлийн тухай хуульд

өөр 2 үйл ажиллагааг ерөнхийлөн нэг тусгай зөвшөөрөл байдлаар оруулсан байгаа нь төрөлжүүлэлгүй хэт ерөнхийлсөн болохыг нь харуулж байна.

Эндээс дүгнэхэд Зөвшөөрлийн тухай хуулийг анхнаасаа боловсруулахдаа тусгай зөвшөөрлийг үйл ажиллагаа тус бүрээр нарийвчлан, тэдгээрийг зааг ялгааг тодорхой болгожгүй, тусгай зөвшөөрлийн тоонд ач холбогдол өгч нэгтгэн хуульчилсан байх ба ийнхүү практикт 1 тусгай зөвшөөрөл салбарын хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд хэд хэд болж салж байгаа нь өмнөх хуулиас зөвшөөрлийн тоог цөөрүүлсэн гэх ач холдогдолгүй болох нь харагдаж байна.

3.2.2 Зөвшөөрлийн тухай хуулиас гадуур зөвшөөрлийн харилцааг зохицуулахгүй байх

1.3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

1.Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл /цаашид "зөвшөөрөл" гэх/-тэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлд мөн хуулийн 8.1, 8.2-т зааснаас бусад төрлийн үйл ажиллагааг эрхлэхэд төрийн ямар нэгэн байгууллага, албан тушаалтнаас зөвшөөрөл авах, бүртгүүлэх зэргээр зөвшөөрөл авахгүй гэдэг агуулгаар хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл энгийн болон тусгай зөвшөөрлийн үндсэнд эрхлэхээс бусад хуульд заагдаагүй үйл ажиллагааг чөлөөтэй эрхэлж болохоор заажээ. Гэтэл хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлсон дээрх заалтын хэрэгжилт бодитой биш байгаагаас зөрчилдөөнтэй байдал үүсч байна.

Тодруулбал Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолын хавсралтаар “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам” батлагдсан⁹ бөгөөд уг журмаар Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх, үүрэг, хариуцлага, худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, тэдгээрт тавигдах шаардлагыг тодорхойлох, бүртгэлжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нутгийн захиргааны эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийх, хяналт тавихтай холбоотой асуудлыг зохицуулж байна.


Энэхүү журмын 2 дугаар зүйлд журмын үйлчлэлд хамаарах худалдаа, үйлчилгээний төрөл, 6 дугаар зүйлд 2 дугаар зүйлд заасан худалгаа, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд нийслэлийн нэгдсэн мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээний нэгдсэн ulaanbaatar.mn портал системийн "Онлайн бизнес төв"-ийн <https://service.ulaanbaatar.mn/home> системийн "Үйлчилгээ эрхлэх бүртгэл" цэсэд нэвтэрч бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх талаар зохицуулсан байна. Уг системд нийт 15 чиглэлээр 145 үйл ажиллагааг бүртгүүлж үйл ажиллагаа эрхлэх боломжтой байна.

Үүний дагуу худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь цахим системд бүртгүүлэхдээ дараах байдлаар журмын 6.1.7 дахь хэсэг заасан баримт материалуудыг бүрдүүлж,

⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530546492421&type=2> ХЗДХЯ-наас ЗХХАЭ №18 2022.06.21-ний өдөр бүртгэж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

холбогдох бусад хэсэгт заасан мэдээллийг цахим системд оруулсанаар бүртгэл үүсэх боломжтой байна.

Зураг №7. Улаанбаатар хотод худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн бүртгүүлэх систем



Нийслэл Улаанбаатар хотын хувьд 2022 оноос эхлэн энэхүү системд бүртгүүлснээр шийдвэр гарсан эсэхээс үл хамааран үйл ажиллагаа явуулах эрх үүсч, үйл ажиллагаа явуулдаг жишиг тогтсон байна.

Гэвч “Бүртгэл” гэж нэрлэсэн дээрх процесс нь эрх бүхий байгууллагаас “Зөвшөөрөл” авч буй процесстой утга агуулгын хувьд агаар нэг байна. Тухайлбал журмын 6.2 дахь хэсэгт “Энэ журмын 2.1-2.3, 2.6, 2.7.2-т заасан үйлчилгээний хүсэлтийг тухайн дүүргийн худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан нэгж хүлээн авч, дүүргийн “Зөвлөл” хянан баталгаажуулна” гээд, 6.3 дахь хэсэгт “Энэ журмын 2.4-т заасан үйлчилгээг нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан газар, 2.5-д заасан үйлчилгээг нийслэлийн биеийн тамир, спортын асуудал хариуцсан газар, 2.7.1-д заасан үйлчилгээг нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан газар, 2.8-д заасан үйлчилгээг нийслэлийн соёл, урлагийн асуудал хариуцсан газар тус тус хүлээн авч, хянан баталгаажуулна” гэж заасан. Журмын дээрх зохицуулалтуудаас үзэхэд эрх бүхий этгээд бүрдүүлсэн бичиг баримтуудыг хянан үзсэний үр дүнд бүртгэлийн хүсэлтийг баталгаажуулж байгаа нь тухайн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг олгож буй үйлдэл ях аргагүй мөн.

Угтаа Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуульд заасны дагуу дараах эрх хэмжээтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ

35.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.14.хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлэх;

35.1.16.худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах;

48.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах бөгөөд түүнийг тухайн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн, баг, хорооны Хурлын хуралдаанд оролцсон иргэдийн олонхын саналаар батална.

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

21.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.3.нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт, заавар батлах;

Гэтэл хуулиар олгогдсон бүрэн эрхээ зохих ёсны дагуу хэрэгжүүлээгүйгээс иргэн, хуулийн этгээдүүдийн бизнесийн үйл ажиллагаад хүндрэл үүсч, хуульд заавал тусгай болон энгийн зөвшөөрөл авахаар заагаагүй бизнесийн үйл ажиллагаа явуулахад дахин нэг шат дамжлагаар явах шаардлагатай болоод байна. Ийнхүү эрх бүхий байгууллагаас захиргааны хэм хэмжээний акт батлан зөвшөөрөл гэх нэрийг ашиглалгүй, өөр арга хэлбэрээр зөвшөөрлийн системчлэлийг бий болгож байгаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн зорилго, үйлчлэх хүрээнээс хальсан, хуулийг зөрчсөн явдал мөн.

Цаашлаад Нийслэлийн иргэний иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гаргасан хууль зөрчсөн хэм хэмжээний актыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шалгаад хуулийн зөрчилгүй гэж үзэж Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн нь Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг байхгүй болгож, үгүйсгэсэн шинжтэй үйлдэл болсон байна.

3.2.3 Бизнесийн дарамт буурсан эсэх

Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн хуулийг шинэчлэн найруулж Зөвшөөрлийн тухай хууль батлагдах гол үзэл санаа, суурь нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрлийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг гурав дахин цөөрүүлж, илүү тодорхой болгох замаар бизнесийн үйл ажиллагаанд ээлтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх, цаашлаад тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор төрийн хүнд суртлыг арилгах, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдүүдэд чирэгдэлгүй хүргэхэд оршино гэж тодорхойлсон байдаг.

Тодруулбал Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан¹⁰ “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.19 дэх хэсэгт “Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган,

¹⁰Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолын хавсралт <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207409&showType=1>

давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана”, 2.12 дахь хэсэгт “Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна”, 5.2.7 дахь хэсэгт “Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчинг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулна” гэсэн зорилтуудыг тус тус дэвшүүлсэн байдаг. Мөн цаашлаад Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан¹¹ “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 2 дахь хэсэгт Зөвшөөрлийн тухай хуулийг боловсруулах болсон үндэслэл, зорилгыг тодорхойлохдоо “Зөвшөөрөл, лицензийн тоог цөөлж, лиценз авдаг олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй, орчиндоо аюултай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хязгаарлагдмал нөөц бүхий нийтийн өмч, эрхийг эзэмших, ашиглахад төрөөс зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, цуцлах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгох” гэж томъёолжээ.

Гэвч Зөвшөөрлийн тухай хууль батлагдан мөрдөгдөж эхлэснээс хойш хэдийнээ 2 орчим жилийн хугацаа өнгөрөхөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж байх үед үүсч байсан асуудлууд цэгцэрч, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д томъёологдсон зорилтууд бодит байдал дээр биелэлээ олж, цаашлаад Зөвшөөрлийн тухай хуулийн үйлчлэл зөвшөөрлийн харилцааг үр дүнтэйгээр зохицуулж буй эсэх нь учир дутагдалтай байна.

Бодит байдал дээр Зөвшөөрлийн тухай хууль зорилгодоо нийцээгүй, хэлбэрийн төдий зохицуулалттай, хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа болох нь энэхүү судалгааны ажлын 3.2.1, 3.2.2 дахь хэсгүүдэд буй нөхцөл байдлаас тодорхой харагдана. Тухайлбал Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно” гэж, 1.5 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт “Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглоно” гэж, 17 дахь хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасан байхад төрөөс олгогдож буй нийт 251 тусгай зөвшөөрлөөс 89 зөвшөөрлийг олгох харилцаа нь эрх бүхий байгууллагаас батлагдсан журмаар, 33 зөвшөөрөл нь хууль болон журмаар давхардсан байдлаар зохицуулагдаж байгаа нь эрх бүхий байгууллагаас захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар хуулиас гадуур зөвшөөрөл олгох шат дамжлагыг илүү өргөсгөж, хүнд суртлыг бий болгох үндэс суурийг тавьж байгаа юм.

Тусгай зөвшөөрөл олгох процессын үе шат дамжлагыг нэмсэн байдлыг жишээгээр авч үзвэл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт

¹¹Монгол Улсын Их Хурлын 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт <https://leginfo.mn/mn/detail?lawId=207617&showType=1>

заасан Амьтныг сэргээн нутагшуулах тусгай зөвшөөрлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор Зөвшөөрлийн тухай хуульд заасан бөгөөд захиргааны байгууллагад ийнхүү эрх олгосон хуулийн зохицуулалт нь Амьтны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг байна. Тус хуулийн заалтаас үзвэл амьтныг сэргээн нутагшуулах тухай тусгай зөвшөөрлийг авахаар хүсэлт гаргагч этгээд нь мэргэжлийн байгууллага байх хуулийн шаардлага тавигдаж байна. Өөрөөр хэлбэл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.4-т заасан Ан, амьтны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь 1.2-т заасан тусгай зөвшөөрлийг авч болохоор байна.

Тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргахдаа албан хүсэлт, Шинжлэх ухааны байгууллагын гаргасан дүгнэлт, Амьтны мэргэжлийн байгууллагын эрх олгосон гэрчилгээ, Ажлын гэрээ, Сэргээн нутагшуулах ажлын төлөвлөгөө буюу аргачлал гэх 5 төрлийн бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай. Гэтэл уг бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлэхийн тулд бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай буюу Шинжлэх ухааны байгууллагаас дүгнэлт авахад, Амьтны мэргэжлийн байгууллагын эрх олгосон гэрчилгээ авахад буюу зөвшөөрлийг олж авахад тухайн эрх бүхий байгууллагуудаас шаардсан бичиг баримтыг бүрдүүлэн хүсэлтээ гаргах ёстой болж байна.

Энэ байдлаар зөвшөөрөл авахын тулд урьдчилсан байдлаар зөвшөөрөл авахыг шаарддаг нөхцөл байдлаас үүдэн төрийн үйлчилгээний хүнд суртал бий болж, бизнес эрхлэгчдийн нуруун дээр нэмэлт ачаа үүсч байдаг нь энгийн зүйл мэт болоод байна. Тиймээс энэ нөхцөл байдлыг цэгцлэх, хуулийн хэрэгжилтийг бий болгох, журмаар бус салбарын хуулиар тусгай зөвшөөрөл олгогддог байдлыг бий болгох шаардлагатай байна. Ингэснээр цаашид төрөөс хамаарсан бизнесийн үйл ажиллагаа илүү түргэн шуурхай, дарамтгүй явагдах нөхцөл боломж бүрдэнэ.

Эцсийн дүнд дээрх нөхцөл байдлаас бизнес эрхлэгчид, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргагч этгээдүүд хохирч байгаа болохыг анхаарч цаашид энэ байдлыг засах, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүндрэлгүй хүргэх арга замыг нарийвчлан судлах шаардлагатай гэж үзлээ.

3.3 ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХИЙДЭЛ, ЗӨРЧИЛ АРИЛЖ, УЯЛДАА ХОЛБОО САЙЖИРСАН ЭСЭХ

3.3.1 Зөвшөөрлийн процессыг хэм хэмжээний актаар зохицуулахгүй байх

Зөвшөөрлийн тухай хууль

1.3.3.Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

1.5.17.Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно.

А. Зөвшөөрлийн хууль болон Захиргааны ерөнхий хуулийн уялдаа холбоо

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт төрийн байгууллагаас олгогдох тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг гагцхүү салбарын, нарийвчилсан хуулиар зохицуулж болох тухай заасан байна. Харин мөн зүйлийн 17 дахь хэсэгт тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг эрх шилжүүлэх байдлаар хэм хэмжээний акт гаргах замаар зохицуулахыг хориглосон байна. Өөрөөр хэлбэл тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой процессын журмыг зөвхөн хуулиар тогтооно гэх агуулгаар хуульчлагдсан байна.

Гэтэл нөгөө талаас Зөвшөөрлийн тухай хуулийн дээрх зохицуулалт нь Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна. Тодруулбал Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлээс 72 дугаар зүйлд захиргааны хэм хэмжээний актын талаар зохицуулж өгсөн бөгөөд эрх бүхий байгууллагад хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хэм хэмжээний акт баталж мөрдүүлэх боломжтой байдлаар зохицуулсан байна.

Хүснэгт №11 Захиргааны ерөнхий хууль болон Зөвшөөрлийн тухай хуулийн уялдаа холбоо

Захиргааны ерөнхий хууль	Зөвшөөрлийн тухай хууль
59.1.Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.	1.5.17.Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно.

Захиргааны ерөнхий хууль болон Зөвшөөрлийн тухай хуулийн дээрх зохицуулалтуудаас шалтгаалж хуулиар нэгэнт тусгайлан эрх олгож хэм хэмжээний акт гаргах бүрэн эрхийг олгосон байхад энэ эрхийг өөр тусгайлсан хуулиар хориглох боломжтой эсэх буюу хуулийн эрэмбэ, хүчин чадал, үйлчлэл хэрхэн хэрэгжих талаар эргэлзээтэй нөхцөл байдал бий болж байна. Үүнийг жишээгээр тайлбарлавал:

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэг буй аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг жишээ болгон авч үзье. Энэхүү тусгай зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд нь Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4-т заасны дагуу Хог хаягдлын талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байна. Хог хаягдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг болон 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт зохицуулсанаар энэхүү тусгай зөвшөөрлийг дараах байдлаар тусад нь олгож байна.

- Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

Энэхүү тусгай зөвшөөрлийн олгохдоо Хог хаягдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийг баримтлах ба мөн зүйлийн 37.9 дэх хэсэгт Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход энэ хуулийн 7.1.2-т заасан журмыг мөрдөнө гэж заасан. Хог хаягдлын тухай хуулийн 37.1-т заасан тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор хүчин төгөлдөр хэрэгжиж буй журам нь Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам” байна. Гэвч тус журам нь тусгай зөвшөөрөл олгох агуулга бус тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд мөрдөгдөх журам байна. Үүнээс өөр тусгай зөвшөөрөл олгох харилцааг нарийвчлан зохицуулсан дүрэм, журам батлагдсан эсэх нь тодорхойгүй нөхцөл байдалтай байгаа бөгөөд хэрэв батлагдсан байсан ч нийтэд ил тод, ойлгомжтой биш байна.

Уг зөвшөөрлийн хүсэлтийг E-business.mn зөвшөөрлийн цахим системд хандан гаргах боломжтой байна. Хүсэлт гаргахад бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт нь хуулиар зохицуулагдаагүй байх тул холбогдох журмаар зохицуулагдаж байж болох юм.

- Аюултай хог хаягдал экспортлох тусгай зөвшөөрөл

Хог хаягдлын тухай хуулийн 38 дугаар зүйлд хог хаягдал экспортлох тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд мөн зүйлийн 38.3 дахь хэсэгт бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг хуульчилж өгсөнөөр бусад тусгай зөвшөөрөлтэй харьцуулахад процессын хувьд илүү тодорхой байна. Мөн Монгол Улсын нэгдэн орсон Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцийн 6 дугаар зүйлд заасан баримтуудыг мөн тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад бүрдүүлэн өгөх шаардлагатай байна. Харин тусгай зөвшөөрөл олгохтой холбоотойгоор тусдаа журам батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эсэх нь тодорхойгүй байгаа юм. Энэхүү тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахим хэлбэрээр E-business.mn зөвшөөрлийн цахим системд хандан гаргах боломжтой байна.

Өмнө нь 2018 оны А/18 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам” нь хүчин төгөлдөр хэрэгжиж байсан боловч хүчингүй болж, энэ харилцааг зохицуулах журам дахин батлагдсан эсэх нь тодорхойгүй байна. Хог хаягдлын тухай хуулийн 37 болон 38 дугаар зүйлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой ерөнхий журмыг зохицуулсан байх боловч энэ нь нарийвчилсан журамгүйгээр, эсхүл хуульд нарийвчлан зохицуулалгүйгээр хэрэгжихэд хүндрэлтэй зохицуулалтууд байна.

Дээрхээс дүгнэвэл аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох процессын журмыг салбарын хууль тогтоомжид зохицуулаагүй учраас процессыг тодорхой болгохын тулд журмаар зохицуулах шаардлага үүсч байна. Гэтэл

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар тусгай зөвшөөрөл олгох процессыг журмаар зохицуулахыг хориглосон байх тул Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг ямар эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж олгох вэ гэдэг нь тодорхойгүй болж байна. Өөрөөр хэлбэл Захиргааны ерөнхий хуулийн заалтыг баримтлан эрх бүхий этгээдээс журам батлан мөрдүүлж тусгай зөвшөөрлийг олгох уу, эсхүл Зөвшөөрлийн тухай хуулийн заалтад үндэслэн салбарын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах уу гэдэг асуудлыг нэг тийш болгож хууль тогтоомжийн хийдэл зөрчлийг арилгаж уялдаа холбоог сайжруулах хэрэгцээ шаардлагатай байна.

Б. Тусгай зөвшөөрөл олгох процессыг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж буй байдал

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд 14 чиглэлийн 251 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэнд эрхлэх талаар хуульчилсан билээ. Тэдгээр үйл ажиллагаанд олгогдох тусгай зөвшөөрөл бүрийн холбогдох салбарын нарийвчилсан хууль тогтоомжийн судлан үзвэл Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасан хуулийн хязгаарлалт бодит байдал дээр огт хэрэгждэггүй болох нь тодорхой болж байгаа юм.

Тодруулбал Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1-д заасан 251 төрлийн тусгай зөвшөөрлөөс 89 төрлийн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, цуцлах, сунгахтай холбоотой процессын ажиллагаа зөвхөн хэм хэмжээ тогтоосон акт буюу эрх бүхий этгээдээс баталсан журмаар зохицуулагдаж байна. Үүнээс гадна 33 төрлийн үйл ажиллагаанд олгогдох тусгай зөвшөөрлийн процессын журмыг салбарын нарийвчилсан хууль болон журмаар хамтад нь зохицуулж байна. Өөрөөр хэлбэл нийт 251 төрлийн тусгай зөвшөөрлийн 122 буюу тал хувийн тусгай зөвшөөрлийн процесс нь захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулагдаж байгаа юм. Энэхүү нөхцөл байдал нь судалгааны тайланд хавсаргасан ажлын хүрээнд нотлогдох бөгөөд тус судалгааны ажлаар Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан 251 тусгай зөвшөөрлийг олгох журмыг ямар хэм хэмжээний актаар зохицуулж байгааг нэр бүрчлэн нарийвчилж судалсан болно.

Эндээс дүгнэвэл Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэг заасан зохицуулалт нь бодит байдал дээр хэрэгждэггүй, өнөөгийн Монгол улс дахь салбарын хууль тогтоомжийн эрх зүйн орчны хувьд ч хэрэгжих боломжгүй хуулийн зохицуулалт болжээ.

3.3.2 Зөвшөөрөл олгох эрхийг бусдад шилжүүлэхгүй байх

Зөвшөөрлийн тухай хууль


3.1.1. Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох бөгөөд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд зөвшөөрөл олгох бүрэн эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Зөвшөөрлийн тухай хуулийн дээрх зохицуулалтаас үзэхэд хуулийн 8.1 болон 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг мөн зүйлд заасан эрх бүхий этгээд олгох бөгөөд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд зөвшөөрөл олгох эрхээ бусдад шилжүүлэх боломжгүй байна. Мөн Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасан байна. Эндээс үзэхэд тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд эрхээ бусдад шилжүүлэхэд зөвхөн хуульд үндэслэсэн байх учиртай бөгөөд захиргааны хэм хэмжээний акт батлах замаар эрхээ шилжүүлэх боломжгүй байна.

Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасан тохиолдолд эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох эрхээ бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, эсхүл Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.7-д заасан хуулийн этгээдэд шилжүүлж болно” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “эрх шилжүүлэх журмыг Засгийн газар батална” гэж заасан бөгөөд Засгийн газраас дээрх чиг үүргээ одоогоор хэрэгжүүлээгүй буюу эрх шилжүүлэх талаар нарийвчилсан журам батлаагүй байна. Үүний улмаас эрх шилжүүлэх зохицуулалт хэрэгжих эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Гэвч бодит байдал дээр зөвшөөрөл олгох бүрэн эрхээ шилжүүлсэн тохиолдлууд гарсан байна. Тухайлбал Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Эрчим хүчний сайдын 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/55 дугаар тушаалд заасны дагуу “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-д Эрчим хүчний тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авах, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах ажлыг зохион байгуулах эрхийг шилжүүлсэн.

Зураг №8. Эрчим хүчний яамнаас зөвшөөрөл олгох ажиллагаатай холбоотойгоор эрх шилжүүлсэн байна¹²



Эрчим хүчний сайдын 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/55 дугаар тушаалыг <https://www.energy.mn> вэб сайтын хууль эрх зүй, сайдын тушаал цэсээс хайгаад олдоогүй тул, зөвхөн Эрчим хүчний яамны танилцуулгаас ишилсэн болно.

Эндээс дүгнэхэд Зөвшөөрлийн тухай хуулиар эрх бүхий албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд өөрт олгогдсон тусгай зөвшөөрөл олгох бүрэн эрхээ бусдад

¹² Эрчим хүчний яамны “тусгай зөвшөөрөл” танилцуулга 2024 оны 12-р сарын __-ний өдрийн

шилжүүлэхийг хориглосон байх боловч бодит байдал дээр захиргааны хэм хэмжээний акт батлан гаргах замаар эрх шилжүүлж буй тохиолдол үүсээд байна. Иймд цаашид Зөвшөөрлийн тухай хууль болон хууль зөрчиж батлагдсан эрх зүйн үйлчлэлтэй захиргааны хэм хэмжээний актыг нэг тийш болгох замаар практикт буруу тогтсон жишгийг арилгах, тусгай зөвшөөрөл олгох процесс ажиллагааг илүү тодорхой болгох хэрэгцээ шаардлагатай байна.

3.3.3 Зөвшөөрлийн тухайн хууль болон салбарын хуулийн хэм хэмжээний өрсөлдөөн, давхардал, нэр томъёоны зөрүүтэй байдал

А. Зөвшөөрлийн тухайн хууль болон салбарын хуулийн хэм хэмжээний өрсөлдөөн, давхардал

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд тусгай зөвшөөрлийн үндсэнд эрхлэх үйл ажиллагаа бүрт зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтныг тухайлан тодорхойлж өгсөн. Мөн салбарын хууль тогтоомжид эрх бүхий албан тушаалтнуудад тусгай зөвшөөрөл олгох эрх олгосон заалтуудыг зохицуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл тусгай зөвшөөрөл олгох эрхийг эрх бүхий албан тушаалтанд олгосон хуулийн зохицуулалт нь хоёр хуульд давхар зохицуулагдсан байгаа нь өрсөлдөх шинжтэй хэм хэмжээ тогтоосны хэлбэр юм.

Зөвшөөрлийн тухай хуульд тусгай зөвшөөрөл олгох процессын журмыг ерөнхий байдлаар хуульчилсан. Тухайлбал 8.1 дүгээр зүйлийн 1.14 дэх хэсэгт заасан химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар зохицуулж байх бөгөөд тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт *“Энэ хуулийн 5.1-д заасан зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна”* гэж заасан байна. Гэтэл Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт *“Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна”* гэж хуулийн үйлчлэх эрэмбийн хувьд юуны түрүүнд тухайлсан хуулийн заалтыг баримтлана гэж салбарын хуулийг хэрэглэх байдлаар буцаан заасан. Эндээс хуулийн хэм хэмжээний өрсөлдөөн бий болж буй тохиолдлууд бий болоод байна.

Салбарын нарийвчилсан хуулиудад тусгай зөвшөөрлийн талаар зохицуулагдсан байдлыг авч үзвэл зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага, шалгуурыг зохицуулж өгсөн байна. Тухайлбал Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 7 дугаар зүйл *“Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”*, 8 дугаар зүйл *“Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг”*, 9 дүгээр зүйл *“Тусгай зөвшөөрөл олгох”*, 10 дугаар зүйл *“Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах”*, 11 дүгээр зүйл *“Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх”*, 12 дугаар зүйл *“Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох”* харилцааг хуулиар нарийвчлан зохицуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл энэ тохиолдолд зөвшөөрөл олгохтой холбоотой бүхий л процессын шинжтэй харилцааг салбарын хуулиар

нарийвчлан зохицуулсан байх бөгөөд Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох ерөнхий процессын журам үйлчлэхээргүй байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан 251 төрлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын журмыг ямар эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан болохыг авч үзвэл нарийвчилсан хуулиар зөвшөөрөлд тавигдах нийтлэг шаардлага, олгох процессыг нь зохицуулаагүй “тусгай зөвшөөрлийн” тоо 109 байх бөгөөд үүний 89 нь журмаар зохицуулагдсан, харин 20 нь журмаар зохицуулагдаагүй буюу зөвшөөрөл авахад бүрдүүлэх бичиг баримт, процессын журмын зохицуулалтгүй тусгай зөвшөөрлүүд байна.

Үүнээс жишээ татвал Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.8.11-т заасан “Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх” тусгай зөвшөөрөл бөгөөд уг тусгай зөвшөөрөлийг зохицуулах тусгайлсан хууль, журам байхгүй бөгөөд эрх зүйн орчин нь огтоос бүрдээгүй байгаа юм. Зөвхөн Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар “Хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага”-аас тусгай зөвшөөрөл олгоно гэж зааснаас өөр хуулийн зохицуулалт байхгүй байдалтай байна.

Б. Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын хуулийн нэр томъёоны зөрүүтэй байдал

Түүнчлэн Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын хууль тогтоомжид зохицуулагдсан тусгай зөвшөөрлийн нэр томъёо хоорондоо зөрүүтэй байгаагийн улмаас тодорхойгүй байдал үүсч байна. Тухайлбал Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан зөвшөөрөл нь “Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл үү, аль эсвэл “Монгол Улсын иргэнийг дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл эсэх нь хуульд тодорхойгүй тусгагджээ. Өөрөөр хэлбэл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.10.1-т хоёр төрлийн тусгай зөвшөөрлийг хуульчилж өгсөн үү, аль эсвэл нэг л тусгай зөвшөөрөл үү гэдэг нь тодорхойгүй байгаа юм.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.8.20-д “Цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, импортлох, экспортлох” тусгай зөвшөөрлийг “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” олгохоор заажээ. Гэвч уг харилцааг нарийвчлан зохицуулсан тусгай хууль болох Цөмийн энергийн тухай хуулийн 15.3.3-ийг харвал уг тусгай зөвшөөрлийг цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгохоор заажээ. Энэ нь салбарын нарийвчилсан хууль болон Зөвшөөрлийн тухай хуулиудад зөрчилдөөн үүсгэх бөгөөд 2 өөр хуулиар 2 өөр эрх бүхий этгээдээс тусгай зөвшөөрөл авах боломжтой мэт ойлгомжгүй байдлыг үүсгэх эрсдэлтэй юм.

Түүнчлэн Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын хуульд заасан зөвшөөрлийн нэр, томъёолол зөрүүтэй байх тохиолдол байна. Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд тусгай зөвшөөрлийн төрлүүдийг хуульчилж өгсөн байх бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.4-т заасан “Суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах” гэсэн төрлөөс өөр найруулгаар салбарын хуульд тусгаж өгчээ. Төмөр замын тээврийн тухай хуулийн 14.1.3-т “төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн эд анги үйлдвэрлэх, угсрах, засварлах;” гэсэн илүү өргөн агуулгаар тусгай зөвшөөрөл олгохоор салбарын хуульд тусгасан байна. Иймд

Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах, хуулийн нэр томъёог жигдлэхгүй бол Төмөр замын тээврийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл болон Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл 2 зөрөх, ойлгомжгүй байдал үүсгэхээр байна.

ДӨРӨВ. ДУГНЭЛТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээний ажлыг гүйцэтгэж дараах байдлаар дүгнэж байна.

Зөвшөөрлийг цахимжуулах зорилтын хүрээнд:

Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 233 дгаар “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг баталж Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас цахим хэлбэрээр шийдвэрлэх харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авахыг, “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ, “И-Монгол академи” УТҮГ-ыг зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргах үйл ажиллагааг цахимжуулахыг тус тус үүрэг болгосон байна.

Өнөөдрийн байдлаар “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-аас хөгжүүлсэн <https://license.mn> системд 53 тусгай зөвшөөрөл, “И-Монгол академи” УТҮГ-аас хөгжүүлсэн <https://e-business.mn> системд 40 тусгай зөвшөөрөл, 4 энгийн зөвшөөрлийг тус тус цахимжуулсан. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудаас хөгжүүлсэн нийт 141 тусгай зөвшөөрөл цахимжсан, 44 энгийн зөвшөөрөл цахимжсан гэх мэдээллийг хэрэгжүүлж буй төрийн байгууллагуудаас ирүүлсэн.

Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудаас 18 тусгай зөвшөөрөл, 37 энгийн зөвшөөрлийг цахимжуулах боломжгүй гэх саналуудыг ирүүлсэн бөгөөд “И-Монгол академи” УТҮГ-аас хөгжүүлсэн <https://e-business.mn> системд зөвшөөрлүүдийн цахимжуулах, систем хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэсэн. Одоогоор тус тусдаа хөгжүүлсэн цахим системүүдийг хэрхэн уялдаатай ажилладаг болгох, холбох, зөвшөөрөл олгож буй байгууллагуудыг нэгдсэн системд нэгтгэх зэрэг ажлыг хэрэгжүүлж байгаа ч бодит нөхцөлд удаашралтай, зөвшөөрөл олгох процесс, тавигдах шаардлагуудыг цахим системд уялдуулах, нийцүүлэхэд хүндрэлүүд үүсдэг байна.

Мөн хуулиар тусгайлан зохицуулаагүй зөвлөл, ажлын хэсэг, хороо гэх зэрэг бүтцээр урьдчилан шийдвэрлэхээр, эсхүл дүгнэлт гаргасны дараа зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтан олгохоор нарийвчилсан хууль, журмаар зохицуулж өгсөн байдаг зэргээс хамаарч хуулийн хугацааг баримтлах боломжгүй, системд тохируулга хийхэд хүндрэл үүсч байгааг гардан гүйцэтгэж байгаа албан хаагчдын зүгээс тодорхой тайлбарладаг.

Гэвч бодит байдал дээр Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан 251 тусгай зөвшөөрлийг нэг бүрчлэн холбогдох захиргааны байгууллага, цахим хуудсаар орж шалгаж үзэхэд, 178 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжтой байгаа бол 73 тусгай зөвшөөрөл уламжлал хэлбэрээр явж байна. Хэдий

<https://license.mn> зэрэг цахим хуудаснаас ихэнх тусгай зөвшөөрлүүдийг авах боломжтой байна гэж холбогдох байгууллагуудаас мэдэгдсэн байх боловч үнэндээ зөвшөөрлийн нэрээр хайхаар илэрц гарч ирэхгүй байх, үйлчилгээ авах цонх нь гарч ирэхгүй байх зэрэг бодитоор үйлчилгээ авч чадахгүй байх асуудлууд тулгамдаж байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1-д заасан тусгай зөвшөөрлүүдээс 73 нь одоог хүртэл уламжлалт цаасан хэлбэрээр явж байгаа бөгөөд тусгай зөвшөөрөл бүрт нарийвчилсан үнэлгээ, шалгалт хийвэл бодит байдал дээр 73-аас ч их тооны зөвшөөрөл уламжлалт байдлаар буюу цахимжаагүй, цахим систем нь ажиллахгүй байх нөхцөл байдалтай байна.

Зөвшөөрлийн нэгдсэн сан:

Засгийн Газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 251 дүгээр “Журам баглах тухай” тогтоолын хавсралтаар “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийн бүртгэл, лавлагаа, мэдээлэл өгөх журам” батлагдаж, “Тааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-аас <https://license.mn/> системд зөвшөөрлийн цахим санг үүсгэн зөвшөөрөл олгож буй байгууллагуудыг холбох ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна.

Зөвшөөрөл олгосноос хойш 2 хоногийн дотор зөвшөөрлийн нэгдсэн санд мэдээллийг оруулах, олон нийтэд нээлттэй байршуулах зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй буюу судалгааны явцад <https://license.mn/> байршсан мэдээллүүдийг шүүж үзэхэд өөрийн системд зөвшөөрөл олгосон гэх мэдээллийг байршуулсан ч зөвшөөрлийн нэгдсэн санд оруулаагүй, зөвшөөрлийн мэдээллийг огт оруулаагүй тохиолдлууд элбэг байна.

Зөвшөөрлийн тоог цөөрүүлж, зөвшөөрлөөс үүсэх бизнесийн орчны дарамтыг бууруулах зорилтын хүрээнд:

Зөвшөөрлийн тухай хуулиар 2001 онд батлагдаж 2022 оныг хүртэл хугацаанд үйлчилсэн Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль болон салбарын 100 гаруй хууль, тогтоомжоор зохицуулж байсан тусгай зөвшөөрлүүдийн харилцааг нэгтгэн зохицуулсан. 2024 оны 12 дугаар сарын байдлаар 257 тусгай зөвшөөрөл, 124 энгийн зөвшөөрлийн нийт 381 зөвшөөрлийг нэр, төрөл, салбар, олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтны жагсаалтыг хуулийн 8.1, 8.2-т зохицуулсан.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5.16-д зөвшөөрлийг нэмэх, задлах, хуваах, салгах, түүний хамрах хүрээг өргөжүүлэхийг хориглохоор заасан ч бодит нөхцөл байдалд анхнаасаа тус тусдаа байсан зохицуулалтыг нэгтгэсэн, нарийвчилсан журмаар салган зохицуулж өгсөн зэрэг нийтлэг зөрчилтэй байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3.1-т заасны дагуу хуулийн 8.1, 8.2-т зааснаас бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болохоор зохицуулж өгсөн.

Гэвч бодит байдал дээр бүртгэл, дүгнэлт гаргуулах зэргээр Зөвшөөрлийн хуулиар зохицуулаагүй үйл ажиллагааг “зөвшөөрөл” авах харилцаа байсаар байна. Тодорхой жишээ дурдахад "Онлайн бизнес төв" буюу <https://service.ulaanbaatar.mn/home> системд 15 чиглэлээр 145 үйл ажиллагааг бүртгүүлж Нийслэл Улаанбаатар хотод худалдаа, үйлчилгээ явуулах эрхийг авч байдаг, бүртгүүлийг дүүргийн "Зөвлөл" гэх

бүтцээр хянан баталгаажуулахаар Нийслэлийн иргэний иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34 дүгээр “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам батлах тухай” тогтоол баталж, хэрэгжүүлж байна.

Зөвшөөрлийн тухай хууль батлагдснаас хойш шинээр зөвшөөрлийг нэмэх нөхцөлд хуулийн 9.3.2-т заасан журмын дагуу дүгнэлт гаргаж, шалгуурыг бүрэн хангасан нөхцөлд нэмж байхаар зохицуулж өгсөн ч энэ хугацаанд 15 удаагийн нэмэлтээр 17 төрлийн тусгай зөвшөөрлийг хуулиар нэмж зохицуулсан. Ингэхдээ хуульд заасан журмыг баримтлаагүй, тусгай горимоор хэлэлцэх баталсан байна.

Зөвшөөрлийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжуудын хийдэл, зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах зорилтын хүрээнд:

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3. дугаар зүйлийн 3-т “Хуулиар зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглахад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж зааж өгсөн нь Зөвшөөрлийн тухай хуулийг зөвшөөрөл олгох харилцааны ерөнхий хууль гэж үзэхэд хүргэж байна.

Гэтэл Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай болон энгийн зөвшөөрөл нь салбар болгоны хуульд нь тусгагдсан байх бөгөөд салбарын хуулиудаас Зөвшөөрлийн хуульд нэгтгэн системчилж өгсөн байна. Энэ нь нэг талаар зөвшөөрлийн харилцааг хэн нэг албан тушаалтны хүсэл зориг, хүнд суртал үүсгэхээс сэргийлж, парламентаар баталсан хуулиар зохицуулж, албан тушаалтны дур зоргыг хязгаарлаж өгөх давуу талтай байж болно. Гэвч Зөвшөөрлийн тухай хууль салбар болгоны зөвшөөрөл олгох процессын онцлогыг өөртөө тусгах боломжгүй тул салбарын хуулиар зөвшөөрөл олгох процессын журмыг нь хуульчилж өгөөгүй л бол эрх бүхий этгээдийн баталсан хэм хэмжээний актаар зөвшөөрөл олгох процессыг илүү нарийвчлан зохицуулж байна. Үүнээс үүдээд Зөвшөөрлийн тухай хуулийн ач холбогдол сулрах, зохицуулах харилцааны хүрээ хумигдах, хууль хэрэглээний эрэмбийн зөрчил бий болгох эрсдэлтэй байна.

Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5.17-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасан нь зөвшөөрөлтэй холбоотой процессын бүхий л журмыг хуульчилж өгөх, хуулиар зохицуулах шаардлагыг хуульчилж өгсөн. Улмаар зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэхтэй холбоотой процессын журам хуульчлагдсан байдлыг судалж үзэхэд, 89 төрлийн үйл ажиллагааг хамаарах тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, цуцлах, сунгахтай холбоотой процессыг зөвхөн хэм хэмжээ тогтоосон акт буюу эрх бүхий этгээдээс баталсан журмаар зохицуул байна. Үүнээс гадна 33 төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн процессын журмыг салбарын нарийвчилсан хууль болон журмаар хамтад нь зохицуулж байна. Өөрөөр хэлбэл нийт 251 төрлийн тусгай зөвшөөрлийн 122 тусгай зөвшөөрлийг хэм хэмжээ тогтоосон актаар, журмаар зохицуулж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2-т заасан зөвшөөрлийг илүү нарийн системчилж өгөх шаардлагатай байна. Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.5.2-т “авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэсэн тусгай зөвшөөрлийг хуульчилж өгсөн байх боловч Зам тээвэр хөгжлийн сайдын 2021.06.30-ны өдрийн А/101 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”-аар тусгай зөвшөөрлийн төрөл, бүрдүүлэх бичиг баримт, процессыг нарийвчлан зохицуулж, тус журмаар энэ төрлийн тусгай зөвшөөрөл нь 15 төрлийн тусгай зөвшөөрөл болон задарч байна.

Мөн түүнчлэн, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.13.18-т “эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх” гэсэн нэг тусгай зөвшөөрлийг олгохоор заасан байх бөгөөд энэ төрлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бүх төрлийн үйл ажиллагаа явуулсан байхыг шаардаж (жишээ нь зөвхөн эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжээс эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн талаар үйл ажиллагаа явуулсан тайлан, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг шаарддаг), тухайн чиглэл тус бүрээр тайлан шаардаж байгаа нь мөн л тусгай зөвшөөрлийн төрлийг зөв ангилж чадаагүйг харуулж байна.

Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрлийн төрөл болон салбарын хуульд заасан тусгай зөвшөөрлийн төрөл зөрөх, нэр томьёо нь өөрөөр хуульчлагдсанаас ойлгомжгүй байдал бий болгох зэрэг зөрчил байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Зөвшөөрлийн тухай хуульд заасан 14 салбарт олгож буй тусгай зөвшөөрлүүдэд хийсэн нийтлэг дүгнэлт, зөвлөмж		
1	Байгаль орчны чиглэл	<p>Байгаль орчны чиглэлийн нийт 31 төрлийн тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд зааж өгсөн. Тэдгээрийг нэг бүрчлэн шалгахад, 12 тусгай зөвшөөрлийг нарийвчилсан хуулиар, 3 зөвшөөрлийг хууль болон журмаар, 10 зөвшөөрлийг журмаар, харин 6 төрлийн зөвшөөрлийн процессын зохицуулалт нь тодорхойгүй (бүрдүүлэх бичиг баримт, олгох процесс) байдалтай байна. Мөн 31 зөвшөөрлөөс 18 төрлийн тусгай зөвшөөрлийг л цахимаар авах боломжтой байна:</p> <p>Байгаль орчны чиглэлийн тусгай зөвшөөрлүүдийг бусад тусгай зөвшөөрлүүдтэй харьцуулахад салбар бүрийг хамарсан процессын зохицуулалт байхгүйн улмаас энэ чиглэлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын ажиллагаанд тодорхойгүй бөгөөд хүндрэлтэй асуудлууд бий болж байна. Өөрөөр хэлбэл байгаль орчны чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой хуулийн зохицуулалт дутмаг байгаа тул эрх бүхий захиргааны байгууллагаас тодорхойгүй нөхцөл байдлыг тодорхой болгохын тулд журмын дагуу зохицуулахаас өөр аргагүй байна. Тодруулбал, “ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах” тусгай зөвшөөрлийн хувьд процессын ажиллагааг зохицуулах журам батлагдсан эсэх нь тодорхойгүй байх боловч практикт цахим хэлбэрээр тусгай зөвшөөрөл олгогдож буй нөхцөл байдалтай байна. Үүнээс үзэхэд дээрх тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцааг зохицуулах журам батлах зайлшгүй шаардлагатай байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангилал тус бүрийн процесс, журмыг салбарын нарийвчилсан хуульд хуульчлах; ❖ Процесс нь тодорхойгүй тусгай зөвшөөрлүүдийг процессжуулах, журамлах, хуульд тусгаж өгөх; ❖ Тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах.
2	Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэл	<p>Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлийн тусгай зөвшөөрлүүдийн ихэнх зөвшөөрөл олгох процесс, шаардлага зэрэг нь хууль болон холбогдох салбарын нарийвчилсан хууль тогтоомж болон журмаар давхар зохицуулагдаж байна. Тодруулбал, нийт 38 тусгай</p>

		<p>зөвшөөрлийн 21 төрлийн тусгай зөвшөөрөл авах процессыг хууль болон журмаар давхар зохицуулж байгаа бол 12 төрлийн тусгай зөвшөөрлийг зөвхөн журмаар, 5 тусгай зөвшөөрлийг огт хуулиар зохицуулаагүй байна.</p> <p>Эдийн засгийн тогтвортой байдалтай холбоотой чухал салбар учраас мөнгө угаахтай тэмцэх зэрэг олон төрлийн хяналт, шалгалтын хүрээнд бусад салбартай харьцуулахад журмаар харьцангуй нарийн зохицуулалтуудыг хийсэн салбар билээ.</p> <p>Цахимжуулалтын хувьд Төв банкнаас олгож буй зөвшөөрлүүд нь цахимаар шийдвэрлэх боломжгүй гэх хариуг өгсөн. Харин Санхүүгийн зохицуулах хорооноос Банк бус санхүүгийн үйлчилгээний чиглэлтэй холбоотой тусгай зөвшөөрлүүдийн хүсэлтийг цахим систем буй 2 цонхоор дамжуулан авч байна. Тодруулбал ББСБ байгуулах зөвшөөрлийг нэг цонхоор, түүнээс бусад бүх зөвшөөрлийг нэг цонхоор хүлээн авч байна. Гэвч тус байгууллагаас олгож байгаа тусгай зөвшөөрлүүд нь бүгд хоорондоо ялгаатай байхад ББСБ байгуулах болон бусад гэж ангилж хүсэлтийг хүлээн авч байгаа нь хэт ерөнхийлсөн шинжтэй байна. Жишээ нь: банк бус санхүүгийн байгууллагын нэмэлт тусгай зөвшөөрөл авах тухай өргөдөл гаргах хэсэг байх боловч аль тусгай зөвшөөрлийг нэмэлтээр гэж үзэж ямар журам, зүйл заалтад үндэслэн олгож байгаа нь тодорхой бус байна.</p> <p>Цахимжилтын хувьд, 38 тусгай зөвшөөрлөөс 24 тусгай зөвшөөрлийг авах үйлчилгээг цахимаар авах боломжтой буюу хангалттай биш гэж дүгнэхээр байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж салгаж хуульчлах; ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангилал тус бүрийн процесс, журмыг салбарын нарийвчилсан хуульд хуульчлах; ❖ Тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах.
3	Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэл	<p>Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлийн нийт 22 зөвшөөрлийг хуульд заасан ба тухайн зөвшөөрөл нэг бүрийг олгох процесс нь бүгд журмаар зохицуулагдаж байна. Нийт 22 зөвшөөрлөөс 21 зөвшөөрлийг цахимаар мэдүүлж байна.</p> <p>Энэ салбарын 22 тусгай зөвшөөрөл олгох процессыг бүгдийг журмаар зохицуулж байгаа нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5.17 заасан хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулахгүй гэж заасантай зөрчилдөж байх бөгөөд салбарын хуулиудад нь хуульчилж өгөх шаардлагатай.</p>

		<p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангилал тус бүрийн процесс, журмыг салбарын нарийвчилсан хуульд хуульчлах; ❖ Тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах.
5	Зам, тээврийн чиглэл	<p>Зөвшөөрлийн тухай хуулиар Зам, тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад 12 төрлийн тусгай зөвшөөрлийг хуульчилж өгчээ. Гэхдээ эдгээр тусгай зөвшөөрөл нь дотроо задарч өөр олон тусгай зөвшөөрөл болж байна. Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.5.2-т “Авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэсэн нэг заалт нь дотроо 15 төрлийн тусгай зөвшөөрөл болон задарч байна.</p> <p>Энэ салбарын 12 тусгай зөвшөөрлийн бүрдүүлэх бичиг баримт, шаардлага, тусгай зөвшөөрөл олгох процессыг журмаар зохицуулж байна. Мөн эдгээр төрлийн тусгай зөвшөөрлийн 11-г уламжлалт байдлаар цаасаар бүрдүүлж байгаа бол 1 тусгай зөвшөөрөл нь цахим хэлбэрт шилжсэн байна.</p> <p>Түүнчлэн, Зөвшөөрлийн тухай хууль болон салбарын хуулиар томъёологдсон зөвшөөрлийн нэр томъёо зөрөх тохиолдол мөн байна. Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.5.4 болон Төмөр замын тээврийн тухай хуулийн 14.1.3 байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж салгаж хуульчлах; ❖ Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын журмыг салбарын хуулиудад нь тусгаж оруулах; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах; ❖ Нэр томъёог жигдлэх
6	Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэл	<p>Энэ төрлийн үйл ажиллагааг эрхлэхэд нийт 12 тусгай зөвшөөрлийг хуульд жагсааж өгчээ. Үүнээс тусгай зөвшөөрлийн процессыг салбарын хуулиараа зохицуулж өгсөн 3, журмаар зохицуулж байгаа 8, хууль болон журмаар зохицуулаагүй 1 тусгай зөвшөөрөл байна. Нийт 10 тусгай зөвшөөрөл цахимжсан бол 2 тусгай зөвшөөрөл цахимжаагүй байна.</p> <p>Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.6.5-т “эд мөнгөний хожворт сугалаа гаргах” гэсэн тусгай зөвшөөрөл байх бөгөөд мөн</p>

		<p>зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.11.4-т “төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх” гэсэн тусгай зөвшөөрөл байх бөгөөд эдгээр тусгай зөвшөөрлийн давхардал хийдлийг арилгах, хэрэгцээ шаардлагыг дахин доторхойлох хэрэгтэй байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.6.5 болон 8.1.11.4-ийн давхардлыг арилгах, хэрэгцээ шаардлагад үнэлгээ хийх; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах;
7	Соёл, боловсролын чиглэл	<p>Соёл, боловсролын чиглэлийн нийт 12 тусгай зөвшөөрлийг хуульд жагсааж өгсөн байна. Үүнээс тусгай зөвшөөрлийн процессыг хуулиар зохицуулж өгсөн 7, журмаар зохицуулсан 3, хууль болон журмаар тусгай зөвшөөрөл олгох процессыг зохицуулж өгөөгүй 2 (Зөвшөөрлийн тухай хуулийн 7.7, 7.9) тусгай зөвшөөрөл байна. Нийт 9 тусгай зөвшөөрөл цахимжсан бол 3 тусгай зөвшөөрөл цахимжаагүй байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын журмыг салбарын хуулиудад нь тусгаж оруулах; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах; ❖ 8.1.7.7 болон 8.1.7.9-т заасан тусгай зөвшөөрлийг процессыг хуульд тусгаж өгөх, аль эсвэл энэ төрлийн тусгай зөвшөөрөл байх шаардлагатай эсэхэд хяналт шинжилгээ хийх.
8	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэл	<p>Уг чиглэлийн тусгай зөвшөөрлүүдээс одоогийн байдлаар 24 төрлийн тусгай зөвшөөрөл салбарын нарийвчилсан хуулиар зохицуулагдаж байгаа бөгөөд 1 тусгай зөвшөөрөл хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа болно.</p> <p>Харин зарим тусгай зөвшөөрлийн хувьд эрх зүйн орчин огтоос бүрэлдэн тогтоогүй байна. Тухайлбал, 8.1.8.11-д заасан “төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх”, 8.1.8.12-т заасан “үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх” зэрэг тусгай зөвшөөрлүүдийг олгох шаардлага, нөхцөл, цааншлад цуцлах, сунгах, түдгэлзүүлэх гэх мэт процессых нь эрх зүйн орчин бүхэлдээ байхгүй байгаа юм.</p> <p>Уг чиглэлийн тусгай зөвшөөрлүүдийн хувьд дээрх 2 тусгай зөвшөөрлөөс гадна 8.1-ийн 8.1, 8.13, 8.28-д заасан тусгай зөвшөөрлүүд ч мөн адил хууль болоод журмаар зохицуулагдаагүй байгаа юм. Харин бусад 25 төрлийн тусгай зөвшөөрлийн хувьд нарийвчилсан хуулиудаар зохицуулагдсан харьцангуй эрх зүйн орчин нь бүрэн тогтсон байгаа юм.</p>

		<p>Тиймээс энэ чиглэлийн хувьд 8.1-ийн 8.1, 8.11, 8.12, 8.13, 8.28-д заасан тусгай зөвшөөрлүүдтэй холбогдох харилцаа, шаардлагын эрх зүйн орчинг бүрдүүлэн бий болгох шаардлагатай байна.</p> <p>Мөн цахимжилтын хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт 30 тусгай зөвшөөрлийн бараг дөнгөж тал хувь нь буюу 16 тусгай зөвшөөрлийн үйлчилгээг л цахимаар авах боломжтой байгаа юм.</p>
9	Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэл	<p>Уг чиглэлийн 15 тусгай зөвшөөрлүүдийн 12 нь хуулиар зохицуулагдаж, 3 нь хууль болон журмаар давхар байдлаар зохицуулагдаж байна. Харин цахимжилтын хувьд бусад салбартай харьцуулахад харьцангуй цахижилт сайн явагдсан буюу 14 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимаар авах боломжтой байна.</p> <p>Салбарын хуулиудад бүхий л зөвшөөрөл олгох шаардлага, процессын журмыг хуульчлан зохицуулсан байна. Хэдий тийм боловч дээрх салбарын хуулиуд дээр өөр өөр төрлийн тусгай зөвшөөрлүүд дээр нийтлэг нэг баримт бичгүүд шаардаж буй нь ажиглагдаж байна. Үүнийг зөвшөөрөл бүрт нь тусгайлан олон давхар чирэгдэлгүй байдлаар сайжруулах хэрэгтэй.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж салгаж хуульчлах; ❖ Тусгай зөвшөөрлийн зарим төрлүүдийн хууль эрх зүйн орчинг бий болгох, сайжруулах ❖ Тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулах
10	Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэл	<p>Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Зөвшөөрлийн тухай хуульд 1 тусгай зөвшөөрөл олгохоор хуульчилжээ. Гэхдээ, Зөвшөөрлийн тухай хуулийн 10.1-т заасан зөвшөөрөл нь “Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл үү, аль эсвэл “Монгол Улсын иргэнийг дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл эсэх нь хуульд тодорхойгүй тусгагджээ. Өөрөөр хэлбэл Зөвшөөрлийн тухай хуулийн 10.1-т хоёр төрлийн тусгай зөвшөөрлийг хуульчилж өгсөн үү, аль эсвэл нэг л тусгай зөвшөөрөл үү гэдэг нь тодохойгүй байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг цахимаар мэдүүлэх систем хөгжөөгүй байна.</p> <p>Харьцангуй сүүлд батлагдсан хууль болохоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлага, зөвшөөрлийг олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх процессын журмыг хуульд өөрт нь суулгаж өгсөн байна.</p> <p>Түүнчлэн, хэрэв энэ төрлийн тусгай зөвшөөрлийн “Монгол Улсын Иргэний дадлагажихад зуучлах” үйл ажиллагааг тусдаа</p>

		<p>тусгай зөвшөөрөл гэж үзвэл, энэ төрлийн тусгай зөвшөөрлийг хойбогдох яам бодит байдал дээр олгохгүй байгаа зөрчил байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж, салгаж хуульчлах; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах; ❖ Дадлагажихад зуучлах тусгай зөвшөөрлийг олгох.
11	Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар	<p>Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар тусгай зөвшөөрөл олгох 13 төрлийн зөвшөөрлийг жагсааж өгчээ. Эдгээрээс зөвшөөрөл олгох процессыг хуулиар зохицуулсан 1, журмаар зохицуулагдсан 12 тусгай зөвшөөрөл байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлөөс 2 зөвшөөрөл нь цахимжиж, 11 зөвшөөрөл цахимжаагүй байна.</p> <p>Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг нэг бүрчлэн шалгаж үзэхэд салбарын тусгайлсан хуульд зөвшөөрөл авахаар хуульчлагдаагүй байхад Зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрлийн төрөл болон хуульчлагдсан байна. Тухайлбал, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.11.2 болон Галт зэвсгийн тухай хуулийн 11.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 11.5 болон Галт зэвсгийн тухай хуулийн 16.1 байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж, нэр томъёог жигдлэн хуульчлах; ❖ Тухайн тусгай зөвшөөрөл нь байх шаардлагатай эсэхэд хяналт шинжилгээ хийх; ❖ Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын журмыг салбарын хуулиудад нь тусгаж оруулах; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах.
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэл	<p>Энэ төрлийн чиглэлээр олгох нийт 14 төрлийн тусгай зөвшөөрлийг жагсааж өгсөн. Үүнээс тусгай зөвшөөрөл олгох процессыг тус тусын хуульд нь тусгаж процессжуулж өгсөн 12, жармаар зохицуулсан 1, хууль болон журмаар зөвшөөрөл олгох процессыг тодорхойлоогүй 1 тусгай зөвшөөрөл байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлөөс 13 зөвшөөрөл нь цахимжиж, 1 зөвшөөрөл цахимжаагүй байна.</p> <p>Харьцангуй сүүлд батлагдсан хуулиуд нь өөртөө тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох процессын журмыг тусгаж өгсөн нийтлэг дүр зураг ажиглагдаж байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах;

13	Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагаа	<p>Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад олгох 17 тусгай зөвшөөрлийг хуульд жагсааж өгсөн байна. Тусгай зөвшөөрлүүдийг нэг бүрчлэн шалгаж үзэхэд тусгай зөвшөөрөл олгох процессыг хуулиар зохицуулсан 3, хууль болон журмаар давхар зохицуулагдсан 5, журмаар зохицуулагдсан 9 тусгай зөвшөөрөл байна. Энэ төрлийн тусгай зөвшөөрлөөс 16 зөвшөөрөл нь цахимжиж, 1 зөвшөөрөл цахимжаагүй байна.</p> <p>Түүнчлэн, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.13.18-т “Эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх” тусгай зөвшөөрлийг бүхэлд нь олгож байх бөгөөд аж ахуйн нэгжүүд энэ тусгай зөвшөөрлөөс зөвхөн эмнэлгийн хэрэгсэл импортлох үйл ажиллагаа явуулж байхад, төрийн байгууллагаас бусад төрлийн үйл ажиллагааг нь явуулахыг шаардах, холбогдох тайлан нэхэх зэргээр хүндрэл учруулдаг байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрлийн төрөл ангиллыг дахин тодорхойлж салгаж хуульчлах; ❖ Энэ төрлийн тусгай зөвшөөрлийг олгох процессын журмыг салбарын хуулиудад нь тусгаж оруулах; ❖ Тусгай зөвшөөрлийг бүрэн цахимжуулах.
14	Эрчим хүчний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагаа	<p>Эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулахад олгох 34 төрлийн тусгай зөвшөөрлийг хуульд заасан байна. Тусгай зөвшөөрлүүдийг нэг бүрчлэн шалгаж үзэхэд тусгай зөвшөөрөл олгох процессыг хуулиар зохицуулсан 34 буюу бүх тусгай зөвшөөрөл хуульд заасан зохицуулалтын дагуу явагдаж байна. Цахимжилтын хувьд license.energy.gov.mn цахим хуудсаар дамжуулан энэ төрлийн бүх тусгай зөвшөөрлийг авах боломжтой байна.</p> <p>Уг салбарын тусгай зөвшөөрлүүдийг бүгдийг нь эрчим хүчний тухай хуулиар зохицуулсан ба олон тооны өөр өөр тусгай зөвшөөрлүүдэд нийтлэг нэг янзын баримт бичиг шаарддаг байдал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл зөвшөөрөл бүрт тавигдах шаардлагыг ялгамжтай тогтоож өгөх байдлаар сайжруулах шаардлагатай байна.</p> <p>Зөвлөмж болгох нь:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагыг ялгамжтай тодорхойлох; ❖ Хуульд заасан процессын шаардлагуудыг хянаж, тухай бүрийн онцлогт тааруулж хуульд тусгах.

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Байгаль орчны чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	12	1.1, 1.7, 1.8, 1.11, 1.12, 1.14, 1.15, 1.17, 1.18, 1.23, 1.24, 1.26
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	3	1.5, 1.20, 1.21
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	10	1.2, 1.3, 1.4, 1.6, 1.9, 1.10, 1.16, 1.22, 1.30, 1.31
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	6	1.13, 1.19, 1.25, 1.27, 1.28, 1.29
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-18 Цахимжаагүй-13	
	Нийт	31 зөвшөөрөл	

Банк, банкнаас бусад санхүүгийн үйчилгээний чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	0	
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	21	2.4, 2.5, 2.13, 2.14, 2.15, 2.16, 2.17, 2.18, 2.21, 2.22, 2.23, 2.24, 2.25, 2.26, 2.27, 2.28, 2.29, 2.30, 2.32, 2.34, 2.36
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	12	2.1, 2.2, 2.3, 2.6, 2.12, 2.19, 2.20, 2.31, 2.33, 2.35, 2.37, 2.38
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	5	2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11,

5	Цахимжсан эсэх	Цахимжсан-24 Цахимжаагүй-14	
	Нийт	38 зөвшөөрөл	

Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	0	
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	0	
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	22	3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.11, 3.12, 3.13, 3.14, 3.15, 3.16, 3.17, 3.18, 3.19, 3.20, 3.21, 3.22,
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	0	
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-21 Цахимжаагүй-1	
6	Нийт	22 зөвшөөрөл	

Зам, тээврийн чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	0	
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	0	

3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	12	5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.9, 5.10, 5.11, 5.12,
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	0	
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-1 Цахимжаагүй-11	
	Нийт	12 зөвшөөрөл	

Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	3	6.2, 6.4, 6.6,
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	0	
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	8	6.1, 6.5, 6.7, 6.8, 6.9, 6.10, 6.11, 6.12,
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	1	6.3,
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-10 Цахимжаагүй-2	
	Нийт	12 зөвшөөрөл	

Соёл, боловсролын чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	7	7.1, 7.2, 7.3, 7.5, 7.6, 7.8, 7.11,

2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	0	
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	3	7.4, 7.10, 7.12,
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	2	7.7, 7.9,
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-9 Цахимжаагүй-3	
	Нийт	12 зөвшөөрөл	

Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн гөрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	24	8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7, 8.8, 8.9, 8.10, 8.14, 8.16, 8.17, 8.18, 8.19, 8.20, 8.21, 8.22, 8.23, 8.24, 8.25, 8.26, 8.27, 8.29, 8.30,
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	1	8.15,
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	0	
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	5	8.1, 8.11, 8.12, 8.13, 8.28,
5	Цахимжсан эсэх	Цахимжсан- 16 Цахимжаагүй- 14	
	Нийт	30 зөвшөөрөл	

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	12	9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.10, 9.11, 9.12, 9.14,
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	3	9.9, 9.13, 9.15,
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	0	
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	0	
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-14 Цахимжаагүй-1	
	Нийт	15 зөвшөөрөл	

Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	1	10.1
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	0	
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	0	
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	0	
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-0 Цахимжаагүй-1	

	Нийт	1 зөвшөөрөл	
--	------	-------------	--

Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	1	11.13,
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	0	
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	12	11.1, 11.2, 11.3, 11.4, 11.5, 11.6, 11.7, 11.8, 11.9, 11.10, 11.11, 11.12,
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	0	
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-2 Цахимжаагүй-11	
	Нийт	13 зөвшөөрөл	

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	12	12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.7, 12.8, 12.9, 12.10, 12.13, 12.14,
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	0	
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	1	12.11,
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	1	12.12

5	Цахимжсан эсэх	Цахимжсан-13 Цахимжаагүй-1	
	Нийт	14 зөвшөөрөл	

Эрүүл мэндийн чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	3	13.17, 13.18, 13.19,
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	5	13.1, 13.2, 13.3, 13.4, 13.5,
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	9	13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12, 13.13, 13.14, 13.15, 13.20,
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	0	
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-16 Цахимжаагүй-1	
	Нийт	17 зөвшөөрөл	

Эрчим хүчний чиглэл

№		Тоо	Тусгай зөвшөөрлийн төрлүүд
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	34	14.1-14.34
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдаж байгаа	0	
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	0	
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж	0	

	өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй		
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-34 Цахимжаагүй-0	
	Нийт	34 зөвшөөрөл	

Нэгдсэн тоон үзүүлэлт

№		Тоо
1	Дан ганц холбогдох тусгайлсан хуулиар зохицуулагдаж байгаа	109
2	Тусгай зөвшөөрөл авах процесс нь хууль болон журмаар давхар зохицуулагдсан	33
3	Тусгай зөвшөөрлийн процесс журмаар зохицуулагдсан	89
4	Хууль болоод журмаар зөвшөөрөл олгохтой холбоотой процессыг нь зааж өгөөгүй өөрөөр хэлбэл ямар ч зохицуулалтгүй	20
5	Цахимжсан эсэх	Цахимжсан-178 Цахимжаагүй-73
	Нийт	251 зөвшөөрөл

ЗУРГАА. ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж

1. Зөвшөөрлийн тухай хууль
2. Агаарын тухай хууль
3. Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам
4. Амьтны тухай хууль
5. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
7. Байгалийн ургамлын тухай хууль
8. Банкны тухай хууль
9. Банк байгуулах зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх журам
10. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль
11. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам
12. Валютын зохицуулалтын тухай хууль
13. Гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан суртлаах зөвшөөрөл олгох үйл ажиллагааны заавар
14. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам
15. Газрын тухай хууль
16. Генетик нөөцийн тухай хууль
17. Даатгалын багц дүрэм
18. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль
19. Зээлийн мэдээллийн тухай хууль
20. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн журам
21. Ойгоос мод бэлтгэх журам
22. Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам
23. Ойн тухай хууль
24. Төв банк /Монгол банк/-ны тухай тухай хууль
25. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгдэгтээр гүйцэтгэх тухай хууль
26. Төлбөрийн системийн журам
27. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
28. Хог хаягдлын тухай хууль
29. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль
30. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам
31. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
32. Ургамлын тухай хууль
33. Усны тухай хууль
34. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль
35. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих журам

36. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам
37. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль
38. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам
39. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
40. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам
41. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль
42. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага
43. Ховордсон амьтан, ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль
44. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам
45. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн түр журам
46. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль
47. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль
48. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам
49. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам
50. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль
51. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам
52. Хувиргасан амьд организмын тухай хууль
53. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам

Хоёр. Ашигласан цахим хуудас

1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам- <https://mddc.gov.mn/mn/>
2. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний талаарх хэлэлцүүлэг- <https://www.mongolchamber.mn/a/1545>
3. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага- <https://license.mrtd.gov.mn>
4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага <http://license.met.gov.mn>
5. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага <https://license.mcis.gov.mn>

6. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
<https://license.gazar.gov.mn>
7. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
<https://cmcs.mrpam.gov.mn/cmcs>
8. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
<https://www.urban.gov.mn>
9. Санхүүгийн зохицуулах хороо <https://license.frc.mn/home>
10. Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга <http://www.license.edu.mn>
11. Харилцаа холбооны зохицуулах хороо <http://customer.crc.gov.mn>
12. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
<http://sas.police.gov.mn>
13. Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн <https://license.mofa.gov.mn>
14. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
<http://vetdrug.mn>
15. Нийслэл Улаанбаатар хот <https://service.ulaanbaatar.mn>
16. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн <http://tzmoh.gov.mn>
17. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
<https://www.license.energy.gov.mn/user/login>
18. Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамж, хийн хангамжийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, бусад тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл
<https://license.erc.mn/auth/login>
19. Эрүүл мэндийн яамны системийн мэдээлэл - <https://tzmoh.gov.mn>
20. Зөвшөөрлийн үйлчилгээ - <https://license.mn>
21. Нийслэлийн нэгдсэн мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээний нэгдсэн цахим хуудас
<https://service.ulaanbaatar.mn/home>
22. ХЗДХЯ-наас ЗХХАЭ №18 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530546492421&type=2>
23. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолын хавсралт <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207409&showType=1>
24. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207617&showType=1>
25. Эрчи хүчний яам - <http://www.energy.gov.mn/>
26. Зөвшөөрлийн үйлчилгээний нэгдсэн систем <https://e-business.mn/main-services>
27. Зөвшөөрлийн үйлчилгээ <https://e-mongolia.mn/services/citizen/sector/all>

ДОЛОО. ХАВСРАЛТ

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2025 ОН**

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.30-д “Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.” гэж, 3.5.11-д “Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.” гэж, 5.3.11-д “Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, 6.2.18-д “Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөц ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны цахим зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2-т заасан “БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ОРЧИН” зорилтын 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, 3.2.2.4-т “Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ.” гэж, 4.2.2-т заасан “ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ” зорилтын 4.2.2.5-д “Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, зөвшөөрлийн тогтолцоог шинэчилж, бүрэн цахимжуулан төрийн захиргааны үйл ажиллагааг идэвхжүүлэх, төрийн албан хаагчдыг тогтмол чадавхжуулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 07 дугаар тогтоолоор Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд үндэслэн зөвшөөрөлгүй эрхлэх үйл ажиллагааг бүртгэл, эрх олголт, дүгнэлт зэрэг баримт бичгээр зөвшөөрөлжүүлсэн, эсхүл нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад бүртгэлгүй захиргааны актаар зөвшөөрөл олгож буй асуудлын хуулийн хариуцлагыг чангатгах, хуулийн нэр томьёо, эрх зүйн зохицуулалтыг оновчтой тодорхойлох, Зөвшөөрлийн тухай хууль, салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, уялдааг хангах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах,

холбогдох хуулийн төслийг боловсруулахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон.

Иймд хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулах нь төрөөс эдийн засгийн баталгааг нь хангах, эрх ашгийг хамгаалах, төрийн оролцоог бууруулах, зөвшөөрөл, хязгаарлалтыг бууруулах нь чухал ач холбогдолтой тул Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг **Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын² 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д заасны дагуу хуулийн төслийн зүйл, заалтын харилцан уялдаа, практикт хэрэгжих боломж, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, улмаар хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан болно.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг дараах үе шаттайгаар хийлээ:

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлыг харгалзан 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо:

1. зорилгод хүрэх байдал;
2. ойлгомжтой байдал;
3. зардал;
4. харилцан уялдаа.

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

² Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3	Зардал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн нөлөөллөөс иргэн аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагад гарах нэмэгдэл зардлыг үнэлж тооцох.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Тус хуулийн төслийн үзэл баримтлалд дараах үндсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

-Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулан зөвшөөрлийн процессыг хялбаршуулж, цаг хугацаа, зардлыг хэмнэж, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай хүргэнэ;

-Зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой шаардах баримт бичгийн тоо, шат дамжлагыг багасгана;

-Ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэнэ;

-Зах зээлийн өрсөлдөөн, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ;

Хуулийн төслийн үзэл баримтлал	Хуулийн төслийн зохицуулалт
<p>-Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулан зөвшөөрлийн процессыг хялбаршуулж, цаг хугацаа, зардлыг хэмнэж, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай хүргэнэ;</p>	<p>- төрийн үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулах, цахимаар авах боломжийг бүрдүүлэх;</p> <p>- аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай хүсэлт шийдвэрлэлтийг цахим хэлбэрээр харах боломжтой, ил тод, нээлттэй байх;</p> <p>- төрөөс үйлчилгээ үзүүлэхдээ аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчээс хуульд заагаагүй баримт бичиг, эсхүл нэмэлт мэдээлэл ирүүлэхийг шаардахгүй байх;</p> <p>Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, 16 дугаар зүйлийн 16.4-т “...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэж тус тус заасан.</p> <p>Иймээс төрийн зүгээс иргэн, хуулийн этгээдийн эрхлэх аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой харилцаанд оролцохдоо баримтлах нийтлэг зарчмуудыг тодорхой тусгасан бөгөөд тэдгээр зарчмыг төрийн бүх шатны байгууллагууд болон хувь хүн, байгууллага (зохих хэмжээнд) дагаж мөрдөх үүргийг хүлээхээр зохицуулсан байгаа нь хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан 1 дүгээр зорилтыг хангаж байна.</p>
<p>-Зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой шаардах баримт бичгийн тоо, шат дамжлагыг багасгана;</p>	<p>- аж ахуйн үйл ажиллагааны төрийн зохицуулалттай холбоотой бодлого, хууль тогтоомж, захиргааны шийдвэр нь тодорхой, хоёрдмол утгагүй, нийтэд ойлгомжтой байх;</p> <p>- төрийн албадлагын арга хэмжээ нь зорилгодоо нийцсэн, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн үйлдсэн зөрчлийн шинж чанарт тохирсон байх;</p>

	<p>Мөн Хуульд “зөвшөөрөл” гэсэн нэр томъёогоор тодорхой зааснаас бусад тохиолдолд өөр хэлбэрээр зөвшөөрлийн шинжийг агуулсан үйл ажиллагаа эрхлэх эрхийг төрийн байгууллага, албан тушаалтнаас олгох зохицуулалтыг хууль болон бусад эрх зүйн актаар зохицуулахыг хориглож, аж ахуйн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хяналт тавих, өмч хөрөнгийг нь хууль бусаар хураан авах, дайчлахыг хориглосон байна.</p> <p>Эдгээр зохицуулалтууд нь хуульд тусгасан зарчмыг хэрэгжүүлэх арга замыг тодорхой болгож, одоогийн хууль тогтоомжийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулахад чиглэсэн зохицуулалтуудыг цогцоор агуулсан байна.</p> <p>Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.</p>
<p>-Ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэнэ</p>	<p>- төрөөс гаргаж буй хууль тогтоомж, шийдвэр нь үндэслэл бүхий, тодорхой, мэдээлэл нь ил тод нээлттэй байх, тухайн шийдвэрээр тогтоож буй шаардлагыг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч биелүүлэх боломжтой, урьдчилан таамаглахуйц байх;</p> <p>- төрөөс хийж буй зохицуулалт нь хөрөнгө оруулагч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн бизнесийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;</p> <p>Дээрх зохицуулалтууд нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн эдийн засгийн эрх чөлөөг төрийн зүгээс хязгаарлах, хориглох арга хэмжээг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд ингэхдээ тус хуулийн төслийг боловсруулах, батлахад тавигдах шаардлагыг тодорхой, хоёрдмол утгагүй зохицуулахаар тусгасан байна. тухайлбал, хуулийн төсөлд тавигдах шаардлага буюу хязгаарласан, хориглосон зохицуулалтын хүрээ, агуулга болон төслийг олон нийтэд танилцуулах, оролцоог нь хангах, санал авах, мэдээлэхтэй холбоотой харилцааг тодорхой тусгаж, иргэн, хуулийн этгээдийн мэдэх эрхийг бүрэн хангасан байна.</p> <p>Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.</p>
<p>-Зах зээлийн өрсөлдөөн, хувийн хэвшлийн</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг,</p>

санаачилгыг дэмжиж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ;	нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсний дагуу төрийн зүгээс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, харилцан туслалцах замаар улсынхаа эдийн засгийн өсөлтийг дэмжих тул хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг хангаж байна.
--	---

3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн боловсруулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгасан.

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг тогтоох зорилгоор иргэд, олон нийтээс хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд ойлгомжгүй байгаа зохицуулалт байхгүй талаар саналаа ирүүлсэн.

Хууль тогтоомжийн тухай хууль 29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн	Уг шаардлагыг хангасан

нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.
30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан

3.3. “Зардал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Төрд үүсэх зардал: Төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй.

Иргэнд үүсэх зардал: Иргэдэд нэмэлт зардал үүсгэхгүй.

Иргэн, аж ахуйн нэгжид: Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар аж ахуйн нэгжид нэмэлт зардал үүсгэхгүй бөгөөд төрийн байгууллагаас үйлчилгээ авахад тулгамдаж буй асуудлууд шийдэгдэж, процессыг хялбарчилснаар цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийг бүхэлд нь авч үзсэн.

Хүснэлт 4. Хуулийн төслийг аргачлалын дагуу үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөл нь энэхүү хуулийн төсөлд төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн, шуурхай хүргэх, харилцан мэдээлэл солилцох зэргээр тэдгээрийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн агуулгатай нийтлэг зохицуулалтыг тусгасан тул хуулийн зорилттой нийцэж байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын стандарт болон бусад хуульд нийцүүлсэн байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцсэн байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Нийцсэн байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Хуулийн төслөөр хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан байна.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан, нэг чиг үүргийг хоёр өөр төрийн

	байгууллага гүйцэтгэх, давхардуулсан зохицуулалт байхгүй байна.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй. Авлига, хүнд суртлыг таслан зогсоох буюу түүнийг шийдвэрлэхтэй холбоотой механизмыг тусгасан.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийг хохироор, төрийг хариуцлагад оруулсан албан хаагч, хувь хүнд албан тушаалын болон эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Дээрх судалгаанаас үзэхэд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хууль тогтоомжтой уялдсан бөгөөд давхардалгүй байна.

Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

Дүгнэлт: Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд хуулийн төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

- Хуулийн төслийн зорилт нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага, үндэслэлийг бүрэн илэрхийлж чадсан байна.

- Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөлд тодорхойлсон зорилго, зорилтыг бүрэн илэрхийлсэн байна.

- Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах шаардлагад нийцсэн бөгөөд төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байна.

- Хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байна.

Тав. Зөвлөмж

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхэд хуулийн төсөл зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байх тул хуулийн төслийг хэвээр үлдээх нь зүйтэй байна.

---oOo---

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл/

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх үүрэг болон тэдгээрийг дагалдан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийнэ.

- 1.Төрийн байгууллагын зардал;
- 2.Хуулийн этгээдийн зардал;
- 3.Иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр ангилан үүсэх зардлыг тооцож, улмаар холбогдох ачааллыг багасгах, зардлыг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулдаг.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, дараах эерэг үр дагаврыг бүрдүүлнэ.

- Бизнес эрхлэхэд таатай орчин бүрдэж, зөвшөөрөлтэй холбоотой авлига, хүнд суртал, албан тушаалтны үйл ажиллагаанаас хамааралтай байдлыг багасгана.

- Зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой шаардах баримт бичгийн тоо, шат дамжлагыг багасгана.

- Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулан зөвшөөрлийн процессыг хялбаршуулж, цаг хугацаа, зардлыг хэмнэж, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай хүргэнэ.

- Ил тод байдал, олон нийтийн оролцоо, хяналт нэмэгдэнэ.

- Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тус хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт гарахгүй.

Өөрөөр хэлбэл, хуулийн өөрчлөлтэй холбоотой үүрэг хүлээгч байгууллагуудад хүний нөөцийн болон захиргааны зардал нэмэлтээр гарахгүй, одоогийн хүний нөөц,

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

үйл ажиллагааны зардалдаа багтаан хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх боломжтой.

Түүнчлэн энэхүү хуулийн төслөөр хувь хүн, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт үүрэг хүлээлгээгүй тул хуулийн хэрэгжилттэй холбоотой тэдгээрээс нэмэлт зардал шаардахгүй.

Төрд үүсэх зардал: Төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй.

Иргэнд үүсэх зардал: Иргэдэд нэмэлт зардал үүсгэхгүй.

Иргэн, аж ахуйн нэгжид: Хуулийн төсөл батлагдсанаар аж ахуйн нэгжид нэмэлт зардал үүсгэхгүй бөгөөд төрийн байгууллагаас үйлчилгээ авахад тулгамдаж буй асуудлууд шийдэгдэж, цаг хугацаа, процессуудыг хялбарчилснаар зардлыг хэмнэнэ.

Иймд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалттай уялдан зардал үүсгэх болон үүсгэж болзошгүй зүйл, заалтыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судлахад төр, хуулийн этгээд ба иргэнд ямар ч нэмэлт зардал үүсэхгүй тул төсөлтэй холбогдуулан зардлыг тооцох шаардлагагүй болно.

--oOo--

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2025 оны 10 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Байршил: Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим

Зохион байгуулагдсан өдөр: 2025 оны 10 дугаар сарын 2-ны өдөр

Оролцогчдын тоо: 237 (Холбогдох төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил)

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал танилцуулсан.

1. Хууль эрх зүйн шинэчлэл

- Хуулийн төслийн агуулгыг танилцуулсан.
- Монгол Улс өмчийн эрх, шүүхийн тогтолцоо, бизнес эхлүүлэх болон зөвшөөрөл авахад хүнд сурталтай тул олон улсын үзүүлэлтүүдэд доогуур үнэлэгдэж байна.

2. Бизнесийн орчны хүнд суртал

- Монголд бизнес эхлүүлэхэд 7 үе шат, 10 хоног шаарддаг бол Эстонид 3 үе шат, 3.5 хоног байдаг.
- Эрчим хүч, гааль зэрэг олон шат дамжлага бизнесийн орчныг хүндрүүлдэг.
- Зөвшөөрлийг цахимжуулах, шаардлагагүй журам цуцлах шинэчлэл эхэлсэн.

3. Төрийн өмчит компаниуд

- 165 ТӨК хувийн хэвшилтэй өрсөлдөж, бизнесийн орчныг боомилж байна.
- Ашиггүй ТӨК-ийг татан буулгаж, зөвхөн стратегийн салбарт төрийн оролцоог үлдээх шаардлагатай.
- Нийтийн өмчийн эзэн тодорхойгүй байгаа асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй.

4. Олон улсын харьцуулалт

- Казахстан, Вьетнам зэрэг улс бизнесийн орчноо сайжруулж, хөрөнгө оруулалт татаж байна.
- Монгол хөрөнгө оруулалтын гэрээг ил тод хэлэлцэж, цахимд байршуулсан нь дэлхийд анхны жишиг болсон.

5. Төсөв, эдийн засгийн бодлого

- 2025 оны төсөвт урсгал зардлыг хязгаарлаж, орлого, зарлагыг бууруулсан.
- Төрийн төвлөрсөн орлогын ДНБ-д эзлэх хувийг 37.1%-аас 30.9%-д бууруулна.
- Татварын багц хуулийн шинэчлэл өргөн мэдүүлэгдсэн.

6. Авлига, засаглал

- Монгол Улс авлигын индексээр 180 орноос 114-д эрэмбэлэгдэж байна.
- Төрийн өмч давамгайл байдал авлига, хүнд сурталд нөлөөлж байна.

Монголын үзүүлэлтүүд (184 орноос):

- Эрх зүйт ёсны индекс: 72
- Бизнесийн эрх чөлөө: 85
- Өмчийн эрхийн баталгаа: 94
- Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал: 109
- Төрийн тогтвортой байдал: 115

Олон нийтээс дараах санал ирүүлсэн:

- Монголд бизнес эхлүүлэхэд олон шат дамжлага, хугацаа шаарддаг.
- Хуульд заагаагүй хяналт шалгалт хийх, хуулиас давсан журам батлахыг хориглож, төр-хувийн хэвшлийн хамтын зөвлөлдөх механизмыг бий болгоно.
- Төр зөвхөн бодлогоор дэмжиж, төрийн чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэхээр тусгажээ.
- Төрийн үйлчилгээг хугацаатай болгох, 120 тусгай зөвшөөрлийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх талаар санал өгснийг хуулийн төсөлд тусгасан болно.



---o0o---